



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2012-2016



Улаанбаатар хот
2016 он

DD 320

M-692

ISBN: 978-99973-806-7-8

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2012-2016 он

Хянан тохиолдуулсан: Б.БОЛДБААТАР

Хэвлэлд бэлтгэсэн: Ш.СОДНОМЖАМЦ, Б.ЯНЖИНЛХАМ,
Ж.НЭРГҮЙ, Г.БҮРЭНЖАРГАЛ, Г.ХЭРЛЭН,
Б.МАНДУХАЙСЭЦЭН, Л.ЖАРГАЛМАА

Дизайнер: Г.СУГАРСҮРЭН
Гэрэл зургийг: Х.СҮХ-ОЧИР, Л.БАЯРСАЙХАН
Г.ХЭРЛЭН

Хэвлэлийн хуудас: 27хх
Хэвлэсэн газар: “Сэлэнгэпресс” ХХК

Энэхүү номын зохиогчийн эрх Улсын Их Хурлын
Тамгын газарт хадгалагдана.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

АЧААНЫ ХҮНДИЙГ ҮҮРСЭН ПАРЛАМЕНТ БАЙЛАА

-Нэгэн бүрэн эрхийн хугацаанд мөр зэрэгцэн ажилласан түшээддээ-



Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа өндөрлөх гэж байна. Энэ удаагийн парламентыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн шинэчилсэн хуулиар анх удаа сонгуулийн холимог хэлбэр, санал хураалтын автоматжуулсан системээр сонгож бүрдүүлсэн онцлогтой билээ. Өнгөрсөн дөрвөн жилд бүрдсэн Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрийн хүчнүүд эв зөийг хичээн үндэсний эв нэгдлийг эрхэмлэж, улс төрийн тогтвортой байдлыг хадгалж улс орны хөгжлийн төлөө бүтээлч, шуурхай, шинэ арга барилаар хандаж ажиллалаа. Энэ удаагийн Улсын Их Хурал нь дэлхийн эдийн засаг хүндэрсэн цаг үед улс орныг удирдаж, угтан ирэх сорилтыг даван туулж ажилласан онцлогтой, ачааны хүндийг үүрсэн парламент байв.

Улсын Их Хурал өнгөрсөн 4 жилд улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжил, бүтээн байгуулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, бодлогын болон эрх зүйн томоохон шийдлүүд гаргаж ажиллалаа. Энэ удаагийн Улсын Их Хурал бүрэн эрхийн хугацаандаа бие даасан 135 хуулийг батлан гаргаж, 950 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан олон улсын гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр 55-ыг соёрхон баталжээ. Түүнчлэн 97 хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Улсын Их Хурлын 370 тогтоол баталсан байна.

Дэлхийн түүхий эдийн зах зээл дэх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн суперциклийн оргил үе 2011 онд тохиож, 2012 оноос эхэлсэн үнийн огцом бууралт үргэлжилсээр байна. Түүхий эдийн үнэ ханш өндөр байх үеийн хэт тэлсэн улсын төсөв, хөөсөрсөн хөрөнгийн зах зээл, хавтгайрсан халамжийн бодлого нь улс орныг гүнзгий хямралд хүргэж болзошгүй эгзэгтэй үед энэ удаагийн Улсын Их Хурал үйл ажиллагаагаа эхэлсэн билээ.

Эдийн засаг, төсөв, мөнгөний зөв, чамбай бодлого баримталж, банк санхүү, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, бизнесийн салбарыг дэмжих чиглэлээр томоохон, чухал хууль тогтоомжуудыг батлан гаргаснаар эдийн засгийн хүндрэлийг үндсэндээ амжилттай туулан гарч байна. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталж, Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг хүчингүй болгосноор хөрөнгө оруулагчийг гадаад, дотоодын гэж ялгаварлахгүйгээр нийтлэг эрх зүйн зохицуулалт, хамгаалалт, баталгааг бий болгож, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүллээ.

Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг баталж, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг шалгаруулахыг хориглож, 370 нэр төрлийн барааны импортын гаалийн албан татварыг 5 хувиас 20 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг Засгийн газарт олголоо. Мөн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортолдог үндэсний үйлдвэрт зээлийн хөнгөлөлт үзүүлэхээр болсон. Эдийн засгийн бодит секторыг дэмжих эрх зүйн орчныг улам боловсронгуй болгож томоохон бүтээн байгуулалт, хөгжлийн зээлүүдийг цаг алдалгүй эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэв. Ялангуяа, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Ногоон хөгжлийн бодлого зэрэг баримт бичгүүдийг баталсныг онцолж байна. Мөн хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр Хүнсний тухай хууль, Тариалангийн тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль зэрэг томоохон ач холбогдол бүхий хуулиудыг батлан гаргалаа.

Энэ удаагийн Улсын Их Хурал нь Монгол Улс хөгжлийн бодлого төлөвлөлтийн цоо шинэ тогтолцоонд шилжих эрх зүйн үндэс, суурийг тавьсан явдлыг онцгойлон тэмдэглэж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдсанаар бодлогын баримт бичгүүдийг цэгцлэн үндэсний, салбарын, салбар хоорондын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой, нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэв. Бидний баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” нь манай орны ойрын 15 жилийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын чухал баримт бичиг болсон юм.

Бүрэн эрхийн хугацаандаа тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоог сайжруулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж үйлчилгээг сайжруулах чиглэлээр томоохон арга хэмжээнүүд авлаа. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиар 1990-1995 онуудад нийгмийн даатгалын шинэ тогтолцоо бүрэлдэх явц, 1995-2000 он хүртэлх Нийгмийн даатгалын шинэ тогтолцоог хэрэгжүүлэх явцад хувь хүнээс өөрөөс нь үл хамаарсан нийгмийн шилжилтийн улмаас албан бус хөдөлмөр эрхэлж байсан, эсвэл ажил хөдөлмөр эрхлээгүй, эрхлэх боломжгүй байсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож нөхөн тооцуулах, цаашид тэдний тэтгэврийн даатгалын баталгааг хангаж өгөх асуудлыг шийдвэрлэв.

Иргэний хуульд нэмэлт оруулах тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баталсан нь ипотекийн зээлийг хэвийн үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлж, иргэдээ орон сууцжуулахад чиглэсэн чухал алхам болсны

зэрэгцээ хөрөнгийн зах зээлийг идэвхижүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих, барилгын салбарыг зогсонги байдлаас гаргах олон талын ач холбогдолтой шийдвэр боллоо. Түүнчлэн боловсрол, эрүүл мэндийн салбарын өнөөгийн хөгжлийн түвшинг цаашид ахиулах, хүртээмж, чанарыг нь дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн чухал шийдвэрүүдийг гаргалаа.

Улсын Их Хурлын бүрэн эрхийн энэ хугацаанд Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд парламент болон Засгийн газрын үйл ажиллагааны уялдаа, холбоог нарийвчлан тодруулсан хэд хэдэн зарчмын чухал өөрчлөлтүүдийг холбогдох хууль тогтоомжинд оруулснаар Засгийн газар эрч далайцтай ажиллах, Улсын Их Хурлын зүгээс өөрийн хяналт шалгалтын чиг үүргийг оновчтой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсноос хойш гишүүн орны хувьд хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хууль хяналтын байгууллагын эрх зүйн шинэтгэлтэй холбоотой багц хуулиудыг батлан гаргаж мөрдүүлэв. Шүүх эрх мэдлийн тогтолцоонд чанарын томоохон өөрчлөлтүүдийг хийж чадлаа. Ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг хамгаалах, шударга ёсыг тогтооход голлох үүрэг гүйцэтгэдэг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж, Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг олон улсын гэрээ, конвенцийн заалтад нийцүүлэв. Эдгээр хуулийн бодитой хэрэгжих нөхцөлийг хангахад зайлшгүй шаардлагатай Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль сахиулах тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай хуулиудын шинэчилсэн найруулгыг хэлэлцэж баталлаа.

Энэ хугацаанд Улсын Их Хурал хууль тогтоох, бодлого тодорхойлох үйл ажиллагаандаа шинжлэх ухаанчаар хандах, судалгаанд үндэслэх, олон нийтийн санал бодлыг сонсох, тэдний оролцоог хангахад ихээхэн анхаарч ажиллав. Хууль тогтоомжийн тухай хуулийг шинээр батлан гаргасан нь энэ чиглэлээр хийсэн томоохон алхам болов.

Монголын нийгэмд эрх зүйт ардчилсан, шударга харилцааг бүрдүүлэхэд үе үеийн парламентчид чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Энэ үйл хэрэгт ард түмний элч төлөөлөгч-Та бидний оруулсан хувь нэмэр зохих ёсны байр суурийг эзэлнэ гэдэгт итгэж байна.

Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хууль тогтоох, төрийн бодлого боловсруулж батлахад чармайлт гарган ард түмний элч төлөөлөгчийн үүргээ хэрэгжүүлж ирсэн нэг танхимын нөхөддөө гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Зандаахүүгийн ЭНХБОЛД

2016 оны 06 дугаар сарын 23

ТАМГЫН ГАЗАР ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГЭЭ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ ИРЛЭЭ



Монгол Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаа энэ цаг үед УИХ-ын үйл ажиллагааны болон Эрхэм гишүүдийн хөрөг нийтлэл бүхий эл номыг уншигч Та бүхэнд дэлгэн тавьж буйдаа баяртай байна. Урьд нь ч УИХ-ын бүрэн эрхийн хугацааны төгсгөлд Тамгын газраас ийм ном бэлтгэн гаргаж ирсэн уламжлалтай.

Энэ удаагийн УИХ бүрэн эрхийн хугацаандаа бие даасан 135 хуулийг батлан гаргаж, 950 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан олон улсын гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр 55-ыг соёрхон баталжээ. Түүнчлэн 97 хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, УИХ-ын 370 тогтоол баталсан байна. Эдгээр тоо баримтын цаана улс орны хөгжил дэвшил, иргэд сонгогчдын амьдралын амин чухал асуудлууд шийдэгдэж ирсэн билээ.

Түүнчлэн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд чуулганы нэгдсэн хуралдаан 303 удаа болж нийтдээ 670 ажлын өдөр зарцуулсан бол Байнгын болон дэд хороод 993 удаа хуралдаж хууль тогтоох үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын Тамгын газар нь Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд, УИХ-ын тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ирлээ. Энэ хугацаанд Тамгын газар нь хуульд заасны дагуу жил бүрийн үйл ажиллагааны тайлангаа УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэн хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага-УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник

зохион байгуулалтын мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байна гэсэн үнэлэлт авч ирсэн нь тус хамт олны бүтээлч үйл ажиллагааны үр дүн юм.

Өнгөрсөн хугацаанд Тамгын газрын үйл ажиллагааны чанар, хүртээмж, шуурхай байдлыг хангах, хүний нөөцийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь зохих үр дүнгээ өгч байна. Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, алба, төвийн чиг үүргийг шинэчлэн боловсруулахдаа хэлтэс, алба, төвийн чиг үүрэг, ажлын давхардал, хийдэгдэл, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нарийвчлан судалж, УИХ-ын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын нэгжийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг удаа дараа гаргаж ажиллуулсан юм. Энэ үндсэн дээр УИХ-ын Тамгын газар зохион байгуулалтынхаа бүтцэд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын уялдаа холбоог сайжруулах, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох гол зорилго тавин ажиллаж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүргийг хэрэгжүүлж ирсэн билээ.

Тамгын газар нь УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд бүтэц, зохион байгуулалтаа шинэчлэн 8 хэлтэс болон Дотоод аудитор, Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв гэсэн үндсэн нэгжтэй, нийт 190 гаруй орон тоотойгоор ажиллаж ирэв. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлж хийдэл, давхардлыг арилгах арга хэмжээний хүрээнд Тамгын газрын үйл ажиллагаанд дахин инженерчлэл хийж Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийг шинээр байгуулсан нь үйл ажиллагааны нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангахад чухал алхам боллоо.

Энэ бүхний үр дүнд төрийн эрх барих дээд байгууллага УИХ-аас хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд УИХ-ын Тамгын газрын зүгээс мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөлөөр хангах хуулиар хүлээсэн чиг үүргээ амжилттай гүйцэтгэж ирснийг тэмдэглэхэд таатай байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН
ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА**



Б.БОЛДБААТАР



2012.07.06



УЛСЫН ХУУЛЬЧИЙН
СОНООН
УЛСЫН АТЛАГААНЫ
БЭРИЙЛЭГ

УЛСЫН ХУУЛЬЧИЙН
СОНООН
УЛСЫН АТЛАГААНЫ
БЭРИЙЛЭГ
2012-07-06



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2012-2016



БҮЛЭГ

ҮНДСЭН ХУУЛИАС:

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн ээлжит сонгууль 2012 оны 06 дугаар сарын 28-ны Пүрэв гарагт орон даяар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай нэгэн зэрэг болов.

Улсын Их Хурлын энэ удаагийн сонгуулийг эрх зүйн шинэ орчинд сонгуулийн хосолсон тогтолцоогоор анх удаа зохион байгуулсан. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын 76 гишүүний 48 нь мандатын журмаар тойргоос, үлдсэн 28 нь сонгуулийн дүнгээр улс төрийн намуудын авсан саналын дүнгээр Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон юм.

Сонгуулийн санал авах, тоолох, дүн гаргах болон сонгогчийн бүртгэл хяналтын үйл ажиллагааг Монгол Улс анх удаа автоматжуулсан системээр амжилттай зохион байгуулж явуулав. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах ажлыг улсын хэмжээнд анх удаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бие даан зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллажээ. Түүнчлэн Монгол Улс түүхэндээ анх удаа гадаад оронд байгаа сонгогчдынхоо саналыг авсан юм.



Энэ удаагийн сонгуульд гадаадад байгаа сонгогчдыг нэмж тооцвол нийт сонгогчдын 67,28 хувь нь оролцож саналаа өгсөн байна. Монгол Улсын Их Хурлын сонгуульд улс төрийн 11 нам, 2 эвсэл оролцохоо илэрхийлж, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн батламж авчээ. Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр 544 хүн бүртгүүлсэн бөгөөд үүнээс 26 тойрогт 354 нэр дэвшигч, нам эвслийн жагсаалтаар 190 нэр дэвшигч бүртгүүлснээс бие даан нэр дэвшигч 26, эмэгтэй нэр дэвшигч 174 байжээ.

Энэ үндсэн дээр сонгуулийн дүнгээр Ардчилсан нам 35, Монгол ардын нам 26, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвсэл 11, Иргэний Зориг ногоон нам 2 суудал авч, бие даан нэр дэвшсэн 3 нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон юм.

Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы 2012 оны 07 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар Сонгуулийн ерөнхий хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн 72 гишүүнээс 69 гишүүний бүрэн эрхийг баталгаажуулж, тангарагаа өргөв. Харин Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Октябрийн Баасанхүү, Цэрэндашийн Цолмон нар 2012 оны 08 дугаар сарын 01-ний өдөр, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашжамцын Арвин, Гаваагийн Батхүү нар 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр гишүүний тангаргаа өргөсөн юм.



Мөн МАН-аас намын жагсаалтаар Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон У.Хүрэлсүхийг хүсэлтийн нь дагуу 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлж, түүний оронд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Д.Сарангэрэл 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр гишүүний тангарагаа өргөв. Түүнчлэн 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цэрэндашийн Оюунбаатарын, 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашзэвэгийн Зоригт, Долгорсүрэнгийн Сумъяабазар нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрснөөр энэ удаагийн Улсын Их Хурал бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах болсон билээ.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 01

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон дор дурдсан нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

- 1/ Норовын Алтанхуяг
- 2/ Ринчиннямын Амаржаргал
- 3/ Агыпарын Бакей
- 4/ Нямжавын Батбаяр
- 5/ Сундуйн Батболд
- 6/ Сүхбаатарын Батболд
- 7/ Жалбасүрэнгийн Батзандан
- 8/ Жамъянсүрэнгийн Батсуурь
- 9/ Халтмаагийн Баттулга
- 10/ Догсомын Батцогт
- 11/ Намдагийн Батцэрэг
- 12/ Мигэддоржийн Батчимэг
- 13/ Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
- 14/ Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- 15/ Зангадын Баянсэлэнгэ
- 16/ Гарьдхүүгийн Баярсайхан
- 17/ Цэвэлмаагийн Баярсайхан
- 18/ Сангажавын Баярцогт
- 19/ Лувсанвандангийн Болд
- 20/ Баярбаатарын Болор
- 21/ Хаянгаагийн Болорчулуун
- 22/ Раднаагийн Бурмаа
- 23/ Сандагийн Бямбацогт

- 24/ Сайнхүүгийн Ганбаатар
- 25/ Дашдондогийн Ганбат
- 26/ Лувсаннъямын Гантөмөр
- 27/ Даваажавын Ганхуяг
- 28/ Батхүүгийн Гарамгайбаатар
- 29/ Раднаасүмбэрэлийн Гончигдорж
- 30/ Цэрэнпилийн Даваасүрэн
- 31/ Цэдэвийн Дашдорж
- 32/ Дамдингийн Дэмбэрэл
- 33/ Самбуугийн Дэмбэрэл
- 34/ Мөнхчулууны Зоригт
- 35/ Данзангийн Лүндээжанцан
- 36/ Батсүхийн Наранхүү
- 37/ Нямтайширын Номтойбаяр
- 38/ Цэндийн Нямдорж
- 39/ Салдангийн Одонтуяа
- 40/ Ёндонгийн Отгонбаяр
- 41/ Санжаасүрэнгийн Оюун
- 42/ Цэдэвдамбын Оюунгэрэл
- 43/ Дуламсүрэнгийн Оюунхорол
- 44/ Ядамсүрэнгийн Санжмятав
- 45/ Чимэдийн Сайханбилэг
- 46/ Янгугийн Содбаатар
- 47/ Отгонбилэгийн Содбилэг
- 48/ Мишигийн Сономпил
- 49/ Алмаликийн Тлейхан
- 50/ Шаравдоржийн Түвдэндорж
- 51/ Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
- 52/ Дэндэвийн Тэрбишдагва
- 53/ Чүлтэмийн Улаан
- 54/ Гантөмөрийн Уянга
- 55/ Дамдингийн Хаянхярваа
- 56/ Чимэдийн Хүрэлбаатар
- 57/ Ухнаагийн Хүрэлсүх
- 58/ Логийн Цог
- 59/ Баттогтохын Чойжилсүрэн
- 60/ Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
- 61/ Жадамбын Энхбаяр
- 62/ Зандаахүүгийн Энхболд
- 63/ Миеэгомбын Энхболд
- 64/ Нямаагийн Энхболд
- 65/ Өлзийсайханы Энхтүвшин
- 66/ Содномзундуйн Эрдэнэ
- 67/ Дондогдоржийн Эрдэнэбат
- 68/ Жаргалтулгын Эрдэнэбат
- 69/ Лувсангийн Эрдэнэчимэг

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 04

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Октябрийн Баасанхүү, Цэрэндашийн Цолмон нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 53

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт, 6.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Ухнаагийн Хүрэлсүхийг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 63

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашжамцын Арвин, Гаваагийн Батхүү, Даваажанцангийн Сарангэрэл нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 72

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 11.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цэрэндашийн Оюунбаатарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 36

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Дашзэвэгийн Зоригт, Долгорсүрэнгийн Сумъяабазар нарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА, ДЭД ДАРГА НАР



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ЗАНДААХҮҮГИЙН ЭНХБОЛД

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг Монгол Улсын Их Хурлын даргаар сонголоо.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА САНГАЖАВЫН БАЯРЦОГТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дэд даргаар Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг сонгов. Харин Монгол Улсын Их Хурлын 2013 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөв.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА РАДНААСҮМБЭРЭЛИЙН ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын дэд даргаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн Гончигдоржийг сонгов.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА ЧҮЛТЭМИЙН УЛААН

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын дэд даргаар МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг сонгов. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөв.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА ЛОГИЙН ЦОГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дэд даргаар МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Логийн Цогийг сонгов.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Монгол Ардын Намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Миеэгомбын Энхболдыг сонгов.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА НАР (2012-2016)**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО



Ц.Цолмон
(2012-2013 он)



Ц.Оюунбаатар
(2013-2014 он)



Ж.Энхбаяр
(2014-2016 он)



М.Сономпил
(2016.01.14-өөс)

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО**



Г.Баярсайхан
(2012-2014 он)



Су.Батболд
(2014-2015 он)



Л.Эрдэнэчимэг
(2015-2016)

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРОО**



З.Баянсэлэнгэ
(2012-2013 он)



Д.Батцогт
(2013-2016)

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО



Р.Бурмаа
(2012-2015 он)



О.Баасанхүү
(2015-2016 он)



Ж.Батзандан
(2016.01.14-өөс)

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



А.Бакей
(2012-2016)

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО



Ц.Даваасүрэн
(2012-2014 он)



Б.Болор
(2014-2015 он)



Ч.Улаан
(2015-2016)

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО



Ш.Түвдэндорж
(2012-2014 он)



Д.Ганбат
(2014-2016)

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО



Б.Гарамгайбаатар
(2012-2014 он)



Ж.Батсуурь
(2014-2015 он)



Ц.Баярсайхан
(2015-2016)

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ХОРООНЫ ДАРГА НАР

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
АСУУДЛЫН ДЭД ХОРОО**



Л.Эрдэнэчимэг
(2012-2016 он)



Ц.Оюунгэрэл
(2016.01.28-аас)

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО**



Х.Болорчулуун
(2012-2014 он)



С.Дэмбэрэл
(2014-2016 он)

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО



М.Батчимэг
(2012-2016 он)

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД
БОЛОН ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ
АСУУДЛЫН ДЭД ХОРОО***



Г.Уянга
(2012-2015 он)



Д.Сумъяабазар
(2015-2016 он)

**2016.02.04-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хороо болгож нэрийг нь өөрчилсөн.*

**НУТГИЙН УДИРДЛАГЫН
ДЭД ХОРОО**



Д.Батцогт
(2012-2015 он)



Н.Батцэрэг
(2015-2016 он)

**СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД ХОРОО**



Ж.Батзандан
(2012-2015 он)



О.Содбилэг
(2015-2016 он)

**ТУСГАЙ ХЯНАЛТЫН
ДЭД ХОРОО**



Р.Гончигдорж
(2012-2014 он)



Г.Батхүү
(2014-2016 он)

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ДЭД ХОРОО**



Р.Гончигдорж
(2012-2016 он)

**ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРОО**



Ж.Эрдэнэбат
(2012-2015 он)



Ч.Хүрэлбаатар
(2015-2016 он)

**ХҮНИЙ ЭРХИЙН
ДЭД ХОРОО**



Д.Ганбат
(2012-2015 он)



Ё.Отгонбаяр
(2015-2016 он)



Л.Болд
(2016.01.20-иос)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД

НЭГ. ТОЙРГООС СОНГОГДСОН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД

Тойргийн дугаар	Аймаг, дүүрэг	Гишүүдийн нэр		Нам, эвслийн харьяалал
1	Архангай	1	Нямжавын Батбаяр	АН
		2	Баярбаатарын Болор	АН
2	Баян-Өлгий	3	Алмаликийн Тлейхан	МАН
		4	Агипарын Бакей	АН
3	Баянхонгор	5	Халтмаагийн Баттулга	АН
		6	Дашдондогийн Ганбат	АН
4	Булган	7	Ёндонгийн Отгонбаяр	МАН
5	Говь-Алтай	8	Цэдэвийн Дашдорж	МАН
6	Дорноговь, Говьсүмбэр	9	Жамъянсүрэнгийн Батсуурь	МАН
7	Дорнод	10	Нямтайширын Номтойбаяр	МАН
		11	Хаянгаагийн Болорчулуун	Бие даан нэр дэвшигч /2016 онд МАН-ын гишүүнчлэлээ сэргээсэн/
8	Дундговь	12	Батсүхийн Наранхүү	АН
9	Завхан	13	Дуламсүрэнгийн Оюунхорол	МАН
		14	Ядамсүрэнгийн Санжмятав	АН
10	Өвөрхангай	15	Гаваагийн Батхүү	АН
		16	Дашзэвэгийн Зоригт	АН
11	Өмнөговь	17	Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ	АН
12	Сүхбаатар	18	Мөнхчулууны Зоригт	АН
13	Сэлэнгэ	19	Жаргалтулгын Эрдэнэбат	МАН
		20	Сангажавын Баярцогт	АН
14	Төв	21	Сундуйн Батболд	МАН
		22	Миеэгомбын Энхболд	МАН
15	Увс	23	Чимэдийн Хүрэлбаатар	МАН
		24	Баттогтохын Чойжилсүрэн	МАН
16	Ховд	25	Сандагийн Бямбацогт	МАН
		26	Догсомын Батцогт	АН

17	Хөвсгөл	27	Лувсанцэрэнгийн Энх-Амгалан	МАН
		28	Цэрэнпилийн Даваасүрэн	Бие даан нэр дэвшигч /2016 онд МАН-ын гишүүнчлэлээ сэргээсэн/
18	Хэнтий	29	Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ	МАН
		30	Батхүүгийн Гарамгайбаатар	АН
19	Дархан-Уул	31	Дамдины Хаянхярваа	МАН
		32	Сайнхүүгийн Ганбаатар	Бие даагч /2016 онд Хөдөлмөрийн үндэсний намд элссэн ч гарсан/
20	Орхон	33	Отгонбилэгийн Содбилэг	МАН
		34	Логийн Цог	"МАХН-МҮАН-ын "Шударга ёс эвсэл" /2016 онд эвслийн бүлгээс гарсан/
21	Хан-Уул, Багануур, Баганхангай дүүрэг	35	Цэдэвдамбын Оюунгэрэл	АН
		36	Лувсанвандангийн Болд	АН
22	Баянзүрх, Налайх дүүрэг	37	Даваажавын Ганхуяг	АН
		38	Жалбасүрэнгийн Батзандан	АН
		39	Дашжамцын Арвин	АН
23	Сүхбаатар дүүрэг	40	Лувсаннъямын Гантөмөр	АН
		41	Ринчиннъямын Амаржаргал	АН
24	Чингэлтэй дүүрэг	42	Гарьдхүүгийн Баярсайхан	АН
		43	Гантөмөрийн Уянга	"МАХН-МҮАН-ын "Шударга ёс эвсэл" /2016 онд Тусгаар тогтнол эв нэгдлийн намд элссэн/
25	Баянгол дүүрэг	44	Содномзундуйн Эрдэнэ	АН
		45	Салдангийн Одонтуяа	АН
26	Сонгинохайрхан дүүрэг	46	Лувсангийн Эрдэнэчимэг	АН
		47	Дэндэвийн Тэрбишдагва	"МАХН-МҮАН-ын "Шударга ёс эвсэл" /2016 онд МАН-д элссэн/
		48	Долгорсүрэнгийн Сумъяабазар	МАН

ХОЁР. НАМ, ЭВСЛИЙН ЖАГСААЛТААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДСОН

Нэг.Ардчилсан нам

- | | |
|------------------------------|------------------------------------|
| 1. Норовын Алтанхуяг | 7. Раднаагийн Бурмаа |
| 2. Зандаахүүгийн Энхболд | 8. Цэвэлмаагийн Баярсайхан |
| 3. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин | 9. Раднаасүмбэрэлийн
Гончигдорж |
| 4. Чимэдийн Сайханбилэг | 10. Мигэددоржийн Батчимэг |
| 5. Дондогдоржийн Эрдэнэбат | |
| 6. Шаравдоржийн Түвдэндорж | |

Хоёр. Монгол ардын нам

- | | |
|--|----------------------------|
| 1. Сүхбаатарын Батболд | 5. Данзангийн Лүндээжанцан |
| 2. Ухнаагийн Хүрэлсүх
(Д.Сарангэрэл нөхөн сонгогдсон) | 6. Цэндийн Нямдорж |
| 3. Дамдины Дэмбэрэл | 7. Нямаагийн Энхболд |
| 4. Өлзийсайханы Энхтүвшин | 8. Янгугийн Содбаатар |
| | 9. Жадамбын Энхбаяр |


Гурав.Иргэний Зориг ногоон нам

- Санжаасүрэнгийн Оюун
- Самбуугийн Дэмбэрэл
/2016 онд АН-д элссэн/

Дөрөв. “МАХН-МУАН-ын Шударга ёс эвсэл”


















- | | |
|--|---------------------------|
| 1. Чүлтэмийн Улаан
<i>/2016 онд МАН-д элссэн/</i> | 4. Зангадын Баянсэлэнгэ |
| 2. Намдагийн Батцэрэг
<i>/2016 онд АН-д элссэн/</i> | 5. Октябрийн Баасанхүү |
| 3. Мишигийн Сономпил
<i>/2016 онд АН-д элссэн/</i> | 6. Цэрэндашийн Цолмон |
| | 7. Цэрэндашийн Оюунбаатар |

НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААГЧ ГИШҮҮДИЙН (УИХ-ын сонгуулийн дүнгээр)



УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Намын харьяалал

/2013.06.01-НИЙ БАЙДАЛААР/		/2016.06.01-НИЙ БАЙДАЛААР/		НАСНЫ БАЙДАЛ /хувиар/	
	35		38		35-45
	26		30		17
	10		4		33
	2		1		46-55
БИЕ ДААГЧИД	3	НАМ БУС	2		26
			1		56-гаас дээш
МЭРГЭЖЛИЙН БАЙДАЛ /хувиар/		ХҮЙСИЙН БАЙДАЛ /хувиар/			
Хуульч	13				65
Эдийн засагч	15				85.5%
Инженер	26				11
Багш	5				14.5%
Бусад	17				

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ АРДЧИЛСАН НАМЫН БҮЛЭГ

Нийгмийн хөгжилд Монголын ард түмнийг анхлан уриалан дуудсан улс төрийн хүчнүүдийн нэгдэл болох Ардчилсан нам үндэснийхээ эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэхээр 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд Эрх чөлөөтэй, Эрүүл чийрэг, Эрдэм боловсролтой, Ажилтай орлоготой, Аюулгүй орчин бүрдүүлэх зорилготой “Монгол Хүн 2020” хүний хөгжлийн цогц хөтөлбөрөөр оролцож, хамгийн олон суудал авснаар төрийн эрх барьж ажиллалаа.



2012 оны Улсын Их Хурлын сонгуулиар Ардчилсан намаас сонгогдсон гишүүд 2012 оны 07 дугаар сарын 24-ний өдөр анхны хуралдаанаа хийж, бүлгийн дүрмээ батлан бүлгийн даргаа сонгож, бүлэг байгуулсан шийдвэрээ Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 31 гишүүнтэйгээр /хоёр гишүүн тангарагаа өргөөгүй байсан/ үйл ажиллагаагаа эхэлжээ. Өнгөрсөн хугацаанд тус бүлэгт Улсын Их Хурлын дөрвөн гишүүн /Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин, Д.Батцогт, Н.Батцэрэг, М.Сономпил/ нэмэгдэж орсноор 37 гишүүнтэйгээр бүрэн эрхийнхээ хугацааг өндөрлөж байна.

Бүлгийн гишүүдийн найм нь докторын зэрэгтэй, 14 нь магистрын зэрэг цолтойгоос хуульч, эрх зүйч 9, инженер 13, эдийн засагч 10, түүхч 3, бусад нь физикч, багш, зураач, эмч мэргэжилтэй юм. Ард түмнийхээ итгэлийг хүлээж Улсын Их Хуралд хоёроос дээш удаа сонгогдон ажилласан 23 гишүүн байна.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд 183 удаа, нийт 280 цаг хуралдаж, нийт 531 асуудал хэлэлцэж, зарим шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл дээр ажлын хэсэг байгуулж ажиллалаа.


Намын бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, Б.Гарамгайбаатар, бүлгийн дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндорж, С.Одонтуяа нар сонгогдон ажиллав.

Тус бүлгийн гишүүд Н.Алтанхуягаар удирдуулсан Шинэчлэлийн Засгийн газар болон Ч.Сайханбилэгээр удирдуулсан Шийдлийн Засгийн газарт ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн яамдыг удирдан ажиллав. Тодруулбал, Шинэчлэлийн Засгийн газарт Н.Алтанхуяг-Ерөнхий сайд, Ч.Сайханбилэг-ЗГХЭГ-ын дарга, Л.Болд-Гадаад харилцааны, Х.Тэмүүжин-Хууль зүйн, Ц.Баярсайхан-Барилга, хот байгуулалтын, Д.Ганхуяг-Уул уурхайн, Я.Санжмятав-Хөдөлмөрийн, С.Эрдэнэ-Хүний хөгжил, нийгмийн хамгааллын, Н.Батбаяр-Эдийн засгийн хөгжлийн, Л.Гантөмөр-Боловсрол, шинжлэх ухааны, Ц.Оюунгэрэл-Соёл, спорт, аялал жуулчлалын, Х.Баттулга-Үйлдвэр хөдөө аж ахуйн, Д.Бат-Эрдэнэ-Батлан хамгаалахын сайдаар тус тус ажиллав.

Шийдлийн Засгийн газарт Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөр нар улиран томилогдож, Ч.Сайханбилэг-Ерөнхий сайд, С.Баярцогт-ЗГХЭГ-ын дарга, Р.Бурмаа-Хүнс, хөдөө аж ахуйн, Д.Эрдэнэбат-Аж үйлдвэрийн, Д.Зоригт-Эрчим хүчний сайдаар тус тус ажилласан байна.

УЛСЫН ИХ ХУРАЛ ДАХЬ МОНГОЛ АРДЫН НАМЫН БҮЛЭГ

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг 2012 оны арванхоёрдугаар сарын 21-нд 25 гишүүнтэйгээр байгуулагдаж, бүлгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдыг, ахлагчийн орлогчоор Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Оюунхорол нарыг сонгов. 2013 онд Монгол Ардын нам бүтцийн өөрчлөлт хийж бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтыг, бүлгийн дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Номтойбаяр, Д.Хаянхярваа нарыг сонгон ажиллуулсан.



Бүлэг байгуулагдсан цагаас эхлэн өөрийн үйл ажиллагааны дүрэм, бүлгийн хуралдааны дэгийг хуралдаанаараа хэлэлцэн баталж, Монгол Улсын Үндсэн

хууль, Улсын Их Хурлын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжуудыг баримтлан ажиллалаа. Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу бодлого боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий Ажлын албыг хуулийн, эдийн засгийн, хэвлэл мэдээллийн, нийгмийн, дотоод ажлын гэсэн 5 хэсэгтэйгээр байгуулж, Ажлын албаны даргаар Д.Батбаатар /2013.01.04-2014.01.02/, Ш.Раднаасэд /2014.01.14-2015.02.10/, Г.Өнөрбаяр /2015.02.01-ээс/ нар томилогдон ажиллав.

2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар У.Хүрэлсүхийг өөрийнх нь хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөв. Түүний оронд намын жагсаалтаас нэр дэвшигч Д.Сарангэрэл нөхөн сонгогдож 2012 оны арванхоёрдугаар дугаар сарын 13-ны өдөр, мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойрогт явагдсан дахин санал хураалтын дүнгээр ялалт байгуулсан Д.Сумъяабазар 2013 оны тавдугаар дугаар сарын 10-ны өдөр тус тус тангараг өргөж гишүүний бүрэн эрх нь зөвшөөрөгдсөнөөр Монгол Ардын намын бүлэг 26 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан. 2016 оны 5 дугаар сард Улсын Их Хурлын бие даагч гишүүн Х.Болорчулуун Ц.Даваасүрэн, Улсын Их Хурал дахь “МАХН-МУАН-ын Шударга ёс” эвсэл”-ийн бүлгийн гишүүн Д.Тэрбишдагва, Ч.Улаан нар Монгол Ардын намын гишүүнчлэлээ сэргээж Монгол Ардын намын бүлэгт нэгдэн орсноор Монгол Ардын намын бүлэг 30 гишүүнтэй болов.

2012-2016 оны бүрэн эрхийн хугацаанд дахь Монгол Ардын намын бүлэг бүрэлдэхүүний хувьд Улсын Бага Хурлын гишүүн 2, Улсын Их Хурлын гишүүнээр зургаан удаа сонгогдсон 3, таван удаа сонгогдсон 1, дөрвөн удаа сонгогдсон 3, гурван удаа сонгогдсон 4, хоёр удаа удаа сонгогдсон 9, анхны удаа сонгогдсон 10 гишүүн байна. Мөн эрдмийн зэрэг, цолтой 21 гишүүнээс 9 нь доктор, профессор юм. Мэргэжлийн байдлаар авч үзвэл хос мэргэжилтэй 16, давхардсан тоогоор эдийн засагч 12, эрх зүйч, хуульч 6, инженер 16, улс төр судлаач, төрийн захиргааны удирдлагын ухааны менежер 9, бизнесийн удирдлагын ухааны менежер 4, дипломатч 2, багш 2, сэтгүүлч 2, агрономч 1 байна.

Энэ хугацаанд бүлгийн хаалттай 202, нээлттэй 3 удаагийн хуралдаан 452 цаг үргэлжилж, давхардсан тоогоор 537 асуудал хэлэлцэн зохих шийдвэрийг гаргасан байна. Хэлэлцсэн асуудлаар 36 санал, дүгнэлт гаргаж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд танилцуулав. Бүлгийн шийдвэрээр болон бүлгийн хуралдаанаас Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж буй хууль, тогтоолын төсөл дээр ажиллах 90 ажлын хэсэг байгуулж ажилласан байна. Гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд цаг үеийн тулгамдсан асуудлаар 50 асуулга тавьжээ.

Бүлгийн гишүүд дангаараа болон Улсын Их Хурлын бусад гишүүдтэй хамтарч давхардсан тоогоор 62 хуулийн төслийг санаачлан боловсруулж өргөн барьснаас батлагдсан 26, хэлэлцүүлгийн шатанд 20, хэлэлцэгдэж эхлээгүй 16 төсөл байна.

Гишүүд энэ хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 90 ажлын хэсэгт, Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 340 ажлын хэсэгт орж ажиллажээ.

“МАХН-МҮАН-ЫН ШУДАРГА ЁС ЭВСЭЛ”-ИЙН БҮЛЭГ

МАХН болон МҮАН нь үндэсний эрх ашгаар засаглаж, монгол хүн, монголын эрх ашгийг аливаа бүхнээс эрхэмлэн дээдлэх үзэл санаагаар нэгдэн Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд эвсэж оролцон Улсын Их Хуралд “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ээс 11 гишүүн сонгогдсон.

“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс сонгогдсон гишүүд 2012 оны 07 дугаар сарын 24-ны өдөр анхны хуралдаанаа хийж, эвслийн бүлгийн дүрмээ батлан бүлгийн ахлагчаа сонгож, бүлэг байгуулсан тухай шийдвэрээ Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн бүлэг албан ёсоор байгуулагдаж үйл ажиллагаа эхлэв.



Эвслийн бүлгийн гишүүдээс хуульч, эрх зүйч 4, инженер 4, эдийн засагч 1, сэтгүүлч 1, багш 1 гэсэн мэргэжлийн хүмүүс байна. Бүлгийн даргаар Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, О.Баасанхүү, бүлгийн дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, З.Баянсэлэнгэ нар ээлжлэн сонгогдож ажиллав.

“МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвсэл нь нийт ард түмнийхээ язгуур эрх ашигт нийцсэн, улс эх орныхоо хөгжилд нөлөөлөхүйц томоохон хөтөлбөр боловсруулан Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд оролцсон. Энэхүү хөтөлбөрөө “Монголоо аврах таван хувьсгал” гэж нэрлэсэн бөгөөд улс эх орондоо шударга ёсыг тогтоож, эх орныхоо баялгийг иргэн бүрт тэгш хүртээж, баялагтаа эзэн сууж, хангалуун, тайван, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлж, эх оронч үндэснийхээ эрх ашгийг дээдэлсэн төрийг бий болгохоор зорьж ажиллав.

Тус эвлээс Шинэчлэлийн болон Шийдлийн Засгийн газрыг хамтран байгуулалцаж, Засгийн газрын гишүүдээр Шадар сайдад Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва, Ц.Оюунбаатар нарыг, Сангийн сайдад Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан, Эрчим хүчний сайдад Улсын Их Хурлын гишүүн М.Сономпил, Эрүүл мэндийн сайдаар Н.Удвал, Г.Шийлэгдамба нарыг, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдад Улсын Их Хурлын гишүүн Н.Батцэрэг, Барилга, хот байгуулалтын сайдад Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ, Батлан хамгаалахын сайдад Улсын Их Хурлын гишүүн Ц.Цолмон, Монгол Улсын сайдад М.Энхсайхан нарыг тохоон томилуулж ажиллуулав.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын гурван гишүүн /Д.Батцогт, Н.Батцэрэг, М.Сономпил/ Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэгт, Улсын Их Хурлын гишүүн хоёр гишүүн /Ч.Улаан, Д.Тэрбишдагва/ Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлэгт нэгдэж орсон. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Уянга, Л.Цог нар тус эвслээс гарч, улмаар УИХ-ын гишүүн Г.Уянга Монголын тусгаар тогтнол, эв нэгдлийн намд элссэн.

Иймээс бүлгийн гишүүдийн тоо нь хуульд заасан шаардлагыг хангахгүй болсон тул Улсын Их Хурал дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн бүлгийн үйл ажиллагаа 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдөр албан ёсоор дуусгавар болсон юм.

----oooOooo---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ОНЦЛОГ ҮЙЛ ЯВДЛУУД

2012-2016

II БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭРХЭМ ЗОРИЛГО

Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, Монголын ард түмний засаглах эрхийг хангах нь Улсын Их Хурлын эрхэм зорилго мөн.

УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАН ЭХЛЭВ

Монгол Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ-ын Анхдугаар чуулган 2012 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хуралдав. УИХ-ын Анхдугаар чуулганыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж удирдан явуулав.



УИХ-ын 2012 оны ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэлийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Лувсанжав танилцууллаа.

УИХ-ын зургаа дахь удаагийн сонгуулийн үр дүнд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдвол зохих 76 гишүүнээс 72 гишүүн сонгогдсон бөгөөд Монгол ардын намаас 25, Ардчилсан намаас 31, “Иргэний зориг-Ногоон нам”-аас 2, “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс 11, бие даан нэр дэвшсэн 3 гишүүн, нийтдээ 72 гишүүний нэрийг Сонгуулийн ерөнхий хорооноос танилцуулсан юм.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД ТАНГАРАГ ӨРГӨВ

Шинээр сонгогдсон УИХ-ын гишүүд 2012 оны 07 дугаар сарын 06-ны өдөр хуралдсан Анхдугаар чуулганаар тангаргаа өргөснөөр зургаа дахь удаагийн УИХ бүрэн эрхээ баталгаажуулсан юм. УИХ-ын гишүүдийн тангаргийн үгийг энэ удаагийн парламентын хамгийн ахмад настны хувиар УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл уншив.



Ийнхүү УИХ-ын Сонгуулийн шинэчилсэн хуулиар анх удаа сонгуулийн холимог хэлбэр, санал хураалтын автоматжуулсан системээр сонгож бүрдүүлсэн УИХ-ын 69 гишүүн энэ өдрийн хуралдаанаар төрийн сүлдэндээ тангаргаа өргөж, үнэмлэх, энгэрийн тэмдгээ гардаж авлаа. Харин УИХ-ын гишүүний түр үнэмлэхээ гардан авсан 3 гишүүн Анхдугаар чуулганд оролцоогүй юм.



УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ ХУРАЛДААН

2012 оны 07 дугаар сарын 24-ний өдөр 76.1 хувийн ирцтэйгээр эхэлсэн УИХ-ын Анхдугаар чуулганы хуралдаанаар УИХ-ын гишүүн Зандаахүүгийн Энхболд УИХ-ын даргаар сонгогдож, төрийн нэр хүндтэй, нэн хариуцлагатай албыг хаших үүргийг хүлээв.



Анхдугаар чуулганаар УИХ-ын дарга, дэд дарга нарыг сонгов. Мөн УИХ-ын Байнгын хороо, дэд хороодыг байгуулж, дарга нарыг сонгосон байна. Энэ удаагийн парламент нээлттэй, ил тод байдлыг хангах, иргэд олон түмний санал бодлыг хууль тогтоох үйл явцад тусгах зорилгоор УИХ-ын бүтцэд Өргөдлийн байнгын хороог шинээр байгууллаа.



2012-2016 оны УИХ-ын Анхдугаар чуулган бүрэн эрхийнхээ хүрээнд хэлэлцэх ёстой бүх асуудлаа хэлэлцэж шийдвэрлэн нийт 30 хоног хуралдаж, 2012 оны 08 дугаар сарын 21-ний өдөр өндөрлөсөн юм. Ийнхүү шинээр эмхлэн байгуулагдсан УИХ төрийн залгамж чанарыг хадгалж, төрийн бодлого тодорхойлох, хууль тогтоох үйл ажиллагаандаа шуудран орсон билээ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАВ

2013 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөр улиран сонгогдсон Цахиагийн Элбэгдоржийн тангараг өргөх ёслолын ажиллагаа УИХ-ын шийдвэрээр анх удаа эзэн Чингис хааны хөшөөний өмнө ард түмнийхээ дунд нээлттэй зохион байгуулагдсанаараа онцлогтой байв.

Ерөнхийлөгчийн энэ удаагийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд зориулсан УИХ-ын хүндэтгэлийн хуралдааныг Төрийн ордны урд талбай, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө тусгайлан зассан талбайд анх удаа ард иргэддээ нээлттэй хуралдуулсан юм.



Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Цахиагийн Элбэгдорж УИХ-д тангараг өргөв. Үүний дараа тангаргаа өргөсөн Ерөнхийлөгчид баяр хүргэж УИХ-ын дарга З.Энхболд, иргэд, сонгогчдыг төлөөлж, Монгол Улсын Ерөнхий сайд асан Монгол Улсын гавьяат эдийн засагч Д.Бямбасүрэн нар үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн УИХ-д тангараг өргөх чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүд, Улсын ерөнхий прокурор зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрийн намуудын удирдлага, олон нийт, шашны болон хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөл оролцлоо.

КАНАД УЛСЫН АМБАН ЗАХИРАГЧ ЭРХЭМСЭГ НОЁН ДЭВИД ЖОНСТОНЫГ ХҮНДЭТГЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Монгол Улсад төрийн айлчлал хийсэн Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон үг хэлэхтэй холбогдуулан 2013 оны 10 дугаар 25-нд УИХ-ын Хүндэтгэлийн хуралдааныг хуралдуулав.



УИХ-ын дарга З.Энхболд Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстоныг Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан УИХ-ын Хүндэтгэлийн хуралдааныг нээж хэлсэн үгэндээ хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж түншлэлийн хүрээнд олон салбарыг хамарч тодорхой үр дүнд хүрч байгааг онцлон тэмдэглэлээ.

Хүндэтгэлийн хуралдаан дээр Канад Улсын Амбан захирагч Эрхэмсэг ноён Дэвид Жонстон үг хэлэхдээ, хоёр улс газар зүйн байршлаараа тусгаарлагдсан хэдий ч алслагдсан орон зайг даван туулах нийтлэг туршлага, чадвараараа нэгдмэл гэдгийг онцлов. Сүүлийн жилүүдэд, нэн ялангуяа байгалийн нөөц ашиглалтын салбарт төвлөрч ирсэн хоёр орны харилцаа өнөөгийн цаг үед нийтлэг сонирхол, нэгдмэл үйл ажиллагаа бүхий өргөн цар хүрээг хамран хөгжиж байгааг цохон тэмдэглэсэн юм.

Мөн тэрбээр хоёр улсын хооронд харилцан ашигтайгаар эдийн засгийн түншлэлээ өргөжүүлэн баяжуулах гайхалтай боломж байгааг дурдаад, нэн ялангуяа боловсрол, барилгын технологийн салбарууд нь ирээдүйд үр өгөөжтэй байж болохуйц түвшинд тооцогдож байна гээд “Монгол Улс өөрийн хосгүй өөрчлөлтийн замаар хөгжиж байна. Монголчууд Та бүхэн улирах хугацаа, угтах ирээдүйн бэрхшээл, боломж алинтай нь ч учирсан энэхүү нөхөрлөлөө Канад Улс хэзээд эрхэмлэн дээдлэх болно” гэлээ.

УИХ-ын дарга З.Энхболд хүндэт зочинд хандаж, халуун дотно үг хэлсэн явдалд Монгол Улсын Их Хурлын нэрийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлэв.

БНХАУ-ЫН ДАРГА СИ ЗИНЬПИНИЙГ ХҮНДЭТГЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаатай холбогдуулан зарласан УИХ-ын Хүндэтгэлийн хуралдаан 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдөр болов.

Хүндэтгэлийн хуралдааныг УИХ-ын дарга З.Энхболд нээж хэлсэн үгэндээ, Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн босгон дээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Эрхэмсэг ноён Си Зиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийж байгаа нь 1994 онд хоёр орны хооронд байгуулсан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ болон хоёр талын харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлж буй бусад баримт бичгийг амжилттай хэрэгжүүлж, цаашид хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг онцлон дурдсан юм.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Зиньпин хэлсэн үгэндээ, энэ удаагийн төрийн айлчлалын хүрээнд Монгол Улсын удирдагч нартай Хятад, Монголын харилцаа болон хамтран сонирхсон асуудлаар гүн гүнзгий санал бодлоо солилцож, өргөн хүрээнд тохиролцоонд хүрсэн. Хоёр тал Хятад, Монголын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд дэвшүүлэх хамтарсан Тунхаглал гаргаж, 20 гаруй хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурлаа. Айлчлалын үр дүнд сэтгэл ханамжтай байна. Хятад, Монголын харилцааны ирээдүйд итгэл төгс байна. Морины сайныг унаж мэддэг, хүний сайныг ханилж мэддэг. 65 жилийн өмнө Хятад, Монгол хоёр улс албан ёсоор дипломат харилцаа тогтоосон. Монгол Улс бол хамгийн эрт шинэ Хятад Улстай дипломат харилцаа тогтоосон билээ гэлээ.

БНЭУ-ЫН ЕРӨНХИЙ САЙД НАРЕНДРА МОДИГ ХҮНДЭТГЭВ

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модиг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлэхтэй холбогдуулан зарласан УИХ-ын Хүндэтгэлийн хуралдаан 2015 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Ням гарагт болов.



Хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нар байлцав.

УИХ-ын дарга З.Энхболд хүндэтгэлийн хуралдааныг нээж хэлсэн үгэндээ энэхүү айлчлалын хүрээнд Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд тогтоосон Иж бүрэн түншлэлийн харилцааны түвшинг ахиулан Стратегийн түншлэлийн харилцаа тогтоох болсонд баяртай байгаагаа илэрхийллээ.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модиг, Монголын ардчиллын 25 жилийн ой тохиож буй жилд ийнхүү Монгол Улсын Их Хуралд үг үг хэлэх боломж олдсон нь их нэр төрийн хэрэг юм. Хэдийгээр бидний хооронд орон зай, газар зүйн саад байдаг ч манай хоёр талын харилцаа улам өргөжнө. Монгол орны эрдсийн нөөц баялаг бидний түншлэлд хөдөлгөгч хүч өгнө. Газар зүйн байршил бол монголчуудын түншүүддээ сонгох эрх чөлөөнд нь хязгаарлалт болохгүй гэж бид үзэж байна. Бид хамтарч байж дижитал ертөнц дэх эдийн засгийн боломжуудыг ашиглах болон өсөн нэмэгдэж байгаа кибер аюул заналаас илүү найдвартайгаар өөрсдийгөө хамгаалж чадна гэлээ.

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модигийн энэхүү айлчлал нь Энэтхэг Улсын Засгийн газрын тэргүүний хувьд манай улсад хийж буй анхны айлчлал гэдгээрээ онцлог байв.

МОНГОЛ УЛСАД БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ БАЙГУУЛАГДСАНЫ 25 ЖИЛИЙН ОЙ

Монгол Улсад Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан УИХ-ын Хүндэтгэлийн хуралдааныг 2015 оны 09 дүгээр сарын 13-ны Ням гарагт хуралдуулав.



Ардын Их Хурлын анхдугаар хуралдаанаар Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга болон 50 гишүүнийг сонгон баталж, 1990 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Бага Хурлын гишүүд тангараг өргөснөөр Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагджээ.

Харин 1992 онд ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллага болох УИХ-д хууль тогтоох эрх мэдлийг дангаар хадгалуулснаар Монгол Улс дахь парламентат ёсны хөгжлийн төлөвшил дараагийн шатандаа орсон хэмээн үздэг. Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан явдал бол монгол төрийн тогтолцооны нэгэн шинэ үеийн түүх бөгөөд парламентын засаглал өнөөдрийг хүртэл шинэ ардчилсан Үндсэн хуулиар баталгаажин эргэлт буцалтгүй төлөвшин хөгжсөөр байна.

Монгол Улсын парламент 25 жилийнхээ түүхэн хугацаанд Анхдугаар хуралдааныг 6, ээлжит чуулганыг 47, ээлжит бус чуулганыг 12, хүндэтгэлийн хуралдааныг 22 удаа хийж, бие даасан хууль 454, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2209, гэрээ соёрхон баталсан, нэгдэн орсон тухай хууль 330, хууль хүчингүй болсон тухай хууль 145, Улсын Бага Хурлын тогтоол 167, Улсын Их Хурлын тогтоол 1779, нийт 5084 хууль, тогтоол хэлэлцэж баталсан байдаг.

Улсын Бага Хурал болон 6 удаагийн Улсын Их Хуралд давхардсан бус тоогоор 326 хүн, давхардсан тоогоор 534 хүн гишүүнээр сонгогдон ажиллажээ.

Энэхүү 25 жилийн хугацаанд парламентын гадаад харилцаа тасралтгүй өргөжиж, 40 гаруй орны парламенттай хамтран ажиллаж Монгол Улсын парламентын спикер давхардсан тоогоор 67 оронд айлчилсан бол 73 орны парламентын спикер Монгол Улсад айлчилсан байна.

Хүндэтгэлийн хуралдааныг УИХ-ын дарга З.Энхболд нээж үг хэлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Улсын Бага Хурлын дарга асан УИХ-ын дэд дарга Р.Гончигдорж нар үг хэлсэн юм.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНУУД

1. **2012 оны 8 дугаар сарын 29-ний өдөр** УИХ-ын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулав. Ээлжит бус чуулган ажлын 21 хоног үргэлжилж, нэгдсэн хуралдаан 7 удаа хуралдсан байна. Чуулганаар хоёр шинэ хууль болон хуулийн шинэчилсэн найруулга, 17 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль нэг, УИХ-ын 15 тогтоол хэлэлцэж баталжээ.

2. Улсын Их Хурлын даргын 2013 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 156 тоот захирамжийн дагуу УИХ-ын ээлжит бус чуулган **2013 оны 09 дүгээр сарын 16-27-ны өдрүүдэд** хуралдав. Тус чуулганаар Засгийн газраас өргөн барьсан Хөрөнгө оруулалтын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудыг холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын хамтаар хэлэлцэж шийдвэрлэв.

3. **2015 оны 8 дугаар сарын 3-ны өдөр** нээгдсэн УИХ-ын ээлжит бус чуулган 11 өдөр хуралдаж, 2015 оны 08 дугаар сарын 14-ний өдөр өндөрлөсөн. Ээлжит бус чуулганаар Галт зэвсгийн тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай, Өршөөл үзүүлэх тухай хуулиудыг батлав. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын өргөн мэдүүлсний дагуу Засгийн газрын зарим гишүүдийг чөлөөлөх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн юм.

4. **2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр** УИХ-ын ээлжит бус чуулган нээлтээ хийв. Тус чуулганаар Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай асуудал болон Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хэлэлцэхээр төлөвлөөд байлаа. Чуулганы хугацаанд Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай УИХ-ын тогтоолыг баталж, Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах боломж бүрдүүлснээр 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр ээлжит бус чуулганыг хаав.

5. **2016 оны 02 дугаар сарын 19-ний өдөр** УИХ-ын ээлжит бус чуулган хуралдав. Тус чуулганаар УИХ-ын 2015 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэж баталсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Барилгын тухай, Ирээдүйн өв сангийн тухай, Зөрчлийн тухай хуулийг дагалдаж гарсан хуулиуд зэрэг нийт 291 хууль болон тогтоолын эцсийн найруулгыг сонсов. Мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах талаарх Улсын дээд шүүхийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хэд хэдэн хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзээд ажлын хэсгийг байгуулсан юм. Түүнчлэн зээлийн хэлэлцээрүүдийг соёрхон баталсан юм.

ЕАБХАБ-ЫН ПАРЛАМЕНТЫН АССАМБЛЕЙН 2015 ОНЫ НАМРЫН ХУРАЛ БОЛОВ

Монгол Улсын Их Хурал Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /ЕАБХАБ/-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурлыг Улаанбаатар хотноо энэ оны 2015 оны 09 дүгээр сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулав.

“ЕАБХАБ-ын бүс нутаг болон олон улсын түвшин дэх аюулгүй байдлын сорилт бэрхшээлүүдийг хэлэлцэх нь: Бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд парламентчдын гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор болсон энэ хуралд 47 орны 300 гаруй төлөөлөгч, олон улсын 13 байгууллагаас 19 төлөөлөгч оролцлоо.

Намрын хурлын нээлтэд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Илкка Канерва, Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд нар үг хэлэв. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хурлын нээлтэд оролцож, мэндчилгээ дэвшүүлсэн юм.



Намрын хурлын хүрээнд гурван салбар хуралдаан боллоо. “Бүс нутгийн аюулгүй байдал, терроризм, хүний наймаатай тэмцэх: ЕАБХАБ-ын үүрэг оролцоо ба бүс нутгийн хамтын ажиллагаа” сэдэвт I салбар хуралдааныг ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн дэд Ерөнхийлөгч Кристин Мютонан даргалж, УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн дарга М.Батчимэг, Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагын Бүс нутгийн терроризмын эсрэг байгууллагын Гүйцэтгэх хорооны олон улсын харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Бахрам Ауанассов нар илтгэл танилцуулав.

II салбар хуралдаан “Бүс нутагт тулгараад буй эдийн засгийн сорилт бэрхшээлүүд, хүнсний аюулгүй байдал, гамшгийн эрсдэлийг бууруулах ба усны менежмент: Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах нь” сэдвийн хүрээнд болсон юм. Тус хуралдааныг ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, байгаль орчны Ерөнхий хорооны дарга Роза Акназарова даргалж, УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын

Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн гишүүн С.Оюун, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /ХХААБ/-ын Улаанбаатар дахь Орлогч суурин төлөөлөгч Кевин Галлахер нар илтгэл танилцуулсан.



III салбар хуралдаан “Ардчилсан институциуд, хүний эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, шашин шүтэх эрх чөлөө, хүйсийн эрх тэгш байдлын хөгжил” сэдвийн дор явагдаж, ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн дэд ерөнхийлөгч Алан Нэри даргалав.

Үргэлжлүүлэн ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн байнгын хорооны хуралдаан болж, ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Санхүүгийн асуудал эрхэлсэн дарга Доррис Барнетт, Ерөнхий нарийн бичгийн дарга Спенсер Оливер тайлангаа танилцуулсан. Мөн хуралдаанаар ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн хөтөлбөрүүдийн талаар хэлэлцсэн юм.

Нээлттэй хэлэлцүүлгийн дараа хурлын хаалтын ажиллагаа болж, УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн гишүүн Н.Энхболд хаалтын үгийг хүргэснээр ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн 2015 оны намрын хурал өндөрлөсөн билээ.

АЗИ, ЕВРОПЫН ПАРЛАМЕНТЫН ТҮНШЛЭЛИЙН 9 ДҮГЭЭР УУЛЗАЛТ БОЛОВ

Монгол Улсын Их Хурал Ази, Европын Дээд түвшний 11 дүгээр уулзалт (АСЕМ)-ын хүрээнд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтыг “Ази, Европын парламентын түншлэлийн АСЕМ дахь үүрэг оролцоо” ерөнхий сэдвийн хүрээнд Улаанбаатар хотноо 2016 оны 04 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулав.

Тус уулзалтад Ази, Европын 32 орны болон Европын парламентын 170 төлөөлөгч оролцлоо. Уулзалтын хүрээнд “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа”, “Ирээдүйн төлөөх түншлэл” сэдэвт салбар хуралдаанууд болж, парламентын төлөөлөгчид илтгэл танилцуулан хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцсон юм.



Уулзалтын хүрээнд хоёр салбар хуралдаан болсон юм. “Үр дүнтэй олон талт харилцаа, хамтын ажиллагаа” сэдвийн дор болсон нэгдүгээр салбар хуралдаанд оролцсон Ази-Европын парламентын төлөөлөгчид дээрх сэдвийн хүрээнд саналаа солилцож, хэлэлцсэн асуудлуудаар бүрэн ойлголцож нэгдсэн нэг шийдэлд хүрсэн байна. Хоёрдугаар салбар хуралдаан “Ирээдүйн төлөөх түншлэл” сэдвийн хүрээнд болсон бөгөөд төлөөлөгчид үндсэн долоон асуудлыг хөндөж ярилцаад шийдэлд хүрсэн талаараа танилцуулж байсан юм.

Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын Нэгдсэн хоёрдугаар хуралдааныг УИХ-ын дарга З.Энхболд даргалан явуулсан.

Ийнхүү Ази-Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын төгсгөлд АЕПТ-ийн парламентчид эрх тэгш байх, бие биеэ харилцан хүндэтгэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмын үндсэн дээр хоёр бүс хоорондын түншлэлийг бэхжүүлэх талаар АСЕМ-д дорвитой дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хүч чармайлтаа цаашид ч үргэлжлүүлэх чин хүсэлтэй байгаагаа дахин нотолсон байна.

Мөн АСЕМ-ын үйл явцын парламентын чиглэлийг бэхжүүлэх, АСЕМ болон АЕПТ-ийн хоорондын хэлхээ холбоог зузаатгах, Ази, Европын улс түмнүүдийн нийтлэг зорилго, эрх ашгийг амьдралд хэрэгжүүлэхэд Парламентуудын үүрэг ролийг нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээг авч ажиллахаа амлажээ.



Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн талаарх хөтөлбөр, эрчим хүчний аюулгүй байдлын асуудлаарх олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, байгалийн гамшгийн менежментийн чиглэлээр АСЕМ-ын гишүүн орнуудын хамтын ажиллагаа, хоёр бүсийн хооронд худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа, ард иргэдийн хэлхээ холбоог бэхжүүлэх, оюуны өмчийн эрхийн асуудлуудыг тусгасан нийт 44 зүйл бүхий Тунхаглалыг батлан гаргасан юм.

---000000---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2012-2016

III

БҮЛЭГ

- Монгол Улсын Их Хурал 4 жилд
- Байнгын хороодын үйл ажиллагаа
- Хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой тоон үзүүлэлтүүд
- Улсын Их Хурлын Тамгын газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ДӨРВӨН ЖИЛД

ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ БҮТЭЭЛЧ, ШУУРХАЙ, ШИНЭ АРГА БАРИЛААР ХАНДАЖ АЖИЛЛАСАН ОН ЖИЛҮҮД

2012-2016 оны УИХ нь өмнөх парламентуудаас нэлээд онцлогтой байв. УИХ-ын сонгуулийн шинэчилсэн хуулиар анх удаа сонгуулийн холимог хэлбэрээр явуулсан энэ удаагийн УИХ-д улс төрийн хоёр нам, нэг эвсэл хуульд заасан 8-аас дээш суудал авч парламентад өөрийн бүлэгтэй болсон билээ. Мөн өмнөх парламентуудаас хамгийн олон буюу 11 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдож ажиллав.


Энэ үндсэн дээр сонгуулийн үр дүнгээр УИХ-д хамгийн олон суудал авсан Ардчилсан нам ИЗНН, “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-тэй хамтарсан Засгийн газар байгуулах гэрээ байгуулан Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан намаас 13 сайд, “Шударга ёс” эвсэл, ИЗНН-аас таван сайд багтсан билээ. Энэ үндсэн дээр Ардчилсан намаас дэвшүүлсэн “Монгол хүн” хөтөлбөрт үндэслэн Иргэний зориг, ногоон намын “Амьдрал” хөтөлбөр, “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн “Монголоо аврах таван хувьсгал” хөтөлбөрүүд, УИХ-д бие даан сонгогдсон гишүүдийн зарим тодорхой саналуудыг тусгаж боловсруулсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг УИХ-ын анхдугаар чуулганаар хэлэлцэн баталсан.

Ерөнхий сайд Н.Алтанхуягийн удирдсан Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдаад 819 өдөр ажилласан бөгөөд УИХ-ын нэр бүхий 28 гишүүн Засгийн газрыг огцруулах тогтоолын төслийг өргөн мэдүүлснийг чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэнээр түүний танхим халаагаа өгсөн билээ.



Ингээд Монгол Улсын 28 дахь Ерөнхий сайдаар Ч.Сайханбилэгийг томилсон 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр шинэ Ерөнхий сайд Шийдлийн Засгийн

газар байгуулна гэдгээ УИХ-ын чуулганы индэр дээрээс мэдэгдээд Засгийн газрын тэргүүлэх, гол чиглэл нь эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг хэмээн онцолсон. Шийдлийн Засгийн газрын бүрэлдэхүүнд УИХ-д суудалтай МАН, “МАХН-МУАН-ын Шударга ёс эвсэл”-ээс сайдууд томилогдсон ч 2015 оны 8 дугаар сард танхимын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, МАН-ын сайдууд албаа өгсөн юм.



Гүйцэтгэх засаглалын тэргүүн солигдож, сайд нар өөрчлөгдсөн хэдий ч улс төрийн тогтвортой байдлыг хадгалж, улс орны хөгжлийн төлөө бүтээлч, шуурхай, шинэ арга барилгаар хандаж ажиллахын төлөө УИХ үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирсэн билээ.

2012-2016 оны УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд бие даасан 135 хууль баталж, 953 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, УИХ-ын 370 тогтоол, олон улсын 55 гэрээ, конвенцийг соёрхон баталжээ. Тухайлбал, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийг баталж, монгол хүн эрүүл саруул амьдрах орчинтой, найдвартай ажлын байр, орлогын эх үүсвэртэй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын хүртээмжтэй, чанартай тогтолцоотой, чинээлэг хангалуун амьдрах ёстой гэсэн зарчмыг тодорхойлов. Уг баримт бичгийг Засгийн газар, төрийн бүх шатны байгууллага, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, иргэд, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар хэрэгжүүлснээр Монгол Улс жигд, тогтвортой хөгжих, хүртээмжтэй өсөлтийг хангах нөхцөл бүрдэх учиртай юм.

Улс төрийн тогтвортой байдлыг хангах үүднээс УИХ-аас 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэж, Сонгуулийн тухай хуулийг баталсан нь улс төрийн чухал шийдвэр болсон билээ. Сонгуулийн тухай хуулиар иргэдийн хурууны хээг таниулах замаар сонгуульд оролцож саналаа өгөх боломжийг бүрдүүлж, сонгуулийн зардлын хэмжээг төрийн аудитын дээд байгууллага тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, хүн амын тоог харгалзан тогтоохоор болсны зэрэгцээ сонгуулийн мөнгөн хандивын дээд хэмжээг иргэн, хуулийн этгээд тус бүрээр хуульчилсан юм.

ШИНЭЧЛЭЛ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ОН ЖИЛҮҮД

“Монгол Улсын хувьд ирэх дөрвөн жил их өөрчлөлт, шинэчлэл, их бүтээн байгуулалтын он жилүүд байх болно. Энэ удаагийн УИХ-аас улс орон, ард түмний өмнө тулгарч буй тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй шуурхай шийдвэрлэх, гаргасан шийдвэрээ иргэддээ нээлттэй байлгаж хэрэгжүүлэх торгон мэдрэмжийг барьж ажиллахыг шаардсан түүхэн үүрэг ногдож байна” хэмээн УИХ-ын дарга З.Энхболд 2012 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан УИХ-ын Анхдугаар чуулганы үеэр хэлж байв. Үнэхээр 2012-2016 он шинэчлэл, бүтээн байгуулалтын он жилүүд байлаа.

УИХ эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт, экспортыг дэмжих хүрээнд 5 тэрбум хүртэлх ам. долларын “Чингис” бонд, малчид, үйлдвэрлэгчдийг урамшуулахад 140,4 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 жилийн хугацаатай үнэт цаас гаргаж, арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсөн нь 2012 он байв.

2013 оны намрын чуулганаар УИХ 2014 оны төсвийг хэлэлцэх явцдаа “авилгажсан” гэх тодотгол бүхий 139,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 243 төсөл, арга хэмжээний 2014 онд санхүүжүүлэх 106,3 тэрбум төгрөгийн төсвийг царцааж, шалтгааныг тогтоолгохоор Үндэсний аудитын газарт шилжүүлэн шалгуулж байлаа.



Харин 2015 оны төсвийг хэлэлцэхдээ УИХ анх удаагаа олон жил алдагдалтай явж ирсэн, өөрсдийгөө хуурсан төсвөөс татгалзаж, төсвийн сахилга бат тогтоосон төсвийг баталсан юм. Энэ төсвөөр эдийн засгийн бодит байдалд нийцсэн, үр ашигтай байх зарчмыг баримталж, олон жил дамжин үргэлжилж байгаа хуучин

объектуудаа дуусгах хариуцлага хүлээсэн шийдвэр гаргаснаараа онцлог байв. Үүний дараа УИХ богино болон дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, ажлын байрыг хадгалах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх үүднээс Эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний хөтөлбөр баталсан юм.

Сүүлийн 25 жил баялаг бүтээгчдэд тулгарч байсан зээлийн хүүгийн дарамтыг 2012 оноос хойш үе шаттай хөнгөлж ирсэн нь их өөрчлөлтийн хүрээнд хийсэн томоохон ажлуудын нэг байлаа. Орон сууцны зээлийн хүү 15-20 хувь байсныг 8 хувь болгож бууруулснаар 80 шахам мянган өрх шинэ байранд оржээ. “Чингис” бондын эх үүсвэрээр 6-8 хувийн хүүтэй үйлдвэрлэл эрхлэгчийн зээлийг шинээр бий болгож, сар шинийн баярын өмнө малчны зээлийн хүүг ч бууруулсан. 2016 оны 2 дугаар сард малчны зээлийн хүү жилийн 18 хувь, сарын 1,5 хувь болж буурсан юм. Харин түүнээс хойш сар гаруйн дараа дээрх зээлийн хүү жилийн 10 хувь, сарын 0.8 хувь болж буурав. Малчид Засгийн газраас хэрэгжүүлж буй дунд хугацааны “Сайн малчин” хөтөлбөрийн шалгуурыг хангаснаар Төрийн банк, ХААН банкнаас сарын 0.8 хувийн хүүтэйгээр малчны зээл авах боломж бүрдэв. Мөн өнгөрсөн хугацаанд орон сууцны зээлийн хүү 8 хувиас 5 хувь руу шилжээд байгаа бөгөөд эхний ээлжинд хотоос алслагдсан 3 дүүрэг, гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдсан цэгүүд, 21 аймагт баригдсан орон сууц худалдан авсан хүмүүс 5 хувийн ипотекийн зээл авах боломж бүрдлээ.

Хөрөнгө оруулагчийг гадаад, дотоодын гэж ялгаварлахгүйгээр нийтлэг эрх зүйн зохицуулалт, хамгаалалт, баталгааг бий болгох, хөрөнгө, орлогоо гадаадад саадгүй гуйвуулах, хөрөнгө оруулагчийн оюуны өмчийг хуульд заасны дагуу хамгаалахаар хуульчилсан Хөрөнгө оруулалтын тухай хууль батлан гаргаж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэв. Түүнчлэн УИХ үндэсний үйлдвэр стандартын шаардлага хангасан бараагаар дотоодын хэрэгцээг хангах боломжтой тохиолдолд гадаадын бараа нийлүүлэгчийг тендерт шалгаруулахыг хориглох, эх орондоо үйлдвэрлэж байгаа 370 орчим нэр төрлийн импортын бараанд ногдуулж байсан 5 хувийн гаалийн албан татварыг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх, түүхий болон анхан шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнийг гадаадад гаргахад нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг болгох өөрчлөлтийг холбогдох хуулиудад хийж, дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг батлах, гаалийн албан татварын хувь хэмжээг барааны онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олгов. Ингэснээр түүхий болон өртөг бага шингэсэн бүтээгдэхүүнийг гадагшаа гаргах урсгалыг хязгаарлаж, дотоодын үйлдвэрлэгчид, иргэдээ дэмжих нөхцөл бүрдсэн билээ.

Түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын 10 саяын босгыг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлж, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч иргэнд худалдан авалтдаа төлсөн НӨАТ-ын 2 хүртэл хувийг буцаан олгохоор болсон. Мөн “Чингис”, “Самурай” бондын санхүүжилтээр хийгдсэн авто зам, төмөр зам, үйлдвэрлэл, уул уурхай, цахилгаан станц, агаарын тээвэр, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт бодит үр дүнтэй байгаа билээ.

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛЖ, АЖИЛГҮЙДЭЛ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭВ

Энэ удаагийн УИХ хүн амаа өсгөх бодлогыг тууштай дэмжиж, настан буурлуудаа тэтгэн дээдлэх төрийн бодлогыг тодорхойлж, хүн ардынхаа эрүүл мэнд, боловсролд анхаарахад бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав. Энэ хугацаанд тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоог сайжруулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж үйлчилгээг сайжруулах чиглээр 20 гаруй хууль, тогтоолыг батлан гаргасан байна.

Шинэ УИХ-ын иргэд рүү чиглэсэн эхний хууль нь Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль байв. Уг хуулиар 1990-1995 оны хооронд ажил, хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан, 1995-2000 оны хооронд нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй буюу төлөх боломжгүй байсан иргэдийн сард нөхөн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоож өгсөн. Ингэснээр олон жилийн туршид тэтгэврээ бодит байдлаас доогуур тогтоолгон хохирч байсан ахмадуудад олгох тэтгэврийг нь шударгаар тогтоох эрх зүйн боломж бүрдсэн билээ.



Засгийн газраас танилцуулсан хавтгайрсан нийгмийн халамжийн тогтолцоог өөрчлөх, үр ашиггүй зардлыг бууруулах, богино хугацаанд тэвчиж болох зардлуудыг хэмнэх бодлогыг УИХ нухацтай хэлэлцэж, Монгол Улсын нэгдсэн төсвийн зарим орлогыг нэмэгдүүлэх замаар цалин, тэтгэврийг тодорхой хувиар нэмэгдүүлж, хүүхэд, одонтой эхчүүдийн мөнгийг хэвээр үлдээхээр шийдвэрлэж байлаа. “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоол баталж, тэтгэврийн тогтолцоог шинэчлэн олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, ахмад настанд зохистой хэмжээний тэтгэврийг үрт хугацаанд тогтвортой олгох нөхцөлийг бүрдүүлэв.

Мөн тогтвортой гэр бүлийн тоог нэмэгдүүлэх, гэр бүлийн үнэ цэнэ, бат бөх байдлыг баталгаажуулж, ахмад настныг сэтгэл зүйн болон эдийн засгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Хамтын тэтгэврийн тухай хуулийг баталсан. Олон жил хамт амьдарсан гэр бүлийн гишүүд /эхнэр, нөхөр/-ийн аль нэг нь нас барсан тохиолдолд үлдэж байгаа гэр бүлийн гишүүн нь нас барсан гишүүнийхээ авч байсан тэтгэврийн тодорхой хувийг үргэлжлүүлэн авахаар хуульчилсан нь тэтгэврийн тогтолцоонд нээгдсэн цоо шинэ хуудас байлаа. Түүгээр ч зогсохгүй Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, малчны мал аж ахуй эрхэлсэн, өөрөөр хэлбэл мал маллаж байсан нэг жилийг 1 жил 2 сар иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тухайн иргэнд өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохоор тогтоосон юм.

Бага насны хүүхдийн эсэн мэнд амьдрах, хүүхдийн эрхийг баталгаажуулах, төрөөс үзүүлж буй нийгмийн үйлчилгээг хүүхэд бүрт тэгш, хүртээмжтэй хүргэх, бага насны хүүхэдтэй өрх, гэр бүлийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн хүүхэд харах үйлчилгээний шинэ хэлбэрийг Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар баталгаажуулав. Ингэснээр цэцэрлэгт хамрагдаж чадаагүй бага насны хүүхдүүд хүүхэд харах үйлчилгээнд хамрагдан, тэрхүү үйлчилгээний тодорхой зардлыг төр хариуцахаар болж байгаа билээ.

Энэ удаагийн УИХ Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг баталснаар хүүхэд хамгааллын зарчим, төрийн чиг үүргийг тодорхойлов. Уг хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бий болгох, нийгэм, гэр бүлийн хүрээнд хүүхдийг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон бүхий л харилцааг зохицуулсан нь эрх зүйн зохицуулалтын хувьд томоохон шинэчлэл байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө өөртөө итгэх, өөрийн бодит боломжид тулгуурлан хөдөлмөр эрхлэх, өөрийн онцлог хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар баталгаажуулж өгөв.

Мөн малчин өрхийн хувьд зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй тохиолдолд эцэг, эхийн хүсэлтийг үндэслэж Сургуулийн зөвлөл шийдвэрлэхээр тусгасан эрх зүйн зохицуулалт бий болгосон нь нүдээ олсон шийдвэр гэж хөдөө орон нутагт амьдардаг иргэд талархан хүлээж авсан юм. Түүнчлэн эрүүл мэндийн даатгал, соёлын салбар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотойгоор олон хууль тогтоомж батлан гаргасан нь нийгмийн сайн сайхны тусны тулд авч хэрэгжүүлсэн чухал шийдвэрүүд байлаа.

ШИНЭ ҮНДСЭН ХУУЛИЙН ДАРАА ОРОХУЙЦ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙЛЭЭ

Энэ удаагийн УИХ эрх зүйн салбарт 1992 оны шинэ Үндсэн хуулийн дараа орохуйц томоохон шинэчлэлийг хийснээрээ онцлог юм.

2013 оны хаврын чуулганаар УИХ Цагдаагийн болон Тахарын албаны тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль зэрэг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт шинэчлэлт хийсэн багц хуулиудыг баталсан билээ. Хуулийн шинэ зохицуулалтаа цагдаагийн байгууллага олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэддээ үзүүлэх шинэ үүргийг гүйцэтгэхээр болж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн туслалцаа, хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулж ажиллах үүрэг хүлээхээр болов. Түүнчлэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хуулиар хамгаалах цоо шинэ зохицуулалтыг бий болгов.



Шүүх, шүүгчийн аюулгүй байдал, яллагдагч, ялтныг хамгаалах үүргийг хууль сахиулах бусад байгууллагын үүргээс салгаж, бие даасан хэлбэрээр зохион байгуулахаар болж, энэ үүргийг Тахарын алба хариуцаж байхаар хуульчлан баталсан нь бас нэг дэвшил болсон юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг улс орны эрх ашиг, нийгмийн хүсэлт, шаардлагад нийцүүлэн эрх зүйн хүрээнд шийдвэрлэхийн тулд УИХ-аас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн баталж, иргэдийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон шинэ зохицуулалтыг тусгаж өгөв.

Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг баталсан нь энэ өнгөрсөн 25 жилийн хугацаанд батлан гаргасан 5 дахь өршөөл үзүүлэх тухай хууль байв. Энэ хуулиар онц аюултай гэмт хэрэгтэн, онц хүнд болон хүнд, албан тушаалын зэрэг 33 гэмт хэргээс бусад гэмт хэрэг үйлдсэн хүмүүст өршөөл үзүүлснээр хорих газраас 1.253 ялтан суллагдаж, 338 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Өршөөлийн хуульд нийтдээ 4.340 хүн хамрагдсан байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа нийгмийн хэрэгцээ, шаардлага, хүмүүсийн амьжиргаанд гарч буй нийтлэг өөрчлөлтүүдийг даган гэмт хэргийн нөхцөл байдал өөрчлөгдсөөр ирсэн. Үүнтэй холбоотойгоор эрх зүйн салбарын суурь хуулиудыг шинэчлэх шаардлага ч бий болоод байв. УИХ энэ шаардлагад нийцүүлэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хуулиудыг батлан гаргав.

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа хорих ял биечлэн эдлэх явдлыг багасгах чиглэлд анхаарч гэрийн хорионд байлгах ял, тэнсэх, албадлагын арга хэмжээ, гэм буруугаа хүлээсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлага, өсвөр насны хүнд оногдуулах ял гэсэн шинэлэг зохицуулалтыг оруулав. Харин Зөрчлийн тухай хуулиар захиргааны зөрчил гаргагсад салбарын 210 гаруй хуульд зааснаар хариуцлага хүлээлгэж байсныг халсан юм. Өөрөөр хэлбэл, захиргааны зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг бие даасан хуулиар зохицуулахаар боллоо.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тогтолцоо, зохион байгуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх хэмжээ, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталснаар гэр бүлийн хүчирхийлэл анх удаа гэмт хэрэгт тооцогдох болов. Өмнө нь хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулдаг хэрнээ энэ төрлийн хэрэг нь зөрчил ч биш, гэмт хэрэг ч биш, иргэний маргаанд тооцогддог байсан нь ийнхүү өөрчлөгдлөө.

Ийнхүү 2012-2016 оны УИХ хууль тогтоох эрх мэдлийнхээ хүрээнд улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралын бүхий л хүрээг хамарсан эрх зүйн томоохон шинэтгэл хийсэн амжилттайгаар бүрэн эрхийн хугацаагаа өндөрлөж байна.

БАЙНГЫН ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО:



Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь эрхлэх асуудлын хүрээнд Хилийн боомтын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай, Тагнуулын байгууллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг батлах тухай, Монгол Улс гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай, Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох тухай, Элчин сайдын яам, Консулын газар гадаадын зарим улсад нээн ажиллуулах тухай, Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай, Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Японы Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ил тод байдлын гэрээ, Нууц протоколыг ил болгох тухай Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын гэрээг соёрхон батлах тухай зэрэг хууль, тогтоол, олон улсын гэрээ, конвенцийг хэлэлцэн санал, дүгнэлт, саналын томъёолол гаргаж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулсан нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох өргөн цар хүрээтэй ажлын нэг хэсэг юм.

- Гадаад худалдааг хөнгөвчлөх, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгох зорилтын хүрээнд хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулах, хилийн боомтод хийж буй хяналт шалгалтын ажлын үр нөлөөг дээшлүүлж, давхардлыг арилгах, дэд бүтцийг хөгжүүлэх, авто зам, төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах, хүчин чадлыг өргөтгөх ажлыг төрийн бодлого, хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэйгээр ажиллах боломжийг бүрдүүлэх зохицуулалт бүхий Хилийн боомтын тухай хууль батлагдсан.

- Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээрийн гол зорилго нь худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр мөрдөж буй болон батлан гаргах гэж буй хууль тогтоомжийн талаар хоёр тал урьдчилан мэдээлэл солилцож байх, бизнесийн орчны ил тод байдлыг хангахад чиглэж байна. Худалдаа, хөрөнгө

оруулалт, засаглалын ил тод байдлыг хангах талаар АНУ-ын тэргүүн туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх нь АНУ-ын төдийгүй дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хөрөнгө оруулагч нарын Монгол уруу чиглэсэн бодит сонирхлыг бий болгох, татах, дотоодын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд мэдээлэл түгээх бололцоог бүрдүүлэхийн зэрэгцээ дотоодын бизнесийн орчны ил тод байдлыг хангах улс төрийн чухал ач холбогдолтойгоороо онцлог юм.

- Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр нь хоёр орны худалдаа, Японы хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингэсэн экспорт, валютын орлогыг тус тус нэмэгдүүлэх, Японы өндөр техник технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, Японы тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах, худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулахад чиглэсэн.

-Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйн хэм хэмжээний цогц байдлыг бүрдүүлж, Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны чиглэл, зэвсэгт хүчний байгуулалтын зарчим, үндсийг тодорхойлж өгсөн.



БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО:




УИХ-ын чуулганы бүрэн эрхийн хугацаанд тус Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд төсөл санаачлагчдын өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийг хийж УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулан түүний биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.

Байгаль орчны салбарын чиглэлээр: Байгалийн нөөцийн хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх, экосистемийн үйлчилгээний тогтвортой, хэмнэлттэй, хаягдал болон хүлэмжийн хийн ялгарал багатай технологи, үйлдвэрлэл, хэрэглээг дэмжин өргөжүүлэх, байгаль орчинд халтай үйлдвэрлэл үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний хэрэглээ, импортыг багасгахад чиглэсэн ногоон татварын бодлого бий болгох замаар хөгжлийн шинэ загварт хүрэх үзэл баримтлал бүхий 2015-2030 хүртэл тодорхой зорилт, үе шаттай хэрэгжих “Ногоон хөгжлийн бодлого”, “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” батлах тухай УИХ-ын тогтоол, Сэлэнгэ аймгийн Мандал, Борнуур сумын нутагт орших Ноён уул орчмын зарим газар нутгийг байгалийн нөөц болон дурсгалт газрын ангиллаар, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост Тосонбумбын нурууны зарим хэсгийг байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авах тухай УИХ-ын тогтоол 15 хууль.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэлийн салбарыг 2015-2025 хүртэлх хугацаанд хөгжүүлэх чиглэл, стратеги зорилтыг тодорхойлсон Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын тогтоол, салбарын суурь хуулиуд болох Хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон шинээр Малын индексжүүлсэн даатгалын тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай, Органик хүнсний тухай болон салбарын 14 нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон хүчингүй болгох тухай хуулиудыг батлуулсан нь хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн орчныг сайжруулах бодлогын чанартай томоохон шийдвэр болсон юм.

УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Байнгын хороо хуулийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын чиглэлээр яам агентлаг, харьяа байгууллагуудын

тайлан, илтгэл мэдээлэл, хурал зөвлөгөөн, уулзалт, семинар, нээлттэй хэлэлцүүлэг, сонголыг тухай бүр зохион байгуулсан байна. Энэ хүрээнд НҮБ-ын хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран “Хүнсний шим тэжээллэг чанар, аюулгүй байдал”, “Хүнсний сав, баглаа боодлын аюулгүй байдал, тулгамдаж буй асуудал, хүний эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөлөл, шийдвэрлэх арга зам” болон “Төрөөс ойн талаар баримтлах бодлого салбарын хуулиудын төсөлтэй холбогдуулан 4 удаагийн хэлэлцүүлэг, Монголын байгаль орчны төрийн бус байгууллагуудын улсын III, IV зөвлөгөөн, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хэрэгжилт” сэдэвт уулзалт-хэлэлцүүлгийг тус тус хийсэн байна.



НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРОО:



Байнгын хорооноос 2012-2016 онуудад тэтгэвэр, тэтгэмжийн тогтолцоог сайжруулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 20 гаруй хууль тогтоолыг батлуулсан байна.

Тус Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, мөн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, УИХ, тус Байнгын хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцаж, дүгнэлт гаргах чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллав.

2012-2016 оны УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд:

- Хүн амын хөгжил, нийгмийн халамж, хамгааллын бодлогын хүрээнд Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд нэмэлт, оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Хамтын тэтгэврийн тухай, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай зэрэг нийгэмд хүлээлт үүсгээд байсан асуудлуудыг зохицуулсан хуулиуд, “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолыг батлуулав. Мөн Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлуулсан нь чухал ач холбогдолтой эрх зүйн зохицуулалт болсон юм.

- Эрүүл мэндийн бодлогын хүрээнд Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүл ахуйн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Монголын Улаан Загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиуд, Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай төрийн бодлогын баримт бичгийг хэлэлцүүлж батлуулав.

- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгааллын бодлогын хүрээнд Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, Ашигт малтмалын тухай, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоол батлагдав.

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, соёлын өв, монгол хэлний бодлогын хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Номын сангийн тухай, Монгол хэлний тухай хуулиуд, мөн Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд тус тус нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг хэлэлцүүлж батлуулав. Түүнчлэн “Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоол батлуулав.



ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРОО



УИХ-ын зургаа дахь сонгуулиар байгуулагдсан УИХ-ын анхдугаар чуулганаар хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор Өргөдлийн байнгын хороо 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2012 онд анх байгуулагдаж, тус Байнгын хорооны үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан Байнгын хорооны дүрмийг баталж, дүрмийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.


УИХ-ын 2012-2016 оны чуулганы хугацаанд тус Байнгын хороо 66,7 хувийн ирцтэйгээр нийт 30 удаа хуралдаж, 76 асуудлыг хэлэлцэж, 8 удаа салбарын сайдын мэдээлэл сонсчээ. Байнгын хорооны хуралдаанаас 30 тогтоол баталж, 11 хуралдааны тэмдэглэл гаргасан байна.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 94040 иргэний 11575 өргөдлийг /нийслэлийн иргэдээс 7393 буюу 63,9 хувь, хөдөө орон нутгийн иргэдээс 4182 буюу 36,1/ хүлээн авч, хариу өгөн шийдвэрлэсэн байна. Үүнээс 1169 буюу 10,5 хувь нь нийтийн эрх ашгийг төлөөлсөн, 9975 буюу 89,5 хувь нь хувийн асуудлаар хандсан өргөдөл байна. Өргөдлийг судлах хүрээнд 6 ажлын хэсэг байгуулагдаж, асуудалтай газар дээр очиж танилцах, иргэдтэй уулзах 51, албан тушаалтнаас тайлбар авах ажил 10, цахим хурал 2 удаа хийж, 16 хэлэлцүүлэг, 2 нээлттэй сонголт зохион байгуулсан.

Байнгын хороо иргэдийн өргөдлийн дагуу байгаль орчин, соёлын өвийг хамгаалах, газрыг тусгай хамгаалалтад авах, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, нийгмийн халамж, хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох, зээлийн хүүг бууруулах, хувьцаа эзэмшигч иргэдийн эрх ашгийг хамгаалах, төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, орон сууцжуулах, гэр хорооллыг дахин төлөвлөх, баг, хороодын эрх зүйн орчныг сайжруулах зэрэг бүхий л салбарыг хамарсан тулгамдсан асуудлуудыг судлан хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр Засгийн газарт чиглэл өгөх, эрх бүхий байгууллагуудад санал хүргүүлэх 30 орчим тогтоол, тэмдэглэл гаргаж шийдвэрлэсэн байна.

Тус Байнгын хороо байгуулагдсанаар хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдэж, улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлаар хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд

иргэдийн өргөдлийг хүлээн авч хэлэлцсэн бөгөөд цаашид хуулийн зөрчил, хийдлийг арилгах, амьдрал дээр хэрэгжихгүй байгаа хуулийн хэрэгжилтийг хянан илрүүлж, хэрэгжилтийг хангуулах, боловсронгуй болгох чиглэлээр иргэдийн оролцоог бодитоор хангаж ажиллах бүрэн боломжтой болохыг энэ хугацаанд харуулсан байна.



Цахим хуудсаар дамжуулан цахим өргөдөл хүлээн авч шийдвэрлэн хариуг нь шуурхай мэдээлэх шинэ системийг амжилттай нэвтрүүлж ажиллажээ.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО



Тус байнгын хороо УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Засгийн газраас “Ажилтай, орлоготой монгол хүн”, “Эрүүл чийрэг монгол хүн”, “Эрдэм боловсролтой монгол хүн”, “Аюулгүй орчинтой монгол хүн”, “Эрх чөлөөтэй монгол хүн” гэсэн таван бүлэг, 319 зорилт, зорилго бүхий Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиуд, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” УИХ-ын тогтоол, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбоотойгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг товлон зарлах; Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах; Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх; Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай хууль тогтоомжуудыг хэлэлцүүлж батлуулжээ.


Мөн Монгол хэлний тухай, Хууль тогтоомжийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Сонгуулийн тухай, Нийтийн сонсголын тухай зэрэг бие даасан томоохон хуулиудыг хэлэлцүүлж батлуулсан байна.

- 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэж, Сонгуулийн тухай хуулийг баталсан.

- Түүнчлэн Ард нийтийн санал асуулгын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай УИХ-ын тогтоолыг батлуулжээ. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний зарчим, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний, салбарын болон аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх харилцааг зохицуулах зорилготой Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг УИХ баталсан бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаар

батлахаар тусгасан. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг 2016-2020, 2021-2025, 2026-2030 он гэсэн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх 4 үндсэн заалтын хүрээнд 45 зорилт, 20 үндсэн үзүүлэлтийг тодорхойлон дэвшүүлсэн.

- УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар дүгнэлтийг хүлээн авсантай холбогдуулан Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох тогтоолын төслүүдийг хэлэлцэж батлав.



ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО:



Төсвийн байнгын хороо энэ удаагийн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд төрийн санхүүгийн бодлогыг боловсронгуй болгох, улсын төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг оновчтой болгох, ил тод байлгах, төсөв санхүүгийн сахилга батыг бүх шатанд чангатган төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улс, гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх чиглэлээр хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулахад түлхүү анхаарч, энэ чиглэлээр олон хуулийн төслийг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ирсэн байна.

- Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлого, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын 2012, 2013, 2014, 2015, 2016 оны Төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013-2016 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2013-2016 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2013-2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2014-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулиуд болон Монгол Улсын 2012, 2013, 2014 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолуудыг батлуулсан байна.

- Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод нээлттэй, ойлгомжтой байх шилэн дансны тогтолцоог бүрдүүлж, мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, иргэдэд ойлгомжтой, шуурхай мэдээлэх замаар байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд цаг тухайд нь олон нийтийн хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар Шилэн дансны тухай хуулийг батлуулав.

- Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ, өрийн зохимжит түвшинг тогтоох, өрийн дарамт болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг

алдагдуулахгүйгээр хэрэгцээтэй санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлдэг байх шаардлагатай байгаа тул өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар өр үүсгэх, дамжуулан зээлдүүлэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор батлуулсан Өрийн удирдлагын тухай хууль хэрэгжиж байна.

- Эдийн засгийн ил тод байдлыг бий болгож бүх шатны бүртгэл, хяналт, мэдээллийн тогтолцоог улам бүр боловсронгуй болгох, эдийн засгийг бүрэн хэмжээгээр нь тодорхойлж чадахуйц тоон мэдээлэлтэй байх хүрээнд илрээгүй байсан хөрөнгө, орлогыг ил гаргаж, тэдгээрийг хууль ёсны бүртгэлд оруулж, цаашид хууль тогтоомжийн дагуу татвар ногдох боломжтой болгож, татварын суурь баазыг тэлэх зорилгоор Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг батлуулсан байна.

- Монгол Улс олон улсын жишигт нийцсэн татварын тогтолцоог бий болгох, татварын тэгш шударга байх зарчмыг нийгэмд төлөвшүүлэх, татвар ногдох аливаа ажил, гүйлгээг бүртгэлжүүлэх зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэн найруулж батлуулав.



ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО:



Хууль зүйн байнгын хороо эрх зүйн салбарт 1992 оны шинэ Үндсэн хуулийн дараа орохуйц томоохон шинэчлэлийг хийсэн хуулиудыг батлуулсан билээ.

- Шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх, хуяглан харгалзах, оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах чиг үүрэг бүхий Монгол Улсын Тахарын албаны тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Тахарын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Тахарын албаны тухай хуулийг, гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулжээ.

- Мөн энэ өдөр хууль сахиулж, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүрэгтэй Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэн батлуулж, нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор Захиргааны ерөнхий хуулийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцүүлэн батлуулжээ.

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг шинэчлэн батлуулснаар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, замын хөдөлгөөний дүрэм зөрчигчдөд хүлээлгэн хариуцлагыг нэмэгдүүлсэн бөгөөд Анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийг батлуулж хорих газраас 1.253 ялтныг суллуулж, 338 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ. Өршөөлийн хуульд нийтдээ 4.340 хүн хамрагдсан юм.

Хууль зүйн байнгын хороо эрх зүйн салбарын суурь хуулиудыг шинэчлэх гол ажлыг нугалсан бөгөөд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хуулиудыг хэлэлцүүлж батлуулсан юм.

- Шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгасан бол Зөрчлийн тухай хуульд хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зохицуулалтуудыг тусгасан байна.

- Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгаас гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцүүлэн батлуулав. Уг хуулиар гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон юм.



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО:



Зургаа дахь удаагийн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд тус байнгын хороо улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, макро эдийн засгийн болон эдийн засгийн бодит салбаруудын бодлого чиглэлийг тодорхойлох, банк-санхүү, хөрөнгө-үнэт цаасны зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, өсөлтийг дэмжих, дэд бүтэц, үйлдвэрлэл, бизнесийн хөгжлийг түргэтгэх чиглэлээр нийт 130 гаруй хууль, 70 гаруй тогтоолыг хэлэлцүүлэн батлуулжээ.

- Бүрэн эрхийн хугацаанд жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төрийн мөнгөний бодлогоос гадна аж үйлдвэр, эрдэс баялаг, эрчим хүч, иргэний нисэхийн салбарын талаарх төрийн бодлогыг тодорхойлж, 2030 он хүртэлх Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг батлан гаргажээ.

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, уг хуульд нийцүүлэн боловсруулж баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” нь Монгол Улсын хөгжлийг шинэ шатанд хүргэх түүхэн ач холбогдол бүхий төрийн бодлогын баримт бичгүүд болов.

- Түүнчлэн байнгын хороо гадаадын хөрөнгө оруулалтад таатай нөхцөл бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, банк-санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, хөрөнгө-үнэт цаасны зах зээлийн хөгжлийг түргэтгэх чиглэлээр Хөрөнгө оруулалтын тухай, Банкын дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиудыг шинээр батлан гаргаж, Үнэт цаасны тухай болон Чөлөөт бүсийн тухай хуулиудыг шинэчлэн батлуулсан байна.

- Эдийн засгийн хурдтай өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацаанд дотоод, гадаадын бондын зах зээлд 5 тэрбум хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг үе шаттай арилжаалж, хөрөнгө босгох шийдвэрийг гаргасан нь эдийн засгийн хүндрэлийг бэрхшээл багатай даван туулж, өсөлтийг хадгалахад чухал түлхэц болсон билээ.

- Байнгын хорооноос шинээр батлуулсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль нь эдийн засаг дахь дотоодын хуримтлал, хадгаламжийг хөрөнгө оруулалтын сангууд байгуулах замаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт элбэрээр ашиглах боломжийг нээж өгөв.

- Аж үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлж, Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих тухай тогтоол, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг шинээр боловсруулж баталсан нь эдийн засгийг олон салбар, чиглэлээр төрөлжүүлж, уул уурхайн салбараас хэт хараат байхаас ангижруулахад чиглэгдлээ.

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг тус тус шинээр баталж, Газрын тосны тухай хуулийг шинэчлэн найруулж, ашигт малтмалын зарим томоохон ордуудыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулж, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, Ашигт малтмалын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах талаар холбогдох хууль, тогтоолуудыг гаргалаа.

- Дэд бүтцийн хөгжлийг түргэтгэх чиглэлээр Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлж, Эрчим хүч хэмнэлтийн тухай, Хот сууринг дахин хөгжүүлэх тухай хуулиудыг шинээр боловсруулан баталж, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, Барилгын тухай хуулийг шинэчлэн найруулж батлуулсан байна.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



(ТООН ХЭЛЭЭР)

/2012-2016 он/

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ҮРГЭЛЖИЛСЭН ХУГАЦАА:





ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ТОО:



Улсын Их Хурлын Тамгын газрын
Хуралдаан зохион байгуулах хэлтэс

УЛСЫН ИХ ХУРЛААР БАТАЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ

/2012-2016 он/



Улсын Их Хурлын Тамгын газрын
Хууль зүйн үйлчилгээний хэлтэс

БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ /2016.06.01/

№	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	Өргөдлийн байнгын хороо	Төрийн байгуулалтын байнгын хороо	Төсвийн байнгын хороо	Хууль зүйн байнгын хороо	Эдийн засгийн байнгын хороо
1	М.Сономпил	Л.Эрдэнэчимэг	Д.Батцогт	Ж.Батзандан	А.Бакей	Ч.Улаан	Д.Ганбат	Ц.Баярсайхан
2	Р.Амержаргал	Д.Арвин	Д.Арвин	Д.Арвин	Н.Алтанхуяг	А.Амаржаргал	О.Баасанхүү	Н.Батбаяр
3	Х.Баттулга	О.Баасанхүү	А.Бакей	О.Баасанхүү	Н.Батбаяр	Н.Батбаяр	Ж.Батзандан	Н.Батцэрэг
4	С.Батболд	С.Батболд	З.Баянсалэнгэ	Ж.Батсуурь	Сү.Батболд	Б.Болор	Б.Бат-Эрдэнэ	Ж.Батсуурь
5	М.Батчимэг	Ж.Батзандан	Г.Баярсайхан	М.Батчимэг	Сү.Батболд	Д.Батцогт	З.Баянсалэнгэ	Д.Бат-Эрдэнэ
6	Д.Бат-Эрдэнэ	Х.Баттулга	Л.Гантөмөр	Р.Бурмаа	М.Батчимэг	Д.Ганхуяг	Л.Болд	Х.Болорчулуун
7	Ц.Баярсайхан	Б.Бат-Эрдэнэ	С.Дэмбэрэл	С.Бямбацогт	Г.Батхүү	Ц.Даваасүрэн	Р.Гончигдорж	С.Бямбацогт
8	Г.Батхүү	Г.Баярсайхан	С.Одонтуяа	С.Ганбаатар	С.Баярцогт	Д.Дэмбэрэл	Д.Лүндээжанцан	Д.Ганбат
9	Б.Болор	Х.Болорчулуун	Ё.Отгонбаяр	М.Зоригт	Р.Гончигдорж	М.Зоригт	Ц.Нямдорж	Д.Ганхуяг
10	Л.Болд	Р.Бурмаа	Ц.Оюунгэрэл	С.Одонтуяа	Ц.Дашдорж	Б.Наранхүү	Ё.Отгонбаяр	Б.Гарамгайбаатар
11	Д.Дэмбэрэл	Ц.Дашдорж	Я.Санжмятав	Д.Сарангэрэл	С.Дэмбэрэл	Ц.Оюунбаатар	Ц.Оюунбаатар	Ц.Даваасүрэн
12	Н.Номтойбаяр	Б.Наранхүү	Д.Сарангэрэл	О.Содбилэг	Д.Лүндээжанцан	Д.Оюунхорол	Ц.Оюунгэрэл	С.Дэмбэрэл
13	С.Оюун	Н.Номтойбаяр	Я.Содбаатар	Ш.Түвдэндорж	Х.Тэмүүжин	Я.Санжмятав	Д.Оюунхорол	Д.Зоригт
14	О.Содбилэг	Ц.Оюунгэрэл	Д.Сумъяабазар	Д.Хаянхярваа	Ч.Сайханбилэг	Д.Сумъяабазар	Ш.Түвдэндорж	Ц.Нямдорж
15	Л.Цог	С.Оюун	А.Глейхан	М.Энхболд	О.Содбилэг	Ч.Хүрэлбаатар	Х.Тэмүүжин	С.Одонтуяа
16	Ц.Цолмон	Я.Содбаатар	Д.Хаянхярваа		Г.Уянга	Б.Чойжилсүрэн	Б.Чойжилсүрэн	А.Глейхан
17	Ж.Энхбаяр	Д.Тэрбишдагва	С.Эрдэнэ		Л.Цог	Д.Эрдэнэбат	З.Энхболд	Г.Уянга
18	З.Энхболд	Ч.Хүрэлбаатар	Л.Эрдэнэчимэг		М.Энхболд	Ж.Эрдэнэбат	Ө.Энхтүвшин	Л.Энх-Амгалан
19	Н.Энхболд	Ж.Энхбаяр	Л.Энх-Амгалан		Н.Энхболд	Л.Эрдэнэчимэг	С.Эрдэнэ	Ө.Энхтүвшин

ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАРЬАЛАЛ /2016.06.01/

№	Ц.Оюунгэрэл	М.Батчимэг	С.Дэмбэрэл	Д.Сумъяабаазар	Н.Батцэрэг	О.Содбилэг	Р.Гончигдорж	Ч.Хүрэлбаатар	Г.Батхүү	Л.Болд	Хүний эрхийн дэд хороо
1	Ц.Оюунгэрэл	М.Батчимэг	С.Дэмбэрэл	Д.Сумъяабаазар	Н.Батцэрэг	О.Содбилэг	Р.Гончигдорж	Ч.Хүрэлбаатар	Г.Батхүү	Л.Болд	Хүний эрхийн дэд хороо
2	Л.Эрдэнэчимэг	Су.Батболд	Ж.Батсуурь	Л.Гантөмөр	А.Бакей	Н.Алтанхуяг	Д.Дэмбэрэл	Д.Ганхуяг	М.Батчимэг	О.Баасанхүү	Тусгай хяналтын дэд хороо
3	О.Баасанхүү	Ж.Батзандан	Х.Болорчулуун	С.Одонтуяа	Н.Батбаяр	Н.Батбаяр	Д.Лүндээжанцан	М.Зоригт	Д.Дэмбэрэл	Ж.Батзандан	Төсвийн зарлагын хяналтын дэд хороо
4	Су.Батболд	З.Баянсэлэнгэ	С.Бямбацогт	Я.Санжмятав	Су.Батболд	Су.Батболд	С.Оюун	Б.Наранхүү	Ц.Цолмон	З.Баянсэлэнгэ	Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо
5	Х.Баттулга	Б.Наранхүү	Д.Ганбат	А.Тлейхан	М.Батчимэг	М.Батчимэг	Ч.Улаан	Ч.Улаан	Ч.Улаан	Д.Ганбат	Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо
6	Б.Наранхүү	Д.Сарангэрэл	Д.Ганхуяг	Д.Хаянхярваа	С.Баярцогт	С.Баярцогт	С.Баярцогт	Я.Санжмятав	Я.Санжмятав	Ё.Отгонбаяр	Нутгийн удирдлагын дэд хороо
7	С.Оюун	Ш.Түвдэндорж	С.Одонтуяа	С.Эрдэнэ	Р.Гончигдорж	Х.Тэмүүжин	Х.Тэмүүжин	Д.Сумъяабаазар	Д.Сумъяабаазар	Ц.Оюунбаатар	Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хороо
8	Я.Содбаатар	Д.Тэрбишдагва	Г.Уянга	Л.Эрдэнэчимэг	О.Содбилэг	Л.Цог	Л.Цог	Б.Чойжилсүрэн	Б.Чойжилсүрэн	Х.Тэмүүжин	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо
9	Ч.Хүрэлбаатар	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	Н.Энхболд	С.Эрдэнэ	Ёс зүйн дэд хороо
	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо										

2012-2016 ОНД БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

Энэ удаагийн УИХ бүрэн эрхийн хугацаандаа улс орны улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн салбарын үйл ажиллагааны чиглэлээр бие даасан 135 хууль, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 953 хууль, гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай 55 хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүйд тооцох тухай 97 хууль, УИХ-ын 370 тогтоол хэлэлцэж баталжээ. Үүнээс бие даасан хуулиуд болон олон улсын зарим гэрээ, конвенци, зээлийн хэлэлцээр соёрхон баталсан хуулиуд, бодлогын шинжтэй УИХ-ын зарим тогтоолуудын жагсаалтыг дор нийтлэв.

БИЕ ДААСАН ХУУЛИУД:

1. Засгийн газрын бүтцийн тухай хууль /2012.08.16/
2. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай /2012.08.16/
3. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль /2012.09.04/
4. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль /2012.09.14/
5. Монгол Улсын 2013 оны төсвийн тухай /2012.11.09/
6. Хүний хөгжил сангийн 2013 оны төсвийн тухай /2012.11.09/
7. Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай /2012.11.09/
8. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд төсвийн тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай /2012.11.08/
9. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай /Шинэчилсэн найруулга//2012.12.13/
10. Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ 2012.12.20/
11. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай /2012.12.20/
12. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга /2012.12.21/
13. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай /2012.12.27/
14. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай /2013.01.03/
15. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай /2013.01.10/
16. Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2013.01.17/
17. Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/ /2013.01.24/
18. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай /Шинэчилсэн найруулга//2013.01.31/
19. Хаягжуулалтын тухай /2013.02.07/
20. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2013.02.08/
21. Монгол Улсын 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай /2013.05.24/
22. Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/ /2013.05.24/
23. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ /2013.05.31/

24. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /автобус, троллейбус/ /2013.06.07/
25. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг / /2013.06.07/
26. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /Газрын тосны бүтээгдэхүүнийг газрын тос, занар болон нүүрснээс үйлдвэрлэлийн аргаар гарган авах төслийн хүрээнд импортоор оруулж байгаа технологийн тоног төхөөрөмж, сэлбэг болон тусгай зориулалтын барилгын материалыг / /2013.06.07/
27. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /модон материал/ /2013.06.07/
28. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /модон материал/ /2013.06.07/
29. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай /2013.07.03/
30. Тахарын албаны тухай /2013.07.05/
31. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай /2013.07.05/
32. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай /2013.07.05/
33. Цагдаагийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ /2013.07.05/
34. Хөрөнгө оруулалтын тухай /2013.10.03/
35. Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2013.10.03/
36. Хөрөнгө оруулалтын сангийн тухай /2013.10.03/
37. Монгол Улсын 2014 оны төсвийн тухай /2013.11.15/
38. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай /2013.11.15/
39. Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай /2013.11.15/
40. Хилийн боомтын тухай /2013.12.26/
41. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай /2014.01.09/
42. Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2014.01.16/
43. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /2014.01.16/
44. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2014.01.16/
45. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /2014.01.24/
46. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2014.01.24/
47. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /Амгалан дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжийг импортлох 2014.05.09/
48. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /Амгалан дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжийг импортлох 2014.05.09/
49. Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ /2014.05.15/
50. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай /2014.05.30/
51. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай 2014.06.06 /
52. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /жижиг, дунд

- үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж буй тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг татвараас чөлөөлөх тухай; 2014.06.06 /
53. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль /2014.06.13/
 54. Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/ /2014.07.01/
 55. Шилэн дансны тухай /2014.07.01/
 56. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай /2014.11.14/
 57. Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай /2014.11.14/
 58. Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай /2014.11.14/
 59. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай /2014.12.04/
 60. Засгийн газрын бүтцийн тухай /2014.12.04/
 61. Номын сангийн тухай /2014.12.19/
 62. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай /Шинэчилсэн найруулга/ /2015.01.29/
 63. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2015.01.29/
 64. Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ /2015.01.29/
 65. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2015.01.29/
 66. Чөлөөт бүсийн тухай /Шинэчилсэн найруулга/ /2015.02.12/
 67. Чөлөөт бүсийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2015.02.12/
 68. Монгол хэлний тухай /2015.02.12/
 69. Өрийн удирдлагын тухай /2015.02.18/
 70. Өрийн удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2015.02.18/
 71. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль /2015.05.21/
 72. Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хууль /2015.05.21/
 73. Хууль тогтоомжийн тухай хууль /2015.05.29/
 74. Шүүх байгуулах тухай /шинэчилсэн найруулга хууль /2015.06.19/
 75. Нягтлан бодох бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль /2015.06.19/
 76. Аудитын тухай /шинэчилсэн найруулга/ хууль /2015.06.19/
 77. Захиргааны ерөнхий хууль /2015.06.19/
 78. Нийслэл хотын албан татварын тухай хууль /2015.06.19/
 79. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль /2015.06.26/
 80. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль /2015.07.02/
 81. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль /2015.07.02/
 82. Галын аюулгүй байдлын тухай хууль /2015.07.02/
 83. Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль /2015.07.02/
 84. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль /2015.07.02/
 85. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль /2015.07.02/
 86. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015.07.08/
 87. Нийтийн сонсголын тухай хууль /2015.07.08/
 88. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль /2015.07.09/
 89. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /шинэчилсэн найруулга/ хууль /2015.07.09/
 90. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг дагаж мөрдөх журмын

- тухай хууль /2015.07.09/
91. Галт зэвсгийн тухай /шинэчилсэн найруулга/ 2015.08.07
92. Галт зэвсгийн албан татварын тухай /2015.08.07/
93. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай /2015.08.07/
94. Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай /2015.08.11/
95. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай /2015.11.13/
96. Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай /2015.11.13/
97. Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай /2015.11.13/
98. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай /2015.11.26/
99. Эрчим хүч хэмнэлтийн тухай /2015.11.26/
100. Хамтын тэтгэврийн тухай /2015.12.03/
101. Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай /2015.12.18/
102. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ /2015.12.03/
103. Зөрчлийн тухай /2015.12.04/
104. Сонгуулийн тухай /2015.12.25/
105. Монгол Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /2016.01.07/
106. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай /2016.01.22/
107. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.01.22/
108. Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ /2016.01.29/
109. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.04/
110. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.04/
111. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /2016.02.04/
112. Эрүүл ахуйн тухай /2016.02.04/
113. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.05/
114. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.05/
115. Онцгой албан татвараас чөлөөлөх тухай /2016.02.05/
116. Ирээдүйн өв сангийн тухай /2016.02.05/
117. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.02.05/
118. Ард нийтийн санал асуулгын тухай /шинэчилсэн найруулга/ /2016.02.05/
119. Хүүхдийн эрхийн тухай /2016.02.05/
120. Хүүхэд хамгааллын тухай /2016.02.05/
121. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай /2016.02.05/
122. Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ /2016.02.05/
123. Барилгын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.02.05/
124. Органик хүнсний тухай /2016.04.07/
125. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай /2016.04.22/
126. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.04.22/
127. Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.05.13/
128. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ /2016.05.13/
129. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.05.13/

130. Хууль сахиулах ажиллагааны тухай /2016.05.13/
131. Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/ /2016.05.19/
132. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга//2016.05.19/
133. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/ /2016.05.20/
134. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2016.05.20/
135. Прокурорын байгууллагын тухай /шинэчилсэн найруулга//2016.05.20/

СОЁРХОН БАТАЛСАН ЗАРИМ ГЭРЭЭ, КОНВЕНЦИ, ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР:

1. Биоаюулгүй байдлын тухай Картагены протоколын хариуцлага ба хохиролгүй болгох Нагоя-Куала Лумпурын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай /2012.12.20/
2. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай /Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төсөл: Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээр/ /2013.05.10/
3. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай /Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл”-ийн зээлийн хэлэлцээр/ /2013.05.10/
4. Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд байгуулсан Улаанбаатар хотын 4 дүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2014.01.30/
5. “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2014.05.23/
6. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2014.05.23/
7. “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн төсөл: Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2014.05.23/
8. “Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллага”-ын конвенцид орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай /2014.11.28/
9. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн нэмэлт Протокол соёрхон батлах тухай /2014.12.11/
10. Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай /2015.04.30/
11. Монгол Улсын Засгийн газар болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага хоорондын Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл /II/-н зээлийн гэрээг соёрхон батлах тухай /2015.06.05/

12. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2015.06.25/
13. “Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилтийн хэлэлцээр” соёрхон батлах тухай /2015.07.09/
14. “Цахим эрүүл мэнд төслийн санхүүжилтийн хэлэлцээр” соёрхон батлах тухай /2015.07.09/
15. “Ухаалаг засаг төслийн санхүүжилтийн хэлэлцээр” соёрхон батлах тухай /2015.07.09/
16. “Мянганы сорилтын компакт гэрээг боловсруулахад дэмжлэг үзүүлэх буцалтгүй тусламжийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай /2015.07.09/
17. “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай /2016.02.05/
18. Тээврийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.05/
19. Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.19/
20. Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгох төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.19/
21. Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.19/
22. “Хөгжлийн хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай” /2016.05.13/
23. “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай” /2016.05.20/
24. “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай” /2016.05.20/
25. “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконгийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай” /2016.05.20/

УИХ-ЫН ТОГТООЛУУД:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай /2012.08.17/
2. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2012.08.17/
3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2012.08.17/
4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай /2013.05.24, дугаар 39/
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан

- авах зарим арга хэмжээний тухай /2013.05.24, дугаар41/
6. Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай /2013.06.06, дугаар 42 /
 7. Монгол Улсын Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар, Консулын газрыг гадаадын зарим улсад нээх, сэргээн ажиллуулах тухай /2013.06.07 №43/
 8. Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай /2013.11.07, дугаар 60 /
 9. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2013.11.14, дугаар 62/
 10. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2014.07.01, дугаар 53/
 11. Цагаан суваргын ордын төрийн эзэмшлийн тухай /2014.07.01, дугаар 54/
 12. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2014.10.07, дугаар 55/
 13. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2014.11.13, дугаар 69/
 14. “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2015.02.18, дугаар 40/
 15. “Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай” /2015.05.14, дугаар 49/
 16. “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай /2015.06.18, дугаар 57/
 17. “Шүүгчийн орон тоо батлах тухай” /2015.06.19, дугаар 59/
 18. “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” /2015.06.19, дугаар 60/
 19. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол /2015.06.19, дугаар 62/
 20. “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай” /2015.06.19, дугаар 63/
 21. “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоол /2015.07.02, дугаар 65/
 22. “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоол /2015.07.09, дугаар 74/
 23. Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай тогтоол /2015.07.09, дугаар 75/
 24. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” /2015.11.13, дугаар 93/
 25. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2015.11.13, дугаар 100/
 26. “Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” /2015.11.13, дугаар 101/

27. “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай /2015.11.13, дугаар 103/
28. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” /2015.11.26, дугаар 104/
29. “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг тогтоох тухай” /2016.01.29, дугаар 09/
30. “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” /2016.01.29, дугаар 10/
31. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай /2016.01.29, дугаар 11/
32. “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” /2016.01.22, дугаар 12/
33. “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” /2016.02.04, дугаар 13/
34. “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” /2016.02.04, дугаар 14/
35. “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах тухай” /2016.04.07, дугаар 31/
36. “Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” /2016.04.07, дугаар 32/
37. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” /2016.04.14, дугаар 34/
38. “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” /2016.04.14, дугаар 35/
39. “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” /2016.05.12, дугаар 41/
40. “Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай” /2016.05.13, дугаар 42/
41. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” /2016.05.13, дугаар 43/
42. “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2016.05.19, дугаар 44/
43. “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2016.05.19, дугаар 45/
44. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай /2016.05.19, дугаар 46/

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

УИХ-ын зургаа дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын Тамгын газар нь Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиуд, УИХ-ын тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон хуульд заасан чиг үүргээ амжилттай хэрэгжүүлсэн байна.

Энэ хугацаанд Тамгын газрын үйл ажиллагааны чанар, хүртээмж, шуурхай байдлыг хангах, хүний нөөцийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, бүтцийн нэгжүүдийн зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр зохион байгуулалтын зарим арга хэмжээ авч хэрэгжүүлж иржээ.

“Ажлын хэсэг байгуулах тухай” УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2012 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн 587 тоот захирамжаар Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын нэгжийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн даргаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулжээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, УИХ-ын 2006 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэмд заасан эрх, үүргийн хүрээнд Тамгын газрын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, УИХ, түүний гишүүд, Байнгын болон бусад хороодод шуурхай үйлчлэх чадварлаг, мэргэшсэн баг, хамт олон бүрдүүлэх чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах ажлыг батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэж, 14 хоногийн хугацаанд Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг үүрэг болгосон байна.

Ажлын хэсэг нь удирдамжид заасны дагуу Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, хэлтэс, алба, төвийн чиг үүрэг, хоорондын ажлын уялдаа холбоо, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг судлан үзэх, зэрэгцүүлэн дүгнэлт хийж болохуйц ижил албан тушаалд ажиллагсдын ажлын нягтралтай харьцуулан дүгнэх, ажилтнуудын илүү цагаар ажиллуулах бодит шалтгаан байгаа эсэх, илүү цагаар байнга ажилладаг ажилтнуудын ажлын үр дүнг тооцох, төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллагсдын ажлын ачааллыг судлах, цаг ашиглалтын программын ашиглалтад тулгуурлан ажилтнуудын ирцийн байдалд дүгнэлт хийх, ажилтнуудын ажлын цаг ашиглалтын байдалд зураг авалтаар дүгнэлт гаргах чиглэлээр ажиллажээ.

Түүнчлэн УИХ-ын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, алба, төвийн чиг үүргийг шинэчлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг УИХ-ын даргын ахлах зөвлөхөөр ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 29 тоот захирамж гаргажээ. Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, хэлтэс, алба, төвийн чиг үүргийг шинэчлэн боловсруулахдаа хэлтэс, алба, төвийн чиг үүрэг, ажлын давхардал, хийдэгдэл, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нарийвчлан судалж, УИХ-ын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтын нэгжийн ажлын ачааллын тэнцвэртэй байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, УИХ-ын Байнгын хорооны удирдлагаас ирүүлсэн саналыг үндэслэн санал боловсруулж танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосон байна.

Энэ бүхний үндсэн дээр УИХ-ын Тамгын газар зохион байгуулалтынхаа бүтцэд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч, нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын уялдаа холбоог сайжруулах, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох гол зорилго тавин ажиллаж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Тамгын газрын дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, УИХ-ын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүргээ амжилттай хэрэгжүүлж иржээ.



Өнгөрсөн хугацаанд Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх чиглэлээр Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хоёр удаа захирамж гаргаж, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Эхний удаад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг, УИХ-ын 2006 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм” -ийн 3.3 -т заасныг үндэслэн УИХ-ын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2013 оны 3 дугаар сарын 6 -ны өдрийн захирамжийн хавсралтаар баталжээ. Энэ шийдвэрийн дагуу УИХ-ын Тамгын газар нь Ерөнхий нарийн бичгийн даргаас гадна Тамгын газрын хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга, Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга гэсэн хоёр нарийн бичгийн дарга, Хууль зүйн үйлчилгээний, Хуралдаан зохион байгуулах, Судалгаа шинжилгээний, Хяналт, үнэлгээний, Гадаад харилцааны, Захиргаа, нийтлэг үйлчилгээний, Мэдээллийн технологийн, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах гэсэн 8 хэлтэс болон Дотоод аудитор гэсэн үндсэн нэгжтэй, нийт 197 орон тоотойгоор ажиллах болжээ. Харин “Орон тоо шинэчлэн батлах тухай” УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 12 дугаар

сарын 23-ны өдрийн 725 тоот захирамжаар Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулж Тамгын газрын захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалыг хассан байна. Түүнчлэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажилтнуудын ажлын ачааллыг жигдрүүлж хийдэл, давхардлыг арилгах арга хэмжээний хүрээнд Тамгын газрын үйл ажиллагаанд дахин инженерчлэл хийж “УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төв”-ийг шинээр байгуулан нээлттэй, ил тод, шуурхай үйлчилгээг эхлүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн хугацаанд Тамгын газрын жил бүрийн үйл ажиллагааны тайланг хуулийн дагуу УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, хуульд заасан чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байна гэсэн үнэлэлт авч ирсэн нь Тамгын газрын нийт хамт олны хүчин чармайлтын үр дүн юм.

Тамгын газрын удирдлагууд



Б.Болдбаатар
*Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга*



П.Амаржаргал
*Хууль зүйн үйлчилгээ хариуцсан
нарийн бичгийн дарга*

УИХ-ын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргаар Б.Цэвээнпүрэв /2013-2014/, Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргаар Н.Отгончимэг /2013-2015/ нар тус тус ажиллаж байв.

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөл

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Зөвлөл нь Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Ерөнхий нарийн бичгийн даргад зөвлөх үүрэгтэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхий нарийн бичгийн дарга, Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргаас гадна Тамгын газрын хэлтсийн дарга нар, Дотоод аудитор, Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч дарга, Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн дарга, ахлах нягтлан бодогч нар ордог.



Зураг дээр: /зүүнээс/ Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга О.Батханд, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Цогтсайхан, Дотоод аудитор Ц.Лхагвагэрэл, Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга Н.Ширэндэв, Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга Л.Энхтуяа, Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар, Хууль зүйн үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга П.Амаржаргал, Судалгааны хэлтсийн дарга Ц.Норовдондог, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаа, Мэдээлэл, үйлчилгээ, удирдлагын төвийн дарга Б.Төгөлдөр, Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Дашдорж, Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн орлогч дарга Л.Батжав нар. 2016.05.31

Улсын Их Хурлын Тамгын газрын эрхэм зорилго, эрхэмлэх үндсэн зарчим

УИХ-ын Тамгын газрын эрхэм зорилго нь эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, монголын ард түмний засаглах эрхийг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь УИХ-д үзүүлэх мэргэжил, арга зүй, техник- зохион байгуулалтын туслалцаа, санхүү, аж ахуйн үйлчилгээ нь УИХ-ын хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн байхад оршино. Энэхүү эрхэм зорилгыг хангаж ажиллахын тулд дараахь үндсэн зарчмыг үйл ажиллагаандаа эрхэмлэнэ.

Эрхэмлэх үндсэн зарчим:

- 1: Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн сахиж, бүхий л үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд хэрэгжүүлэх
- 2: Төрийн албаны ёс зүйг сахин мөрдөж, улс төрөөс ангид байж, хариуцлага хүлээх чадвартай байх
- 3: Тамгын газрын үйл ажиллагаа нь мэргэшсэн, шуурхай, соёлтой, найдвартай, тасралтгүй байх



Улсын Их Хурлын Тамгын газрын хамт олон. 2016.05.31



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

2012-2016

IV

БҮЛЭГ

- Парламентын Бүлгэмийн хамтын ажиллагаа
- Гадаадын парламентын төлөөлөгчдийн айлчлал
- Улсын Их Хурал ба Олон Улсын Парламентын Холбооны хамтын ажиллагаа

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА

Монгол Улс үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогын зарчмыг баримтлан идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэ үндсэн дээр дэлхийн улс орнуудын парламентуудыг эгнээндээ нэгтгэсэн байгууллага болох Олон улсын парламентын Холбоо /ОУПХ/-ны гишүүн Монгол Улсын Их Хурлын парламент хоорондын хамтын ажиллагаа агуулга, хэлбэрийн хувьд улам бүр баяжсаар ирэв. Эдүгээ 170 орны парламент тус байгууллагын гишүүнчлэлийн статустай бол 11 улс ажиглагчаар элссэн байна.

Энэ удаагийн УИХ бүрэн эрхийн хугацаандаа 58 улстай парламент хоорондын харилцах бүлэг байгуулж ажилласнаас гадна Монгол-Ази, Номхон далайн орнууд, Монгол-Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг, Монгол-Европын парламент, Монгол-Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблей, Монгол-НАТО-гийн Парламентын Ассамблейтай тус тус харилцах бүлгийг шинээр байгуулсан байна.

УИХ-аас 2012-2016 онд хэрэгжүүлсэн гадаад, дотоод айлчлал, арга хэмжээнүүд нь УИХ-ын гадаад орнуудын хууль тогтоох дээд байгууллагуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагааг бүх түвшинд өргөжүүлэх, уламжлалт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн тодорхой түвшинд ахиулах, парламентын Байнгын хороо, Монголын парламентын Бүлгэм, Тамгын газрууд хоорондын харилцааг өргөжүүлэхэд чиглэгдэж иржээ. Энэ үндсэн дээр 2012 онд 40, 2013 онд 256, 2014 онд 156, 2015 онд 91 гадаад айлчлал, олон улсын хурал, семинар, танилцах аялал зэрэг арга хэмжээнд УИХ-ын гишүүд оролцсон байна. Мөн УИХ-ын Тамгын газраас давхардсан тоогоор 2012 онд 60, 2013 онд 43, 2014 онд 63, 2015 онд 81 ажилтан УИХ болон олон улсын байгууллагын зардлаар айлчлал, олон улсын хурал, семинар, сургалт, туршлага судлах, танилцах аялалд хамрагджээ.

ПАРЛАМЕНТЫН БҮЛГЭМИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Энэ хугацаанд УИХ болон Монголын парламентын Бүлгэмийн шугамаар гадаад оронд хэрэгжсэн айлчлалуудыг тоймловол:

2013 он:


- УИХ-ын дарга З.Энхболд тэргүүтэй парламентын төлөөлөгчид АНУ, Канад, БНТУ-д тус тус албан ёсны айлчлал хийв.

- БНХАУ-д зохион байгуулагдсан Азийн төлөөх Боао-гийн чуулга уулзалт, Швейцарийн Холбооны Улсын Женев хотноо зохион байгуулагдсан ОУПХ-ны 129 дүгээр Ассамблейд оролцов.

- УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн дарга С.Баярцогт УИХ-ын дарга З.Энхболдын АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж айлчлав.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Н.Энхболд, УИХ-ын гишүүн, УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга Н.Батцэрэг, УИХ-ын гишүүн Б.Болор нар УИХ-ын дарга З.Энхболдын Канад Улсад хийсэн албан ёсны айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж айлчлав.

- УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дарга Л.Цог, УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Г.Баярсайхан, УИХ-ын гишүүн Д.Арвин, Ж.Батсуурь, Д.Ганбат, Ц.Оюунбаатар нар ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлд тус тус айлчлав.



2014 он:

- УИХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид БНСУ, БНХАУ-д албан ёсны айлчлал хийв.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, УИХ дахь Монгол-Францын парламентын бүлгийн дарга Н.Батцэрэг тэргүүтэй төлөөлөгчид БНФУ-ын Сенатад айлчлав.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн дарга М.Батчимэг, УИХ-ын гишүүн Н.Номтойбаяр нар БНАУ-ын Вена хотноо зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн өвлийн 13 дугаар хуралд оролцов.

- УИХ-ын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Батцогт, УИХ-ын гишүүн С.Одонтуяа, Б.Болор, Д.Ганбат, С.Дэмбэрэл, Ж.Эрдэнэбат нар Япон Улсын “Сасакава Энх тайвны сан”-гийн урилгаар Япон Улсад айлчлав.

- УИХ-ын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн Су.Батболд нар Кувейт Улсад айлчлал хийв.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Буриадын парламентын бүлгийн дарга Д.Арвин тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын БНБуру-д айлчлав.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай

харилцах бүлгийн гишүүн Н.Энхболд Женев хотноо зохиогдсон ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын хуралд оролцов.

2015 он:

- УИХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид Япон, ХБНГУ, БНПУ, ОХУ-д тус тус албан ёсны айлчлал хийлээ.

- АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан Дэлхийн спикерүүдийн 4 дүгээр бага хуралд оролцов.

- БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан “Торгоны зам” сэдэвт Азийн улс төрийн намуудын олон улсын бага хуралд оролцов.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн дарга М.Батчимэг БНАУ-ын Вена хотноо зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн өвлийн хуралд оролцов.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Казахстаны парламентын бүлгийн дарга А.Тлейхан тэргүүтэй төлөөлөгчид БНКаЗУ-д айлчлав.

- УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, УИХ дахь Монгол-Киргизийн парламентын бүлгийн дарга А.Бакей тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Киргиз Улсад айлчлав.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Вьетнамын парламентын бүлгийн дарга З.Баянсэлэнгэ, УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл, Н.Энхболд, Ж.Батзандан нар Ханой хотноо зохиогдсон ОУПХ-ны 132-р Ассамблейд оролцох үеэрээ тус улсын Үндэсний Ассамблейд ажлын айлчлал хийв.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн гишүүн Л.Болд Данийн Вант Улсын Копенгаген хотноо зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Товчооны хуралд оролцов.

- УИХ-ын дэд дарга, УИХ дахь Монгол-Оросын парламентын бүлгийн дарга Р.Гончигдорж тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-ын Чита хотноо ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөл дахь Монголтой харилцах бүлэгтэй хамтран “ОХУ-ын Сибирийн Холбооны тойргийн субъект болон Монгол Улсын аймгуудын хил орчмын хамтын ажиллагаа /Байгалийн хязгаар болон Монголын зүүн аймгуудын жишээн дээр”, “Фашизмыг ялахад Монголын оролцоо: Түүхэн туршлага ба хойч үедээ үлдээх сургамж” сэдэвт бага хурлуудад оролцов.

- УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн дарга М.Батчимэг, УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн гишүүн Л.Болд, Д.Тэрбишдагва нар БНФинланд Улсын Хельсинки хотноо зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн ээлжит хуралд оролцов.

2016 он:

- УИХ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсад ажлын айлчлал хийв.

- УИХ-ын дэд дарга Р.Гончигдорж, УИХ-ын гишүүн Ё.Отгонбаяр ОХУ-ын Москва хотноо зохиогдсон Евразийн бүс нутгийн орнуудын парламентын дарга нарын анхдугаар зөвлөгөөнд оролцов.

ГАДААДЫН ПАРЛАМЕНТЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АЙЛЧЛАЛ:

2012 он:

- Тайландын Вант Улсын Үндэсний Ассамблейн Төлөөлөгчдийн танхимын нэгдүгээр орлогч дарга Чарён Чанкомол тэргүүтэй төлөөлөгчид,
- Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Ардын Дээд Хурлын дарга Чой Тэ Бок тэргүүтэй төлөөлөгчид,



2013 он:

- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурлын Байнгын хорооны дарга У Бангуо тэргүүтэй төлөөлөгчид тус тус албан ёсны айлчлал хийв.
- Данийн Вант Улсын Фолькетингийн дарга Могенс Люккетoft тэргүүтэй төлөөлөгчид,
- ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Р.Миглиори тэргүүтэй төлөөлөгчид,
- Бүгд Найрамдах Польш Улсын Сенатын Маршал Богдан Борусевич тэргүүтэй төлөөлөгчид,
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн Дэд Ерөнхийлөгч Эдуард Освальд тэргүүтэй төлөөлөгчид,
- Бүгд Найрамдах Финланд Улсын парламентын дарга Эеро Хейнэлүома тэргүүтэй төлөөлөгчид,

- Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн дарга Кан Чан Хий тэргүүтэй төлөөлөгчид тус тус албан ёсны айлчлал хийв.

2014 он:

- Холбооны Бүгд Найрамдах Улсын Холбооны парламентын дарга бөгөөд Төлөөлөгчдийн танхимын дарга Тура У Швэ Манн тэргүүтэй төлөөлөгчид,

- ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга В.И.Матвиенко тэргүүтэй төлөөлөгчид,

- БНТУ-ын Үндэсний Их Хурлын дарга Жемил Чичек тэргүүтэй төлөөлөгчид,

- БНПУ-ын Сеймийн Дэд Маршал Ежи Вендерлих тэргүүтэй төлөөлөгчид тус тус айлчлав.

2015 он:

- Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкин тэргүүтэй төлөөлөгчид,

- Бүгд Найрамдах Чех Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга ноён Ян Хамачек тэргүүтэй төлөөлөгчид тус тус айлчлав.

- ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкин айлчилж, Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын хуралд оролцов.

- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Үндэсний Ассамблейн дэд дарга Хуинь Нгок Сөн тэргүүтэй төлөөлөгчид,

- Бүгд Найрамдах Чех Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга ноён Ян Хамачек тэргүүтэй төлөөлөгчид,

- БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дэд дарга Янь Зюньчи тэргүүтэй төлөөлөгчид тус тус айлчлав.

2016 он:

- Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Доод танхим /Лок Сабха/-ын дарга хатагтай Сумитра Махажан Ази-Европын Парламентын Түншлэлийн 9 дүгээр уулзалтын зарим арга хэмжээнд оролцохоор албан ёсны айлчлал хийв.

- Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Пьетро Грассо албан ёсны айлчлал хийж, Ази, Европын парламентын түншлэлийн 8 дугаар уулзалтын Ерөнхийлөгчийн хувьд Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын нээлтэд үг хэлэв.

- Япон Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн Казүнори Танака тэргүүтэй төлөөлөгчид

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагийн гишүүн, Бундестаг дахь Христосын Ардчилсан Холбоо намын бүлгийн дарга Герда Хассельфелдт, Бундестагийн гишүүн, Бундестаг дахь Христосын Ардчилсан холбоо намын бүлгийн дэд дарга Макс Штраубингер нар

- АНУ-ын Конгрессын төлөөлөгчдийн танхимын Ардчиллын түншлэлийн хөтөлбөрийн дарга, төлөөлөгчдийн танхимын гишүүн Питр Роскам тэргүүтэй Конгрессын гишүүд тус тус айлчиллаа.

Дээрх айлчлалууд нь хоёр орны парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, шинэ агуулга, хэлбэрээр баяжуулж үр өгөөжийг нь нэмэгдүүлэхэд үр дүнтэй чухал алхам болсон билээ.

ПАРЛАМЕНТУУД ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА:


УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд олон улсын парламентууд хоорондын хамтын ажиллагаа идэвхитэй хөгжиж ирэв. Тухайлахад, 2013 онд Улаанбаатар хотноо болсон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дугаар бага хурлын хүрээнд Ардчиллын төлөөх парламентчдын чуулга уулзалт, “Евро-Азийн тээвэр: Бүс нутгийн оролцоо” сэдэвт олон улсын бага хурал, Зүүн хойд Азийн эмэгтэй парламентчдын чуулга уулзалтыг “Боловсролоор дамжуулан энх тайван, хөгжлийг урагшлуулахад эмэгтэй парламентчдын гүйцэтгэх үүрэг” сэдвийн дор тус тус зохион байгуулав.



2014 онд Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хороо хооронд хамтын ажиллагааны байнгын механизм байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг, Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их Хурал хооронд Хамтын ажиллагааны протокол байгуулсан бол Монгол Улсын Их Хурлын Тамгын газар Чех, Польш, Лаос Улсын Парламентын Тамгын газруудтай Хамтын ажиллагааны санамж бичиг, Данийн Парламентын Тамгын газартай Хамтын ажиллагааны протокол байгуулжээ.

- 2015 онд ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын чуулган Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдсан нь Монгол Улсын нэр хүнд бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсын тавцанд өсч, бүс нутаг, олон улсын чанартай аливаа асуудлыг шийдвэрлэхэд манай улсын үүрэг, оролцоо нэмэгдэх чухал ач холбогдолтой болсон юм.
- 2016 оны 4 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Ази, Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтад 32 орны 170 гаруй төлөөлөгч оролцов.

Монгол Улсын Их Хурал 2012-2016 он





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД

2012-2016

V

БҮЛЭГ

- Улсын Их Хурлын гишүүд
- З.Энхболдын ангийнхан
- Парламентын гишүүд
гэрэл зургийн дуранд





Улсын Их Хурлын гишүүн Норовын АЛТАНХУЯГ

БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ



“Өөрийн стратеги байхгүй бол бусдын тактикт автдаг”. Ийм нэг үг бий. Өөрөөр хэлбэл өөрийн гэсэн хэтийн зорилгогүй хүн бусдыг аялдан дагадаг гэсэн утгатай. Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайд Н.Алтанхуяг энэ удаагийн сонгуульд төрсөн нутагтаа нэр дэвших болсон гэдгийг сонсоод хамгийн түрүүнд төрсөн сэтгэгдэл минь энэ.

Монгол төрийг удирдаж явсан хүмүүс бүгдээрээ л өөр өөрийн гэсэн авир араншин, арга барилтай байсан. Ялангуяа сүүлийн үеийн удирдагч нар. Энэ бүгдээс хамгийн их ялгаралтай нь Н.Алтанхуяг. Аливаа асуудалд тун их алсын хараагаар хандана. Аливааг маш сайн урьдчилан харж, тооцоолдог. Бас бусдыг хэр барагтай бол аялдан дагадаггүй. Тиймээс хандлага бүхэн нь хожим биеллээ заавал олдог. Бас нэг чанар нь маш их хөдөлмөрч. Хүүхэд байхын гэрийн хүмүүжил нь өсөхийн хэрээр улам “сэдэрч”, Увсчуудын хөдөлмөрч ген ч нөлөөлж түүнийг ажилсаг нөхөр болгосон биз. Хөдөлмөрч хүн бол мөнхийн бүтээгч байдаг.

Анх ардчиллын салхи Монгол оронд үлээж эхлэхэд их сургуулийн багшийн ажлаа орхин байж энэ тэмцэлд оржээ. Түүний улс төрийн намтар аядуухан эхэлсэн. МУИС-ийнхаа өрөөнд хэсэг нөхдөө цуглуулаад МСДН-ыг байгуулав. Энэ бол түүний төрийн өндөрлөг, засаглалын оргил өөд өгсөх улс төрийн шатны эхний гишгүүр байлаа. Тэгээд л тун алгуурхан, бас итгэлтэйгээр дээш өгссөн байдаг.

Олон гишгүүр дээр зогссон тэрбээр МСДН-ын нарийн бичгийн дарга гэсэн албанд очив. Хийлээ. Журмын нөхөд нь түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга болгов. Ахилаа. УИХ-ын гишүүн болов. Улмаар Засгийн газрын гишүүн болж, хөдөө аж ахуй хариуцсан сайдаар томилогдлоо. Дараа нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга гэсэн албан тушаалд очив. Удалгүй

МҮАН, МСДН нэгдлээ. Энэ нэгдлийн эх сурвалж нь бас л тэр. Ахиад л Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга болов. Энэ албанд дөрвөн удаа томилогдож “мөнхийн генсек” нэртэй болов. Сангийн сайдаар томилогдлоо. Өгсөв. Ардчилсан намын дарга болж намаа удирдав. Ингэхэд зургаан жил намын дарга хийж, таван удаагийн ялалтыг авч ирсэн түүхийн эзэн бол яалт ч үгүй Н.Алтанхуяг. Тэрбээр Тэргүүн шадар сайдын суудалд суулаа. Дээшлэв. Монгол Улсын Ерөнхий сайд боллоо. Бүтээн байгуулав. Дотроо тооцоотой, толгойдоо зорилготой, түүнийгээ хэрэгжүүлдэг хүний алсын хараа, хэтийн төлөвлөгөө ийнхүү хэрэгжсэн байдаг. Бас ард олон хийгээд журмын нөхдийнхөө итгэл даалгавраар энэ бүх ажилд томилогдож, хичээж зүтгэж ажилласан хэрэг.

Н.Алтанхуяг гэдэг хүнд бусдыг татах, бас уриалах хэд хэдэн онцгой чанар бий. Хэр барагтай бол хэл ам, хэрүүл уруул хийхгүй. Хэн нэгэнтэй энгэр заамандаа хүрэлцэж байгаагүй. Харин аливаа хүндрэл бэрхшээлтэй асуудлыг юуны өмнө олон хувилбараар тархин дотроо тунгаадаг. Физикч хүний давуу чанар ч байж болох. Ингээд хамгийн биелэгдэх магадлалтай хувилбарыг сонгодог. Мөн тэр хувилбар унавал дараа нь үүнийг санал болгоно гэсэн “жоорыг” заавал хадгална. Санаатай тарвага салаа нүхтэй гэдэг шиг. Энэ бол түүний ээжээсээ өвлөсөн чанар.

“Дуучин шувууны мах амтгүй” гэж дорно зүгийнхэн ярьдаг юм. Манайд уран гоё ярьдаг хүмүүс зөндөө бий. Гэтэл уран гоё яриа ихэвчлэн хоосон байх нь элбэг. Харин Н.Алтанхуяг уран гоё илтгээд байдаггүй. Тиймээс энгийн, бүүр хар үгээр ярина. Тэр нь ч иргэд бидэнд ойлгомжтой байдаг. Ер нь амьдралыг байгаагаар нь л ярьчихдаг нөхөр. Ямар ч гоёл чимэггүй. Тэрбээр олон жил намынхаа Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж, асар их туршлага хуримтлуулсан. Намынхаа гол холбон тоглогч, төлөвлөгч, найруулагч, нярав, нягтлан, ухуулагч, урагшаа зүтгэгч, уриалан дуудагч, сэлээсэр... Товчхондоо тэр бол маш сайн багийн тоглогч.

Олон удаа Эвслийн гэх нэртэй Засгийн газарт орж ажиллав. Бас толгойлов. Мөн түүнийг Ардчилсан намын дарга байх үед урьд хожид үзээгүй ялалтууд байгуулсан. УИХ-ын, Ерөнхийлөгчийн, Нийслэлийн, орон нутгийн сонгууль гээд энэ нам анх удаа таван удаагийн сонгуульд ялалт байгуулж, бүх шатандаа төр барих хэмжээнд хүрэв. Энэ бол ойлголтын зөрүүтэй хэсэг бүлгийг хооронд нь зохицуулж, ойлголцуулан, олон фракцын учир начрыг олж чаддаг байсан түүний онцгой авьяас, мэдрэмжийн хамгийн том жишээ. Баг хамт олноо атгасан гар шиг цул байлгаж, ажлыг нь хийлгэж чаддаг хүн бол Н.Алтанхуяг.

Асуудлыг шийдэх гарцыг хамгийн түрүүнд олж хардаг тэрбээр хариуцлагыг өөр дээрээ авахаас огтхон ч эмээдэггүй. Хамгийн гол нь ямар ч шүүмжлэлийг тэсвэр тэвчээртэйгээр хүлээж авах нь удирдагч хүний туйлын ховор чанар. Ер нь Н.Алтанхуяг улс орон, ард иргэдээ хаашаа хөтөлж яваагаа маш сайн мэддэг удирдагч. Тиймээс ч өнгөрсөн хугацаанд асар олон бүтээн байгуулалтыг хийж, эхлүүлж, хэрэгжүүлсэн БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ Ерөнхий сайд байв.

Одоо түүний тэр нэгэн цагт хийсэн “шатанд” хэдэн гишгүүр үлдсэн, мань эрийн толгойд ямар төлөвлөгөө байгаа, алсын хараа нь юу байгааг тааж мэдэшгүй. Гагцхүү Н.Алтанхуяг энэхүү “шатаа” улс орон, ард түмнийхээ төлөө хийсэн гэдгийг хэн ч хэлнэ. Ямар ч үед анд нөхөд, Ардчилсан намынхан, ард түмэнтэйгээ ХАМТДАА байх хүн бол Норовын Алтанхуяг. Тэр бол багийн тоглогч.

Улсын Их Хурлын гишүүн Ринчиннямын АМАРЖАРГАЛ ОНЦГОЙРОХ ШАЛТГААН



Нүдний шилнийхээ дээгүүр нэвт хардаг, хааяадаа хөмсгөө зангидчихсан явдаг энэ нөхрийн мөрөөдөл дэндүү гоё. “Ааш муутай” ч шударга үнэнийг хэлдэг учраас түүнд зарим хүн дургүй. Үнэндээ тэр дэндүү ихийг мэддэг учраас мэдлэггүйчүүдэд ааш муутай харагддаг юм. АНУ-ын долларыг дэлхий даяар “шүтэж” буйн адил тэр Монгол Улсынхаа мөнгөн тэмдэгтийг тахин шүтүүлэх мөрөөдөлтэй. Тэр мөрөөдлөө биелүүлэхийн тулд өөрийн хувь нэмрийг оруулах ёстой. Үүний л төлөө төрд хоёргүй сэтгэлээр зүтгэж иржээ. Гэхдээ түүний мөрөөдөл ганц Р.Амаржаргалын оролцоотой шийдэгдэхгүйд хамаг учир бий юм.

Ардчилалд шилжээд арав хүрэхгүй жилийн нүүрийг үзэж, Монголын эдийн засаг энхэл донхолтой асан үед гүйцэтгэх засаглалын тэргүүний ажлыг торох юмгүй хийж явсан тэрбээр тулгамдсан асуудлын шийдлийг тодорхойлж чаддаг, ярьж буй асуудлаа дэндүү сайн мэддэг нэгэн. Ийм л хүний үг өнөөгийн эдийн засгийн хямралт тогтолцооны үед ус, агаар мэт дутагдаж байна. Улс орны эрх ашгийн төлөөх ямар нэг шийдвэрлэх асуудлаас халгаад байдаггүй, зарчим, жанжин шугам ярьдаг улстөрч өнөөгийн улс төрд цөөн. Харин одоогийн парламентад байгаа тийм цөөн эрхмийн нэг нь Р.Амаржаргал юм. Тиймдээ ч “ангийн” нөхөд нь төсөв, эдийн засгийн асуудалд Амаржаргал ул суурьтай ярина даа хэмээн амыг нь харах нь бий.

Тэрбээр эдийн засгийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, Монголын эдийн засгийн шинжлэх ухааныг шинэ шатанд гаргах чиглэлд дорвитой ажил хийх нэгэн мөнөөсөө мөн. Өөрөө ч тэтгэвэртээ гарсны дараа 1990 оноос хойш өдийг хүртэл явж ирсэн шинэ үеийн Монголын эдийн засгийн түүх яаж өрнөсөн, яагаад ийм шийдвэр гаргасан, үүнээс өөр шийдвэр байгаагүй юу гэх мэтчилэнг улс төр, эдийн засгийн ухаан талаас нь шинэчилсэн анализ хийсэн бүтээл гаргана гэдгээ нэг бус удаа хэлж байв.

Би түүнд итгэж байна. Учир нь тэрбээр сурсан, мэдсэн, сонссон зүйлээрээ онцгойрдог. Мэдлэг, боловсрол, туршлагаараа ажлыг нугалж, асуудлыг шийддэг сэхээтнүүдийн нэг. Улс төрд түүний туулсан замнал, татсан шан нь онцгойрох шалтгаан юм. Зарчим ярьдаг ясны зан нь түүний имиж. Энэ ч утгаараа эдийн засгийн хямралт байдлыг өөрчлөх, зөв оношлох хүн бол Р.Амаржаргал мөн билээ.

Ардчилсан намын ҮЗХ-ны гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж, “УИХ-ын гишүүнээс минь хүртэл чөлөөлж өг” хэмээн “аархаж” явсан тэрбээр Монголын урдаа барьдаг эдийн засагчдын нэг яах аргагүй мөн. Түүнийг Ерөнхий сайдаар ажиллаж байх үед тухайн үеийн банк санхүүгийн шинэтгэл, төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, амьжиргааны доод түвшинг дээшлүүлэх талаар дорвитой ажил хийгдсэн гэж судлаачид дүгнэдэг юм билээ.

Түүний амжилтын нууц их энгийн гэж би боддог. Тэр нь өнөөг хүртэл өөрийн үзэл баримтлал, аав ээжийнхээ зааж сургасан, “өвлүүлсэн” зан чанараас ухраагүйд оршдог байх. Хэн нэгэнд таалагдах гэж явсангүй, өөрийн итгэл үнэмшил, зөв гэсэн зүйлдээ л найдаж, замнаж ирсэн нь өнөөдрийн Р.Амаржаргалыг бий болгожээ.

Армид ажилласан он жилүүд нь “мужик” Р.Амаржаргалыг бэлтгэсэн юм болов уу. Тэрбээр армид найман жил алба хаахдаа эдийн засгийн чиглэлийн сургалтыг эрхэлж, багшилж байв. Эндээс тэр оюуны, хувийн, сэтгэлгээний сахилга батыг өөрийн “хард диск”-тээ буулгаж чадсан. Үүнээсээ улбаалан тэгш байх, шударга байх, чигч байх, эх орныхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэх сэтгэл зүйгээр өвч бүрэн “тоноглогдсон” нэгэн. Иймийн учир л зөвийн төлөө хоёргүй сэтгэлээрээ зүтгэж яваа гэж түүнийг тодорхойлж болно.

Тэрбээр хариуцлага, шударга ёс байнга ярьдаг. Хариуцлага “үнэртэхгүй” байгаа учраас шударга ёс тогтохгүй байна гэж хэлдэг энэ эрхэм өргөө гэрийнхээ болоод намынхаа тулх багана нь юм. Ардчилсан намд Р.Амаржаргал байна гэдэг ардчилал амьд байгаагийн шинж гэж хэлж болно. Гэхдээ тэр улс төр дэх дараа дараагийн Р.Амаржаргалыг бэлдэх үйлсэд хойрго хандаж байна уу даа гэж би хардаг. Мэдлэгт суурилсан үзэл санааг төлөвшүүлэх, шударга ёсыг намдаа тогтоож чадсан хүн энэ нийгмийг авч явах ёстой гэж тэр үздэгийнхээ адилаар ийм боловсон хүчинг бэлдэх шаардлага бий юм. Энэ ёс суртахууны мандат, эрхийг тэр л нутагшуулж, төлөвшүүлж чадна.

Хүүхэд байхаасаа л эрдэм номыг эрхэмлэж ирсэн түүний амьдралыг номгүйгээр төсөөлөхийн аргагүй. Тэрбээр амралтын өдрүүдэд хамгийн багадаа дөрвөөс доошгүй ном уншдаг нь номтой хэр сайн нөхөрлөдгийг бэлхнээ харуулах биз. Аливаа асуудалд байр сууриа илэрхийлэхдээ ч асуудлыг олон талаас хардаг тэрбээр үзэл санааны лидер, ноён нуруутай улстөрч билээ.

Улсын Их Хурлын гишүүн Дашжамцын АРВИН ТҮҮНИЙ ЗАМ ДАНДАА ДАРДАН БАЙГААГҮЙ



УИХ-ын гишүүн Д.Арвин 1959 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт төрсөн. Түүний аав Монголын ардын арми, Зэвсэгт хүчний нэртэй дарга нарын нэг хурандаа Д.Дашжамц Дорнод аймагт томилолтоор ажиллах болсон учраас Д.Арвин 1971-1976 онд Чойбалсан хотын Н.Ф.Гастеллогийн нэрэмжит 10 жилийн дунд сургуулийг төгсөж, бүрэн дунд боловсрол эзэмшжээ. Улмаар 1976-1981 онд МУИС-ийн түүхийн ангийг түүхч, түүхийн багш мэргэжлээр дүүргэсэн байна.

Тэрбээр аавынхаа замналаар ажлын гараагаа армиас эхэлж, 1981-1987 онд Ардын армийн 221, 162 дугаар ангиудад ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн даргаар томилогдон 1982, 1986 онуудад Цэргийн нэгдсэн дээд сургуулийн дэргэдэх Офицериин мэргэжил дээшлүүлэх дээд курсыг төгсгөж, офицериин албанд нэр хүндтэй ажиллажээ. Дараа нь бизнест хөл тавьж, 1991-2000 онд Барилга, худалдаа, аялал жуулчлалын “Их өргөө” компанийг үүсгэн байгуулж, захирлаар нь ажилласан аж. Улмаар их улс төрд орж, 2000 оны УИХ-ын ээлжит сонгуулиар УИХ-ын гишүүнээр сонгогдсоноос хойш өнөөдрийг хүртэл төрийн түшээгээр дөрвөнтөө сонгогдон ажиллаж байгаа мэргэшсэн парламентч гэж хэлж болно.

Түүхч мэргэжилтэй, армийн гялалзсан офицер түүнд тэвхийсэн шинель нь гайхалтай зохиж, сониуч олны хараа булаадаг байсан тухай хэн нэгнээс сонсож байлаа. Тэрбээр эвлэлийн хороон дарга хийж, залуу бага насандаа армид ихийг амжуулсан эршүүд дайчин бүсгүй. Олон хүүхэдтэй айлын ууган охин Д.Арвины амьдралд багаас үүрсэн ачаа их гэдэг юм билээ. Аавыгаа өөд болсноос хойш ахуй амьдралаа залж явах үүрэг оногдсоноор “Их өргөө” компаниа байгуулж, олон айлыг байртай болгосон бүтээн байгуулалтын түүх бий. Барилгын ажлын

хүнд хүчрээс тэр огт халгаагүй л барьж авчээ. Тэгээд санасан бодсоноо амжуулж чадсан аж.

Хүссэн хүн бүрийн, тэр тусмаа эмэгтэйчүүд тэр бүр амжилт олоод байдаггүй монгол төрийн сэнтийд завсаргүй дөрвөнтөө сонгогдоод буй энэ хатагтайн улс төрийн зам тийм ч дардан байгаагүй. Гэхдээ түүнийг 2012 оны УИХ-ын ээлжит сонгуульд хотын хамгийн том тойрог болох Баянзүрх дүүргээс ялаад гарч ирэхэд хүний, өөрийн намынхан нь эрхгүй хүлээн зөвшөөрсөн юм. Хар багаас оюун бодлоо төвшитгэж сурсан бодлууд нь Д.Арвин хатагтайг ийм амжилтад хүргэсэн биз ээ.

Өнгөрсөн сонгуулийн үеэр тэрбээр олон ч үг хэвлэлээр дайж, хар цагаан пиар ч хийгээгүй гэдэг. Намын нөхдийнхөө хүйтэн хандлага, хүнийрхүү сэтгэлийг алхам тутамдаа мэдэрч байсан Д.Арвин уйлан дуугарч, нугарч хугаралгүй даван гарч, сонгогч олныхоо итгэлийг өвөрлөн УИХ-ын танхимд нүүр бардам орж ирсэн нь эмэгтэй хүнд тэр бүр заяадаггүй түүний эршүүд зан, дайчин чанарын илрэл гэлтэй. Магадгүй тэрбээр улам ч хатуу байхыг өөртөө андгайлж, бүсээ чангалж, сэтгэлээ хатуужуулж явсны ач тус болов уу.

Олны өмнө үгийг нь хэлүүлэхгүй хааж боож, илтэд гадуурхах намын нөхөддөө гомдож, хоолой зангирахын амаргүйг эмэгтэй хүн л болсон хойно амссан нь мэдээж. Ядаж байхад Баянзүрх дүүрэг дэх сонгууль дахиж, бас л хэдэн сар нурууг нь тэнийлгээгүй. Тэр хооронд юу эс болсон гэхэв. Өрсөлдөгчийнх нь зүгээс байсгээд л амар заяаг нь үзүүлэхгүй элдэв дайралтууд хийж, тэвчээрийг нь шалгасаар байсныг хэвлэлийн шарласан хуудсууд өнөө ч гэрчилнэ. Нөгөө талаар улс төрд олон жил явсан Д.Арвин гишүүний хувьд энэ мөчүүд нь эргэн харахад өөрт нь чамгүй их ухаарал, хатуужил өгсөн, улстөрчийн хувьд өөрийгөө таньж, мэдрэхэд нь тус болсон их эргэлт, сонголтын үе байсан мэт санагддаг.

Улс төр бол улс төр. Энэ хатагтай тэрхүү замаар зөвхөн өөртөө итгэж, өөрөөрөө л байж иржээ. Зүтгэл чармайлтынхаа ачаар хэдхэн сарын өмнө үүдээ нээсэн “Амгалан” төрөх эмнэлгийн барилгад шаардлагатай хөрөнгө мөнгийг УИХ-аар шийдүүлж, Баянзүрх дүүргийн эхчүүд, эмэгтэйчүүдийн магнайг тэнийлгэсэн ачтай нэгэн. Хүч, сэтгэл зүтгэл тавьж ашиглалтад оруулсан энэхүү эмнэлгийн нээлтийн үеэр тэрбээр туйлын сэтгэл хангалуун харагдсан. Ямартаа ч түүний сэтгэл, зүтгэлийн үр дүнд Баянзүрх дүүргийн эмэгтэйчүүд орчин үеийн, тохилог 7 давхар төрөх эмнэлэгтэй болж, Монголын 3 сая дахь иргэний үе чацуутнууд тэнд дуу хадаан хорвоод мэндэлж байгаа нь юутай ч зүйрлэшгүй буянтай үйл билээ.

Д.Арвин энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд гурван байнгын хорооны бүрэлдэхүүнд орж ажилласны зэрэгцээ УИХ дахь Монгол-Буриадын парламентын бүлгийн дарга, Монгол-ОХУ, Монгол-Лаосын парламентын бүлгийн гишүүнээр ажиллажээ. Олон хууль тогтоомжийн төслийг журмын нөхөдтэйгөө хамтран боловсруулж, олон хуулийн төслийн ажлын хэсэгт орж, зарим ажлын хэсгийг ахалж ажилласан байна. Тэр дундаа хүүхэд, эмэгтэйчүүд, байгаль хамгаалал, иргэдийн амьжиргаа, ахуй амьдралтай холбоотой асуудалд голлон анхаарч, санаа бодлоо нэмэрлэж, шийдвэр гарч арга замыг олохыг хичээж ирсэн аж.

Монголын төрд 16 жил хийсэн ажил, хэлсэн үгтэй зүтгэж яваа Дашжамцын Арвин хатагтайн тухай цухас өгүүлэхэд ийм буюу. Түүний оронд өөрийгөө тавиад үзэх аваас бас л амаргүй төсөөлөгдөх ажээ.

Улсын Их Хурлын гишүүн Октябрийн БААСАНХҮҮ ХОЛЫН ЗОРИЛГО АМЖИЛТАД ХӨТӨЛНӨ



УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Хүн хэчнээн хол зорилго тавина, тэр хэрээр амжилт ирдэг гэж боддог” хэмээн нэгэн ярилцлагадаа дурдсан нь бий. Өөрийнх нь намтар ч үүний бодит биелэл гэж хэлж болно.

Октябрийн Баасанхүү Сонгинохайрхан дүүргийн 42 дугаар сургуулийг дүүргэсэн. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хоёрдугаар курсийн оюутан байхаасаа хуулийн зөвлөх хийж эхэлсэн тэрбээр 1997 онд их сургуулиа онц дүүргэжээ. Шинэхэн эрх зүйч ажил, хөдөлмөрийн гараагаа багшаар эхэлсэн түүхтэй. Гэхдээ алдаж эндсэн нэгнийг түшдэг аврал нь болсон өмгөөлөгчийн ажлыг хийсээр байжээ. Намтрынхаа энэ үеийг тэрбээр “Хүний эрхийг хамгаалж, цагдаа, шүүх, прокурортой нь хуулийн хүрээнд “байлдаж” явсан үе” хэмээн тодорхойлсон удаатай. Түүний туршлага нэгэн арваны дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүний эрхийн орон тооны бус зөвлөлийн гишүүний хэмжээнд үнэлэгдэн, ажил хөдөлмөрийнх нь талбар “Advocates International” олон улсын байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгч, Монгол Улс дахь Япон Улсын Элчин сайдын яаманд хуулийн зөвлөх болж өргөжсөн аж.

УИХ-ын зургаа дахь удаагийн сонгууль дэлхийн ихэнх орны хэрэглэж буй холимог тогтолцоогоор явагдсанаар “МАХН-МҮАН-ын Шударга ёс” эвслээс нэр дэвшиж өрсөлдсөн О.Баасанхүү өмгөөлөгч намын жагсаалтаар төрийн түшээгээр сонгогдож УИХ-ын гишүүний тангараг өргөв. Улс төрийн тогоонд тэр шинэ хүн байсан байж болох ч харин хууль тогтоох дээд байгууллагад туршлагатай хуульч байв. Тиймдээ ч “Шударга ёс тогтоохын төлөө ажиллана. Шударга ёс гэж миний бодлоор хуульд нийцсэн үйлдэл, тиймээс хууль шударга байх ёстой. Хууль тогтоох байгууллагад ажиллаж байгаагийн хувьд шударга хууль гаргахын төлөө тэмцэх болно” хэмээн хэлж байв.

Тэрбээр хүний эрхийг хамгаалж, иргэдийн эрх чөлөөний зохицлыг хангаж, амьдралд нийсэн хуулийг санаачлан УИХ-аар батлуулж, хэрэгжүүлэх зорилгынхоо

хүрээнд 2012-2016 онд нийт 32 хууль, тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлжээ. Тухайлбал, 2000-3000 хүнд яаралтай тусламж, 1000-2500 хүнд мэс заслын, 100-250 мянган хүнд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг хангасан Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн барилгыг зориулалтаар нь ашиглалтад оруулах асуудлыг хөндөн Засгийн газарт үүрэг өгөх тухай УИХ-ын тогтоолын төсөл санаачилж батлуулжээ. Мөн үүрэн холбооны сүлжээнд “дугаартайгаа шилжих үйлчилгээ”-г нэвтрүүлэх харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хийж, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөөнийг зөв хэлбэрээр нэмэгдүүлэх ач холбогдол бүхий Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсныг Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй нэгтгэж баталсан юм. Түүнчлэн Тамхины тухай хуулийн зарим зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл зэргийг санаачлан боловсруулжээ. Үүний зэрэгцээ хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэд хэдэн хэсэгт багтаж ажилласан байна.

Хууль тогтоох дээд байгууллагын нүсэр ажлын дундуур О.Баасанхүү гишүүн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зарчмыг тууштай баримталж, өөрийн үйл ажиллагааны нэг чиглэл болгон ажиллаж ирсэн. Энэ хүрээнд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, хууль ёсыг даган мөрдүүлэх үүднээс барилгын ажлын явцад хүний эрх зөрчигдөж байгаатай холбогдуулан хууль, тогтоолын хэрэгжилт, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа эсэхэд хяналт тавих зэргээр иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн олон ажлыг амжуулж ажиллажээ.

Иргэд, УИХ-ыг холбосон Өргөдлийн байнгын хороог тэргүүлж ажилласнаар нь түүний үүрэг хариуцлага даах, ажил хэрэгч чанаруудыг илэрхий харж болно. Хууль тогтоох болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, нийгмийн болон парламентат ёсны хөгжлийн бодит шаардлагаар олон улсын жишгийн дагуу байгуулагдсан Өргөдлийн байнгын хороог О.Баасанхүү гишүүн нэг жил даргалж ажилласан. Эрчтэйхэн ажилласан энэ хугацаанд байнгын хорооны дүрмийг шинэчилж, нэг аймгийн иргэдээс нэг сарын хугацаанд 100-гаас дээш өргөдөл ирүүлсэн тохиолдолд тухайн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдэд танилцуулан саналыг нь авч ажилладаг, нэг аймаг, дүүргээс 500-гаас дээш өргөдөл ирүүлсэн тохиолдолд Байнгын хорооны гишүүд газар дээр нь очиж танилцдаг, 900-гаас дээш иргэний гарын үсэгтэй өргөдөл ирүүлсэн тохиолдолд Байнгын хорооны хуралдаанаар шууд авч хэлэлцдэг болгов. Энэ хүрээнд тэрбээр иргэдийн өргөдлийн дагуу Архангай, Хөвсгөл, Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Завхан, Ховд, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Дорнод, Өмнөговь аймгуудад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдаг.

Өргөдлийн байнгын хороог “амилуулж”, үйл ажиллагааг нь эрчимжүүлэн хэлэлцүүлэг, ажил хэргийн уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байв. Түүгээр ч барахгүй цахим хуудсаараа дамжуулан өргөдөл хүлээн авч шийдвэрлэн хариуг нь шуурхай мэдээлдэг шинэ системийг нэвтрүүлэн амьд холбоог бүрдүүлж чадсан ажил хэрэгч, санаачилгатай, зорьсноо хэрэгжүүлэхийн төлөө тууштай зүтгэдэг түшээ.

Улсын Их Хурлын гишүүн Агипарын БАКЕЙ

ТҮШИГ, ЗАНГАРАГ



Баян-Өлгий аймгаас 2012 онд парламентын гишүүнээр сонгогдсон А.Бакей парламентын бүрэн эрхийн хугацаанд Байнгын хорооны даргаар тасралтгүй дөрвөн жил ажилласан гишүүн. УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей энэ хугацаанд Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай, Төрийн аудитийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг есөн хуулийн төслийг УИХ-ын бусад гишүүдийн хамт боловсруулж өргөн барьжээ.

Мөн Нийгмийн даатгалын сангийн тухай, Хүний хөгжил сангийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай зэрэг 35 хуулийн төслийн ажлын хэсгийн ахалж, заримд нь ажлын хэсгийн гишүүнээр ажиллажээ. Түүнчлэн одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Сонгуулийн тухай хуулийг батлуулах ажлын хэсэгт орж зүтгэсэн хүмүүсийн нэг нь. Тэрбээр Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, төрийн албанд “мерит” зарчмыг мөрдүүлэх талаар зүтгэл гаргасан нэгэн.

Алга дарам газрыг ч мөнгө болгож харсан сувдаг сэтгэлтнүүд төв, суурин газрын олон ч сургууль, цэцэрлэгийг газаргүй болгож, хүүхэд багачуудын тоглох талбайгаас хумсалсан. Өнөөдөр ч энэ байдалд цэг хатгаж чадаагүй л байна. 2004-2008 оны УИХ Боловсролын тухай багц хуульд өөрчлөлт оруулж, боловсролын байгууллагыг газрын төлбөрөөс чөлөөлснөөр эзэмшил газар руу улайм цайм дайрдаг байсан балмад явдалд багагүй хориг, хязгаар тавьж чадсан юм. Энэ санааг А.Бакей гишүүн тус хуульд шигтгэсэн гавьяатай нэгэн.

Түүнийг “үндэсний цөөнх казах иргэдийн төлөөлөл” гэдгээр л тодорхойлбол хэт өрөөсгөл болох биз ээ. Учир нь боловсролын байгууллагад 25 жил хүчин зүтгэсэн эл эрхэм салбартаа элэгтэй байж, санаа тавьж иржээ. Ингэхдээ

2004 оноос хойш Баян-Өлгий аймаг дахь сургууль, цэцэрлэг, дотуур байрны хөрөнгө оруулалтад юун түрүүнд анхаарал хандуулж, цөөнгүйг бий болгож, олон хүүхдэд сурч, боловсрох таатай нөхцөл бүрдүүлжээ. Саяхан баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичигт өөр хэл бүхий үндэсний цөөнх нь өөрийн хэл дээр сурч боловсрох эрхтэй гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тунхаг төдий, бүдэг тусгасан байсныг казах иргэд суурь боловсролыг эх хэл дээрээ эзэмшиж, дараагийн шатны боловсролыг хос хэлээр судлах боломжтой гэсэн агуулгаар баяжуулж, тун тодорхой хуульчлахад А.Бакей гишүүн идэвх, санаачилгатай ажилласан. Цаашид төв, суурин газар амьдарч буй казах иргэд эх хэлээ сонгож суралцах боломж бий болгоход анхаарч буй юм билээ.

Энэ бүхнийг алс баруун хязгаарт буй сонгогч түмнээ эргэж тойрч, санал бодлыг нь сонсох үеэр илүүтэй мэдэрч, мартах учиргүйгээ ухаардаг гэсэн. Түүнийг тавдугаар ангид байхад эцэг, эх нь хаврын их ажилд туслуулахаар сургуулиас нь хэнэггүйхэн аваад явчихсан гэсэн. Тавдугаар ангийн хичээлийнхээ талд суулгүй, цаашлаад зургадугаар ангийнхаа эхний улирлыг хийдүүлж, хөдөө хонь хариулаад явж байхдаа багийн даргадаа баригдаж, сургууль, боловсролын замд эргэж буцалтгүй орсон тухайгаа тэрбээр дурссан нь бий.

Магадгүй тэр малчин болоод хоцорсон бол Монголд шинжлэх ухааны доктор нэгээр дутах байсан биз. 23 жилийн өмнө эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалсан тэрбээр оны өмнөхөн зэргээ ахиулж, “Монголын бэлчээрийн аж ахуйн тогтвортой хөгжлийн онол, арга зүйн зарим асуудал” сэдвээр шинжлэх ухааны доктор болсон байна. Хөдөө аж ахуйн эдийн засагч мэргэжилтэй тэрбээр салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулахад санаачилгатай ажиллаж иржээ. Энэ удаагийн парламентын баталсан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, Үндсэн хуулиар төрийн хамгаалалтад байна гээд тунхаглачихсан мал сүргийг зах зээлийн зарчимд нийцүүлэн эрсдэлээс хамгаалах эрх зүйн боломжийг бий болгоод байна. Түүнчлэн Хүнсний тухай, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг батлах ажлын хэсэгт ажиллажээ.

Тэрбээр 2004-2008 оны парламентад Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажиллаж байв. Ингэхдээ байгаль орчныг хамгаалах нь зөвхөн төрийн үүрэг гэсэн үзэл баримтлалыг шинэчилж, энэ чиглэлд олон нийтийн хариуцлагыг дээшлүүлэх үндсийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. 1990-ээд оны үед ХААИС-д багшилж байхдаа бусад багшийн хамт малыг хэрхэн хувьчлах талаар санал боловсруулж байсан юм билээ. Энэ бүхнийг нь төрөөс үнэлж, гавьяат эдийн засагч цолоор шагнасан байна.

Тэрбээр хөдөө аж ахуйн эдийн засагч мэргэжилтэй ч үе үеийн парламентад хамгийн их улстөржиж, үл ойлголцох гээд байдаг засаглал, тогтолцоо, төрийн байгууллага, тэдгээрийн хоорондын харилцааны түвэгтэй асуудлууд овоордог Төрийн байгуулалтын байнгын хороог энэ УИХ-д сонгогдсоноосоо хойш удирдаж буй. УИХ-ын бүтцийн байгууллага болох Байнгын хороодын удирдлагад жилдээ нэг салхи оруулдаг ч энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд тасралтгүй Байнгын хороо удирдах эрх олгосоор ирсэн нь түүний ажлыг үнэлэх нэгээхэн үзүүлэлт болох биз ээ.

Улсын Их Хурлын гишүүн Нямжавын БАТБАЯР
СЭТГЭЖ, САНААЧЛАХЫН ЗАГВАР



«Хүүхдийн мөнгө» өнөөдөр монголчуудын амин хэрэгцээ байсаар байна. Анх хүүхдийн мөнгө батлагдаж, хэрэгжүүлэх болоход «Өгөх мөнгө нь хаана байна» гэдэг асуудал хурцаар тавигджээ. Үнэндээ тэр үед өгөх мөнгө Монгол Улсад байгаагүй юм. «Хүүхдийн мөнгө» үлгэр болдгийн даваан дээр эх үүсвэрийг нь ингэж олъё хэмээн сэтгэсэн хүн бол УИХ-ын гишүүн Н.Батбаяр буюу «Фортуна» билээ. Олон улсын зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс үүдэлтэй гэнэтийн ашгийг татваржуулах замаар эх үүсвэр бүрдүүлэх Н.Батбаярын санаачлага ийнхүү ажил хэрэг болсноор Монголын ирээдүй болсон хүүхэд бүрт «Хүүхдийн мөнгө» олгогдож эхэлсэн түүхтэй.

Н.Батбаяр Орост эдийн засгийн мэргэжил эзэмшсэн хүн. Тийм ч учраас Монголын эдийн засгийн том бодлогуудтай түүний нэр ямар нэг байдлаар ямагт холбогддог. МАН-ын үед Чингис бондын мөнгийг хэд дахин үржүүлсэн өр зээл тавигдаж үрэн таран хийгдсэн бол Н.Батбаярын олж ирсэн «Чингис бонд»-ын мөнгө бодит бүтээн байгуулалт болсон. Аймгуудыг холбосон зам тавигдаж, «Гудамж» төсөл хэрэгжиж, салбар бүрт үндэсний томоохон үйлдвэрүүд байгуулагдлаа. Цементээ гаднаас авах бус гадагшаа экспортлох хэмжээнд хүртлээ үйлдвэрлэл хөгжиж байна.

«Америкт хардаг гудамжийг Архангайн төвд харлаа» гэсэн сэтгүүлчийн тэмдэглэл саяхан нэг сонинд нийтлэгджээ. Эдийн засаг, төсвийн байнгын хорооны гишүүний хувьд Н.Батбаяр тойрогтоо хөрөнгө оруулалт татах, нутагтаа бүтээн байгуулалт хийх тал дээр хэнийг ч урдаа гишгүүлэхгүй. Анх нэр дэвшихдээ малчин айл өрхийг «Гэрэлтэй, худагтай, утастай» болгох хөтөлбөр дэвшүүлж байсан тэрбээр энэхүү санаачлагынхаа төлөө зүтгэсээр ирсний хүчинд өнөөдөр малчид нарны гэрэлтэй, зурагтай, гар утастай болж, хөгжилд хөл нийлүүлэн

амьдарч байна.

Тэр ерээд оны шинэ нийгмийн улс төрийн магнайд явсан нэгэн. Ерэн оны анхны Үндсэн хуулийг батлалцаж, нийгмийн хувьсал өөрчлөлтийн түүхэн үед АИХ-ын орлогч даргаар ажилласнаараа өнөөдрийн улстөрчдөөс ялгарна. Тиймдээ ч өнөөгийн улс төр, нийгэмд болж бүтэхгүй байгаа зүйлийг бусдаас түрүүлж хардаг, асуудлын шийдлийг олж чаддаг. Улс төрийн гацаанаас гарч, хөгжлийг түргэтгэх цор ганц арга зам бол Үндсэн хуулиа шинэчилж, ард иргэд нь сумын Засаг даргаа сонгодог, Ерөнхий сайд нь Засгийн газраа толгой мэдэж бүрдүүлдэг, эрх мэдэл, үүрэг хариуцлага нь тодорхой тийм тогтолцоонд шилжих ёстой хэмээн хуулийн төсөл боловсруулаад буй. Ингэхдээ парламентад суудалтай бүх намын төлөөлөл багтсан ажлын хэсгийг ахлан мэргэжлийн судлаач, академичдийн саналыг тусгаж, жил гаруй хугацаанд ажиллажээ. Өнөөдөр Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудал яах аргагүй олны анхаарлын төвд багтаж, одоогийн болон 2016 оны сонгуулиар гарч ирэх УИХ-ын түүхэн үүрэг хариуцлагыг тодорхойлох асуудал болж хувираад байна.

УИХ-ын гишүүн Н.Батбаярын малчдыг дэмжсэн бодлогын үр дүнд малчдад ноос, арьс ширний урамшуулал өгөхөөр болж, малчдын худаг усны асуудал төрийн анхааралд очиж, тэр байтугай малын хулгайтай тэмцэх асуудал ч түүний анхаарлын гадна үлдээгүй. Малчдыг зээлийн хүүний дарамтаас салгаж жилийн 30 хувийн малчны зээлийн хүүг 10 хувь болгон бууруулсан «Сайн малчин» хөтөлбөр ч мөн л Батбаяр гэсэн автортой.

Өнөөдрийн энэ их барилгажилт, орон сууц бий болох анхны шанг мөн л Н.Батбаяр тавьсан юм. Одоогоос арав гаруй жилийн өмнө тэрбээр Барилга, хот байгуулалтын сайд байхдаа «40 мянган айлын орон сууц» хөтөлбөрийг дэвшүүлэхэд нь нэг танхимд тохой залган суусан журмын нөхөд нь «Үлгэр дээ» гэсэн байдаг. Өнөөдөр харин тэр «үлгэр» нь биелж, бүр «100 мянган айлын орон сууц» болж хэрэгжсэн. Бусдаас хол түрүүлж харна, бодлого гаргана, ярина, хэрэгжүүлнэ гэдэг энэ.

Эдийн засгийн хөгжлийн сайд байхдаа ОХУ, БНХАУ-ыг Монголын тал нутгаар дамжуулан холбох «Талын зам» төслийг санаачлан хоёр хөршийн удирдагч Путин, Си Зинпинь нарыг 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдөр нэгэн зэрэг Монгол Улсад урьж авчран «Талын зам» төслөө танилцуулна хэмээн зүтгэж явсан хүн. Эцэст нь БНХАУ-ын Дарга Си Зинпинь 2014 оны 08 дугаар сарын 21-нд, ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 2014 оын 09 дүгээр сарын 03-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, олон асуудлыг шийдвэрлэснийг бид мэднэ. Төд удалгүй Путин, Си Зинпинь хоёр хоёулаа олон улсын тавцанд Монголын талаас санаачилж буй «Талын зам» төслийг дэмжин ажиллахаа мэдэгдэж байв.

Н.Батбаяр гишүүний зөвхөн «Хүүхдийн мөнгө», «Чингис бонд», «Гудамж» төсөл, «40,000 айлын орон сууц» хөтөлбөр, «Талын зам» төсөл, «Сайн малчин» хөтөлбөр гээд санаачилж хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй ажлуудынх нь наад захын эдийн засгийн бодит үр дүнг хэн ч харсан «Энэ нөхөр чинь үнэхээр эдийн засагч юм байна» гэж тодорхойлох нь мэдээж.

Улсын Их Хурлын гишүүн Сундуйн БАТБОЛД ТӨРИЙН ХҮНИЙ НОЁН НУРУУ



Монголын парламентад туршлага, мэдлэгээрээ илүүрхэж, хэлэлцэгдэж байгаа гол гол хуулийн төслийн усыг шавхаж, төрийн ачаанаас түүртэлгүй үүрч, асуудлын голыг олж, байр сууриа хатуухан хамгаалчихдаг цөөн хэдэн улстөрч бий. Тэдний нэг нь Сундуйн Батболд. Дөрвөн парламентад дараалан сонгогдсон эрхэм гишүүн улс төрийн хүрээнд хэлье гэснээ хэлчихдэг, туйлшраад байхгүй, өөрийнхөөрөө, буйр суурьтай, төрийн өндөр албан тушаалыг хашихад ажлын дадал, туршлага, мэдлэг чадвар хамгийн сайн хань болдгийн жишээг залуу гишүүдэд харуулж яваа нэгэн. Түүний үеийн улстөрчид энэ цаг үеийн, нийгмийн өнгийг тодорхойлж, хувь хүн талаасаа ч, хийж бүтээснээрээ жинхэнэ утгаар үлгэр дууриал үзүүлэх насан дээрээ ирцгээжээ.

Су.Батболд гишүүн төрийн хүний ноён нурууг илтгэх цэгцтэй намба, хувь хүний ноён нуруугаа хадгалж, элдэв дуулианд нэр холбогдож, намба алдсан нь үгүй. Нутгаа, аймгаа, улс орноо, олон түмнээ гэсэн сэтгэлээр 14 дэх жилдээ их улс төрд зүтгэж, нөхөддөө монгол төрийн тулхтай түшээдийн нэг хэмээн үнэлэгдэж иржээ. Итгэл даадаг болохоор нь, зон олондоо элэгтэй учраас ачаа үүрч, амласнаа биелүүлчихдэг, асуудалд голч, шударга хандаж, хэнийг ч ялгалгүй жаргал, зовлонг нь анхааралтай сонсч, яаж ийгээд тус хүргэхийг хичээдэг энэ эрхэмд нутгийнхан нь дөрвөн удаа итгэл өгч УИХ-д сонгосон байх. Су.Батболдод итгэж үүрүүлсэн ачаа, аль нэг ажил, үүрэг ямагт ном журмын ёсоор гүйцэлддэг гэдгийг төрийн хэмжээнд ойлгодог, мэддэг болсон. Тэглээ гээд тэрбээр омогшиж эвдрээгүй. Ааш зангийн хувьд, анд нөхөдтэйгээ харилцахдаа, анх их улс төрд хөл тавихдаа ямар байсан, тэр л янзаараа яваа нь бахархууштай.

2002-2016 онд эрхэм гишүүн УИХ-ын зүгээс Үндсэн хуулийн цэцэд гаргах

маргаан, тайлбарыг гардан хийж, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэх бүрт УИХ-ын гишүүд өөрсдийн цалин хангамжийг нэмэгдүүлэх асуудал яригддагыг эцэслэхээр Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн УИХ тогтоож байх заалт оруулж байлаа. Мөн зарим нэг гишүүдийн эв хавгүй ааш авирыг цэгцлэх УИХ-ын гишүүний Ёс зүйн дүрэм, Монгол Улсын эдийн засгийн суурь салбарын хөгжлийг түргэтгэх “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Монголын ардчиллын хөгжилд шинэ хуудас нээсэн Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль зэргийг батлахад тэр чухал үүрэгтэй оролцсон. УИХ-ын гишүүдийг ёс зүйн дүрэмтэй болгох асуудал 2000-2004 оны парламентын үеэс яригдаж эхэлсэн. Харин Су.Батболд 2004-2008 оны УИХ-д Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа АНУ-ын Бүгд найрамдахчуудын хүрээлэнтэй хамтран ёс зүйн асуудлаар сургалт, семинар зохион байгуулж, АНУ-аас ёс зүйн талаар мэргэшсэн зөвлөх урьж, ёс зүйн дүрмийг боловсруулах, тус ажлын хэсгийн гишүүд бусад улс орны парламентын гишүүдийн ёс зүйн дүрмийг судлах ажлыг амжуулж, 2009 оны хавар УИХ-ын ёс зүйн дүрмийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар батлуулж байв.

Өнгөрч буй дөрвөн жил Монголын улс төр, парламентад олон халуун үйл явдал өрнөсөн нэлээд ярвигтай он жилүүд байв. УИХ-д сөрөг хүчний үүрэг гүйцэтгэсэн МАН-д эрх баригч АН-ын дураараа аашлах, хуулийг санасныхаа зоргоор өөрчлөх гэсэн этгээд авирыг таслан зогсоох хүнд үүрэг ногдсон гэж хэлэхэд болно. Улс оронд хэрэгтэй, ирээдүйг чиглэсэн шийдвэр гаргахад тэнцвэртэй хандах, төрийн бодлого, залгамж халааг шоргоолжны үүр шиг эвдүүлэхгүй гэсэн хатуу байр суурийг Су.Батболд гишүүн энэ хугацаанд баримталж иржээ.

Үүний зэрэгцээ иргэд олон түмэнд өгөөж тустай хуулийн төслүүдийг санаачлан УИХ-аар батлуулсан бол зарим нь хараахан УИХ-аар хэлэлцэгдэж амжаагүй байгаа аж. Түүний санаачилсан хуулиуд нийгмийн ачааны хүндийг үүрч дүүрч яваа салбар, иргэд рүүгээ чиглэсэн байдаг. Эдгээрээс онцлоход Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг дурдаж болно. Уг хуулийн төсөлд улс орны эдийн засгийн уламжлалт салбар мал аж ахуйд ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцохтой дүйцэхүйц арга хэмжээ болгон 1995 оноос хойших 20 жилийн хугацаанд төлөгдөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх боломж олгох зохицуулалт хийхээр тусгажээ.

Хэрэв энэ хууль батлагдвал Монгол Улсын эдийн засаг, хүн амын хөдөлмөр эрхлэлтэд томоохон байр суурь эзэлдэг, дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг дангаараа үйлдвэрлэдэг мал аж ахуйн салбарт ажилладаг малчдын амьдралд өгөөж тустай төрийн чухал шийдвэр болох ажээ. Учир нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид малчид нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах боломжтой ч орлогын түвшин доогуур, мал аж ахуйн үйлдвэрлэл улирлын чанартайгаас сар бүр шимтгэл төлөх боломжгүй зэргээс шалтгаалан даатгалд хамрагдаж чадахгүйд хүрдэг. Иймээс энэ салбарт хөдөлмөр эрхэлж буй хүн амын 30 орчим хувийг эзэлж, нийт өрхийн 20 орчим хувь нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьжиргаагаа залгуулдаг малчдаа төрийн бодлогоор дэмжих үүднээс эрхэм гишүүний ийм нэг гарцыг олж харжээ.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын БАТБОЛД СОЁЛТОЙ УЛСТӨРЧИЙН ЖИШИГ



МАН-д байдаг нэг сайн тал нь боловсон хүчнээ үе үеэр нь бэлтгэн гаргаж улс төрд оруулдаг явдал. Цаашаа хол явна гэж үзсэн залуусаа МАН-ынхан дэд сайд, газар агентлагийн дарга, нийслэлийн удирдлага зэрэгт ажиллуулан төрийн ажилд гаршуулж байгаад том улс төрд хүч үзүүлдэг нь их сайн тал. УИХ-ын 2004 оны сонгуулиар эрч хүч дүүрэн нэгэн шинэ үеийнхэн парламентад хүч түрэн орж ирсэн юм. Тэд бол Сү.Батболд, Ц.Мөнх-Оргил, М.Энхболд тэргүүтэн байлаа. Сү.Батболд тэгэхэд Гадаад хэргийн дэд сайд байгаад УИХ-д орж ирж байв.

Анх төрийн түшээ болохдоо тэрбээр хэдийнэ монголчуудад тустай олон сайн үйлсийн автор болчихсон байлаа. Дотоодод үйлдвэрлэсэн барааг хил алгасуулан наймаалах юм гэж хэрийн хүний санаанд ороогүй байх үед Гадаад хэргийн дэд сайд Сү.Батболд Европын Холбооны 25 оронд “Made in Mongolia” шошготой 7200 нэр төрлийн барааг 10 жилийн турш татваргүй гаргах эрхийг олж авсан юм. Сансрын хөлгийн эд анги зэрэг Монголд хийнэ гэхэд арай л эртдэх зарим нэг зүйлийг эс тооцвол дотоод бараа гадагш гарах эхлэлийг түүгээр тавьсан. Тэр бол 2000-аад оны эхэн үе байв. Богинохон хугацаанд татваргүй бараа экспортлох тогтолцооны хүрээнд Европын 25 улсын зах зээлд монголчууд 70 сая ам долларын бараа бүтээгдэхүүн нийлүүлж байжээ.

АНУ-д хөл тавих гэдэг диваажинд морилохоос илүү мөрөөдөл байсан тэр цагт Гадаад хэргийн дэд сайд Сү.Батболд АНУ-аас Монголд сууж асан Элчин сайд Жон Дингерийн хамт дипломатч хүний хүчин зүтгэл гаргаснаар монголчуудыг 10 жилийн визтэй болгож билээ. Гадаад паспорт дээрээ АНУ-д зорчих 10 жилийн хугацаатай виз даруулж байсан иргэд түүнийг Сү.Батболд гишүүн хөөцөлдөж зөвшөөрүүлсэн юм гэдгийг тэр бүр мэдээгүй л байх.

Сү.Батболд бизнесмэн хүний хувьд нэлээд дээхнэ Тавантолгойн лицензийг авч, нүүрсний энэ том ордыг монголчуудынхаа мэдэлд байлгаж, төрд шилжүүлж

чадсан нь түүний томоос том гавьяа мөн билээ. Цатгалан хүн өлсгөлөнгийн, морьтой хүн явганы зовлонг мэддэггүй юм гэнэ лээ. Сү.Батболд гишүүн хөлсний үнэ цэнийг мэднэ. Тэрбээр УИХ-аар орлого багатай, амьдралын боломж тааруу иргэддээ хүнсний хөнгөлөлт эдлүүлэх хөтөлбөрийн төслийг санаачлан хэлэлцүүлж байсан удаатай. Энэ эрхэм Монгол Улсын Гадаад харилцааны яамыг нэг хэсэг толгойлохдоо гадаад харилцааг эдийн засагжуулах гэсэн нэр томъёог гаргаж, тэр чиглэлээр ажилласан нь цоо шинэ алхам байв.

Засгийн газрын тэргүүн асан С.Баярын дараа 2009 оны намраас тэрбээр Монгол Улсын 26 дахь Ерөнхий сайдаар томилогдсон. С.Баяр түүнд “Дипломатч зангаар дандаа “yes” гэж болохгүй, хааяа ч гэсэн “no” гэж хэлж сураарай” хэмээн захиж байсан гэдэг. Тэр захиасыг гайгүй сайн биелүүлэх шиг болсон. Түүнийг Ерөнхий сайд байх үед Оюутолгойн төсөл ажил хэрэгт шилжсэн. Сайн муугаар хэлүүлдэг ч “Эрдэнэс-Тавантолгой” төслийн үр шимээс иргэдэд хүртээж, хүний хөгжлийн сангаас 21 мянган төгрөг тараасан. Мал сүргийн тоо 50 саяд хүрэв. Улаанбуудай, төмсний хэрэгцээг дотоодоосоо бүрэн хангадаг болов. Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт урьд өмнө хэзээ ч байгаагүй 17,5 хувьд хүрсэн юм.

Дэлхийн банкны үнэлгээгээр Монгол Улс дундаж орлоготой улс орны тоонд жагсч, нэр хүнд бүхий “Стандарт энд Пүүрс” компанийн үнэлгээгээр Монголын зээлжих зэрэглэл урт хугацаанд ВВ, богино хугацаанд В үнэлгээнд хүрч хэтийн төлөвөө “Тогтвортой” хэмээн дүгнүүлсэн. “Фитч” хэмээх өөр нэг компани урт хугацааны зээлжих зэрэглэлийг бүр нэгээр ахиулан В+ болгож зарлав. Монгол Улс эдийн засгийн үзүүлэлтээрээ ийнхүү дэлхийн олон орны дунд нүүр улайхааргүй байр суурь эзэлсэн юм. Хөгжлийн банк байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлж, 600 сая ам.долларын эх үүсвэрийг мөнгөний авдарт нь хийж өгчээ. Малаа мадаггүй тоолдог атлаа иргэнээ тоолж чаддаггүй байсан цаг ард хоцорч, түүхэнд анх удаа хурууны хээний сан, дижитал зургийн мэдээллийн сантай болгов. Хөдөө аж ахуйн Монгол орон энэ хэдхэн жилд уул уурхайн том улс болох төрхөө олж, дэлхий нийтээрээ Монголын зүг хардаг байсан нь саяхан.

Ердөө энэ хэдэн өгүүлбэрийг хэлэхэд л 26 дахь Ерөнхий сайдын хийсэн ажлын дүн нуруу харагдах болно. Энэ зэрэгт хүргэхэд мэдээж тийм амар байгаагүй нь лавтай.

Улстөрчийнхөө хувьд С.Батболд төлөвшсөн, соёлтой улстөрчийн жишгийг харуулж чаддаг нэгэн. Улс төрийн тавцанд өрсөлдөгч намтайгаа хамтран байгуулсан Засгийн газрыг тэрбээр өнгөрсөн жилүүдэд чадамгай залж чадсан. Удирдах арга барил, зөвшилцлийг сайн хийж чадсанаараа Засгийн газар тогтвортой ажиллаж ирсэн. Тэгсэндээ ч дэлхийд өндөр хурдацтай эдийн засгийг улсдаа суурьшуулж чадсаныг хүн бүхэн хүлээн зөвшөөрөх биз ээ. Гадаад хэргийн дэд сайд байхаасаа л тэрбээр гадаад харилцааг эдийн засагжуулна гэсэн томъёолол гаргаж ирсэн эрчээрээ Ерөнхий сайд байхдаа улс орноо хэтийдсэн улстөржилтөөс гаргаж, эдийн засагжуулж чадсан юм.

УИХ-ын гишүүнээр ажилласан өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн, Худалдааны тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг гишүүдийн хамт санаачлан боловсруулжээ. Мөн УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг орж ажилласан байна.

Улсын Их Хурлын Жалбасүрэнгийн БАТЗАНДАН

“МОНГОЛОО ӨМӨӨРНӨ, МОНГОЛЧУУДАА ӨМГӨӨЛНӨ”



2004-2008 онд Иргэний нийгмийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх хүсэл зоригийн хүрээнд “Эрүүл нийгэм-Иргэний хөдөлгөөн”-ийг санаачлан зохион байгуулж, нийгэмд газар авсан шударга бус байдал, авлига, хээл хахуультай тэмцэх, шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог хангах, нийгмийн баялгийн шударга хуваарилалт зэрэг асуудлуудын талаар иргэдийн дуу хоолойг төр, засагт хүргэх хөдөлгөөнийг удирдан тэмцсэн хүн бол одоогийн УИХ-ын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга, хууль зүйн ухааны доктор Ж.Батзандан байлаа.

Тэрбээр 1974 онд наран мандах нутаг Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод аймгийн прокурор Жалбасүрэнгийн 8 дахь хүү болж мэндэлжээ. 1982-1992 онд Баруун-Урт хотын 10 жилийн дунд сургуулийг онц дүнтэй төгсөн МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд элсэн орж нэг жил суралцаад шалгалт өгч БНУУ-ын Мишкельцын Их сургуульд суралцсан аж. 1999 онд сургуулиа улс төр судлал, эрх зүйч мэргэжлээр амжилттай дүүргэж, Их сургуулийнхаа докторантурт урилгаар элсэн суралцаж, улмаар 2003 онд Захиргааны эрх зүйн чиглэлээр хууль зүйн ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан эрдэмтэн гишүүн билээ.

Сургуулиа дүүргэн эх орондоо ирж, ажлынхаа гарааг “Их засаг” их сургуулийн эрдэмтэн багшаар ажилласан нь санамсаргүй зүйл байсангүй. Шинэ үеийн залуусын эрдэм боловсрол, мэдлэгт өөрийн зүгээс оруулж болох оюуны хөрөнгө оруулалтыг хийсэн нь тэр. Улмаар 2010-2012 онд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүн, 2011-2012 оронд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгуульт ажлыг хийж байсан нь эх орныхоо баялгийг үр ашигтай хуваарилахад иргэдийн хяналтыг бий болгох түүний зарчмыг илэрхийлж буй юм.

Залуу хууль эрдэмтэн Ж.Батзандан УИХ-ын 2012 оны ээлжит сонгуульд Ардчилсан намаас нийслэлийн Баянзүрх, Налайх дүүрэгт нэр дэвшин өрсөлдөж иргэд, сонгогчдынхоо итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар 2015 оны 1 дүгээр сараас УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллаж байгаа билээ. Энэ бүхэн нь иргэдийнхээ дуу хоолойг төрд хүргэх, шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоог хангах түүний амлалт, мөнхүү зарчим нь биеллээ олсны нэг илрэл юм.

Энэ хугацаанд тэрбээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хамтын тэтгэврийн тухай, Эрүүгийн хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зэрэг нийт 34 хуулийн төслийг бие даан болон хамтран санаачилж, 8 хуулийн төслийн ажлын хэсгийг ахалж, 47 хуулийн төслийн ажлын хэсэгт орж ажилласан байна.

Иргэдийнхээ хүсэлт, хүлээлтийг ажил хэрэг болгоход анхаарч Гуравдугаар амаржих газар, “Амгалан” дулааны станц, Улиастай-Гачууртын, Хонхор, Налайхын чиглэлийн зам засварын зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлыг өөрийн сонгогдсон Баянзүрх дүүрэг, Налайх хотод хийж амжуулсан байна. Энэ нь дүүргийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ажил, асуудлыг шийдвэрлэж бодит ажил хэрэг болгон хийж, бүтээж яваагийн илрэл юм. Тэрбээр хийж бүтээхийн сацуу иргэд, сонгогчдын төлөөллийн хувьд иргэдээ сонсож ажиллахыг чухалчлан Баянзүрх, Налайх дүүргийн бүх хороонд уулзалт зохион байгуулж, иргэдээс нийт 2400 гаруй өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авч 10 гаруй хувийг нь газар дээр нь шийдвэрлэн, 40 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж, 50 гаруй хувийг холбогдох эрх бүхий байгууллагад нь уламжилж шийдвэрлэснийг харахад чамлах үзүүлэлт биш юм.

2012 оны УИХ-ын сонгуульд иргэд, сонгогчиддоо “Монголоо өмөөрнө, Монголчуудаа өмгөөлнө” хэмээн амлалт өгч оролцсон Ж.Батзандан үнэхээр л иргэд олон түмнээ өмөөрч, өмгөөлж ирсэн нь түүний хийж бүтээсэн зүйлээс тов тодхон харагдана. Тэрбээр иргэд сонгогчдоо өмгөөлж хамгаалахын зэрэгцээ басхүү тэднийхээ төлөө хийж бүтээж, шинийг сэдэж санаачилж яваа бүтээн байгуулагч, залуу түшээ билээ.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Жамъянсүрэнгийн БАТСУУРЬ

ГОВИЙНХОНДОО ИВЭЭЛТЭЙ ТҮШЭЭ



Олон түмнийхээ дунд явж, санаа бодлыг нь сонсож ахуйд “төрд өнөөдөр төрийн ажлын туршлагатай, оногдсон үүргээ биелүүлж, гишүүний ажлаа л хийдэг ийм хүн олон байх хэрэгтэй” гэж УИХ-ын гишүүн Жамъянсүрэнгийн Батсуурийн тухай онцлон хэлж байв. Энэ үг улстөрчдийн элдэв дуулиан шуугианаас хол, иргэд олныхоо төлөө төрийн ажлаа л хийж, хоёргүй сэтгэлээр зүтгэж яваа эгэл түшээгийн хувьд оносон тодорхойлолт төдийгүй түмэн олноос түүний ажлыг үнэлсэн үнэлэмж юм. Нээрээ ч УИХ-ын гишүүд маань бүгдээрээ төрийн бодлого боловсруулах, хууль тогтоох үндсэн үүргээ дор бүрнээ биелүүлээд, өөрсдөө үлгэрлэж хуулиа сахин мөрдөж ажилладаг бол түмэндээ ээлтэй, төр шиг төр байхын үндэс тэрсэн.

Ж.Батсуурь говь нутагтаа дунд сургуулиа амжилттай дүүргээд алсын моринд хөл дөрөөлж, холын Европод алдартай их сургууль төгсөж, эдийн засаг, инженерийн боловсрол эзэмшжээ. Их сургууль дүүргэж ирээд улсдаа нэртэй эрдэм мэдлэгийн томоохон төвүүд болох МУИС, ШУТИС-д багшилсан байна. Улмаар Дорноговь аймгийнхаа Засаг даргаар найман жил ажиллах хугацаандаа тус аймгийг улсдаа тэргүүлэгчдийн эгнээнд хүргэж байв. Өнөөдрийн Дорноговь аймгийн хөгжил цэцэглэлтэд хөдөлмөрч, шаргуу Ж.Батсуурь даргын оруулсан хувь нэмэр их бий. Хөдөө орон нутагт хөгжил тааруу, хөрөнгө мөнгөний гачаал дутагдалтай 2000-аад онд аймгийнхаа хөгжлийн үндсийг тавьж, өнгө төрхийг нь өөрчилж чадсан хүн гэж говь нутгийнхан нь бахархан ярих дуртай. Үнэхээр тийм юм билээ. Тэрбээр аймагтаа бүтээн байгуулалтыг эхлүүлж, амьдралын тав тухтай орчныг бүрдүүлэхийн төлөө хичээж ажилласнаар тухайн үед эхлээд байсан хүрээ хот руу нүүдэллэсэн иргэд, залуусын цувааг зогсоож чадсан гэдэг. Хийж бүтээсэн олон ажлаас нь жишээлэхэд, нутагтаа сайхан амьдрах боломж бүрдүүлэхийн тулд эдийн засгийн бэрхшээлтэй тэр цагт аймгийн төв, сумдад

соёлын төв, спорт заал, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, сумын Засаг даргын Тамгын газрын барилгуудыг шинээр бариулах, иж бүрэн их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн нь орон нутгийн боловсрол, соёл, эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, хүртээмжийг нь нэмэгдүүлэхэд чухал алхам болж, олны талархал хүлээж байлаа.

Олон жил аймгийн Засаг дарга хийж, үргэлж өмнөө зорилго тавин зүтгэж, бүтээн байгуулалт өрнүүлж, ус бэлчээр, ган зудын бэрхшээлээс эхлээд олон сорилттой тулгарч, малчид, иргэдтэйгээ хамт зовлон, жаргалыг нь хуваалцаж ирсэн, өөрөө ч сүргийн бэлчээр, малын захад өссөн малчны хүү болохоор тэрбээр цаг ямагт орон нутгийнхаа өмнө тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг ойлгож мэддэг. Тэр бүхнийг даван туулах арга эв, ажлын туршлага хуримтлуулж хат суусан хүний хувьд тэдгээрийг хууль эрх зүй, төрийн бодлогын түвшинд зохицуулах, шийдвэрлэхийн төлөө зорьж зүтгэж яваа, орон нутгийн удирдлагаар дөмөгхөн мэргэшсэн төрийн түшээ болохыг нь хэн хүнгүй мэднэ.

Ж.Батсуурь олныхоо итгэлийг хүлээн УИХ-д сонгогдож, төр түшилцэх хугацаандаа өндөр мэргэжил эзэмшсэн эдийн засагчийн хувьд эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлуудад түлхүү анхаарч, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороог толгойлж, улс орны нийгэм, эдийн засгийн амьдралтай холбоотой олон чухал хуулийг санаачилж, ажлын хэсгүүдийг ахалж, гишүүнээр нь ажиллаж төрийн ажлын их туршлага хуримтлуулсан түшээ билээ. Тухайлбал, Хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүд, Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг ажлын хэсгийн ахлагчаар ажиллажээ.

Нийгэм, иргэдийн ахуй амьдралын тулгамдсан асуудлууд, орон сууц, аж ахуй эрхлэх, бизнес, эдийн засгийн харилцааг зохицуулахад голлох үүрэгтэй эдгээр олон чухал хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулж ажилласан зэргээр нь жишээлэн түүний төрийн хууль боловсруулах, батлах ажилд оруулсан санаачилга, зүтгэл, хувь нэмрийг илэрхийлж болно.

Ж.Батсуурь гишүүн аливаа хууль нь аль болох амьдрал, хэрэглээнд нийцтэй, Монголын онцлог, уламжлалыг тусгаж хадгалсан байж л сая бодитой хэрэгжиж тухайн харилцааг зохицуулж чадна, түүнээс биш бусдыг дууриасан, аль нэг гадаад орноос хуулбарласан хууль монгол хөрсөнд бууж хэрэгжих боломжгүй хэмээн үзэж, энэ зарчмаа чанд баримталж, нарийн судалгаатай ажилладаг ажээ.

Төрж, өссөн говь нутгийнхаа төлөө ажил үйлс, хүч хөдөлмөрөө зориулж яваа Жамъянсүрэнгийн Батсуурийг цаашид хийж бүтээх төрийн их үйл, түмний их итгэл хүлээж буй.

Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн БАТТУЛГА ҮЙЛДВЭРЖСЭН МОНГОЛЫН ТӨЛӨӨХ ЭРЭЛХИЙЛЭЛ



“ME Consulting” судалгааны агентлагийн хийдэг улс төрийн барометр тодорхойлох судалгааны “Таны хамгийн ихээр дэмждэг улстөрч” гэсэн үзүүлэлтээр сүүлийн хоёр жил дараалан эхний гурваас буухгүй яваа улстөрч бол УИХ-ын гишүүн, МоАХ-ны дарга Халтмаагийн Баттулга билээ. Монголчууд түүнийг анхлан байгуулсан компаниар нь “Женко” хэмээн онцолж дууддаг. Мянга мянган эгэл хүмүүсийн үлгэр дууриал болж, дундаршгүй эрэлхийлэл, шийдлээр бизнесээ босгон, мянга мянган монголчуудыг ажилтай орлоготой байлгаж, улмаар үйлдвэржсэн Монгол Улсыг байгуулахын төлөө тууштай тэмцэгч гэж түүнийг хэлж болно.

Х.Баттулга үйлдвэрлэл, үйлчилгээний компаниудаа хөл дээр нь бат зогсоосны дараа 2004 оны УИХ-ын сонгуулиар улс төрд алхан оржээ. Парламентад суусан эхний хоёр жилээ хууль тогтоох, улс төрийн тэмцэл өрнүүлэх ажилд хичээнгүйлэн суралцсан Х.Баттулга 2006 онд Ардчилсан намд элсч, улмаар МоАХ-ны дарга болсноор их улс төрд эргэлт буцалтгүй орсон юм. 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа богинохон хугацаанд туршлагажиж, байр сууриа олсон түүнийг Засгийн газрын гишүүн болгож, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар тохоон томиллоо.

Монголын үндэсний үйлдвэрлэлийг тодорхойлогч “Мах импекс”, “Талх чихэр” зэрэг компаниудыг удирдаж байхдаа үйлдвэржихийн ач холбогдлыг мах цусаараа мэдэрч ойлгосон Х.Баттулга ардчилсан хувьсгалын хоёр дахь шат нь үйлдвэржилт юм байна гэсэн бат итгэл үнэмшлийг олж авсан байдаг. Тэр үед өгсөн нэгэн ярилцлагадаа Х.Баттулга “Уеийн үед ямар нэг зүйл хийж, үйлдвэрлэдэг ард түмнүүд л сайхан амьдарч, нэр төртэй байж чаддаг. Юу ч хийдэггүй, үргэлж

бусдаас авч хэрэглэдэг улс орнууд сайн сайхны төлөөх эрэлхийлэлгүй, тусламж, тэтгэлэг горьдсон улс болж хувирдаг. Та нар юу хийж чаддаг юм бэ, та нарын хийдэг зүйл юу юм бэ гэсэн асуултад ам бардан хариулах үйлдвэржилтийг өрнүүлсэн цагтаа л монголчууд хангалуун сайхан амьдралд хүрч, тогтвортой орлоготой болох болно” хэмээж байжээ. Тийм ч учраас Сайншандын аж үйлдвэрлэлийн цогцолбор төслийг өөрийн хөрөнгөөр боловсруулж, улмаар төрийн бодлого болгохоор дэвшүүлсэн билээ.

Тавантолгойн нүүрсний ордод эзэн суухаар санаархсан гадны гар хөл бологч, нам дамнасан “нүүрсчин” бүлэглэл гадаад захиалагчид нь илтэд ашиггүй “Шинэ төмөр зам”-ын төслийг гацаах, гутаан доромжлох кампанит ажлыг өрнүүлж, арга нь явуургүйтэх үест Х.Баттулга ба түүний хамтрагчдыг хилс хэрэгт унагах мэх зохион хэрэгжүүлсэн байдаг. Гэвч даравч дардайх, үнэнээр явбал үхэр тэргээр туулай гүйцэхийн үлгэрээр гүтгэлэг тараасан хэвлэл, мэдээллийн байгууллагууд шүүх дээр гүтгэлэгт мэдээллээ нотолж чадаагүйн улмаас гүтгэлэг тарааснаа хүлээн зөвшөөрч, уучлал гуйсан билээ.

Х.Баттулгын үйлдвэржсэн Монгол Улсын төлөөх эрэлхийлэл, тэмцэл дуусаагүй, дундраагүй байна. Алдарт “Zara” брэндийг эзэмшигч Испанийн үйлдвэрлэгчидтэй монгол малын арьс, ширээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл хийхээр тохирч, багагүй ажлыг амжуулснаа “Бүрэн зураглал” нэвтрүүлгийн үеэр харуулж байсан.

Х.Баттулга намын дотоод харилцааны ариун цэврийг сахих, ирээдүйг баталгаатай болгож олон нийтэд зөв, цэвэр нам харагдахын тулд гадны гар хөл болсон, өрсөлдөгчдийн нууц зэвсэг болж намд шургалсан хүмүүсээс салахыг ил тод уриалах болсон. Үүнийг намын жирийн гишүүд, дэмжигчид нь халуунаар хүлээн авч дэмжиж байгаа бөгөөд өнөөх шургалсан туршуулууд харин улс төрийн карьераа хадгалж үлдэхийн тулд “намын эв нэгдлийг бусниулагч” хэмээн дайрч довтолсоор л. Энэ асуудалд Х.Баттулга яаж хандаж байгааг лавлахад “Хэрвээ эв нэгдлээ хадгалах нэрээр олон нийтэд тараа таниулсан, үндэсний эрх ашгаас урвасан хүмүүсийг авч үлдвэл харин ч эв нэгдлээ сүйтгэсэн хэрэг болно. Дотоод ариун цэврээ сахиж, нэр төрөө хадгалахын тулд бохироосоо салах нь харин эв нэгдлийг бататгах хамгийн шилдэг арга байх болно” хэмээн хариулж байна.

Улс үндэстнээ үйлдвэржсэн, хөгжингүй улсын эрэмбэд аваачихын төлөө цуцашгүй эрэлхийлэгч тэрбээр энэхэн цаг дор хөгжлийг түүчээлэх намынхаа эв нэгдлийг хангах бодитой шийдлийг эрэлхийлж байна. Улс төрийн нам бол бодлогын байгууллага. Намын бодлого амьд байх үндсэн нөхцөл нь эрэлхийлэгчид, шийдэл санал болгогчдоор эгнээгээ дүүргэх билээ.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн БАТХҮҮ

ТӨРД ШИЛЭГДСЭН ТҮШЭЭ



УИХ-ын гишүүнээр гурав дахь удаагаа сонгогдон ажиллаж буй Гаваагийн Батхүү Авто засварын заводод засварчнаас эхлээд гурван Засгийн газарт төрийн сайдаар томилогдон ажиллах хүртлээ Монголын төрд 30 гаруй жил зүтгэж буй эрхэм. Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрж өсөн, сургуулиа төгсөөд ЗХУ-ын Харьков хотын Инженер-эдийн засгийн сургуулийг төгсгөсөн тэрбээр тээвэр, дэд бүтцийн салбараас бараг холдоогүй билээ. Засварчнаас хэлтсийн дарга, яамны ахлах мэргэжилтэн, газрын дарга, сайд, УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга... Ингэж л өгсөж яваа Г.Батхүү төрөлх Өвөрхангай, бие хүнээс төрийн хүн болтлоо төлөвшсөн тээвэр, дэд бүтцийн салбартайгаа уяатай нэгэн.

Үйлдвэрээс өгсөн ажлыг хийх, үйлдвэр байгуулах, төрийн бодлогоор улсыг удирдалцах гээд энэ бүх холбоотой хэрнээ ялгаатай үйл явцыг 30-аад жилийн дотор туулж Монголын төрд “дархлагджээ”. Гэхдээ хүссэндээ биш, нутгийн зон олон нь түүнийг дархалчихаад байсан хэрэг. Улс төр гэдэг их ухаан, энгэрийн ромбо, эрээн диплом шаардахаасаа илүү “За” гэдэг үгийг андгай мэт хүлээн авч, хэлсэндээ хүрдэг бай гэж сонгогчид шаарддаг. Түүнийг хэлсэндээ хүрдэг, талцал, хагаралд бус эвлэрч нэгдэхэд уриалж явдаг, нутаг усаараа ялгарахын оронд Монгол гэдэг зургаан үсгийн дор нэгдэж чаддаг байхыг залууст сургадаг нэгэн гэж улстөрчид тодорхойлдог. Тиймээс ч ус нутгийнхан нь АН, МАН гэлтгүй “Өвөрхангайн” Г.Батхүү учраас түүнтэй элдэв харьяаллаас эмээлж, эрээлэлгүй эр хүний ёсоор нөхөрлөж яваагаа өгүүлэх дуртай. Өсийг эвээр зөөллөж, энэ улс оронд ч, элссэн намдаа ч эвийн цавуу нь болж явахыг хүсдэг.

Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүүгийн өнгөрсөн он жилүүдэд хийсэн ажил, санаачилж батлуулсан хууль, тогтоомжуудыг нь төрийн ой санамж ч, төрөлх нутгийн сонгогчид нь ч сайн мэдэх учир нурших нь илүүц. Харин энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд хамгийн тод томруунаар дурдах ёстой хууль гэвэл түүний санаачлан батлуулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм. Жолоочийг, зорчигчийг, тэр ч байтугай жолоочтой дарга, захирлуудыг замын цагдаатай нь хариуцлагажуулсан, согтууруулах ундаа хэрэглээд тээврийн хэрэгсэл жолоодсон л бол бурхантай найзласан ч хариуцлагаас бултах аргагүй гэдгийг сайтар ухааруулсан энэ хууль цаанаа хэчнээн хүний амь насыг аварч буйг таашгүй.

“Хэл, хил, мал” гурваа эрхэмлэдэг монгол түмний хувьд тусгаар тогтнолын үндэс болсон Монгол хэлний тухай хууль, Монголын төрийн засаг, захиргааны байгууллагуудын удирдлагын харьяалал, хяналтын тогтолцоо, хараат бус байдлыг өөрчилж, босоо бүтэцтэй болгосон Төрийн аудитын тухай хуулийг санаачлан батлуулсныг заавал онцлох учиртай. Энэ бол УИХ-д олуулаа байх завшаан эдлээгүй үед бол төдийлөн олдохгүй боломж юм.

Тэрбээр энэ хугацаанд зам тээвэр, дэд бүтцийн салбартаа Дамжин өнгөрөх тээвэр, ложистикийн талаар төрөөс баримтлах бодлого, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай зэрэг хуулийн ажлын хэсэгт нь орж ажиллажээ.

Төрийн алба улс төрөөс хараат бус, тогтвортой, мэргэшсэн, төрийн хар хайрцагны залгамж чанарыг хадгалсан байх ёстой гэж тэр үздэг. Тиймээс ч Улсын Их Хурлаас баталж буй аливаа томилгоог батлалцахдаа хаана, ямар ажил үүрэг эрхэлж байсан, хэр амжилт гаргасан, ажил хүлээн авбал юу хийх гэж байгааг нь “байцааж” гардаг нь цаанаа учиртай.

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт 1996-2016 онд баригдсан авто зам, гүүр, байгууламж, гудамж, объектууд л гэхэд 32 том ажлыг жагсаасан байдгаас 2011-2016 онд 8 их наяд 255 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий автозамын засвар арчлалтын ажил онцгой анзаарагддаг. Эрчим хүчний салбарт 14 их наяд 481 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий цахилгаан дамжуулах шугам, дэд станц, дулааны хангамжийн чиглэлийн ажлыг аймаг, орон нутгийнхаа төлөө Улсын Их Хурлаар батлуулж чаджээ.

УИХ-ын гишүүн Г.Батхүү нь 2012-2016 онд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороонд гишүүнээр, мөн Тусгай хяналтын дэд хорооны даргаар ажиллалаа. Тэрбээр энэ хугацаанд 15 хуулийн төслийг санаачлан батлуулж, 6 ажлын хэсэгт ахлагчаар, 12 ажлын хэсэгт гишүүнээр орж ажиллажээ. Мөн 20 орны парламентын бүлгийн гишүүн, Монгол-Ази, Номхон далайн орнуудтай харилцах бүлгийн дарга, Монгол-Латви, Монгол-Нидерланд, Монгол-Латин Америк, Монгол-Украин, Монгол-Израилийн парламентын бүлгийн дарга, Монгол-Хятадын парламентын бүлгийн дэд даргаар тус тус ажилласан байна.

Өнгөрсөн 20-иод жилийн хугацаанд түүний гадаад орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх чиглэлээр болон албан томилолтоор ажилласан тайланг харахад Гаваагийн Батхүүг Өвөрхангай байтугай Монгол Улс, дэлхий танихаар болсон гэхэд хилсдэхгүй. Монголоосоо “Нобелийн шагналтан” бэдэрч байхаар монгол ухаант дэлхийд танигдсан төрийн хар хүнийг олоод ир гэвэл Гаваагийн Батхүү шилэгдэнэ үү гэхээс гологдохгүй.

Улсын Их Хурлын гишүүн Догсомын БАТЦОГТ

БЭРС ГАРАХ ХҮҮ



3. Энхболдын ангийнхан цугларч, шатрын өрөг дээрх улс төрийн нүүдлээ эхлүүлснээс хойш дөрвөн хавар нэгэнтээ өнгөрчээ. Өнөөдөр хэн гурван нүүдлийн цаадахыг харж, хэн нь ойрын зайн тоглолт хийж, хэн нь нүүж ч амжилгүй “идүүлснийг” ард түмэн шүүгээд дүнгээ тавина. Д.Батцогт гэгч эрхмийн хувьд УИХ хэмээх хууль тогтоох энэ өрөг дээр хэн байв гэдэг нь сонирхолтой.

Тэрбээр төрийн түшээгийн сэнтийд суухаасаа өмнө монгол түмэндээ хэдийнэ эчнээ танил болчихсон нэгэн. “Амлалт нэхэх ард түмний холбоог” байгуулж, 2008 оны УИХ-ын сонгуулиар ард түмэнд амласан бэлэн мөнгөө өгөхийг засаг барьж байсан МАН, АН-ынхнаас шаардаж эхэлсэн нь тухайн цаг үедээ төдийгүй улс төрийн тавцанд ч шинэ үзэгдэл байв. Гадаа гандаж, хөдөө хөхрөн байж эрх баригчдаас амлалтаа биелүүлэхийг шаардсан нэхэл хатуу шаардлага нь олны дунд хөвдөнд тавьсан гал шиг дүрэлзэж, нийгмийг сэрээж чадсан нь улс төрд хийсэн түүний анхны оновчтой, уран нүүдэл байв.

Зөв зүйл хөндөж, зоримог алхам хийсэн тэрбээр төрийн түшээ болох дараагийн нүүдэл хийхдээ хэдийнэ олны хүрээлэлд орж, итгэл найдварыг нь тээж чадахуйц нэгэн болсон байв. Намын жагсаалтад орж “лифтэнд” суулгүй, чанга өрсөлдөгчтэй, хатуухан тойрогт өрсөлдөж, Ховдчуудын итгэлийг хүлээн парламентын хаалгыг тогшиж бус, түлхэж орж ирсэн бядтай нэгэн. Түүнийг гишүүн болохоос өмнө ард түмэн Д.Батцогтын улс төрийн өрөгт хийсэн анхны нүүдлийн үр шимийг хүртсэн. 2012 оны УИХ-ын сонгуульд намууд бэлэн мөнгөний хоосон амлалт өгч зүрхлээгүй. Улстөрчийн хувьд хэр холыг харж чадсаны нэгэн гэрч энэ биз.

Өнгөрсөн хугацаанд тэрбээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Үндэсний

үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд олон хуулийн төсөл санаачилж өргөн барьжээ. Санаачилсан хуулийн төслүүд нь нийгэмд цагаа, гарцаа хүлээсэн чухам тэр зүйлийн шийдэл болсон байдаг. Тухайлбал, Малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг санаачилж батлуулсан. Малчид улсын эдийн засгийн маш том ачааг нуруундаа үүрч яваа, соёл уламжлалыг хадгалж байгаа тийм онцлогтой хүмүүс гэж тэрбээр үздэг. Тийм хүмүүсээ төрийн бодлогоор дэмжих ёстой гэдэг. Энэ эрхмийн буянаар малчид нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулахад шимтгэл төлөх хугацаагаа өөрсдөө сонгож сар, улирал, хагас жил, жилээр төлөх боломжтой болсон төдийгүй малчнаар ажилласан нэг жилийг нэг жил, хоёр сараар тооцуулдаг болсон юм.

Д.Батцогт гишүүний хувьд үндсэн ажлаа түүртэлгүй хийхийн зэрэгцээ хууль эрх зүйн шинэчлэлт хамгийн эрчимжиж байгаа чухал салбаруудыг хамарсан Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороог гурван жил дараалан удирдав. Байнгын хорооны дарга нар жил болоод солигддог бол Д.Батцогт гишүүнийг гурав дараалан сонгосон нь түүнийг ажилдаа эзэн байж чадсаныг гэрчилнэ. Байнгын хорооны даргаар томилогдсон даруйдаа хамгийн их нэхэл дагуулсан эрүүл мэндийн салбарын ажилтай газар дээр нь биечлэн танилцсан нь хэвлэлийнхний хараанд өртөж, “Хамгийн санаачлагатай байнгын хорооны дарга”-аар тодруулж байсан удаатай.

Ер нь түүний нүүдэл бүр улс эх орны төлөө, ард иргэдийн сайн сайхны тусын тулд чиглэсэн байдаг. “МАХН, МҮАН-ын Шударга ёс” эвслийг анхлан орхиж, хэсэг хугацаанд “сул” гишүүн байсан тэрбээр угшлаа даган АН-даа эргэж ирсэн. УИХ-ын гишүүдийн давхар дээлийг тайлах тухай хэлэлцэхэд цөөнхийн байр суурь дээрээ бат зогссон. Бүлгийн зарим түшээд шиг “кнопны гишүүн” байхыг тэрбээр хүссэнгүй. Намын харьяалалтай ч түмний эрх ашиг хөндөгдөх зүйлд Батцогт гэдэг эрхэм ард түмнийхээ талд байж чадсан. Лоббидсон, хуйвалдааны шинжтэй асуудал хэлэлцэх үед намын нөхдийнхөө нүүрэн дээр тасхийсэн жинтэй үг илгээчихдэг, ар хударгаар муулдаггүй шударга зантай. Хэвлэлийнхэн ч түүний шударга занд талтай. Парламентын сэтгүүлчдийн хувьд эрхэм түшээгээс олзуурхдаг бас нэг зан нь ямар ч асуудлаар, ямар ч асуултаас зугаталгүй байр сууриа илэрхийлдэг явдал.

Түүний бусад гишүүдийн хамт санаачилсан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл нь гишүүдийн ирцийг нэмэгдүүлж, УИХ-ын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн. Өөрөө бол ирцийн хувьд бусдадаа үлгэр болохуйц нэгэн. Үүнийг нь УИХ-ын Тамгын газраас гаргадаг чуулганы хуралдааны ирц бэлхнээ нотлоод өгнө. Түүний хувьд өнгөрсөнд чуулганы хуралдаанд 100 хувийн ирцтэй оролцсон цөөн хэдэн гишүүний нэг.

Нэгэнтээ Ж.Энхбаяр гишүүн УИХ-ыг тараахаар гишүүдээс гарын үсэг цуглуулах үед Д.Батцогт гишүүнээс байр суурийг нь сонссон сэтгүүлчийн асуултад “Улс төрийн ашиг хонжоо хайсан үйлдэл биш байвал дэмжинэ. Гишүүний суудалтай амь хоргодон суудаг нь би биш” хэмээн мэдэгдэж байв. Улс төрийн их өрөг дээр алхам алхмаар урагшлан нүүсээр буй тэрбээр хэзээ ч ухарч нүүдэггүй. Яг шатрын хүү шиг. Бэрс гарах хүү ч байж мэднэ.

Улсын Их Хурлын гишүүн Намдагийн БАТЦЭРЭГ

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ГИШҮҮН



УИХ-ын гишүүн Н.Батцэрэг 2012-2016 оны парламентын бүрэн эрхийн хугацаанд чуулганаар батлагдсан 27 хуулийн төсөл, 25 ажлын хэсэгт орж ажиллажээ. Мөн тэрбээр УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн дарга, Нутгийн удирдлагын дэд хорооны дарга, Эдийн засгийн байнгын болон Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн, улмаар Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар ажилласан түшээ.

Тэрбээр улс төрд орж ирсэн цагаасаа “Монголчууд бид эв нэгдлээ эрхэмлэн, биесээ дэмжиж, хүчээ нэгтгэн байж хамтдаа хүндрэл бэрхшээлээ даван туулж хөгжил дэвшилд хүрэх ёстой” гэдгийг өөрийн улс төрийн чиг шугамаа болгож, ирсэн туршлагатай парламентчдын нэг.

УИХ-ын 2012 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгийн даргаар томилогдон дөрвөн жил ажиллахдаа парламент дахь нам, эвслийн бүлгийн улс төрийн тэнцвэртэй байдлыг хангах, аливаа асуудлыг зөвшилцлийн арга замаар шийдвэрлэхэд анхаарч иржээ. Үүний нэг тод илрэл нь энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд УИХ дахь нам, эвслийн бүлгийн дарга нар ажлын хэсгийг нь ахлан ажиллаж батлуулсан бодлогын томоохон баримт бичиг болох “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” юм. Энэхүү урт хугацааны бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Н.Батцэрэг гишүүн ажиллаж, 2016 оны 1 дүгээр сард УИХ-ын чуулганаар “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хэмээх

ойрын 15 жилийн урт хугацааны бодлогын баримт бичгийг батлуулсан нь энэ удаагийн парламентаар батлагдсан чухал баримт бичгүүдийн нэг болсон билээ.

Тэрбээр 2015 оны 1 дүгээр сараас Монгол Улсын Үндсэн хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах комиссын 9 гишүүний нэг байж, голлох үүргийг гүйцэтгэсэн бөгөөд одоо хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-аар батлуулах ажил үлдээд байгаа юм. Мөн Н.Батцэрэг гишүүн УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүнээр ажиллахын зэрэгцээ Нутгийн удирдлагын дэд хорооны даргаар томилогдон ажиллаж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна.

Н.Батцэрэг 2015 оны 9 дүгээр сараас Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдаар томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын үндсэн чиг үүргийн яамыг толгойлж ажилласан энэ богино хугацаанд толгойлж буй яамаа улсын эдийн засгийн нэг том тулгуур болгохыг зорьж, бодлогын томоохон шинэчлэлүүдийг хийж эхэлжээ. Олон зуун жилийн түүх, өв соёл, газар нутгаа түшиглэж ирсэн аялал жуулчлалын салбарт хийгдэж ирсэн дэвшлийг бүс нутгийн хэмжээнд хөгжүүлэхээр томоохон гэрээ хэлцлүүдийг энэ хугацаанд амжуулсан төдийгүй дэлхийн 33 орны сайд нарын дээд хэмжээний уулзалтыг эх орондоо зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байга аж.

Энэ хүрээнд “Нүүдэлчдийн аялал жуулчлал, хотуудын тогтвортой хөгжлийн Торгоны замын хуралдаан” олон улсын аялал жуулчлалын анхдугаар хуралдааныг 2016 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран зохион байгуулахаар болжээ. Монгол Улс энэ хуралдааныг эх орондоо зохион байгуулснаар “Нүүдэлчдийн замаар аялахуй” аяллын брэндийг хөгжүүлж, түүний манлайлагч орон байх, олон улсын зах зээл дээр өрсөлдөхүйц аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх өргөн боломж бий болох юм. Аялал жуулчлалын салбарыг шинэ шатанд гаргаж ирснээр уул уурхай, хөдөө аж ахуй гэсэн хоёр тулгуурт эдийн засаг дээр нэгэн шинэ эдийн засгийн тулгуур хөлийг бий болгох зорилт тавиад байгаа аж.

Байгаль орчны яамны үндсэн нэг салбар болох ойн салбарын хувьд ч мөн ойн сангаа нэмэгдүүлж хамгаалах, ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах томоохон шийдвэрүүдийг гаргасан байна. “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ойн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор улсын хэмжээнд болон жишиг хоёр сумын хэмжээнд хэрэгжүүлэх ойн цэвэрлэгээний төслийг боловсруулжээ. Түүнчлэн Тусгай хамгаалалттай газар нутгийн одоо байгаа 17,39 хувийг 2030 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт тавьжээ. Энэ хүрээнд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших “Ноён” уул орчмын газар, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Тост, Тосон бумбын нурууг УИХ-ын тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авсан. Хууль эрх зүйн хүрээнд ч хуулийн тодорхой шинэчлэлүүдийг хийхээр ажилласан байна. Мөн “Бурхан Халдун” уул, түүнийг хүрээлсэн газар нутгийг Дэлхийн өвд бүртгэсэн ЮНЕСКО-гийн батламжаа гардаж авчээ.

Н.Батцэрэг гишүүн ууланд авирах хоббитой нэгэн. Тэрбээр Гималайн нурууны зүүн салаа алдарт Кайлас хайрхны горооны 53 км замыг 19 цагийн дотор туулж, 5971 метрийн өндөртэй Далмапаст хөл тавьсан анхны монгол уулчин. Монголынхоо өндрийн оргил болсон хайрхнууд дээрээ ч мөн мөрөө гаргасан туршлагатай уулчдын нэг юм билээ.

Улсын Их Хурлын гишүүн Мигэйдоржийн БАТЧИМЭГ

ЗӨВ СЭТГЭЛ, ЗӨВ ТӨРХ



Тэрбээр 1973 онд Өвөрхангай аймагт инженер аав, багш ээжийн охин болж мэндэлсэн. Араасаа гурван дүү дагуулсан айлын ууган охин. Аюулгүй байдал, улс төр судлаач мэргэжилтэй. Англи, хятад, орос хэлтэй нэгэн. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын 21 жилийн туршлагатай. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, засаглал, батлан хамгаалах, гадаад бодлогын хүрээнд хүчтэй дуу хоолой болж чаддаг.

Монгол Улсын төрийн тогтолцоо, засаглалын хэлбэрийг сайжруулах чиглэлд бодлого боловсруулахад идэвхтэй оролцдог.

Төрийн ажилд гарч байгаа алдаа доголдолд улстөрчид буруутай ч сайн тогтолцоо бий болгохгүйгээр төрөө засч, улс орноо хөгжүүлж чадахгүй гэж М.Батчимэг үздэг. Муу хүнд завших боломж олгодоггүй, хувийн тоглолтыг бус хамтын ажиллагааг дэмжсэн засаглалын сайн тогтолцоог бий болгох нь эн тэргүүнд тулгамдаж буй асуудал үнэхээр мөн.

Үндсэн хуулийн шинэчлэл, засаглалын хэлбэрийг сайжруулах чиглэлд онолын судалгаа хийж ирснээ тэрбээр одоо практикт оновчтой ашиглаж байна. М.Батчимэг Үндсэн хуульд зөв өөрчлөлт хийх тухайд хүчтэй дуу хоолой болж ирсэн, УИХ-ын хэтийдсэн эрх мэдлийг Засгийн газарт шилжүүлэх нь зүйтэй гэж үздэг улстөрчдийн нэг. Төрийн албаны тухай, Улс төрийн намын тухай хуулиудыг шинэчлэх төсөл боловсруулахад идэвхтэй оролцож, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн боловсруулж УИХ-д өргөн барьсан.

Гадаад бодлогыг нэг цонхоор явуулах, албан тушаалтнуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, дипломат албыг бэхжүүлэхэд санаачилга гарган ажиллаж, Монгол Улсын гадаад харилцааны тухай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлсэн нь УИХ-аар хэлэлцэгдэн батлагдах шатандаа явж байна. Түүнчлэн М.Батчимэг

аюулгүй байдлын салбарт ажиллаж ирсэн туршлагатай цөөн гишүүний нэгийн хувьд батлан хамгаалах салбарын тулгуур баримт бичиг Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тогтоолын төслийг боловсруулах, УИХ-аар хэлэлцэн батлахад манлайлан оролцож байв.

Энэ бүхнээс үзэхэд улстөрч, УИХ-ын гишүүн хүн гэдэг олон талт асуудалд дүн шинжилгээ хийж, түүнийг нэгтгэн дүгнэх замаар бодлого боловсруулдаг бодлоготон байх нь зүйтэй гэх тодорхойлолтод М.Батчимэг яг таг тохирч байх шиг санагддаг. Хууль тогтоох байгууллагад ажиллаж, улс орны хөгжилд хэрэгтэй шийдвэрүүдийг хамтаар гаргах хүсэл эрмэлзлэл түүнд бий.

Бас үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны салбарт бодитой хийсэн ажил, туурвисан бүтээл түүнд олон бий. УИХ-аас 2010 онд шинэчлэн баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах ажлыг М.Батчимэг манлайлан ажилласан. Чухам тэр үеэс сэтгэлдээ тээж явсан зорилгоо ажил хэрэг болгож, Монгол хэлний тухай хуулийг санаачлан УИХ-аар батлуулсан. Энэ хууль нь үндэстэн оршихын баталгаа болсон эх хэл, соёлоо хамгаалахад жинтэй хувь нэмэр оруулах, цаг үеэ олсон чухал ажил боллоо хэмээн салбарын эрдэмтэн судлаачид, ард иргэд талархан хүлээж авсан юм. Эх орноо гадаадад таниулах, гадаад харилцааг хөгжүүлэхэд тустай олон томоохон ажил санаачилж хийжээ.

Тэрбээр Монгол бол Хятадын нэг хэсэг гэж үзэж, энэ байр сууриа дэлхийд зарладаг байсан Тайваний бодлогыг өөрчлүүлэхэд тууштай зүтгэсэн цөөн хүний нэг. Тайваньд улс орноо төлөөлөн ажиллаж байхдаа Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүндэтгэж, хүлээн зөвшөөрдөг гэсэн анхны бөгөөд цорын ганц нот бичгийг хүртэл гаргуулж авч байжээ. АНУ-ын Беркли дэх дэлхийд алдартай Калифорнийн Их сургуульд монгол хэлний хичээл заах, Монгол судлалын хөтөлбөрийг дахин эхлүүлэхэд М.Батчимэгийн гүйцэтгэсэн үүрэг багагүйг тус сургуулийн эрдэмтэн профессорууд, монгол судлаачид өгүүлдэг.

Хатуу зарчимч, мэдлэг боловсролтой аав, ээжийн үргэлжлэл болсон тэрбээр гэр бүл, гэр бүлийн хүмүүжлийг нийгмийн суурь асуудал, хувь хүний амжилтын үндэс гэж үздэг байна. Аав нь орон нутагтаа удирдах албан тушаал эрхэлж байсан хөдөлмөрч тууштай нэгэн бол ээж нь хатуу зарчимтай багш хүн. Гэр бүлийн ургийн бичгээс нь харвал аавынх нь талаас Ардын Их Хурлын гурван депутат төрж гарчээ. Тиймээс М.Батчимэг гэр бүлдээ дөрөв дэх УИХ-ын гишүүн гэсэн үг. Төрийн ажлынхаа хажуугаар түүх, гүн ухааны ном унших, судалгаагаа орхихгүйг хичээдэг аж. Буудлагын спорт сонирхдог агаад цаг зав гаргаж, тууштай хичээллэвэл ирээдүйтэй тамирчин гэж дасгалжуулагч нь үнэлдэг юм билээ.

Гэр бүл, нийгмийн сайн сайхны төлөө үйлсэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж явдаг тэрбээр гэр бүлд чиглэсэн олон ажил санаачилж, “Хайрлацгаая” сайн үйлсийн аянд нэгдэж, эрдэм номд шамдагч хүүхдүүдэд ухаалаг хөрөнгө оруулалт хийж явна. Түүнчлэн Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран ажилгүйдэл, архины хамаарал, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг бэрхшээлийг туулж буй 50 залуу гэр бүлийг хамруулж, мэргэжлийн болон гэр бүлийн сургалтад хамруулах, ажил амьдралын гараагаа зөв тавихад нь туслах ажлыг хэрэгжүүлж байгаа аж. Түүнчлэн УИХ-ын эмэгтэй гишүүдийнхээ хамтаар гэр бүл, хүүхдийн сайн сайхан, нийгмийн чиглэлийн санал санаачилгад идэвхтэй оролцдог нэгэн.

Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн БАТ-ЭРДЭНЭ

АВАРГА, ГАВЬЯАТ, БААТАР, ДОКТОР ГИШҮҮН



Монгол Улсын дархан аварга Б.Бат-Эрдэнэ бөхийн дэвжээндээ манлай амжилт, бахархалт сайхан замнал үлдээгээд улс төрд хөл тавьсан билээ. Адармаат улс төрийг зарим нэгний адил алдар хүнд олох арга, хөлжиж бэлжих боломж, нуугдах халхавч гэж тэр сонгоогүй. Учир нь түүнд хамгийн өндөр алдар нэр, боломжийн цагаан амьдрал байсан бол бултан нуугдах хар бараан үйлс, зам мөр байсангүй. Ингээд аварга маань аварга хүн хаана ч, юунд ч аварга л байдгийг харуулан УИХ-ын гишүүнээр анх 2004 онд төрөлх Хан Хэнтий нутгаасаа тодрон гарч ирсэн. Шинэхэн гишүүн тэр даруйдаа л хуучин шинэ бүх гишүүддээ даган дуурайх зөв үлгэрийг үзүүлж эхэлсэн. Энэ нь юу байв гэвэл чуулганы хуралдаандаа хэдэн минутын өмнө орж ирээд суучихдаг, бусдаас асуулт асуух, хэлэлцэж буй асуудлаар санал бодлоо хэлэхдээ зөөлөн дугаар уур бухимдалгүй ярьдаг монгол ахуй, монгол бөхөөсөө олж авсан эрхэм хоёр чанар нь байлаа.

УИХ-ын эрхэм аварга гишүүн маань анхнаасаа л байгаль дэлхийнхээ онгон дагшин, бүрэн бүтэн байдал, хүн ардынхаа тайван амгалан, тэгш дүүрэн амьдрал, хойч үеийнхээ гэрэлт сайхан ирээдүйн төлөө дуугарч, хууль санаачилж, хуулийн хэрэгжилтийг хангах талаар хичээл зүтгэл гаргаж, болж бүтэхгүй бүхэнтэй шаргуухан тэмцэж улстөрчийн замналаа эхэлсэн. Төрд үгээ хэлэх гэсэн, жагсаж тэмцсэн хэнтэй л бол хэнтэй аварга гишүүн маань очоод уулздаг, санал бодлыг нь сонсоод чуулганы танхимдаа бусаддаа дуулгадаг, зүгээр нэг дуулгаад орхихгүй хүмүүсийн санаа бодол, шаардлагыг тусгасан хуулийг санаачилдаг хүн ардаа гэсэн сэтгэлтэй төрийн жинхэнэ түшээ болон өсч өндийсөн. Энэ ч чанараараа тэрбээр УИХ-д гурвантаа сонгогдож ажиллахдаа ард түмэн, олон нийтийн хайр талархал хүлээсэн хамгийн ноён нуруутай, төрийн тулхтай зүтгэлтэн болохоо харуулж, чансаагаараа шилдгүүдийн тоонд тогтвортой багтсаар явна.

Баатар Б.Бат-Эрдэнэ гишүүний ямар цараатай улстөрч, нэр хүндтэй төрийн том зүтгэлтэн болсныг 2013 онд болсон Ерөнхийлөгчийн сонгууль яруу тод харуулсан. Төдийлөн шударга биш болсон энэ сонгуульд тэр “Миний нэр цэвэр, миний гар цэвэр, миний сэтгэл цэвэр” гэсэн алдарт үгээ хэлэн өрсөлдөж, нийт сонгогчдынхоо тэн хагасын саналыг авсан билээ. Олон зуун мянган гишүүнтэй нам нь түүний нэрийг Ерөнхийлөгчид дэвшүүлэхдээ ард түмний буюу намынхаа жирийн гишүүдийн саналд үндэслэсэн байдаг. Олон аймгийн сонгогчид онгоцны буудлаасаа аймгийнхаа төв хүртэл эгнэн зогсоод гар барин сайныг ерөөж, өвгөд хөгшид нь үнсэж, өөдөсхөн үрсээ аваргадаа үнсүүлж байсан нь сайхан.

Гавьяат Б.Бат-Эрдэнэ гишүүний тухай сэтгүүлчид, эрдэмтэд, улстөрчид, зохиолчид, бөхчүүд ярьсан нь хэвлэлийн хуудаснаа дурайна. Тэдгээрээс цөөн хэдийг ишлэвэл “Монгол эр хүнд байх учиртай хамгийн сайхан шинжүүдийг шингээснийх нь төлөө, монгол төрд дутагдаж буй бүхнийг нөхөж чадна гэж итгэсний учир би түүнийг дэмжиж байна”(Сэтгүүлч С.Батбаатар), “Аварга маань ажлыг үүсгээд орхидоггүй, тэвчээр заан эцсийн үр дүнг нь үздэг нэг онцлогтой”(Ардын уран зохиолч Д.Цоодол), “Б.Бат-Эрдэнэ шиг газар шорооныхоо төлөө тууштай тэмцэж байгаа улстөрч миний мэдэхээр лав алга” (Төр, нийгмийн ахмад зүтгэлтэн Г.Очирбат), “Улстөрчийн хувьд ухааны хуримтлал бат болсон хүн. Энэ нь УИХ-ын чуулган дээр хэлж буй үг, байр суурь, санал сэдлээс нь тодорхой харагддаг” (Доктор Б.Лигдэн) гэх зэрэг ажээ. Харин түүний тухай сөрөг юм хэлсэн хүн байна уу гээд шүүрдэхэд олдох юм алга.

Аварга, гавьяат Б.Бат-Эрдэнэ гишүүний нэгэн том гавьяа бол “Урт нэртэй хууль” хэмээн алдаршсан байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах тухай хууль билээ. Энэ хууль гараад хэрэгжиж эхэлсэн хэдэн жилийн дотор ган, зудын аюулгүй зун нь зун шиг, өвөл нь өвөл шиг болж, олон нуур цөөрөм, гол горхи эргэж сэргэснийг 4 жил тутамд хийгддэг усны тооллогын дүнгээс харагдаж байсныг монголчууд мартаагүй. Байгаль, хүн хоёрын хүйн холбоо гэдэг энэ. Аварга гишүүн маань Оюутолгойн булхайтай гэрээний тухай анхнаас нь хамгийн тод дуугарч, энэ гэрээг засч сайжруулах тухай хамгийн тууштай тэмцсэн. Тэрбээр “Дубайн гэрээ” гэгчийг бас л хүчтэй эсэргүүцсэн. Тэр бас гадаадаас тооцоо судалгаагүй их зээл авч байгааг эсэргүүцсэн байна. Энэ л асуудлууд өнөөдөр Монгол Улсын хувь заяаг дээсэн дөрөөн дээр тавиад байгааг хүн бүхэн харж байна.

Аварга, баатар гишүүн Б.Бат-Эрдэнэ гадаад, дотоодод ажлаар явсан тухайгаа аян замын тэмдэглэл бичин хэвлэлд нийтлүүлэх, нийтлэлүүдээ эмхэтгээд ном болгож хэвлүүлэх зэргээр бүтээлчээр ажилладаг. Гишүүн маань “Спортын эрх зүйн зарим асуудал”(2003), “Монгол бөхийн хөгжлийн үндсэн асуудлууд”(2014), “Миний байр суурь:Улс төр, Уул уурхай, Унаган байгаль” (2015), “Монгол бөхийн ариун ёс жудаг” (2016) номууд бичин хэвлүүлж, 2015 онд зургаан жил хийсэн судалгааны ажил бүтээлээрээ ОХУ-д докторын (Ph.D) зэрэг хамгаалсан байна.

Аварга, гавьяат, баатар, доктор гишүүн Б.Бат-Эрдэнийн амьдрахуйн зарчим нь “Алт ухахгүй, амьтны амь таслахгүй, архи үйлдвэрлэхгүй” гэдэг өөрөө өөртөө тавьсан тангараг. Энэ л зарчмаа даган улс төрд орохоосоо өмнө оюуны бизнес эрхлэн “Аварга” биеийн тамирын дээд сургууль байгуулсан нь энэ чиглэлийн дээд сургуулиудаа манлайлан амжилттай ажиллаж, олимп, дэлхийн анхдагч аваргууд, улсын их баяр наадмын түрүү бөхчүүдийг төрүүлсээр байгаа нь бахархалтай.

Улсын Их Хурлын гишүүн Дашдэмбэрэлийн БАТ-ЭРДЭНЭ МӨН ЧАНАРААС НЬ МОНГОЛ ҮНЭРТСЭН ТҮШЭЭ



Өөрийн эцэг, эхийн овгоос гадна ажил, мэргэжил, ааш араншин, үзэл бодол, хоч гээд онцгой содон шинжээрээ овоглогдон олноо алдаршсан хүмүүс байдаг. “Ажнай” Бат-Эрдэнэ тэдний нэг. Тэрбээр Өмнөговийн уугуул, өвөө, эмээ, ээжийн хүү, өнөө цагийн Монголын аргагүй содон эрхмийн нэг. Яагаад гэвэл тэр хаа байгаа газраа өөрийн гэсэн орон зайг үүсгэн, хүрээллийг эрхгүй болгож чаддаг хүн. Түүнтэй хамтарч, түүнтэй нөхөрлөж, хамгийн гол нь түүнд итгэж явдаг хүмүүсийн хүрээлэл их өргөн. Хэрийн нэгэн ингэж бусдыг дагуулж, хүндэтгэлийг хүлээж чаддаггүй, ясны лидер, манлайлагч хүнд л ийм чанар байдаг.

Өмнөговийн арван жилийн сургуулиа алтан медальтай төгсөөд Уралын их сургуулийг философич мэрэгжлээр дүүргэн, Цэргийн их сургуулийн багшаар ажил, амьдралын гараагаа эхэлж байхдаа, Монголын хувийн хэвшлийн салбарт анхдагчдын нэгэн болж “Ажнай” группийг үүсгэн байгуулж, өөрийнхөө овог болтол нь алдаршуулан бизнесийн салбарт тодрон товойхдоо, уугуул нутаг, Өмнөговийнхоо ард иргэдийн итгэл сэтгэл, хүндэтгэлийг хүлээн монгол төрийн түшээгээр сонгогдон төр, түмнийхээ төлөө зүтгэхдээ ч тэрбээр жинхэнэ ХҮН чигээрээ байж чадсан, өөрийн үзэл бодол, баримтлалаа цагийн салхины аяс даган өөрчлөөгүй, ааш араншингаа хувиргаагүй эрхэм. Ийм хүнийг монголчууд “ноён нуруутай” хүн гэгцгээдэг. Бизнес, нийгэм, улс төрийн салбарт түүнээс үлгэр авахуйц, даган жишээлэхүйц сайн жишээ, тоочин өгүүлэх амжилт олон буй ч тэр бүхнийг өгүүлэхэд бүхэл бүтэн ном бичихэд хүрнэ. Хэзээ нэгэн цагт Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнийн ертөнцийг бүхэлд нь илтгэсэн тийм ном ч гарах буй за.

Ханилж байж гэмээнэ хүнийг, унаж байж гэмээнэ хүлгийг таньдаг гэдэг. Басхүү хэлж ярьж буй үг, хандлагаар нь ч шинжиж болдог. Амьдралын жир цагт ч, албаны хийгээд чуулганы танхимд ч тэр, түүний агдан сандарч, бачимдан цухалдаж, бусад руу асан дүрэлзэж, эс бөгөөс телевизийн дуран руу тэмүүлэн

элдэв популист дүрд жүжиглэж байхыг нь харсангүй. Тэр өөрийнхөө натур араншингаа өөрчилж, хиймэл дүр эсгэж огт чаддаггүй, бусдыг тийм байхад ч туйлаас дургүй нэгэн. Ярихаас илүү бодож, тунгаах нь түүний эрхэм чанарын нэг. Энэ нь аливаа учир шалтгааныг зөв дэс дараалал, зүй тогтлоор нь шинжилж судалдаг философич мэргэжилтэй нь холбоотой байх.

Түүнээс анзаарагддаг бусдаас онцгой басхүү нэгэн зан чанар бий. Өнөө цагт туйлын ховордсон МОНГОЛООРОО байх, жинхэнэ МОНГОЛ ХҮН байх, монгол хүний үнэ цэнэ, монгол ухаан, соёл, өв уламжлалыг дээдлэн биширдэг бүр гайхалтай хүчтэй үзэл бодолтой, бат итгэлтэй, үүнийгээ ч бусдад түгээж явдаг эрхэм.

“...Үндэстэн өөрийн гэсэн өвөрмөц шинж, төрхөө алдаж эхэлбэл үндэстэн биш болж, мөхлийн сүүдэр нөмөрнө гэсэн үг. Монголчууд эх түүх, зан заншил, хэл, соёлоороо ямагт бахархах учиртай. Бид бол язгуурын эзэн заяатай үндэстэн. Биднийг хэн ч дийлж байгаагүй, дийлэгдэх ч ёсгүй...”

“...Хөгжил гэдэг ганц хөрөнгө мөнгөнд суурилдаг зүйл биш ээ, түүнийг цогцлоодог, бүтээдэг чадвар, зөв зохицуулдаг ухаан, эв нэгдэл, ёс зүй, бахархал, хүндлэлийг бий болгодог монгол зарчим, үндэстний өв соёл, оюуны сэтгэлгээ, бидний хүлээсэн үүрэг, хариуцлага, эх оронч үзэл санаанд суурилдаг юм...” Тэрбээр ийн хэлдэг.

Басхүү Монгол хамгийн хүчирхэг улс болно. Монгол хүн, Монголын улаан паспорт энэ дэлхийд хамгийн үнэ цэнэтэй болно. Тийм цаг удахгүй, ийм байхын төлөө монгол хүн бүр хичээн зүтгэх ёстой гэж ярьдаг, үүндээ ч хатуу итгэл үнэмшилтэй хүн. Мөн чанараа монголоороо, гэхдээ чин сэтгэлээсээ ингэж гоёж, эрчмээр цэнэглэж явдаг түшээд олон байвал улс орон маань өндийн босно оо. Өнөө цагт бид бүхний хүн чанарыг зулман шарах арчаагүй зан суртахууны түймэр дундаас юунд ч хайлахгүй, шатахгүй, бас хэзээ ч хөлдөхгүй, жинхэнэ хүн чанарын халуун илч, гэрэл, гэгээ гэрэлтүүлэн яваа эрхмийн нэг бол Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ. Амьдралын замнал нь үүнийг нотлох бөлгөө. УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар ажиллаж байхдаа тэр өөрийн мөн чанараа тодоор илтгэсэн. Монгол Улс, монголчуудынхаа төлөө үнэнийг харж, зөвийг олох хараа, ухаан, сэтгэл зүтгэл түүнд хангалттай буй.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Зангадын БАЯНСЭЛЭНГЭ ГЭР ХОРООЛЛООС ТӨРСӨН ТҮМНИЙ ТӨЛӨӨЛӨЛ



Зангадын Баянсэлэнгэ 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар МАХН-аас нэр дэвшин намын жагсаалтаар Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, 2012-2013 онд Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргын алба хашиж байв. Улмаар 2015 оны 9 дүгээр сараас Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байна.

Бүрэн эрхийн хугацаанд Засгийн газрын тухай, Гэр бүлийн тухай, Хог хаягдлын тухай, Галт зэвсгийн тухай, Өршөөлийн тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Эрүүл ахуйн болон холбогдох хуулиуд, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг олон хууль тогтоомжийн төслийн санаачлагч болон хамтран санаачлагчийн хувьд эдгээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, батлуулахад санаачилга, идэвхи зүтгэлтэй ажилласан гишүүн. Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох орчны талаар санал боловсруулах, Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгүүдэд орж ажиллажээ.

Парламентын хашир түшээд ч түүнийг үнэлдэг

Нийслэлийн гэр хорооллоос, эгэл ардын гэрээс төрийн түшээ болж чадсан энэ бүсгүйн улс төртэй анх холбогдсон түүх их энгийн. 2012 онд УИХ-ын гишүүн болохоосоо өмнө хэрэг бүртгэгч, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн арбитрч, хорооны Засаг дарга, хүн ам гэр бүлийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн гээд төрийн албыг хашиж явсан нь түүнийг иргэдийн амьдралыг гүн дотроос нь мэдэрч, ойлгож чадсан нь төрийн түшээ болох эхлэлийг тавьсан биз ээ. Улс төрд орсон хугацаа нь ахархан ч олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож,

эрх мэдэлтнүүдийн аливаа хууль бус шийдвэрүүдийг зоригтой шүүмжилдэг, дуу хоолойгоо хүргэдэг байсан нь түүнийг хэдийнэ олны танил болгосон гэхэд хилсдэхгүй.

Анх түүнийг УИХ-ын гишүүн болоход “гэр хорооллоос шарилж ургахаас биш сарнай дэлбээлдэггүй” хэмээн гоочилж байлаа. Гэвч чин сэтгэл, хичээл зүтгэл байвал ямар амжилтад хүрч болдгийг тэр харуулж чадсан юм. Түүнийг олны хэлдгээр “аз” түшдэг. Гэвч амьдрал сохор азаар дардан яваад байдаггүй. Түүнд багын дайчин, тууштай зоримог зан болоод аливаа зүйлийг соргогоор хүлээж авч оновчтой шийдвэр гаргадаг, аливаа мэдээллийг өөрийн болгож өөртөө нягт суулгаж чаддаг суурь чадвар, боловсрол байсны ачаар тэр богино хугацаанд улс төрд хэнээс ч дутахааргүй төлөвшиж сайн түшээ болж чадсан билээ. Парламентын хашир түшээд хүртэл түүнийг онцгойлон магтсан нь бий. Үнэхээр ч үнэн үг, шударга байр суурь, хэний ч нөлөөнд автахгүй үзэл бодолдоо үнэнч байдаг зан чанар нь түүнийг улс төрд цоо шинэ “тод өнгө” болгож хувиргасан юм.

Барилгын салбарын анхны эмэгтэй сайд

Төсөв мөнгө нь тасалдаж, орон сууц, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурснаас цөөнгүй бэрхшээл, хүндрэл тулгарсан хүндхэн цаг үед барилгын салбарт төрийн эмх цэгцтэй, холыг харсан бодлого, тууштай хэрэгжилт, сахилга бат, хот төлөвлөлтийн нарийн уялдаа холбоо, мэргэжилтэй ажиллах хүчний хангамж гээд олон талын өөрчлөлт шинэчлэлт, оновчтой зоримог шийдвэр гаргах “зангидсан гар” хэрэгтэй байв. Харин Засгийн газраас УИХ-ын гишүүн З.Баянсэлэнгэд энэхүү хариуцлагатай үүргийг оноож Барилга, хот байгуулалтын сайдаар томилсон билээ. Ийм чухал салбарыг удирдаж байгаагийн хувьд З.Баянсэлэнгэ өмнөх сайд нарын шийдвэр, тогтоол, стратеги төлөвлөлтийг үргэлжлүүлэхийн хажуугаар өөрийн гэсэн бодлогын түвшний олон ажлыг гүйцэтгэж амжсан.

Удтал яригдсан Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар батлуулсан бөгөөд өмнөх хуульд байгаагүй, амьдралд нийцэхгүй олон зохицуулалтыг тусгахад сайдын үүрэг оролцоо тун чухал байр суурь эзэлсэн. Энэ салбарт ажиллаж байгаа зуу гаруй мянган хүн, аж ахуйн нэгж, цаашлаад энэ салбарын хэрэглэгчид болох бүх ард иргэд, олон нийтийн эрх ашгийг хамгаалсан, төрийн бодлогыг оновчтой тодорхойлсон, цаг үеэ олсон хууль зүйн шийдлийг тэр өлгийдөж авсан юм. Салбарын сайдаар ажиллах хугацаа нь багахан ч бодлого хэрэгжүүлэлтийн тал дээр ипотекийн зээлийг сэргээсэн, түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн, газрын анхны үнийг шинэчилсэн, барилгын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой бүх төрлийн зөвшөөрлийг тодорхой хугацаатай болгосон, хүнд суртал ихтэй ажиллагаануудыг мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлэхээр болсон, бригадаар ажилладаг хүмүүсийг даатгалжуулж, цалингийн доод хэмжээг тогтоосон гээд энэ салбарынхны талархлыг хүлээсэн ажлуудыг ч тэр амжуулж чадсан юм. Бас ахмадуудаа ипотект хамруулах, гэр хорооллыг амины орон сууцны хороолол болгох, төрийн ажлыг хөнгөвчилж иргэддээ чирэгдэлгүй болгох гэсэн олон санаа, чин сэтгэл нь түүнийг салбарын томоохон бодлогын зохицуулалтын, их бүтээн байгуулалтын оргил өөд хөтөлж явна.

Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн БАЯРСАЙХАН

**ШИНЭ САЙД ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫГ
ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛАВ**



Гарьдхүүгийн Баярсайхан. Энэ нэр Монголын улс төрд ч, монголчуудад ч хэдийнэ танил болжээ. Хэдийгээр түүний нас залуу, дөнгөж дөч гарч яваа ч Монголын улс төрд магтаал, шүүмжлэл, гүтгэлгийн аль алиныг хангалттай амсч, тэр хэрээр улстөрчийн хувьд төлөвшиж амжсан нэгэн. Төрийн эрх барьж, хууль тогтоох дээд байгууллага УИХ-д хоёронтоо сонгогдсон нь Гарьдхүүгийн Баярсайханыг үеийнхнээс нь тодруулах нэг том онцлог.

Гарьдхүүгийн Баярсайхан УИХ-д анх удаа “Ногоон бүлэг” байгуулж журмын нөхдөө төдийгүй сөрөг хүчний улстөрчдийг ч “уруу татаж” чадсан. Олноо “Ард Аюуш” хэмээн хүндлэгдсэн Хөх овогт Алдаржавын Аюушийн үр сад тэрбээр хөрс судлаач эрдэмтэн аавынхаа үргэлжлэл болж, эх орныхоо газар шороо, байгаль экологийн төлөө сэтгэл чилээн зүтгэснийх нь үр дүнд өнөөдөр ногоон хувьсгал ярьдаггүй түшээ ховор болсон нь яах аргагүй үнэн. Бүрэн эрхийн хугацаанд нийт 43 ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд санаачилсан болон УИХ-ын гишүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдээс ихэнх нь чуулганы хуралдаанаар орж батлагдсан байна. Санаачлан боловсруулж өргөн барьсан хуулийн төслүүдийнх нь зарим гол санааг онцлоход “Газар өмчлүүлэх ажиллагаанд тэгш, шударга байдлыг бий болгоно”, “Хог хаягдлыг ангилал, тээвэрлэх, дахин боловсруулах асуудал шийдэгдэнэ”, “900 мянга гаруй иргэн даатгалаа нөхөн тооцуулах боломжтой болов”, “Хамтын тэтгэврийн даатгал үр өгөөжөө өгнө”, “Эмнэлгийн удирдлагыг сайд томилохгүй”, “Донорын тухай хуулийг өөрчлөв”, “Хот тосгод өөрийн дүрэмтэй болно” гэх зэргээр улс орны нийгэм, эдийн засаг, иргэдийн амьдралын чухал асуудлуудыг хөндсөн байх жишээтэй.

Улс төрд дардан биш даваа гүвээтэй замыг тэвчээртэй туулсан залуу улстөрч парламентад Ёс зүйн дэд хороог хамгийн удаан тэргүүлсэн нь ч нэгийг

өгүүлнэ. Тэрбээр 2012-2014 онд УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажиллаж, 2015 оноос Шийдлийн Засгийн газарт Хөдөлмөрийн сайдын амаргүй албыг хаших болсон юм. Тэрбээр сонгогдсон, томилогдсон албан тушаал бүртээ өөрийгөө хэн бэ, юу хийж бүтээж чадах вэ гэдгээ тун ч хурдтайгаар харуулж чаддаг. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай асуудал нь байгаль хамгаалах бодлогын цөмд байх ёстой гэсэн хатуу байр суурьтай Байнгын хорооны залуу дарга эх орныхоо байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахын зэрэгцээ сүйрч доройтсон газар нутгийг нөхөн сэргээх, түүх, соёлын өвийг хамгаалах, дэлхий нийтэд нүүрлэж буй уур амьсгалын өөрчлөлтийн улмаас багассан усны нөөцийн хомсдол, түүнээс улбаалсан цөлжилтийг зогсоодоггүй юм гэхэд нэмэхгүй байх чиглэлээр дорвитой ажлуудыг хийж, хэрэгтэй хуулиудыг батлуулж чадсан билээ. Үүнийг нь үнэлж түүнийг “Байгальд ээлтэй гишүүн”-ээр хоёронтоо өргөмжлөөд байгаа.

Хөдөлмөрийн сайдаар томилогдоод ч энэ салбарт шинэдэж түүртэхгүй нэгэн гэдгээ мөн л богинохон хугацаанд харуулж амжсан. Эдийн засгийн хямрал дагаж ажилгүйдэл нэмэгдсэн хөдөлмөрийн зах зээлийн байдал сайнгүй нөхцөлд салбар удирдахаар томилогдсон тэрбээр ард иргэдийнхээ амьдралыг сайжруулахын тулд ажилтай, орлоготой байлгах бүхий л бололцоог судалж, хэрэгтэй шийдвэрүүдийг зоригтой гаргаж ирсний үр дүн эхнээсээ гарч байна. Үндэсний боловсон хүчний хомсдолд орсон салбаруудад цоо шинэ ажиллах хүч бэлтгэх санаачилгыг амжилттай өрнүүлж чадсанаар гаднаас ажиллах хүч авдаг хэд хэдэн салбар бусдын гар харахааргүй өөрийн гэсэн үндэсний мэргэжилтнүүдтэй болж байна. Малчдын залуу халааг төрөөс бодлоготойгоор бэлтгэхээр нээсэн “Сайн малчин” анги ч түүний санаачилга, цэргийн алба хаагчдыг зах зээлд эрэлттэй мэргэжлээр сургах, Дэлхийн банк, Фридрих Эбертийн сангуудтай хамтран ажилласан, Р.Гандийн нэрэмжит сургууль шинэ тоног төхөөрөмж хүлээн авлаа, Японд ажиллах дадлагажигчийн тоог нэмэх гэхчилэн хөдөлмөрийн салбарыг хөдөлгөөнд оруулж, улс орны хөгжлийн хувьд цонх болчихоод байсан орон зай түүнийг энэ яаманд ирснээс хойш нөхөгдсөн нь үнэн. Энэ бүхэн нь түүний хийж хэрэгжүүлсний ердөө нэг л хэсэг.

Түүнд бусад гишүүдээс давуу бас нэг чанар байдаг нь сонгогчиддоо дэндүү үнэнч. Чингэлтэй дүүргийн хэмжээнд: “Гудамж” төсөл-Чингэлтэйд, Гэр хорооллын дахин төлөвлөлт-Чингэлтэйд, Гэр хорооллын гудамж, залга холбосон нийт 11 гүүр барьсан, Халуун сэтгэл аян-Чингэлтэйд 7000 хүүхэд баярлуулав, Долоон буудлын эцэст “Улаанбаатар номын сан” байгуулсан, 700 гаруй ахмадыг амралт, сувилалд амраалаа, дүүргийн хэмжээнд 5 цэцэрлэгийн хөрөнгө оруулалтыг, сургуулийн урсгал зардал, дүүргийн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгыг буулгаж шинээр барих хөрөнгийг, сургуулийн урлаг спортын заалыг өргөтгөх, спорт цогцолборын барилгын хөрөнгө зэргийг улсын төсөвт суулгах ажлыг гүйцэтгэсэн гээд хийсэн ажлуудыг нь тоочвол барахгүй.

Гарьдхүүгийн Баярсайханд төрийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргах чадвар хангалттай суусан. Хувь хүнийхээ хувьд ч их эрч хүчтэй, бас хурдтай. Гэхдээ шийдвэрийг өөрийнхөөрөө гаргачихдаг “гэмтэй”. Тэр шийдвэр нь буруу биш байсан гэдгийг нийтлэлд дурдсан цөөн хэдэн баримт, бас түүний ямар нэг муу юманд хутгалдаагүй нэр цэвэр, хийсэн бүтээсэн юмгүйгээс цэрвэн УИХ-д нэр дэвших тойргоо сольж зугтдаггүй шалтгаанууд цухасхан боловч харуулна.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэлмаагийн БАЯРСАЙХАН

АСУУДЛЫН ГОЛЫГ ОЛЖ ХАРДАГ УЛСТӨРЧ



УИХ-ын гишүүн Ц.Баярсайхан өнөөгийн парламентад суугаа өндөр боловсролтой цөөн хэдэн улстөрчид, тэр дундаас парламент дахь шилдэг эдийн засагчдын нэг. Улсын мөнгө санхүүгийн бодлого, эдийн засгийн анхаарал татсан асуудалд дуугардаг, даацтай үг хэлдэг, эдийн засгийн чиглэлийн хууль тогтоомж боловсруулахад түүний үг, санал бодол их нөлөөтэй. Үүнийг нь ч төр, засгаас өндрөөр үнэлж, түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Гавьяат эдийн засагч цолоор шагнасан. Түүний оруулсан санал, боловсруулсан хуулийн төсөл нь дандаа жинтэй байдаг нь түүнийг ямархуу чадварлаг эдийн засагч болохыг хэлээд өгнө.

Барилгын салбарыг хөл дээр нь босгосон сайд

УИХ-д дөрвөн удаа сонгогдож, 16 жил төрд ажиллах хугацаанд нам нь болон төр түүнд дандаа чухал албан тушаалыг даатгаж байлаа. Тэр тусмаа уналтад орсон, эсвэл хөгжлийн зөв замаар явуулах шаардлага үүссэн салбарыг түүнд итгэж хариуцуулдаг. Тэрбээр Эдийн засгийн байнгын хорооны даргаар удаа дараа сонгогдож ажилласны зэрэгцээ Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Барилга хот байгуулалтын сайдаар ажиллаж байв. Тухайлбал, 2012 онд АН-ынхан олонхийг бүрдүүлэх эрхийг авч Засгийн газраа байгуулахад түүнийг Барилга, хот байгуулалтын сайдын албан тушаалд томилсон. Барилгын үнэ тэнгэрт хадчихсан, дотоодын компаниуд хаалгаа барьж, барилгын материалыг урдаас хямд үнээр татаж байсан цаг. Яг энэ үед Ц.Баярсайхан сайд Засгийн газар болон Монголбанктай хамтран Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн дотоодын барилгын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжсэнээр импортын бараа материалаас хямд үнэтэй атлаа чанартай бараа бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн түүнийг сайд байх үед эхлүүлсэн найман хувийн хүүтэй зээлийн ачаар олон мянган айл өрх тохилог орон сууцтай болов. Арван мянган залуус энэ хөтөлбөрийн ачаар зорилготой амьдарч, мөн барилгын компаниуд ч дампуурлаас гарч чадсан билээ. Найман хувийн хүүтэй зээл нь ямархуу нүдээ олсон бодлого байж вэ гэдгийг эдүгээ таван хувьд хүргэж үргэлжлүүлэн олгож байгаа шийдвэрээс харж болно.

Асуудлын голыг олж хардаг улстөрч

Тэрбээр дөрвөн удаа УИХ-д сонгогдохдоо хууль боловсруулах, батлуулах үндсэн үүргээ хангалттай гүйцэтгэжээ. Малчдын амьдралд бодит дэмжлэг болсон “Монгол мал” хөтөлбөрийг нэр бүхий гишүүдтэй хамт санаачлан боловсруулж батлуулж байв. Үндсэн хуулийн гажуудал өнөөгийн засаг төрийн сул, тогтворгүй байх шалтгаан болж буйг тэр хамгийн түрүүнд олж харж, өмнөх УИХ-ын үед Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэр бүхий гишүүдтэй хамт санаачилж байв.

Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллаж байхдаа иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор Хотыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг өргөн барьж байлаа. Чамгүй урт хугацаанд хэлэлцүүлэгт орж, маргаан мэтгэлцээн үүсгэж явсаар энэ хууль өнгөрсөн онд эцэслэн батлагдсан. Ингэснээр буруу төлөвлөлтөөр явж ирсэн гэр хорооллыг дахин төлөвлөх, нийтийн эдэлбэр газар, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг шинээр барих зэрэг асуудал хуулиар баталгаажиж, өдгөө гэр хорооллын дахин төлөвлөлт, хуучин барилгуудыг нурааж шинэ барилга барих ажил шат дараатай, эрчимтэй хийгдэж иргэдийн талархлыг зүй ёсоор хүлээж байна.

Мөн аялал жуулчлалын байгууллагаас хөтөч-тайлбарлагч хүртэл нарийн зүйл, зааптуудыг тусгасан Аялал жуулчлалын тухай хуулийг санаачилж батлуулав. Байгаль хамгаалах асуудлын хүрээнд нэлээд хууль тогтоомж батлуулснаас Тусгай хамгаалалттай газар орчны бүсийн тухай хуулийг санаачлан, Монгол Улсын нийт газар нутгийн 11 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар байсныг 16 хувь болгож нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулжээ. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих Зээлийн батлан даалтын сангийн тухай, Компанийн тухай, Статистикийн тухай зэрэг түүний автортай хууль чамгүй олон бий.

Ц.Баярсайхан гишүүнд Өмнөговийн ард түмэн 100 хувь итгэл үзүүлдэг. Төрд өөрсдийгөө төлөөлүүлэх хүнээр түүнийг гурван удаа сонгож илгээсэн гэхээр тэрбээр ямархуу нэр хүндтэй улстөрч вэ гэдэг нь тодорхой. Эрхэм гишүүн нутгийн зон олныхоо итгэлийг алдсан удаагүй. Олон улсын нисэх онгоцны буудалтай болгох ажлын араас цөхрөлтгүй явсаар орон нутгийн чанартай, хатуу хучилттай хөөрөх, буух зурвастай болгосон. Аймгийнхаа сумдыг эрчим хүчний асуудлаас гаргах зорилтоо биелүүлсэн. Аймгаа нийслэл хоттой хатуу хучилттай замаар холбох ажлыг ч гар бие оролцон хийлгэсэн гээд амлалтаа биелүүлсэн, биелүүлэх гэж эхлүүлсэн ажлыг нь дурдаад байвал дуусахгүй.

Авлига, мөнгө хөрөнгөний элдэв асуудлаас холуур, тулхтай, нэр цэвэр, ажлаа мэддэг, амласнаа биелүүлж чаддаг чанарыг нь намын хамт олон, сонгогчид нь хүлээн зөвшөөрч түүнийг УИХ-д дөрвөнтөө сонгожээ. Боловсролтой улстөрч эрж хайдаг болсон энэ цагт эрхэм гишүүний эдийн засгийн мэдлэг Монгол Улсын хөгжилд, тэр тусмаа эдийн засгийг солонгоруулах их үйлсэд нэмэр болох нь дамжиггүй.

Улсын Их Хурлын гишүүн Сангажавын БАЯРЦОГТ

АЧАА ДААХ ЧАДВАР



Сэлэнгэ нутгийнхаа төдийгүй Монгол Улсынхаа төлөө, Монголын ардчиллыг бэхжүүлэхийн төлөө чөмгөө дундартал зүтгэх чин үнэнч сэтгэлтэй нэгэн бол С.Баярцогт. Монголын парламентын түүхэнд Сэлэнгийн, Сүхбаатарын, Сангийн, Сангажавын гээд Баярцогтыг нэрлэх нь бий.

Сангажавын Баярцогт 1967 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод төрж, 1984 онд Г.Бумцэндийн нэрэмжит Сүхбаатар хотын 1 дүгээр сургуулийг алтан медальтай төгсчээ. Улмаар 1989 онд Ломоносовын нэрэмжит Москвагийн улсын Их сургуулийг эдийн засгийн ухааны багш, эдийн засагч мэргэжлээр, 1996 онд ХБНГУ-ын Баден-Вюртембергийн гадаад худалдааны академийг бизнес удирдлагын мэргэжлээр, 2002 онд АНУ-ын Нью-Йорк хотын Колумбын их сургуулийг олон улсын эдийн засагч мэргэжлээр, 2003 онд Монгол Улсын Их сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн. Эдийн засгийн онолын багш, эдийн засагч, хуульч мэргэжилтэй. Олон улсын эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

Сэлэнгийн гэхийн учир нь С.Баярцогт ажил хөдөлмөрийн гараагаа Сэлэнгэ аймгийн Эвлэлийн хорооноос эхэлжээ. Аливаа хурал цуглаанд тэрээр шударга, үнэний дуу хоолой болж, хэлэх гэсэн үгээ шууд хэлчихдэг байсан нь магадгүй цөөнгүй хүний бухимдлыг төрүүлж байсан ч бас олон хүний итгэлийг мөн олж авч байлаа. С.Баярцогт нь МХЗЭ-ийн онц их хурлаар Эвлэлийн төв хорооны дэд даргаар сонгогдов. Төдөлгүй Монголын парламентын түүхэнд хамгийн залуудаа буюу 23-хан насандаа Ардын Их Хурлын депутатаар сонгогдож, улмаар шинэ Үндсэн хуулиа батлалцаж, Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогджээ. Тэрбээр Монголын залуучуудын холбоог 1997 он хүртэл удирдаж, намын үзэл суртлын байгууллагаас бие даасан хараат бус төрийн бус байгууллага болгон төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд хүчин зүтгэлээ нэмэрлэжээ.

1992 оны анхны ардчилсан чөлөөт сонгуулиар өрсөлдөж ялагдал хүлээсэн нь түүний хувьд ялагдал биш ялалт байв. Учир нь тэрбээр ялагдлыг боломж болгон харж ХБНГУ-д суралцсанаар илүү мэдлэгтэй, илүү алсын хараатай, илүү хүчирхэг болж чадсан. 1996 оны УИХ-ын сонгуульд аймагтаа өрсөлдөн ялалт байгуулсан цагаас хойш нийтдээ таван удаа Сэлэнгэчүүдийн итгэлийг хүлээж УИХ-д сонгогдов. Итгэнэ гэдэг их хүндлэл, тэрхүү олон түмний итгэлийг дааж явах их ачааг тэр өөрөө сонгоогүй, харин Сэлэнгэчүүд түүнд үүрүүлсэн юм.

Сангийн гэхийн учир нь С.Баярцогт УИХ-ын гишүүн, Байгаль орчны сайд, ЗГХЭГ-ын дарга зэрэг төрийн өндөр албыг хаших хугацаандаа үргэлж ачааны хүнд болгоныг үүрч гарсан байдаг. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг угтаж Төрийн ордны бунхныг шилжүүлж, их эзэн Чингис хааны хөшөө цогцолборыг байгуулах нүсэр ажлыг гардаж зохион байгуулсан. Архины лонх дээр байсан Их хаан энэ цагаас эхлэн Төрийн ордон, төв талбайнхаа хоймор заларсан түүхтэй.

2008-2012 онд түүнийг Сангийн сайдаар ажиллах хугацаанд дэлхийн эдийн засгийн хямралыг Монгол Улс эрсдэл багатай даван туулсан юм. Мөн олон Засгийн газар дамжиж ирсэн Оюутолгойн түүхэн гэрээ түүнийг Сангийн сайдаар ажиллах хугацаанд байгуулагдаж Монгол Улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрсэн байдаг.

Монголын ард түмэн, Сэлэнгэ нутгийнхан түүнийг 23-хан настай байхаас төрийн хамгийн хүнд ажлыг үүрүүлж, Монголын Улсын хөгжилд зүтгүүр болгож ирсэн түүхтэй. Ардчилсан хувьсгалд манлайлан оролцсон, ардчилсан Үндсэн хууль батлалцсан, ОХУ-д төлөх их өрийг тэглэх ажлын хэсгийг ахалсан, хамгийн олон хууль санаачилсан Сэлэнгийн, Сүхбаатарын, Сангийн сайд, Сангажавын Баярцогтод ард түмэн илүү их ачааг үүрүүлэх учиртай. Учир нь С.Баярцогт шиг хат сууж, хал үзсэн, төрийн жинхэнэ хар хүнийг бэлдэхэд хамгийн багадаа 20-30 жил шаардагдана.

Тэрбээр 2012-2016 оны бүрэн эрхийн хугацаандаа Засгийн газрын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын бодлогыг тодорхойлох, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичиг, төсвийн шинэчлэл хийх, төрийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа хууль журмууд, хөрөнгө оруулалт, татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэсэн олон хууль тогтоомжийн төсөл боловсруулж батлуулахад санаачилга, зүтгэлээ нэмэрлэж хэд хэдэн ажлын хэсгийг ахалж ажиллажээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын Япон Улсад хийх ажлын айлчиллын бэлтгэлийг хангах, Монголын эдийн засгийн чуулганыг зохион байгуулах зэрэг ажлыг амжилттай хэрэгжүүлж, Ази, Европын дээд түвшний уулзалт /АСЕМ/-ыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажиллаж байна.

Төр мэдэхүй сайдаа гаднаа суулгаж

Зэвийн морио гэр зуур унаж

Бухгүй үхэр, азаргагүй адуу мэт бид явах ёсгүй гэсэн мэргэн үг байдаг.

Сангажавын Баярцогтод илүү их итгэл хүлээлгэж, илүү их ачаа үүрүүлэхэд түүний туршлага, мэдлэг, чадвар, Монголын төлөө гэсэн сэтгэл багадахгүй ээ.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанвандангийн БОЛД

ҮНДЭСНИЙ СЭХЭЭТЭН



Чингисийн үеэс л ертөнцөд танигдсан Монголын нийгэм, улс төрийн элит хэсгийн удам XX зууны эхээр таслагдсан юм. Алтан ургийн ноёд, тайж нар, хутагт гэгээдийг устгаснаар Монголын оюун санааны хөтөч явж, их гүрний бодлого боловсруулж, үндэстнийхээ голомтыг хадгалах үзэл санааны хөтөч нар дууссан.

XX зууны 1930-50-иад он бол сэхээтний тасалдлын үе байв. Харин их хядлага, дэлхийн дайн аль аль нь дуусч, нийтээрээ хотжин боловсорч эхэлсэн тэр цагаас буюу XX зууны дунд хэсгийг дамнан шинэ Монголын үндэсний сэхээтэн төрж эхэлсэн юм.

Тэдний нэг нь XX зууны сэхээтэн, гоо зүйч С.Лувсанвандан юм. Монголын говь нутагт малчны гэрт төрж өсөөд эрдэм боловсролын мөр хөөж, нэрт эрдэмтэн, шинэ цагийн гэгээрүүлэгч болсон түүний замнал нь манай соёлын амьдралын тод жишээ болж харагддаг. Түүний энэ сонирхолтой намтар нь миний сэтгэлийг татаж, “XX Зууны сэхээтэн С.Лувсанвандан: Жимээс Замд” ном бичсэн юм. Нэг ном бичээд зогссонгүй, шинэ цагийн соёлын сэдэв миний хобби болж эхэлсэн бөгөөд “Соёлын довтолгоо: Хоньчноос барилгачин”, “Иргэншлийн замд: Монголын соёлын альманах” зэрэг бүтээлийн маань сэдэл болсон билээ.

С.Лувсанвандангийн өөрийн төдийгүй гэр бүлийн намтар нь их сонин. Нэг талаасаа их нийтлэг юм. Монголын малчин ардын хүүхдүүд хэрхэн үндэсний сэхээтний алтан аргамжийн тасархайг биеэр залган үргэлжлүүлсэн түүхийн гэрч харагддаг. Бас хэрхэн гэр орноо шинэ цагийн сэхээтний гэрийн сургууль болгохыг зорьж, үр хүүхдээ хүмүүжүүлсэн туршлага нь бас л сонин бөгөөд судлууштай үлгэр болж харагддаг.

Харин Лувсанвандангийн буюу Лу.Болд бол манай улс үндэстний амьдралд үе залгамжилсан сэхээтнүүд төрж эхэлсний жишээ юм. Манай эх оронд үндэсний оюун ухааны залгамж халаа бий болсны гэрч бөгөөд энэ үеийнхэн өнөөдөр манай улсын ачааны хүндийг үүрч явна.

Л.Болд 1990 оны ардчилсан хувьсгалын тугийг өргөлцсөнөөсөө хойш улс орныхоо шинэчлэлийг манлайлж яваа хүн.

Манлайд явж харагдах, манлайлах хоёр бас өөр шүү. Эхнийх нь албан тушаалтан, удаах нь зохион байгуулагчийн нэр. Түүний удирдсан салбар сайн зохион байгуулагчийн гарт орсон нь дорхноо мэдрэгдээд ирдэг юм. Батлан хамгаалахын сайд байх үед нь Монголын энхийг сахиулагчдын үүрэг, нэр хүнд хэрхэн өсч, зэвсэгт хүчний сурталчилгааны оргил үе эхэлж, нэгэн үе цэрэгт мордохгүй гэж танил тал хайдаг байсан залуус цэрэгт явах гэж арын хаалга эрдэг болсныг хүмүүс мэдэх тул нуршаад яах вэ.

Түүнчлэн өнөөдөр олон хүн “Миний АСЕМ”, “Би АСЕМ хийхийн тулд” хэмээн бахдаж байгаа дэлхийн чуулганыг эх орондоо хийлгэх, зохион байгуулах ажлыг сэдэж, бэлтгэлийг нь ханган, товлуулсан хүн бол тэр үеийн Гадаад хэргийн сайд Л.Болд гэдгийг мэдэх нэг нь мэдэж байгаа. Олон юм бий л дээ, олон ч хүн мэднэ. Жишээлэхэд, тойрогтоо юу хийснийг нь сонгогчид нь хэлэх байх.

Үндэсний сэхээтнүүд нийгэм, улс төрийн шуурган дунд урсаж биш сөрж явах ёстойг үлгэр жишээчээр харуулж яваа Л.Болд хүний эрхийн төлөө тэмцэгч гэдгээрээ бусад улстөрчөөс ялгардаг. Зүгээр ч нэг хэлж яриад явалгүй хүний эрх, эрх чөлөөний төлөө хууль, эрх зүйн салбарт хувьсгал хийлцсэн гэдгийг нь онцлох хэрэгтэй юм.

Ер нь аливаа парламент ямар нэг томоохон хууль, эрх зүйн шинэчлэлийг хийх гол зорилготой байдаг. Харин энэ удаагийн парламентын гол шинэчлэл нь хууль, эрх зүйн салбарт хийсэн хүний эрхийн том хувьсгал гэж үзвэл Л.Болд гишүүн нэг автор нь болж биелүүлж өгсөн бөгөөд үүнийг өмч хувьчлал, улс төр, эдийн засгийн хувьсгалтай дүйцэхүйц хэмжээний гэж гадуур дүгнээд байгаа юм.

Ардчилалд хөл тавиад 26 жилийг туулсан тусгаар улсын хувьд хууль ёсондоо хүний эрхийн хувьсгал хийх нь зайлшгүй үүрэг байсан юм. Энэ үүрэг, хариуцлагыг жинхэнэ монгол үндэсний сэхээтнүүд л олж харж биелүүлэх байсан нь Л.Болдод оногдсонд миний хувьд гайхах зүйл байсангүй. Болох ёстой юмыг Болд болгож л байна.

Ер нь Л.Болдын ажиллах зарчмыг, хуулийн төсөл санаачилж байгааг хараад байхад “Бид ямар нийгмийн төлөө, юуны төлөө хувьсгал хийсэн юм бэ?” гэсэн асуултад байнга хариулт олж, шийдэл гаргаж явдаг бололтой. Монголын баялаг иргэдийнх байх ёстой гэж тэр байнга хэлдэг. Тиймдээ ч баялаг Монгол орныхоо үүцийг задлахад төрөөс баримтлах бодлого дээр сэтгэлгээний шинэчлэл болгосон “Баян Монгол”-ын тухай үзэл санааг тэрбээр анх дэвшүүлж байлаа. Монгол хүн баялгийнхаа төдийгүй газрынхаа эзэн байх ёстой гэж бас тэр үздэг. Түүгээр ч зогсохгүй өмчилсөн газар дээр үр удмаараа өвлөн амьдрах өв хөрөнгөтэй байх ёстой гэсэн үзэл санааг тэр үргэлж баримталж бас хамгаалсаар ирсэн билээ. Тиймдээ ч иргэд болон газрын харилцааны холбогдолтой хуулийн шинэчлэлийг хийхээр тэр одоо ч ажилласаар байгаа нь түүний ажлын цар хүрээнээс харагддаг.

Товчоор хэлэхэд, тэр яахын аргагүй шинэ цагийн монгол сэхээтний нэр төртэй удам, шинэ цагийн улс төрийн нэртэй зүтгэлтэн бас мөн.

Б.Цэнддоо (Сэтгүүлч, нийтлэлч, Төрийн шагналт)

Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын БОЛОР ТӨРИЙН ХАМГИЙН ЗАЛУУ ТҮШЭЭ



Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Болор бол монгол төрийн өсөх ирээдүйтэй залуу түшээдийн нэг. Европт өндөр боловсрол эзэмшсэн, гадаад хэлний өндөр мэдлэгтэй тэрбээр мэргэжлийн сайд гэдгээрээ онцлог бөгөөд Шийдлийн Засгийн газрын хамгийн залуу сайд билээ.

Тэрбээр 1978 онд Архангай аймгийн Чулуут суманд төрсөн бөгөөд Бельгийн вант улсын Европын их сургуулийг эдийн засагч мэргэжлээр, ШУТИС-ийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.

Их сургуулиа төгсөж ирээд төрийн өмчит “НИК” ХК-д гадаад харилцааны мэргэжилтнээр ажлынхаа гарааг эхлүүлсэн Б.Болор 2001-2006 онд “Гарьд Тур” ХХК-ийн ерөнхий захирал, 2006-2008 онд “Тиара Монголиа” төслийн удирдагчаар ажилласан байна. Улмаар 2008 онд Гадаад харилцааны дэд сайдаар томилогдон ажилласнаар төрийн алба хашиж эхэлжээ. Тэрбээр Гадаад харилцааны дэд сайдаар ажиллах хугацаандаа чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг бүгдийг нь ахалж ажиллаж байсан бөгөөд тэр дундаа Европын холбооны орнуудтай Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулсан нь чухал ач холбогдолтой ажил болж чадсан юм. Уг хэлэлцээрийн үр дүнд Монгол Улс Европын холбооны улсуудтай бүх талаар хамтарч ажиллах боломж бүрдсэн билээ.

2012 онд Архангай аймгаас Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Б.Болор нь багийнхаа хамтаар идэвхи, зүтгэл гарган ажилласны дүнд тус аймагт улсын хэмжээнд хамгийн их хөрөнгө оруулалт хийгдэж, түүхэнд тэмдэглэгдэж үлдэхээр бүтээн байгуулалтын ажил өрнөсөн бөгөөд 2015 оны “Монгол Улсын шилдэг аймаг”-аар шалгарчээ. Мөн Улсын Их Хурлын гишүүний хувиар Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Үүрэн холбооны дугаартайгаа шилжих үйлчилгээний ерөнхий журам зэрэг чухал ач холбогдолтой олон хууль, тогтоомжуудыг бусад гишүүдийнхээ хамтаар санаачлан батлуулсан байна. 2014-2015 онд Улсын Их

Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар ажиллах хугацаандаа Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг санаачлан батлуулсан нь цаг үеэ олсон чухал хууль болсон юм. Уг хуулийн үр дүнд 34.7 их наяд төгрөгийн хөрөнгө, орлого ил болж, улс орны эдийн засаг эргэлтэд орж, эрүүлжих үндэс бүрдсэн билээ.

Тэрбээр 2015 онд Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилогдож, залуу хүний хувиар зоримог алхмууд сэдэж, төсөв, эдийн засгийн чиглэлд томоохон өөрчлөлт, шинэчлэлүүдийг хийж хэрэгжүүлэн ажиллаж байна. Орлого, зарлагаа бодитойгоор тооцсон эрүүл төсөв боловсруулж батлуулах, төрийн данхар бүтцийг багасгах, төсөв хэмнэх, эдийн засгийг эрүүлжүүлэх, далд эдийн засгийг ил болгох, НӨАТ-ын орлогыг ил болгох, эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ард иргэдэд чиглэсэн Орон сууцны ипотекийн зээл, “Сайн малчин”, “Сайн оюутан”, “Сайн хашаа” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон төрлийн үр дүнтэй томоохон ажлуудыг санаачлан ажиллаж буй монгол төрийн чадварлаг боловсон хүчин юм. Эдгээрээс НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь улс орны эдийн засагт эерэгээр нөлөөлсөн хууль болсон. Уг хууль хэрэгжсэнээр бүртгэл, тооцоог сайжруулах замаар татварын мэдээллийн санг шинэчлэх, далд эдийн засгийг бууруулах, улмаар төсвийн орлогыг бодитой төвлөрүүлэх, иргэдийг урамшуулах, иргэдийн хэрэглээгээ хянах соёлыг төлөвшүүлэх, худалдаа, үйлчилгээний төлбөрт багтсан НӨАТ-аас тодорхой хувийг буцаан авах, төлбөрийн баримтаараа бэлэн мөнгөний хонжвор бүхий сугалаанд оролцох, иргэдийн оролцоотой татварын хяналт шалгалт хийх, бизнесийн цэвэр, таатай орчныг бүрдүүлэх, татварын хяналт шалгалтыг багасгаж, хялбаршуулах боломжийг олгож байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Болор нь өнөө үеийн залуусын үлгэр дууриалал болсон шинэ цагийн өндөр боловсролтой залуу боловсон хүчин билээ.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Хаянгагийн БОЛОРЧУЛУУН ПАРЛАМЕНТАД ГАНЦДААГҮЙ ГИШҮҮН



Хөдөө орон нутагт, тэр дундаас төрж өссөн нутагтаа насаараа ажилласан хуруу дарам цөөхөн гишүүдийн нэг бол Хаянгагийн Болорчулуун юм. Тиймдээ ч 2012 оны сонгуульд “Бие даагч”-аар нэр дэвшин өрсөлдөж Дорнод нутгийнхаа зон олны итгэлийг өвөртлөн УИХ-ын гишүүнээр сонгогдсон билээ.

Тэрбээр Хөвсгөл, Дарханаас сонгогдсон хоёр бие даагч гишүүнийхээ хамт зөвлөл байгуулан ажиллаж, эрх баригчдын алдаа дутагдлыг засч залруулах, хүн амын дийлэнх хувийг эзэлдэг нам бусчуудын дуу хоолой, байр суурийг төрд төлөөлөх үүргээ амжилттай хэрэгжүүлж иржээ. Ялангуяа уул уурхайн салбарт баялгийн эзэд болон хөрөнгө оруулагчид харилцан ашигтай байх, байгалийн баялаг, ашигт малтмалаа зөв зохистой ашиглаж, ард иргэддээ өгөөж, хишгийг нь хүртээе гэсэн чин эрмэлзлэлээр Тавантолгой, Оюутолгой, Ноён уул, Тамсагийн нефть, алтны ашиглалтын татвар зэрэгт хатуу боловч зөв байр суурь баримталж, идэвхтэй тэмцлийг өрнүүлж ирсэн билээ.

Х.Болорчулуун болон бие даагч гишүүдийн тэмцлийг Монголын ард түмэн, Дорнод нутгийн зон олон, шударга иргэд уухайлан дэмжиж, хань түшиг болж сэтгэлийн дэм өгч байдаг. Тиймдээ ч улс төрийн намд үзүүлэх иргэдийн итгэл суларсан сүүлийн 2-3 жилийн хугацаанд бие даагч гишүүдийн рейтинг ямагт өндөр байж, эрх баригч намуудтай эн тэнцүүхэн өрсөлдөж ирснийг социологийн судалгаануудаас харж болно. Бүрэн эрхийн хугацаанд дангаараа болон бусад гишүүдтэй хамтарч 20 орчим хууль, тогтоолын төсөл санаачлан батлуулжээ. Эдгээр бодлогын баримт бичгүүд нь янз бүрийн салбарыг хамарч буй ч ихэвчлэн эдийн засаг, бизнесийн орчинг сайжруулах, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ХАА-н салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжууд зонхилж байгаа нь энэ чиглэлээр түлхүү ажилласныг нь илтгэнэ. Тухайлбал, орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор 14 гишүүний хамт Аж

ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл санаачилж батлуулсан нь 2017 оноос мөрдөгдөж эхлэх юм. Хуулийн өөрчлөлтөөр нийслэлээс 550 км-ээс алс зайтай аймгуудад байнгын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн төлөх орлогын албан татварыг 50 хувь хөнгөлөх юм. Энэ бол орон нутгийн бизнес эрхлэгчдэд үзүүлж буй бодит дэмжлэг, ажлын байр нэмэгдүүлж, төв рүү тэмүүлсэн их нүүдлийг сааруулах ухаалаг алхам гэж хэлж болно.

Сүүлийн жил гаруйн турш өрнөсөн “Халх гол” чөлөөт бүсийн эсрэг тэмцэлд Х.Болорчулуун гишүүн манлайлан оролцов. Халх гол орчмын бүст ХАА-н үйлдвэрлэл явуулахдаа чөлөөт бүсийн онцгой дэглэм тогтоох нь буруу гэдгийг тэрбээр эрх баригчдад сануулж, УИХ-ын 75 дугаар тогтоолыг цуцлах, улмаар “Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүс байгуулах” тогтоолын төслийг 2015 оны 11 дүгээр сард 8 гишүүний хамт санаачилж өргөн барьсан. Уг төслийг хэлэлцэх явцад эрх баригч нам олонхиороо хүч түрэн “Бүтээн байгуулалтын бүс” нэртэй шинэ төсөл оруулж, нэрийг нь өөрчилсөн ч чөлөөт бүсийг цуцлах талаар хөөцөлдсөн бүтэн жилийн тэмцлийн үр дүн гарч, УИХ-ын 75 дугаар тогтоол хүчингүй болоод байна.

Монгол Улс дэлхийн жишигтэй харьцуулахад газрын тосны борлуулалтаасаа хамгийн бага хувь хүртэгч орон. Үүнийг өөрчлөх зорилгоор Газрын тосны хууль санаачилж өргөн барьсан ч харамсалтай нь энэ хууль УИХ-ын нийт гишүүдийн 50:50 хувийн саналаар тэнцэж, анхны хувилбараар батлагдаж чадаагүй. Харин Газрын тосны хуулийн хоёр дахь хувилбарт “Газрын тосны олборлолтоос нөөц ашигласны төлбөр буюу роялти авах” заалт тусгуулснаар манай улс Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүртэж буй 24 хувь дээрээ 5-15 хувийн роялтийн татвар авах боломж бүрдсэн. Хууль батлагдаад хоёр жилийн хугацаа өнгөрч байгаа ч эрх баригчид гэрээлэгч талаас энэ татварыг аваагүй тул тэрээр Ерөнхий сайдад удаа дараа асуулга тавьж, шаардлага хүргүүлсээр иржээ.

Х.Болорчулуун гишүүний бас нэгэн онцлох ажил нь Дорнод аймагт Зүүн бүсийн шүүхийг төвлөрүүлсэн явдал. Шүүх байгуулах хуулийн төсөл хэлэлцэх явцад Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Эрүүгийн болон Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийг Өндөрхаанд байгуулахаар санал оруулж ирсэн ч түүний хүчин зүтгэлийн үр дүнд Давж заалдах шатны шүүхийг Чойбалсан хотод байгуулах шийдвэрт хүрсэн юм.

Тойрогтоо шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулах нь УИХ-ын гишүүний идэвхи чармайлтаас их шалтгаалдаг. Өнгөрсөн дөрвөн жилд улс Х.Болорчулуун гишүүн тойрогтоо 120 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалт хөөцөлдөж татсан дүн гарчээ. Тухайлбал, Дорнод аймаг дахь БОЭТ-ийн 50 ортой шинэ төрөх, Хэрлэн сумын 13 мянга орчим иргэнд хүрч үйлчилдэг “Асралт үйлс” ЭЗМТ-ийн шинэ байр, МСҮТ-ийн зургаан давхар хичээлийн шинэ байр, Хөлөнбуйр суманд Хэрлэн голын төмөр бетон гүүр, Чойбалсангаас Халх гол хүртэлх 35 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Залуу гэр бүлийг бага зардлаар орон сууцжуулах “Залуус” хороолол, Чойбалсан хотын төв замын чанарыг сайжруулж, гэрэлтүүлгийг анх удаа иж бүрэн шинэчилсэн гээд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүтээн байгуулсан томоохон ажлуудыг дурдаж болно. Мөн аймагтаа мэргэжлийн боловсролын 1, ерөнхий боловсролын 2 сургууль, цэцэрлэг, 6 спорт заал, Чойбалсан хотын 9 байршилд спорт талбай байгуулах зардлыг улсын төсөвт тусгуулж чаджээ.

Улсын Их хурлын гишүүн Раднаагийн БУРМАА БУРУУД ХАТУУ, ЗӨВД ЗӨӨЛӨН



Р.Бурмааг зарим нэгэн “Сонгогчдын Бурмаа” гэх нь бий. Үнэхээр сонгогч олныхоо итгэлийг даадаг, бусдаас тод нэгэн чанар түүнд бий. Багаасаа нийгмийн идэвхитэй, бусдыгаа манлайлагч зан төрхөөрөө ялгардаг байсан Р.Бурмаа 1992 оноос Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг үүсгэж, тэргүүнээр нь ажиллахдаа эмэгтэйчүүдийн асуудалд улс төр, үзэл бодлын ялгаатай ханддаг хандлагыг халж, нийтлэг нэг эрх ашгийг хамгаалж ирсэн байдаг. Энэ бол иргэн бүр эрх тэгш байх тухай түүний эрхэмлэдэг зарчим.

Тэрбээр улс орноо ирээдүйд авч явах залуусыг бэлдэх ёстой гэдгийг ямагт бодож, ажил хэрэг болгохын төлөө боломжтой бүхнийг хийж иржээ. “Нэг ертөнц”, “Мини парламент” зэрэг төсөл хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгч байсан. Сонгогчдын боловсрол” төвийг 1997 онд байгуулж, улс төрийн тогтолцоо, хууль тогтоох үйл явцыг ил тод болгохын төлөө зүтгэв. Үүний үр дүнд Сонгуулийн ерөнхий хороонд нам бусаар иргэдийг төлөөлж байв. 2012 онд УИХ-ын гишүүн болоод хамгийн анх хийсэн ажил нь иргэд, сонгогчдынхоо эрх ашгийг хамгаалах Өргөдлийн байнгын хороог байгуулах санаачилга гаргаж, анхны даргаар нь ажиллаж иргэдийн санал, өргөдөл, гомдлоор дамжуулан төр, засгийн байгууллагыг хариуцлагатай болгох эхлэлийг тавилаа. Энэ байнгын хороо эдүгээ иргэдэд хамгийн ойр ажилладаг, төрд хүргэх иргэдийн үгийг шууд анхаарч хэлэлцдэг болсон.

Р.Бурмаа бол Хүнс, хөдөө аж ахуйн яамны анхны эмэгтэй сайд. Тэрээр сайд болонгуут нийгмийн дунд хүлээлт ихтэй, олон жил шийдэгдэхгүй явсан, чухал хуулиудыг санаачлан батлуулсан. Тухайлбал, Тариалангийн тухай хууль, Органик хүнсний тухай хууль зэргийг дурдаж болно. Үүнээс гадна Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогыг боловсруулан батлуулсан нь хөдөө аж ахуйн салбарын олон ажлууд урагштай явахын үүдийг нээв. Эмэгтэй хүний гярхай, ард түмнийхээ ахуй, амьдралын онцлогийг сайн мэддэгийн хувьд мал

маллах нь гэр бүлийн хамтын хөдөлмөр гэдэг талаас нь хандаж “Улсын сайн малчны” цол тэмдгийг эхнэр, нөхөр хоёрт хамтад нь олгох нь зүйтэй” гэсэн санал гарган Засгийн газраар батлуулав.

Уул уурхайн лиценз нэрийн дор монголын үүц болох зүүн хязгаар нутгийн газрын хэвлий дэх баялгийг гадагш зөөх гэсэн цөөн хэдэн хүний хэл ам, дайралт, гүтгэлэг, эсэргүүцлийг үл хайхран “Төр нь газар нутгаа хамгаалалтандаа авч, монголчууд бид өөрсдийн газар нутагт бүтээн байгуулалт хийж, тарьж ургуулж, үр шимийг нь хүртэж байх учиртай” хэмээн үндэснийхээ эрх ашгийн өмнө хатуу зогсч чадсан. “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн төсөл” нь үндэсний эрх ашгийг эрхэмлэсэн эх оронч шийдвэр байв. Халх голоос эхлэлтэй бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн бүсийг хязгаар нутгуудад бий болгох холын зорилго биеллээ олж эхэллээ.

Монголчууд өнгөрсөн онд 56 сая толгой мал тоолуулсан нь бас л сайн мэдээ. Яг энэ цаг үед бидэнд ургадаг, үрждэг уламжлалт баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулж, малчид, орон нутгийн иргэд нь өөрсдөө үйлдвэрлэгчид болж, орлогоо нэмэгдүүлэх, урт хугацаанд тогтвортой аж ахуй эрхлэх олон талт боломжуудын үүд нээгдэж байна. Малын түүхий махны экспортын асуудлыг ч Р.Бурмаа ХХАА-н сайдаар ажиллаж байгаа энэ богино хугацаанд санаачлан “Мах” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, энэ хавар БНХАУ руу анх удаа үхэр, хонь, ямааны түүхий махыг экспортод гаргалаа. Энд баруун аймгууд, ОХУ-д ойр хил залгаа Дархан, Сэлэнгийн бүс нутгийг хамруулах боломжийг ч бүрдүүлэв. Р.Бурмаа сайд тариаланчдад олгож байсан Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг өргөжүүлж, жимс ногоо тариалдаг иргэдэд адил олгох шийдвэрийг гаргасан.

“Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг Засгийн газар “МОНГОЛ ТАРИАЛАН” нэртэйгээр батлан гаргасан. Тариаланчдын олон жил хүсэн хүлээж байсан асуудлыг хуулиар шийдэж өгөв. Тариаланчдад газар эзэмшүүлэхдээ 15 жилээр өгдөг байсныг 40-өөс доошгүй жил болгов. 40 жил нэг газар эзэмшинэ гэвэл, миний хүүхэд ч энэ газрыг цаашид эзэмших юм байна гэж бодоод хөрсөө бордох, хэвийн байлгах, хөрсөндөө ээлтэй тоног төхөөрөмж ашиглах зэргээр өөриймсөг хандах байдлыг нээлттэй болгов. Мөн газрын гэрчилгээг барьцаалж, зээл авах эрхийг нээж өгсөн. “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” дээр баталгаат агуулах гаргаж өгөөд тэнд будаагаа хадгалуулсан бол түүнийгээ барьцаалж зээл авах боломжтой болов. Хөдөө аж ахуйн биржээр дамжуулж гурил үйлдвэрлэгч нартай гэрээ хийж намар хурааж авах ургацаар нь зээл авах боломж олгосны зэрэгцээ 100 тэрбумын хөнгөлөлттэй зээлийг батлуулав. Уг зээлийн эхний ээлж болох 50 тэрбум төгрөгийг арилжааны банкуудаар дамжуулан өгч эхэллээ. Малчны зээлийн хүү ч бас буурлаа.

Төр иргэддээ хатуу бус зөөлөн, хууль эрх зүйг дээдэлсэн байх ёстой гэсэн зарчмаа тууштай барьж ирсэн нь түүний улс төрийн замналын нэг илүүрхэл. “Намайг сайд байх үед хуулиас гадуур үйл ажиллагаа явуулахыг би хэрхэвч зөвшөөрөхгүй” гэж хэлсэн сайд энэ төдийгүй өмнөх Засгийн газарт ч байгаагүй. Харин Р.Бурмаагийн зүтгэж хийсэн энэ их ажлыг үгүйсгэн хараар будагчдын хувьд тэр яаж ч болдоггүй “Бурууд хатуу, зөвд зөөлөн Бурмаа” хэвээрээ л байна.

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн БЯМБАЦОГТ БОДЛОГОТОН



Уулсын нөмөр бусдад өмөг түшигтэй байхыг, уулсын оргил бууршгүй цог хийморьтой явахыг, уулсын салхи хүнд зориг, тэвчээртэй байхыг сургаж, ухааны чагтага бөхөлдөг бөлгөө. Тийм болохоор түүнд нутгийнхаа уулс шиг эрэмгий байхын ухаан хар нялхаас нь суусан...

Тэр хан их Алтайн өвөр нөмөрт өсч, хаан түшигтэй аавынхаа удмын нэрийг өргөж яваа Ховдын хүү. Тэр гэдэг маань олон ястны өлгий, оршихуйн хөх судар болсон Ховдын цэнхэр хязгаараас хотол олныхоо итгэл хайрыг дааж, төр засах ухаанд гүн суралцаж, түмнээ гэсэн сэтгэлээр жигүүр хийн хойч Монголынхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэн буй С.Бямбацогт билээ. Төр түшсэн өнгөрсөн найман жилд тэр хэдийнэ монгол төрийн бодлоготон болжээ.

“Борооны ус давсгүй, бодлоготны үг худалгүй” гэдгийг үг, үйл хоёроороо баталж, залуу улстөрчөөс зангарагтай улстөрчийн эрэмбэд хэдийнэ дэвшсэнийг нь бултаараа харж, сонсч, басхүү хүлээн зөвшөөрч байна.

Хар багадаа өнчирч, хатуу хөтүүтэй нүүр тулсан зургаан дүүдээ, халуун залуугаараа ханиасаа хагацаж хал үзсэн хөөрхий ээждээ хань бараа болж, өрх гэрээ өөд нь татаж, өнчин дүү нараа өсгөж тэтгэж, айлын том хүүгийн ачааг даасан шиг дааж чадсан тэр л үеэс аливаад хаттай, хариуцлагатай хандаж сурсан биз ээ.

Цаг хугацааны учрал тохиол, хувь заяаны зураг төөрөг, олон түмний хийгээд намынх нь журмын нөхдийн итгэл дэмжлэг түүнд УИХ дахь МАН-ын бүлгийн дарга хэмээх нэр төртэй хэрнээ нэн хариуцлагатай албыг тохоосон. Нэн хариуцлагатай гэхийн учир нь 2012 оны сонгуулиар хууль тогтоох байгууллагад МАН цөөнх болсон хэрэг. Түүнийг бүлгийн даргаар сонгогдсоны анхны мэдэгдэл нь “Бүтээлч цөөнхийн бүлэг байна” гэсэн үг.

Өнгөрсөн дөрвөн жилд түүний удирдсан бүлэг илүү санаачлагатай, бүтээлч ажилласан. Монголын ард түмний нийтлэг эрх ашиг, олон түмний хүсэл саналыг төрд цөөдүүлэхгүй, хүч дутаахгүйн тулд ойлголцол, зөвшилцөл, шахалт, шаардлага гээд улс төрийн бүхий л арга, эвийг амжилттай хэрэгжүүлсэн.

Зүйрлүүлж хэлбэл, бүлгийн даргын алба гэдэг эгээ л цэргийн жанжин мэт арга ухаантай, эрмэг шийдэмгий байж сумны зэв, жадны үзүүр байхыг шаардана. Харин С.Бямбацогт энэ үүргээ огтхон ч түүртэлгүй биелүүлэхийн сацуу төр холч хараатай, мэргэн бодлоготой байж гэмээнэ улс орон хөгжинө гэдгийг үйлс санаачилгаараа харуулсан билээ. Төр сонгуулийн дөрөвхөн жилийн мөчлөгөөс цаадахыг харж чадахгүй харалган байх, улс хөгжлийн бодлогогүй дороо хий эргэхийн уршиг ямархан хортойг гурван сая монгол яс махандаа тултал ойлгож буй энэ цагт Хөгжлийн урт хугацааны бодлогыг гардан санаачилж УИХ-аар батлуулж, Монгол Улсын холын харааг эмнэсэн нь түүний гавьяа. Үүний ачаар энэ сонгуульд улс төрийн бүх нам, эвсэл 2030 он хүртэлх тэрхүү хөгжлийн бодлогод Мөрийн хөтөлбөрөө заавал нийцүүлэх босготой, бас тотготой болсон юм. Төрийн бодлогын алтан аргамжийг бөхлөхөд мэдээж үүн шиг чухал зүйл юусан билээ.

УИХ дахь сөрөг хүчин гэдэг эрх баригчдын зөвд ташуур, бурууд хазаар байх учиртай. Хэрэв олонхи хадуурч давхиад эмээлээ гэдсэндээ хийчихсэн эмнэг адуу шиг цамнаад байвал түүнийг барьж тогтоох, номхруулж сургах эзний үүрэг цөөнхийн бүлэгт бий. Тэр дундаа нийтийн том эрх ашгийн төлөө гал барих, өөртөө оноо алдах ч өрөөл бусдад хожоо болох хүнд эрсдэлийг дааж, давж гарна гэдэг гагцхүү том улстөрчдөд л оногддог хувь тохиол гэлтэй. Зарчимтай байх, үнэний талд байх, түмний итгэл хүлээсэн төрийн түшээгийн үүргээ холбиролтгүй мөрдөх нь түүний өөртөө ч, бусдад ч тогтоосон хэм хэмжээ.

Хоёр жилийн өмнө түүнийг Ховдод шатахууны үнийг хотынхтой адил болгох тухай ярьж, эрх баригчдыг шахааж шаардаж, гарц гаргалгааг нь зааж зөвлөж явахад хэрэгжинэ гэдэгт итгэх хүн тун цөөхөн байсан. Сэтгэл байгаад зүтгэж чадвал ярьсан үгээ хуурай цуурай болголгүй ажил хэрэг болгож болдгийн ганцхан жишээ гэвэл энэ.

Тулгандаа галтай байхад айл гэрийн амьдрал аандаа болоод л ирдэг. Түүн лүгээ адил өнгөрсөн он жилүүдэд тэр Ховддоо илч дулаан, гэрэл гэгээ түгээх эрчим хүч, их хөгжлийг ойртуулах зам дэд бүтцийг байгуулахад оройлон зүтгэсэн гэдэгтэй хэн ч маргахгүй.

Арьс ширний, хүнсний ногооны, малын тэжээлийн, мах махан бүтээгдэхүүний гээд хөнгөн үйлдвэрийн парк түшсэн олон жижиг, дунд үйлдвэрүүд байгуулагдаад ирэхээр түүний нөхдийн хамт санаачилж батлуулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон Хүн амын орлогын албан татварын тухай хуульд орсон татвараас чөлөөлөх хөнгөлөлтүүд ус агаар шиг нэмэр болно. Бүсийн нэмэгдлийн нэгээхэн хэсэг болсон энэ ажлаа бүтэн болгоход одоо түүнд болоод тулхтай, туршлагатай намд нь дахин итгэх итгэл, олны дэмжлэг хэрэгтэй.

Үеийн үед, цагийн цагт Ховдоос монгол төрийн бодлоготон төрж, төрийн алтан жолоо атгалцаж ирсэн. Одоо тэрхүү бахархалт түүчээг тэрбээр үргэлжлүүлэн залгуулах цаг нэгэнт болжээ. Ховдоо ч, хотол Монголоо ч зөв зүг чигт залах түүний улс төрийн замналд сүү өргөө. Төрийн сүлд түшиж, төрсөн нутгийнх нь уул ус мөнхөд ивгээх болтугай.

Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн ГАНБААТАР ҮНДЭСТНЭЭ ДЭВЖҮҮЛЭХ БАРИМЖАА



Баянхонгор нутгийн уугуул С.Ганбаатар Дархан хотод ерөнхий боловсрол эзэмшиж улмаар эдийн засгийн ухааныг судалж, энэ чиглэлээр зохих түвшний ажил эрхлэхийн зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж иржээ.

Тэрбээр олон түмэндээ байр зүйн ухааныг ойлгуулах, залууст гадаад хэл-англи хэл зааж сургах, эрдэм сурах арга замыг хэрхэн олох талаар яриа, лекц унших, хүүхэд багачуудаа “Хөх цэрэг” аялалд хамруулж эх орноо таньж мэдэх, үндэсний үзлээ олж төлөвшихөд нь дэмжих зэргээр түмний төлөө үйл хэрэгт хувь нэмрээ оруулж ирсэн аж. Улмаар 2005 оноос “Эрс шинэчлэл”, “Үндэсний соёмбо” хөдөлгөөний тэргүүн, 2007-2012 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Монголын үйлдвэрчний эвлэлийн Холбооны ерөнхийлөгчийн сонгуульт алба хашсан байна. Эдгээр сэдэл санаачилга, сонгуульт ажлууд нь түүний нийгмийн төлөөх зүтгэлтний идэвхийг өрнүүлж, хатуужуулсан аж.

С.Ганбаатар нийтийн эрх ашгийг хамгаалахын төлөө МҮЭ-ийн гишүүд, хөдөлмөрчдийн жагсаал, цуглаан, МҮЭХ-ны ерөнхийлөгчийн ганцаарчилсан суулт, нийгмийн зөвшлийн гурван талын харилцааг идэвхжүүлж төгөлдөржүүлэх, төр, засгийн дээд байгууллагуудад шаардлага, сануулга хүргүүлэх зэрэг тал бүрийн арга хэлбэрээр тэмцэж байв. Ганцхан баримт дурдахад 2008 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Сүхбаатарын талбайд 20 мянга гаруй хүн оролцсон цуглаан, жагсаал зохион байгуулсны үр дүнд Засгийн газрын 2008 оны 139 дугаар тогтоол гарч, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн тооцоог төрийн сангаас салган Засгийн газраас Нийгмийн даатгалын санд төлөх өрийн хэмжээ 236,3 тэрбум төгрөг болохыг зөвшөөрч, хэсэгчлэн төлөх үүрэг авчээ. Мөн сангийн чөлөөт үлдэгдлийг “Хуримтлалын сан” хэлбэрээр арилжааны банкуудад байршуулж эхэлсэн байна.

С.Ганбаатарын үйл ажиллагаа, тэмцлийн суурь нь иргэн бүрийн санаа бодол, эрх ашиг, сонирхол, арга хэрэгсэл нь “олны хүч оломгүй далай” гэсэн мэргэн үг юм. Тиймээс ч иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах нь үндэстнээ дэвжүүлэх чиг баримжаа гэж үздэг байна.

Тэрбээр 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Дархан-Уул аймагт бие дааж нэр дэвшин өрсөлдөж УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Энэ хугацаанд хууль санаачлагчийн хувьд Эрүүл мэндийн даатгалын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулалцаж батлуулжээ. Мөн гишүүний бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмалын тухай, Сүрьеэгийн өвчинтэй тэмцэх тухай, Хүнсний хяналтын тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, саналыг нь авахаар Засгийн газарт хүргүүлээд байгаа аж. Түүнчлэн бусад гишүүдтэйгээ хамтран Эрүүл мэндийн даатгалын тухай, Татварын мэргэшсэн зөвлөхийн үйл ажиллагааны тухай, Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай, Үндэсний их баяр наадмын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг хэлэлцүүлж батлуулсан байна.

С.Ганбаатар гишүүн энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд УИХ-ын Төсвийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Өргөдлийн байнгын хорооны гишүүнээр ажиллажээ. Байнгын хороодын гишүүний хувьд хуулийн төсөл, түүнтэй холбоотой үүрэг бүхий 7 ажлын хэсгийг ахлаж, 9 ажлын хэсгийн гишүүнээр ажилласан байна.

Оюутолгой төслийг эх орон, ард түмэндээ ашигтай, ээлтэй байлгах талаар 2007 оноос л дуу хоолойгоо хүргэж, олон ч удаа нийтлэл, нэвтрүүлэг хийж, шаардлага тавьж, мэдэгдэл гаргажээ. Энэ төслийн монголын талын удирдагчийн нэгтэй хийсэн телевизийн халз мэтгэлцээн нь тодорхой мөр үлдээсэн. Оюутолгой төслийн үр шимээс монголчуудын хүртэх хугацааг үлэмж хойшлуулсан “төлөвлөгөө” гэгч гэрээг “дубайдах” гэсэн нэршилтэй болтол нь олонд таниулсан.

УИХ-д иргэдээс ирүүлсэн байгаль хамгаалах, ашигт малтмал, уул уурхай, усны хэрэглээ, бэлчээрийн ашиглалтын чиглэлийн өргөдөл, санал хүсэлтийг нэгтгэн судлах ажлын хэсгийг ахалж, Цагаан агуйг хамгаалах, бэлчээрийн менежментийг сумдад хангах, усны хуулиудын зөрчил, давхцалыг арилгах, ашигт малтмалын лиценз олголтод сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг хариуцлагажуулах, иргэдээ сонсох баримт бичгүүд, холбогдох шийдвэрүүдийг гаргуулсан байна. Бүх сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд газар өмчлөл, бэлчээрийн тухай санаагаа бичгээр хүргүүлсэн. Тэд минь болгоож байгаа байх аа хэмээн итгэнэ.

Тэрбээр УИХ-ын хамгийн идэвхтэй гишүүдийн нэг. Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанар хэлэлцэж буй асуудалд ямагт олон түмний эрх ашгийн үүднээс, ажил хэрэгч байр сууринаас хандан асууж тодруулж, саналаа хэлдэг. Бас хуралдаандаа байнга оролцдог хамгийн өндөр ирцтэй гишүүдийн нэг. Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдөг, тус байнгын хороог иргэдээ сонсох УИХ-ын чих, хамгаалах бамбай гэж хэлэх дуртай.

Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн ГАНБАТ ШИНЭЧЛЭЛИЙН ЗҮТГҮҮР



Монгол төрийн ард түмэндээ амласан хууль эрх зүй, шүүх засаглалыг шинэчлэх гол ажлыг нугалалцсан түшээ бол УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат юм. 2012 оны УИХ-ын сонгуульд Баянхонгор аймагт нэр дэвшин өрсөлдөж ялалт байгуулаад УИХ-д орж ирэхэд нь “Шинэ хүн суудал бөглөхөөс хэтрэхгүй дээ” гэж харсан нь олон болохоос хууль эрх зүйн салбарт бодлогын том шинэчлэлийг хийчихнэ гэж төсөөлөө ч үгүй биз. Гэвч түүний удирдсан баг Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Прокурорын байгууллагын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслүүдийн “усыг” шахаж, бүрэн эрхийн хугацаа нь дуусаж байгаа энэ удаагийн УИХ-ын нүүрийг тахлах том “ажлууд”-ыг нугалж чадлаа.

Хуульгүй явж ирсэн хууль сахиулагчдыг мөрдөх хуультай болгосноороо ялтанд ч, хууль сахиулагчдад ч эдлэх эрх бий гэдгийг эдгээр хуулиуддаа тодорхойлж өгсөн юм. Гэхдээ энэ бүх шинэчлэлийг хийх зам дардан байгаагүй ч түүнийгээ сүр болголгүй эвийг нь олоод л хуулиудаа батлуулсан байдаг.

Олон жил бизнес эрхэлж, хүнд хүчрийг давж гарсан зан чанар нь оногдсон ажлаа чанартай хийгээд цаана нь гарах тэвчээрт ч сургасан ч байдаг биз. Мөн ч олон дайралт, давшилтын ард гарсан даа, Д.Ганбат дарга. Өршөөлийн хуультай холбоотойгоор их ч “цавчуулсан”. УИХ-ын Хууль зүйн байнгын хороогоор Өршөөлийн хууль боловсруулагдаж гарсан учраас тэр. Зах зухаас нь хөндвөл “Д.Ганбат аа, Н.Энхбаярт хэзээнээс тэгтлээ хайртай болчихсон юм бэ, Ерөнхий сайд асан Н.Алтанхуягийн хүргэн Г.Дэнзэн, “Нүүрс” хөтөлбөрөөс тэрбумаар нь мөнгө “идсэн” Л.Гансүх нарыг өршөөлд хамруулахаас ичихгүй байна уу. Хуулийг тэд захиалсан уу, авлигад нь хэдийг авсан бэ” гэцгээгээд л тал талаас нь боорлосон. “Чи мөн энэ хуулийг батлуулна даа” гэж ам асуух нь холгүй баалсан

нь ч бий. Яаж энэ бүхнийг тэсэж тэвчиж суудаг юм бол оо гэж өмнөөс нь халгаж суусан хүн ч олон. Гэвч Өршөөлийн хууль батлагдаж, хэрэгжилтийн дүнд нь 100 мянган иргэн жолооны үнэмлэхээ сэргээлгэж, 3000 орчим иргэн шоронгоос суллагдаж, гэр бүлдээ эргэн очсон мэдээлэл бий.

Д.Ганбат даргад байдаг бас нэг авууштай чанар бол баталсан хуулийн хэрэгжилтэд анхаарч, араас нь сураг ажиг тавьж, зарим тохиолдолд гэнэтийн шалгалт хийж гэнэдүүлэх нь бий. Ямар сайндаа л “Хорихоос суллагдсан иргэдийг ажлын байраар хангаж, нийгэмшүүлэх нь дан ганц Хөдөлмөрийн яамны ажил юм уу. Нийслэлийнхэн ч гар хуруугаа хөдөлгөх ёстой шүү” гэх үг хэлээд намынхаа зарим нөхдөд адлуулж суух билээ дээ.

Ер нь тэгээд зарчим яриад зүтгэсэн бол түүнээсээ ухрахгүй чигээрээ. Жил гаруйн өмнө УИХ-ын түвшинд шүүгч нарын цалинг танах асуудал босоход цээжээрээ хамгаалсаар цаана нь гарсан түшээ бол Д.Ганбат. УИХ-ын дарга З.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж нартай халз үзсээр төсвийг нь тануулалгүй авч гарсан юмдаг. УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Шүүгчдийн цалинг хасаж болохгүй гээд л үсчээд байх юм. Чи л зөвхөн шүүгч нарын жаргал, зовлонг мэддэг хүн үү” гэж баахан довтолсон ч бууж өгөөгүй. Хуулийнхан түүний энэхүү тууштай занг нь үнэлж “Шүүхэд ээлтэй түшээ” гэж тодотгосон байдаг.

Монгол Улс авлигачидтай тэмцье гэвэл шүүх засаглалын хараат бус байдлыг хангахад УИХ анхаарах ёстой. Ийм л зарчмыг Д.Ганбат дарга барьж ажилласан хэрэг. Үүний хүчинд өнөөдөр Монголын ард түмэн шүүгч нараас шударга ёс нэхэх эрхтэй болсон. Прокурорын байгууллагын тухай хууль шинэчлэн батлагдсанаар нийгмийн баталгаа нь хангагдаж, цалин нь нэмэгдэх эхлэлийг тавьж чадлаа.

Нийгмийн тулгамдсан асуудал болсон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин цоо шинээр бүрдсэн нь мөн л УИХ-ын Хууль зүйн байнгын хорооныхны ажлын үр дүн. Уг хуулийг төслийн “усыг” шахах ажил Д.Ганбат даргад л ногдсон байдаг. Одоо энэхүү шинэ бодлогын дүнд эхнэрээ зодсон эр зохих шийтгэлээ хүлээхээс эхлээд албадан сургалтад хамрагдаж засрах, хүчирхийлэл үйлдэгчийн талаарх цагдаагийн байгууллагад өгсөн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хүчирхийллээс бий болсон хохирлыг нь нөхөн төлүүлэх зэрэг шинэ харилцаа үүснэ.

Үндсэн хуулийн цэцээс Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн төсөлтэй холбогдуулж хориг тавихад гацааг нь арилгаж, ипотекийн зээл үргэлжлэх эрх зүйн орчинг шинээр бүрдүүлсэн санаачлагч нь УИХ-ын гишүүн Д.Ганбат. Ипотекийн зээлийн үр дүнд өнөөдөр Монголын 80 мянга гаруй залуус орон сууцтай болсон бол мөн тэдний араас мянга, мянган залуус байртай болохоор хөдөлмөрт шимтэн тэмүүлж байна. Гацаа арилснаар барилгын салбарт ч сэргэлт авчирч, мянга мянган залуус ажлын байртайгаа үлдэж, тэр хэрээр “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх хөшүүрэг болсон билээ.

Тэрбээр шинэчлэгчдийн эгнээнд багтах Монгол төрийн “зүтгүүр” юм.

---000000---

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннjamын ГАНТӨМӨР

ПАРЛАМЕНТЫН ЗАЛУУ ҮЕИЙНХНИЙ ТҮҮЧЭЭ



Монголын парламентад нэгэн үе солигдох гэж байна. Тавь, жараад оныхон халаагаа өгч далаад оныхон ачааны хүндийг үүрэх цаг болжээ. УИХ-ын гишүүн Л.Гантөмөрийг парламентын залуу үеийнхний түүчээ хэмээн нэрлэж болно. Энэ жилийн УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг ажиглаж байхад түүний үеийнхэн одоо л улс төрд хөл тавьж байгаа аж. Харин түүний хувьд бол аль хэдийнэ туршлагатай парламентч болсон. УИХ-д гурвантаа сонгогдсон гэхээр хэзээний хал үзэж, халуун чулуу долоочихсон гэсэн үг. Одоо түүний хувьд хийсэн ажил нь гарт нь орж, хийх ажил нь сэтгэлд нь багтаж байгаа буй заа. Нас, бие, ухаан, мэдлэг, туршлага тэгширч, хийж бүтээх ид үедээ яваа гэдгээ ч тэрбээр өнгөрсөн жилүүдэд хангалттай харуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан гэдэг Монголын оюун, сэтгэлгээний ертөнцийг тэр чигт нь хамарсан гурван том салбарын бодлогыг тодорхойлж, удирдан чиглүүлнэ гэдэг амаргүй. Л.Гантөмөр сайдын хувьд өнгөрсөн хугацаанд бараг л гурван сайдын дайтай үүрэг, хариуцлага, ачаалал хүлээж ажиллажээ. Бахархуштай нь гурван салбараа гурвууланг нь шинэчилж, сэргээж, сэргээж чадсан байна.

1990-ээд оноос хойш шинэчлэгдэх тухай хамгийн их ярьсан атлаа дорвитой өөрчлөлт хийгээгүй унтаа, дүнсгэр байсан боловсролын салбарыг шинэчилнэ гэж зоригтой амалж, түүндээ хүрнэ гэдэг залуу хүний зүрх, зоригор л хийх ажил. Юутай ч тэрбээр БШУ-ы сайд болмогцоо боловсролын салбарын шинэчлэлийг зоримог эхлүүлсэн. “Зөв монгол хүүхэд” хөтөлбөр, “Авьяс”, “Ном” дэд хөтөлбөр хэрэгжүүлэн хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилт тавьсан нь урьд өмнө байгаагүй цоо шинэ үзэл баримтлал байв. Үүний зэрэгцээ ерөнхий боловсролын цөм хөтөлбөрүүдийг шинээр боловсруулан батлуулж, суурь боловсролын хөтөлбөрийг бүрэн шинэчилж чадсан. Дээд боловсролын шинэчлэлийг ч мөн амжилттай

хэрэгжүүлж байгаа. Тухайлбал, манай их, дээд сургуулиудын хөтөлбөрүүд олон улсад магадлан итгэмжлэгдэж, монгол хүн эх орондоо суралцан дэлхийн боловсролын эзэмших боломж нээгдсэн нь хамгийн сүүлийн сайхан мэдээ. Тэрбээр УИХ-ын гишүүний хувьд Боловсролын тухай багц хуулийг шинэчлэн батлуулж чадсанаар боловсролын салбарт хийсэн шинэчлэлээ хууль эрх зүйн хувьд баталгаажуулжээ. “Монгол Улсын хөгжлийн тулгуур нь Оюутолгой биш оюунт толгой юм” хэмээн Л.Гантөмөр сайд дөрвөн жилийн өмнө хэлж байсан. Тэгвэл өнөөдөр энэ үгээ ажил хэрэг болгон амьдрал дээр батлан харуулж байна. Мэдлэгт суурилсан эдийн засаг Монголын хөгжлийн гарц гэдгийг өнөөгийн нийгэмд тэр ойлгуулж, мэдрүүлж чадсан.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд их, дээд сургуулиуд сургалт, судалгааны төвүүд болон өөрчлөгдөж, инновацийг нэвтрүүлж эхлэв. Их, дээд сургуулиудад түшиглэсэн гарааны компаниуд ч байгуулагдаж байна. Энэ чиглэлээр их, дээд сургуулиудад тэтгэлэг олгож, мөн залуу эрдэмтдийн судалгааны бүтээлүүдэд сайдын нэрэмжит грант олгох болсон нь шинжлэх ухааны салбарыг хөгжил хөдөлгөөнд оруулав. Их сургуулиуд шинжлэх ухааны паркттай болж, шинжлэх ухаан инженерчлэлийн музей, эсийн судалгааны цөм лаборатори нээгдсэн гээд энэ салбарыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр хамгийн олон шийдвэр гаргаж, хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн байна.

Улстөрчид, эдийн засагчид уул уурхай, зам барилгын салбарт хөрөнгө оруулах тухай л ярьж байхад Л.Гантөмөр сайд “Оюуны салбарт хийсэн хөрөнгө оруулалт хэдэн арав, бүр хэдэн зуу дахин өсдөг” гэж мэдэгдсэн. Мэдэгдээд зогсохгүй оюуны томоохон хөрөнгө оруулалтыг салбартаа татаж чадсан юм. Тухайлбал, 1000 инженер Японд сурч байгаа. Техник, технологи өндөр хөгжсөн арлын оронд манай инженерийн арми бэлтгэгдэж байна гэсэн үг. Тэд Монголыг аварна, улс орныхоо ирээдүйг хөтөлнө гэдэгт сайд итгэл төгс байдаг. Түүгээр зогсохгүй монгол залуус дэлхийн шилдэг 100 их сургуульд тэтгэлэгтэй суралцан, БСШУЯ алдарт MIT-тай хамтран ажиллах гэрээ байгуулж чадлаа.

Соёл, урлагийн салбарт Соёлын тухай, Монгол хэлний тухай зэрэг олон жил яригдаж байсан хуулиудыг шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулан батлуулж, соёлын үйлдвэрлэлийг эхлүүлэх хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж чадав. Соёл, урлагийн салбарт цоо шинэ бодлого, менежмент хэрэгтэйг тэрбээр ийнхүү олж харж, шийдэл, гарцыг нь тодорхойлж өгчээ. Хойч үедээ уламжлалт соёл, түүх, зан заншлыг өвлүүлэн уламжлуулах, өв соёлоо хадгалж, хамгаалах, үндэсний соёлоор бахархах үзлээр хүмүүжүүлэх, дэлхийн зах зээлд үндэсний соёлыг сурталчлах, монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой “Монгол уран бүтээл” үндэсний хөтөлбөрийг батлуулж чадсан нь Л.Гантөмөр сайдын хийсэн нэг том ажил.

Ийнхүү хариуцсан салбаруудаа шинэчилж, хөгжлийн гарцыг нээж өгөхийн тулд залуу сайд өнгөрсөн дөрвөн жил завгүй ажиллажээ. Шинэчлэлийн Засгийн газар бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө Шийдлийн Засгийн газарт халаагаа өгсөн. Тэгэхэд өөрчлөгдөлгүй үлдсэн хоёрхон сайдын нэг нь Л.Гантөмөр. Энэ бол нэг талаар боловсролын салбарын шинэчлэлийг тасалдуулах аргагүй байсных. Нөгөө талаар танхимынхаа сайд нар дотроос хамгийн сайн ажилласныг нь ч харгалзсан болов уу. Ямар ч байсан Л.Гантөмөр сайд аль ч засгийн үед итгэл алдсангүй, зүтгэл цалгардсангүй. Шинэчлэлийг зоригтой хийж, шийдлийг ухаалгаар олж харж чаддаг улстөрч гэдгээ нотлон харуулав.

Улсын Их Хурлын гишүүн Даваажавын ГАНХУЯГ

ОЛНЫ ИТГЭЛ ДААХ ЧАДВАР



Хийсэн, бүтээснээрээ хэдийнэ олны танил болсон УИХ-ын гишүүн Д.Ганхуяг 2004 оноос хойш улс төрийн гал тогоонд буцалж, УИХ-ын халуун бүлд гишүүнчлэгдэж яваа нэгэн. Монголын хууль тогтоомжийн сан хөмрөгт түүний нэрээр нэрлэгдэх “бүтээл” хангалттай олон болжээ. Хамгийн илэрхий жишээ гэвэл газрыг иргэн бүрт өмчлүүлэх тухай түүхэн шийдвэрийг нэрлэж болно. Анх айл өрхөд өмчлүүлэх бодлоготойгоор батлагдсан хуульд зарчмын гэж хэлж болохуйц шинэчлэлт хийж, өлгийтэй нярай, өтгөс буурал ялгалгүй бүх хүнд 0.07 га газар өмчлүүлж, өмчийн эзэд болгох суурь концепцийг тэр батлуулсан. Хууль хэрэгжих хугацааг 2018 оны тавдугаар сарын 1-ний өдөр хүртэл сунгасны зэрэгцээ газрын эрхийн гэрчилгээ олгох, түүнийг худалдан борлуулж, захиран зарцуулж болох боломжийг ч бүрдүүлсэн. Ямар нэгэн ажил эхлүүлсэн л бол гүйцээж, ард нь гардаг зангаараа тэр өнөө хэр иргэн бүрийг газаржуулах бодлогоо ийнхүү төгөлдөржүүлсээр явна.

“Жижиг, дунд үйлдвэр бол Азийн бар улсуудын хөгжлийн нууц нь юм” гэж тэр өөрийнхөө бодлогын “нууц”-ыг тайлсан. УИХ-ын гишүүн болмогцоо анх түрүүнд батлуулсан хуулиудын нэг нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль байсан нь ийм учиртай. Улмаар Япон Улсаас авах жижиг, дунд үйлдвэрт зориулсан хоёр шатлалтай, урт хугацаатай, нийт 100 гаруй сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийг шийдвэрлүүлж, бодлогоо санхүүгийн хувьд тордсон. Цаашлаад Өрсөлдөөний тухай хуулийг батлуулж, жижиг, дунд үйлдвэрлэлийн бизнесийн орчныг цэгцэлж өгсний дээр “Зээлийн батлан даалтын санг” бий болгосон. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд арилжааны банкуудын өндөр хүү, хөрөнгийн барьцааны асуудал бэрхшээл учруулж байв. Энэ бэрхшээлийг бууруулах гарцыг бодлогын түвшинд шийдэж, тэрээр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг УИХ-аар батлуулсан бөгөөд энэ хуульд

100 сая төгрөгийн зээл авлаа гэхэд баталгааны 60 хувийг уг сан дааж, зээлдэгч 40 хувийн баталгаагаа гаргах зохицуулалтыг тусгаж өгсөн.

Өнөөдөр улстөрчдийн дийлэнх нь хөгжлийн гарц, шийдлийг эрж хайсан “эхлэлийн шатан”-даа явцгааж байна. Д.Ганхуяг шиг аль эрт бодлогоо бодоод хариуг нь гаргачихсан, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө багагүйг амжуулчихсан нь цөөн. УИХ-ын гишүүд ч, мэргэжилтэн судлаачид ч түүнийг Монголын аж үйлдвэрийн, бизнесийн, төсөв төлөвлөгөөний эрх зүйн бодлогыг зангиддаг мэргэшсэн бодлоготнуудын нэг гэж хүлээн зөвшөөрдөг.

УИХ-ын гишүүнээр ажилласан ихэнх хугацаандаа тэрбээр Монгол-Японы парламентын бүлгийн даргын сонгууль үүргийг гүйцэтгэжээ. Өмнө өгүүлсэн жижиг, дунд үйлдвэрийн хоёр шаттай зээлээс эхлээд удахгүй үүд хаалгаа нээх гэж буй Хөшигийн хөндийн нисэх буудлын асуудлыг ч тэр анх санаачилж, өөрөө хөөцөлдөж бүтээсэн. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр буюу Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах саналыг 2004 оноос эхлэн тавьж, бэлтгэл ажил болгон хоёр орны төр засаг, хувийн хэвшлийн хамтран ажиллах “Монгол, Японы хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. Энэ өтөлбөрийн үр дүнд өнгөрсөн онд Монгол Улс анхны чөлөөт худалдааны хэлэлцээрээ Япон Улстай байгууллаа. Энэ бол хоёр улсын харилцааны түвшин хамгийн дээд хэмжээндээ хүрч буйн илрэл.

Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдах үед стратегийн ордууд, эдгээрийн дотор Оюутолгой, Тавантолгойн ордуудыг ашиглахтай холбоотой асуудал улстөржилтийн үнэмлэхүй хэмжээнд хүрч улайссан байв. Монголын эдийн засгийг хөөсрүүлсэн эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ унаад эхэлчихсэн үед уул уурхайн энэ салбарыг түүнд хариуцуулсан. Уул уурхайн сайд Д.Ганхуяг чухам ямар өгөгдөлтэй ажиллахаа, бас түүнийг яаж даван туулж, хэрхэн урагшлуулахаа ч мэдэж байлаа. Тэр бол эрх ашгийн эрэмбэ, үнэт зүйлийн дарааллыг ягштал баримтлах суурь үзэл санаа байв. Өөрөөр хэлбэл, улс орныхоо, монголчуудынхаа нийтлэг эрх ашгийг нэгдүгээрт тавьж, хоёргүй утгаар нь хуулиа чандлан сахих баримтлалаар асуудалд хандаж, шийдэж явах зарчимтай.

Юуны өмнө тэрбээр салбарын эрх зүйн орчныг шинэчилж, урт хугацаанд тогтвортой, өрсөлдөх чадвартай болгож чадсан. Алтны нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувь болгож бууруулснаар гадагш хяналтгүй урсаж байсан алтны хууль бус экспортыг зогсоосноор Монголын алт Монголдоо үлддэг болж, улсын нөөц үлэмж хэмжээгээр нэмэгдсэн. Газрын тосны бүтээгдэхүүний гадаад худалдааг нэгдсэн бодлоготой болгож, экспортолж буй түүхий нефтийнхээ оронд бензин, шатахуун авдаг болсноор ОХУ-ын ганц компаниас хэт хамаардаг байдал үндсээрээ өөрчлөгдөв. Мөн бензин, шатахууны хилийн үнийг түүхий нефтийн олон улсын биржийн үнээс тооцдог болсноор 320 ам.доллараар бууруулж, худалдааг бизнесийн зарчимд нийцүүлж, нөөцийг 2.6 дахин нэмлээ. Эрдэнэт, Багануурын уурхайнуудад хамаарах хайгуулын талбайнууд булхай луйврын аргаар хувийн хэвшлийн компаниудад оччихсон байсныг буцаан авч, улсыг хохиролгүй болгосон. Ингэснээр Эрдэнэт үйлдвэрийн насжилт 25-30 жилээр уртасч, Багануурын нөөц 450 сая гаруй тонноор буюу 65 хувиар нэмэгдсэн байна.

Өөрийгөө мартаж, өрөөл бусдыг бодож, тэтгэж чаддаг хүн чанартай, эрх ашгаа эрэмбэлж мэддэг зарчимтай, эх орноо хамгаалж чаддаг эр зоригтой хүн л үүрүүлсэн үүрэг, хариуцлагыг хөсөрдүүлэхгүй авч явж чадна. УИХ-ын гишүүн Д.Ганхуяг тийм л түшээдийн нэг. Дээр өгүүлсэн бүхэн үүнийг хангалттай нотолно.

Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн ГАРАМГАЙБААТАР

ХАН ХЭНТИЙН “ХУЙХТАЙ” ХӨВҮҮН



Хэнтийчүүд 2012 онд Б.Гарамгайбаатарыг УИХ-д төлөөлөгчөө болгож илгээсэн. УИХ-ын гишүүний эрхэм алдрыг анх удаагаа овогтойгоо хамт бичүүлж яваа хэдий ч хийе гэсэнд арга, хийхгүй гэсэнд шалтаг үргэлж олддогийг тэрбээр чимээгүйхэн харуулсаар яваа. Өнгөрсөн хугацаанд хийсэн ажил нь хэзээний хашир парламентчдаас дутахааргүй гэх. Хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах, ажлын хэсэг ахлах гээд барагтай гишүүний “бяр чадал” нь дутдаг ажлаас эмээлгүй, шантралгүй үүрэлцсээр ирж. Хууль гэдэг нэг хүний санаачилж хийдэг зүйл биш. Түүний ухаанаа ширгээж, үгээрээ хачирласан хууль, тогтоолын жагсаалтыг гаргавал Компанийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай, Статистикийн тухай хуулийн төслүүдийг нэрлэж болно. Мөн Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай, Түр хороо байгуулах тухай, Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 зэрэг тогтоолын төслүүдийг хэлэлцүүлж батлуулжээ.

Хийх ёстой ажлаа хийсэн шиг хийж, түмнээ төлөөлсөн төрийн түшээгийн үүргээ биелүүлсэн шиг биелүүлж чадаж яваа гэж түшээдийн нэг. Ялангуяа далд эдийн засгийг ил болгоод зогсохгүй иргэдийн хувьд хэдийнэ урамшууллыг нь хүртээд эхэлчихсэн НӨАТ-ын хуулийг анх санаачилсан. Мөн түүний сэтгэл зүтгэл гарган ажиллаж батуулсан хуулийн дагуу олон мянган монгол айл бага хүүтэй зээлд хамрагдах боломж бүрдэж, шинэ орон сууцанд гал голомтоо бадраасаар байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тэрбээр журмын нөхдийн хамт өргөн барьсан нь ипотекийн зээлийг үргэлжүүлэн олгож, гацаанаас гаргасан шийдэл байв. Энэ тухайгаа

“Найман хувийн зээлийг авахад 18 мянган иргэнд хүлээлт үүсээд байгаа гэсэн тоо бий. Тэгэхээр ийм хүлээлт үүсчихээд байхад гарцыг нь олох шаардлага тулгарсан. Тиймээс хууль эрх зүйн орчинг сайжруулах нь УИХ-ын гишүүн бидний үүрэг. Би үүргээ л биелүүлсэн” гэж даруухан өгүүлсэн нь хэвлэлийн хуудаснаа түүх болон үлдэнэ.

Хэнтийчүүд түүнд хууль тогтоох дээд байгууллагад өөрсдийг нь төлөөлөх эрхийг “өвөртлүүлсэн” бол нэг ангийн нөхөд нь Эдийн засгийн байнгын хороог толгойлох чухал албыг хариуцуулсан. Тэрбээр 2012-2014 онд тус байнгын хорооны даргаар ажиллах хугацаандаа банк санхүү, эдийн засгийн чиглэлийн томоохон хуулиудыг боловсруулж, энэ салбарын шинэчлэлд гар бие оролцсон юм.

Ачааны хүндийг үүрсэн ч “би” гэж дуугарч байсан удаагүй түүний эл чанар, эхлүүлсэн ажлаа эцэст нь хүргэдэг чадварыг Хэнтий аймгийн Ардчилсан намын даргаар олон жил ажиллаж, улс төрийн дөлөнд олон жил ширээгдэж хатаагдсаны буян гэж дотны нөхөд нь хэлэх нь бий.

Хувь хүний тухайд эл эрхэм аядуу, зөөлөн зантай нэгэн. Гэхдээ өөрийн байр суурийг хамгаалах, үзэл бодол, байр сууриндаа зогсох талдаа заримдаа ч хатуугаас хатуу зан гаргах нь бий. Энэ нь түүнд өнгөрсөн хугацаанд сайн муугийн аль алиныг нь авчирсан гэж хэвлэлийнхэн онцлох дуртай. Зарим асуудалд байр сууриа илэрхийллээ ч гэсэн хэвлэлийнхний ээрэлтээс халгахгүйгээр “үгүй” гэж хэлэх нь энүүхэнд. Тэр байтугай шууд нэвтрүүлэгт орж байхдаа үзэл бодол нь таараагүй нэгний яриаг таслаад эфирийг хаяж гарсан зоригтой нэгэн. Учир нь улстөрчид хэвлэлийнхэнд таалагдах, тэр тусмаа зурагтын дэлгэцээр сайхан харагдахын гайхамшгийг үзүүлдэг бол түүнд тийм зан үгүй.

Аядуу зөөлөн зантай түүнийг 2014 онд УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга болоход нь аливаа асуудалд нээлттэй ханддаг, шулуухан үгтэй журмын нөхдөө удирдаж чадах уу гэдэг асуулт хэн хүнд сонирхолтой байлаа. Харин намын бүлгийн дарга төд удалгүй өөрчлөгдөнө гэж байсан хүмүүсийн таамаглал зөрж, өнөөдрийг хүртэл ая эвийг нь тааруулаад бүлгээ удирдаж ирсэн нь түүнийг лидер болохыг харуулна. 11 хүүхэдтэй айлын ууган хүү тэрбээр бусдыг ингэж удирдаж чиглүүлнэ гэдэг багаас сурсан эрдэм нь аж. Түүний аав нь малын эмч, ээж нь эх барих эмэгтэйчүүдийн эмч. Гэрийн бараа харахгүй хөдөөгийн эмч нарын цаг наргүй ажлын ар талын үнэнч туслагч нь айлын том хүү байх нь гарцаагүй. Тиймээс гэр орны ажил, дүү нараа асарч халамжлахад тэрбээр багаас суралцжээ. Энэ нь хожим компани толгойлохоос эхлээд улс төрд өдий зэргийн мөртэй явахад нь тус болсон хэрэг. Долоон эрэгтэй дүүгээс нь архи уух байтугай тамхи татдаг хүн үгүй нь хэр зангарагтай ах байсныг нь харуулах биз.

Хууль тогтоох дээд байгууллагад ажиллах хугацаандаа амжуулсан их ажлынхаа зэрэгцээ аймагтаа хоёр ч томоохон үйлдвэр барих шийдвэрийг гаргуулж чадсан. Түүнчлэн аймгийн ард иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр нэлээд чармайлт гаргаж хөөцөлдсөн бүтээн байгуулалтын ажлуудыг нь тоочвол их ээ. Аливаа ажил нарийн судалгаа, тооцоолол дээр үндэслэн, төгс гүйцэтгэлтэйгээр хийгдэх учиртай гэсэн инженерийн зарчимтай энэ эрхмийг нутгийн зон олон нь хийж байгаа ажлаараа хэн гэдгээ харуулдаг “хуйхтай хөвүүн” хэмээдэг.

Улсын Их Хурлын гишүүн Раднаасүмбэрэлийн ГОНЧИГДОРЖ

ТӨРИЙН ЗҮТГЭЛТНИЙ ТУЛХ, ТӨРХ



Улам-Оргих овгийн Раднаасүмбэрэлийн Гончигдоржийн төрийн үйл хэрэгт гаргаж буй уран нарийн шийдэл, алсыг харсан чухал сонголтууд, төр, нийгмийн төлөөх хөдөлмөр, зүтгэлийг нь хүмүүс бусдаас нь ялгаж, “төрийн түвшин нуруу” хэмээн гуайлж, үнэлдэг.

Олон жилийн турш улс төрийн халуун тогоонд чанагдан хат сууж, сайн муугаараа бишгүй л нэг дуудуулж яваа төр, нийгмийн зүтгэлтний нэг нь тэрбээр яахын аргагүй мөн. Олноо “Гончигоо дарга” хэмээн хүндлэгдсэн түүний туулсан зам, намтар түүхийн хуудаснаас Монгол Улсын парламентын түүх, түүхэн он цагийн өрнөлтөд үе үеийн парламентаас хэрэгжүүлж байсан төрийн бодлого, улс төрийн сонголтууд бүхэлдээ уншигддаг. Мэдмээр ч юм энд их бий. Хэнд ч мэдрэгдэггүй хэрнээ авууштай зүйл олон ч байгаа.

Р.Гончигдорж хэмээх улстөрчийн бодрол, ухаарал, эргэцүүлэл, бясгалгал, алсын хараа, бас ээдрээтэй асуудлын мөчлөг бүрийг өөрөөр харах ухааныг түүний хэлсэн үг, үйл хэргээс төвөггүй мэдэж болно. Ардчиллын анхдагчийн хувьд үүрэг хүлээсэн улстөрчийн чадвар, том эрдэмтэн, академич хүний ухааны зангараг харагддаг. Тэртээ 1990 оны үед нэг намын үзэл суртлын нөлөө, хуарангийн дэглэм бүхий ёс суртахууны хүрээнд “Шударга үйлийн төлөө иргэний зориг, эх орныхоо хөгжлийн төлөө амиа золиослох сэтгэлийн тэнхээ хэрэгтэй” гэж хэлж чадаж байсан нь Раднаасүмбэрэлийн Гончигдорж. Улс төрийн аливаа тэмцэл талуудын хатуу ширүүн сөргөлдөөн дунд өрнөж эхлэхэд хатууг нь ямагт зөөллөж, улс төрийн алдаа мадагтай буруу үйлдэл бүрийг зөв рүү нь эргүүлэх арга ухаан нь Р.Гончигдорж гишүүнээс хуралдааны танхимд сонсогдож, төрийн бодлого болж хэрхэн хуульчлагддагийг бараг гуч орчим жилийн дараа л хүмүүс ойлгож байна.

Түүнтэй мөр зэрэгцэн төрийн хэрэгт зүтгэж явсан түшээд Гончигоог “Өргөн мэдлэгтэй, боловсрол өндөртэй, орчин үеийн төрийн зүтгэлтний шинж төрх

бүрдсэн улстөрч” хэмээн үнэлсэн байдаг. Мөн зарим нь “Аливаа асуудалд туйлшралгүй, хамтын оновчтой шийдэлд хүрч чаддаг хүн. Эв нэгдлийг эрхэмлэн асуудлыг хурцатгалгүй шийдвэрлэх чадвартай түүн шиг хүн өнөөдөр Монголын төрд үгүйлэгдэж байна” гэсэн ч бий.

Монгол Улсын гавьяат хуульч агсан Б.Чимид гуай “Р.Гончигдорж хоёр удаагийн хууль тогтоох дээд байгууллагыг зургаан жил тэргүүлсний хувьд засаг, төр барихын утга учир, арга дадлыг олж, онол номд гаршсан хүний нэг аргагүй мөн. Өөлөх юм гэвэл дэндүү зөөлөн гэдэг. Өндөр дээд тушаалын хүн тэр тусмаа төр тэргүүлэх үндэсний эв нэгдлийг илэрхийлэх их үүрэгтэй зүтгэлтэн хуйхалчих шахсан хуйсагнуур байх нь зохимжгүй” гэж онцолж үнэлсэн нь парламентын түүхэнд бичигдэж үлджээ.

Улсын Бага Хурлын дарга, Монгол Улсын дэд Ерөнхийлөгч, УИХ-ын даргаар ажиллахдаа Раднаасүмбэрэлийн Гончигдорж парламентыг удирдсан түүх нь бусад спикерүүдээсээ ихэд онцлогтой. УИХ, Засгийн газрын түвшинд гарсан алдаа дутагдал нь албан тушаалын төлөөх хувь хүмүүс, хэсэг бүлэглэлийн явцуу ашиг сонирхлын санаа сэдлээр голдуу өдөөгдөж, улс төрийн хурц сөргөлдөөнд хүргэх тэр мөчид аядуу зөөлөн, ухаалаг бодлого барьж 1996-2000 оны парламентыг тарж бутраалгүй үүргээ биелүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлснээр түүний төрийн хэрэгт оруулсан хувь нэмэр олон түмэнд танигдсан байдаг. 1990 оны Ардын Их Хурлын чуулганы депутатуудын итгэлийг олж шинэ хуучин үзэл суртлын ид сөргөлдөөний үед нэг намын гэлтгүй аливаа хүмүүстэй үг хэлээ ололцон, уян хатан ухаалгаар ажиллаж байсан голч тууштай улстөрч хэмээн хамтран зүтгэгчид нь түүнийг үнэлсэн нь бий.

Ардчилсан парламентын үйл ажиллагаанд олонхи нь цөөнхөө хүндэтгэн нээлттэй мэтгэлцдэг, асуудлыг мухардлаас зөвшилцлөөр ойлголцон гарах арга замыг аль аль талаасаа эрэлхийлдэг нь ардчилсан төр мөнхөд оршин байх улс төрийн сонгодог ухаан, урлаг юм. Тийм гэгээн үйлсийн эрхэм хөтөчдийн нэг нь Раднаасүмбэрэлийн Гончигдорж. Эдүгээ гуч шахам жилийн цаг хугацааны үнэлэмжээр түүний гутаагдсан, доромжлуулсан нэр, элдэв хоч бүрийн ард ардчилсан төр мөнхөд оршин байхын төлөөх зүтгэл, хэн хүнд заяагдахааргүй тэвчээр зааж, хатууг зөөллөж, бурууг зөвд нь эргүүлэх алхам хийж чадаж байсан нь түүхийн хуудаснаа үлджээ.

Р.Гончигдорж түшээг нутгийн хөгжлөөс нь салгаж бодох аргагүй. Тэр нутаг амьтай хүн. 1990 оны эхээр сумаа сэргээн байгуулах гэж шуугиулсан, сүүлдээ “Архангай аймагт хамаг юмыг авчихлаа, жагсаалтаар гарчихаад жалгаа бодлоо” гэж шүүмжлэгддэг хүн. Ганц жишээ дурдахад 1997 онд УИХ-ын дарга байхдаа Хархорин-Солонготын давааны автозамыг “Хэвтээ тэнхлэгийн төв зам” статустай болгож, одоо бүтэн хатуу хучилттай болсон бол Өгийн нуур-Рашаантын “босоо тэнхлэгийн зам” цээжинд нь багтаад явж байгаа юм билээ. Олон жил парламентад сууж санаа нийлсэн олонтой болсны л зангараг юмуу даа.

Улс төрийн амьдралд түүнд тохиолдсон, бас тулгарч ирсэн сонголт бүрийн өмнө ямагт гарцыг нь олж, тэмцсэн тэмцлийн түүх бүхэлдээ бидний өмнө байна. Хэнд ч өөрөө хэлээд байдаггүй, тэр болгон улстөрчдөд мэдрэгддэггүй тийм нарийн нандин шийдэл, гарцууд Раднаасүмбэрэлийн Гончигдорж хэмээх улстөрчид байгаа нь Монголын парламентад ёсны цаашдын хөгжилтийн явцад авч хэрэгжүүлэх чухал түлхүүр бүхий туршлага юм.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн ДАВААСҮРЭН БАЯЛГАА ҮР АШИГТАЙ АШИГЛАХ НЬ ТҮҮНИЙ ЗАРЧИМ



Цэрэнпилийн Даваасүрэнг монгол түмэн төрийн хүн, чадварлаг эдийн засагч гэдгээр нь андахгүй. Энэ үнэлэмжээр түүний нэр сүүлийн жилүүдэд ТОП-10 улстөрчдийн дунд тогтмол дуулдах болов. “Төр намайг хөрөнгө зарж бэлдсэн, олон түмэн намайг түшиж өдий зэрэгт хүргэсэн учраас хоёргүй сэтгэлээр монгол төр, олон түмэндээ зүтгэх ёстой” гэсэн бодолд хөтлөгдсөн хоймор нутгийн хүү Ц.Даваасүрэн хоёр удаа УИХ-д сонгогдохдоо үнэхээр ч төрийн бэлтгэгдсэн түшээдийн нэг гэдгээ харуулсан гэхэд болно.

Тэрбээр улс төрд орж ирэхээсээ өмнө чадварлаг эдийн засагч гэдгээрээ салбарынхан дундаа танигдсан байв. 1995 оноос 2005 оныг хүртэлх хугацаанд Сангийн яамны валютын харилцаа, Эдийн засгийн бодлого, гадаад харилцаа, Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээ, Төрийн сан зэрэг хариуцлагатай газруудад ажиллаж, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын орлогч, газрын дарга гэсэн төрийн албаны бүх шат дамжлагыг туулсан гэдэг. Манай улс ОХУ-д төлөх их өрийн дарамтаас гарахад техникийн ажлын хэсгийг нь ахлан ажиллаж байсан туршлагатай эдийн засагч. Түүний санаачилж, удирдан зохион байгуулж хэрэгжүүлсэн төрийн сангийн тогтолцоо бий болсноор монгол төр мөнгөний гачаалаас гарсан гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг юм билээ. Цалин, тэтгэвэр, тэтгэмж олон сараар тавигдахгүй удаашрах, төрийн байгууллагуудын данс улайх зэрэг хүндрэлүүд түүх болж үлдсэн юм. Мөн Монгол Улсад өрийн удирдлагын сонгомол тогтолцоог бий болгох, Засгийн газрын нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлийг хийхэд ч Ц.Даваасүрэн өөрийн мэдлэг оюунаа харамгүй зориулсан нэгэн.

Тэрбээр улс төрийн шахалтаар Сангийн яамаа орхисон 2005-2007 онуудад боловсрол, соёлын салбарын санхүүг удирдаж, бэхжүүлж өгсөн гавьяатай нэгэн. Тэр үед боловсролын салбарын төсөв 159 тэрбумаас 273 тэрбум төгрөг

болж өссөн, хөдөөд соёлын төвийн орон тоо 8 болж нэмэгдсэнийг Сангийн яамныхандаа ойлгуулж өгсний үр дүн гэж үнэлдэг юм билээ.

Улмаар 2008-2012 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллахдаа жил бүрийн төсвийн тухай хууль, төсвийн тодотгол, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөв санхүүтэй холбогдолтой асуудлыг УИХ-аар хэлэлцэхэд ажлын хэсгийг ахлах болон гишүүнээр тогтмол хариуцан ажиллаж байв. Өнгөрсөн хугацаанд УИХ-ын Төсвийн байнгын хороог хоёр удаа даргалсан нь түүнийг ангийнх нь нөхөд төсөв, санхүүгийн чиглэлээр үнэлж, сонсдогийн илрэл юм. Төсвийн асуудлаар түүний үг үнэтэй. Эдийн засаг, хөдөө аж ахуйн асуудлаар ч түүнийг амыг харах нь олонтаа.

Хөдөөгийн хөгжил, ялангуяа малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ихээхэн анхаарч ирсний илрэл нь “Монгол мал хөтөлбөр” юм. Уг хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар өнгөрсөн дөрвөн жилд хамгийн их дуугарч, хяналт тавьж ажилласан хүн бол Ц.Даваасүрэн гишүүн байлаа. Түүний улс орноо хөгжүүлэх хөгжлийн загвар ч малтай холбоотой. Тэрбээр мал аж ахуй бол хямралгүй, тогтвортой хөгжлийн үндэс, малчид дундаас олигархи төрөхгүй, тэд газар нутгаа харийнханд зарахгүй гэж байнга ярьж, нөхдөдөө ухуулж ирсэн. Монгол орон хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийг түлхүү анхаарч, түүнийг аялал жуулчлал, бусад салбараар дэмжих ёстой гэсэн загварыг тэр хэлдэг. Энэ замаар явбал баялгийн үнэ дагасан хямралаас бид сална гэдэг юм билээ.

Мөн Ц.Даваасүрэн гишүүнийг манай иргэд байгалийн баялгаа үр ашигтай ашиглахын төлөө тууштай тэмцэгч гэдгээр нь үнэлдэг. Тэр Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг УИХ-аар хэлэлцүүлэхэд “үр ашигтай байх ёстой” гэдэг өөрийн байр суурийг хатуу баримталж ирсэн цөөхөн гишүүний нэг. Түүнчлэн урт нэртэй хууль буюу Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг санаачлан, алтны нөөцийн 10 хувийн татварыг 2.5 хувь болгож бууруулах, газрын тосны ашгийг нэмэгдүүлэх, Ноён уулаа ухах, Дубайн гэрээг цуцлуулах асуудлуудыг хэлэлцэхэд тэр өөрийн байр сууриа хатуу баримталж иржээ.

Боловсролын салбараас төрсөн УИХ-ын гишүүний хувьд багш нарын нийгмийн асуудал, тэтгэвэр, тэтгэмжийн асуудал УИХ-аар орж ирэхэд онцгойлон анхаардаг. Үүний үр дүнд хоёр ч удаа багш нарын нэмэгдэл, тэтгэлгийг хасах асуудал Төсвийн хуультай хамт орж ирээд батлагдаж чадалгүй буцсан. Мөн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, хэлэлцүүлж батлуулсан байна.

2012 онд УИХ-д бие даан нэр дэвшиж сонгогдсон гурван гишүүн зөвлөл байгуулан ажиллаж иргэдийн дунд намуудаас дутахааргүй ажиллаж чадсан гэсэн өндөр үнэлэмж хүртсэн нь түүний зүтгэлийн үр дүн:

Чуулганы хуралдааны ирц сайтай гишүүдийн нэг байхын зэрэгцээ тойрогтоо хамгийн олон удаа ажилласан гишүүний нэгэнд зүй ёсоор ордог. Тэрбээр 2012-2016 онуудад Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай гээд олон хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулсан гээд дурдах ажил ихтэй төрийн эрхэм түшээ.

Улсын Их Хурлын дарга Цэдэвийн ДАШДОРЖ

УЙДАХ ЗАВГҮЙ ХҮН



/Тэнгэр газрын завсарт/
Нэг.

УИХ-ын гишүүн Ц.Дашдоржтой Хонгконг руу нисэх онгоцонд таарав. Тэрбээр “Путин” хэмээх номын хуудсыг салаавчлан барьчихсан, баахан сонин сугавчилсан байхыг үзвэл уйдах завгүй яваа нь илэрхий. “Одоо бидний яриад байгаа зүйлийн олон зангилаа энэ номд байна” гэсээр мөнөөх номоо надад өгч байна.

Уг нь тэр дуугүй талдаа хүн боловч нэг яривал яриасаг ажээ. Бидний ярианы сэдэв улс төр. Онгоцны бүдэг дуунд зарим үг нь үл сонсогдом намуухан ярих юм. Би түүний үг өгүүлбэр бүрийг алдалгүй сонсох гэж чихээ дэлдийлгэнэ. Тэр Монгол Улс, олон улсын хүрээний том улс төр ярина. Улс төрийн талаар илэн далангүй, тэгэхдээ нарийн ширийн задаргаа бүхий шаглаж ярих нь үнэхээр сонирхолтой. Аргагүй л УИХ-д гурвантаа сонгогдож, монгол төрийн яамны сайд, дэд сайдын алба хашиж явсан тулхтай улстөрчийн хувьд ийм ч байлгүй яахав гэх бахархах бодол төрнө.

Ц.Дашдорж бол оюутан ахуй цагаасаа улс төрийн гал тогоонд чанагдсан нэгэн. Хөх Алтайн зангарагт эрчүүдийн нэгний хувьд тэрбээр Монголын төрийн босго шалгуурыг төвөггүй давж хойморлон сууж барилга, зам тээврийн салбарын төрийн бодлогыг нэгэн үе тодорхойлж, хэрэгжүүлж явсан итгэл найдвар хүлээсэн шигшмэл боловсон хүчин юм.

Харин хатуу ширүүн, хүнд бэрх шийдлийн ирмэг дээр ямагт дэнжигнэж байдаг улс төрийн амьдралыг туулсан хүн гэхэд тэр дэндүү зөөлөн. Түүний төвийг сахисан бодлого, хэн нэгэнтэй тэрсэлдэж дарийн утаа баагиулаад байдаггүй зан чанар нь магад Монгол Улсын хөгжлийн олон бэрх асуудлыг зөв шийдэхэд зөөлөвч болж, улс төрийн гацаанаас асуудлыг гаргаж, алсыг харсан тулхтай үйлсийн зам мөрийг тодотгож байсан нь гарцаагүй.

Тэр бол зөвшилцлийн ардчиллыг эрхэмлэдэг төрийн туршлагатай улстөрчдийн нэг. Их ярьдаг хүнийг бус их тунгаан боддог хүнийг улстөрч гэдэг юм байна. Тэгвэл тэдний нэг нь Ц.Дашдорж юм.

Хоёр.

Ц.Дашдорж гишүүн намайг бизнес классын зэрэгцээ суудалдаа урьж суулгасан тул бид хоёрын яриа Улаанбаатартаас Хонгконг хүртэл нисэх онгоцонд үргэлжлэв. Ярианы бас нэг сэдэв бол нутаг орон байлаа. Бид хоёр Говь-Алтайн цэнхэр хязгаарт төрсөн улс аа.

Тээр жил наадмын өмнө төрөлх сумынхаа уяачидтай уулзаж явахад зүүн зүгийн адуу олширсон байв. Манай нутгийн адуу зүс сайтай, эрмэг аргамаг боловч хурдан удмын цус сэлбэсэнд уяачид талархалтай байсан. Адуучид адуугаа өөрсдөө сонгож авсан боловч зүүн аймгаас баруун аймаг хүртэл зам хол, зардал их. Түүнд нь Ц.Дашдорж гишүүн тус болсон төдийгүй улсын манлай алдарт уяачидтай уулзуулж сургалт семинар зохион байгуулан сум бүрийн уяачдын холбоонд их зургаан ханат өргөө гэр бэлэглэсэн нь ихээхэн урам зориг бэлгэшээл агуулсан байсныг нь би сайн санаж байна.

Манай удмынхан бол Өгөөмөрийн голоор нутагтай тэмээчид. Ц.Дашдорж гишүүн “Их говийн тэмээний баяр”-ыг санаачлан арван жил дараалан зохион байгуулж, энэ жил баруун бүсийн хэмжээнд тэмдэглэсэн нь говь, тэмээ хоёрыг зэрэглээн дунд зээрийн янзага шиг бүүвэйлэн санадаг миний хувьд түүний хамгийн эрхэм ажлын нэг хэмээн санагддаг. Ялангуяа тэмээн сүргийн тоо толгойгоор улсад гуравт эрэмбэлэгддэг Говь-Алтайчуудын хувьд яав ч энэ нь эгэл жилийн ажил бус аа.

Ц.Дашдорж гишүүний боловсруулж хэрэгжүүлсэн “Алтайн хөгжлийн гурвалжин” түүнийг уйдах завгүй болгодог нь илэрхий. Нөөц баялагтай ундны ус, найдвартай эрчим хүч, нийслэлтэй холбосон тосон зам гээд хийж эхлүүлсэн, гүйцэтгэсэн, хийхээр төлөвлөсөн их ажлуудыг бодохуйяа нуган үрийн сэтгэл зүрхний чин эрмэлзэл тэмтрэгдэнэ. Тэр үнэхээр нутаг амьтай хүн ажээ.

Гурав.

Ц.Дашдорж бол зөөлөн-хатуу хүн. Зөөлөн гэдэг нь түүний төрөлх зан чанар бөгөөд хатуу гэдэг нь үзэл бодолдоо үнэнч шударга байдлыг хэлж байна. Ийм хүн ховор бөгөөд бэрх хэцүү байдаг. Зөөлчлөх гэсэн хүнд хана хэрэм мэт хатуу атлаа зөв байна гэдэг бэрх хүний л чадвар. Дашдорж бол тийм л хүн.

Тэрбээр ямар ч цаг үед шард шарваж, хөхөд хөөрч өөрөөсөө урваж явсангүй. Хүчирхэг хүн, төлөвшсөн бодгаль бол дотоод итгэл үнэмшилдээ тууштай байдгаараа бусдаас ялгардаг. Харилцааны өндөр соёл, оюуны дээд боловсрол, түмний их хүндэтгэл, төрийн түшээ, сайдын суудал тэргүүтэн түүний эгэл жирийн дүр байдлыг өчүүхэн ч өөрчилсөнгүй.

Ц. Дашдорж гишүүнтэй уулзахад нэг л дулаан дотно санагдана. Харц нь хилэн үгүй дөлгөөн, үг нь хатуу үгүй зөөлөн, сэтгэл нь хир үгүй тунгалаг аж. Засагт ханы хөх харцуулын язгуур шинж, мөн чанар ингэж өөрчлөгдөж байна. Хүн чанар, мөн чанарын хэмжүүр гэж байдаг бол төрд хүндлэлтэй, нутаг амьтай, хувь хүний төгс төгөлдөр төлөвлөөс эхлэлтэй байдаг байх.

Уйдах завгүй хүн бол бүтээлч хүн юм. Тэдний нэг нь Цэдэвийн Дашдорж аж.

Ү.ХҮРЭЛБААТАР (Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч)

Улсын Их Хурлын гишүүн Дамдины ДЭМБЭРЭЛ

ДААСАН БОДЛОГОТОН



Дамдингийн Дэмбэрэл гишүүн бол Монголын төрийн, Монгол Улсын Их Хурлын илэрхийлэл юм. Манай улсын парламентат засаглалын бүхий л түүхийн сайн муу, санамж ой, араг багана, алдаа оноо, ноён нуруу нь энэ хүн. Төрийн хүний хэв төрх, намба төлөв, ёс зүй, зарчим, итгэл үнэмшил энэ хүнээс л ойлгогддог. Тэрбээр Улсын Их Хуралд зургаан удаа сонгогдож, 2008-2012 онд спикерээр ажилласан юм. Түүний бодлогын хат тулх өндөр, үг үйлдэлд нь алдаа байдаггүй. Бүхий л зүйлд эрүүл зөвийн зарчмыг барьж, үлгэр тэгш үйл хэргээр хашсан алба, үүргээ ширээж ирсэн хүн гэвэл түүнээс өөр олонгүй.

Төрийг тогтвортой авч явах, түүгээр дамжуулан дэвшилтэл хөгжил өргөсдөгийг түүний удирдсан парламентын дөрвөн жилээс харж болдог. Улстөрч хүн, ер нь хүмүүс ёс зүйг эрхэмлэж үүнийг сахилга хариуцлагын хэмжүүр болгохыг чухалчилдаг. Түүний удирдсан парламентад сайд нарыг огцруулах тухай нэг биш удаа асуудал, тулгалт тавигддаг байв. Энэ бүхэнд Д.Дэмбэрэл дарга сайн зөвшилцлөөр бүтээгдсэн зөв үр дүн, шийдвэрийг гаргаж, сайд нарт ажиллах боломж олгодог байсан. Төрийг тогтвортой, ард түмний итгэлийг даалгаж оршоох түүний бодлого үр дүнгээ өгч, манай улсын эдийн засаг түүхэндээ анх 17 хувийн өсөлттэй гарч байв. Тэр сайд нарт “Улсын Их Хурал Та бүхнийг огцруулаагүй ч ард түмэн та нарыг сэтгэлдээ огцруулна шүү” гэсэн ёс зүйн хариуцлага хүлээлгэх замаар идэвхжүүлэн ажиллуулж байсан нь төрийг барих сайн үлгэрийн нэгэн жишээ магад мөн.

Д.Дэмбэрэл дарга зарчмыг онцгой хангахыг удирдлага болгодог. Ямарваа юманд, ялангуяа улс төрд, улстөрчдөд зарчим алдагдвал тэр хүнээс, тэр улс төрөөс ямар ч эрүүл үр дүн хүлээж болохгүйг тэрбээр өндөр ухамсарласан, тиймээс өөрийн байгаа газраа ийм зүйл гаргуулахгүйг нэгдүгээр асуудал болгодогийг түүнээс ойлгодог. Зарчим зөв явж байгаа газарт эрүүл бодлого, ажил

үйлсийн зөв эрэмбэ, бүтээлч хандлага ноёлж, тэр хэрээр сайн үр дүн, үр ашиг гардгийг дэргэдээс нь харж болно. Хамт олон нь ч сайн хандлагыг илүү ойлгож, баг хамт олон нягт чамбай ажилладаг. Д.Дэмбэрэл дарга ямар ч үед бүтээлч ажил хийнэ. Хуулийн төслийг нягт нямбай унших нь түүний унаган дадал. Хууль тогтоох ажиллагааг онцгой өндөр түвшинд эзэмшсэний нь ур ухаан энд гардаг. Сонгогчдоос ирсэн өргөдөл гомдлыг нэгбүрчлэн уншина, хариу, илгээмжийг бичнэ.

Д.Дэмбэрэл дарга Ховд нутгийнхныхаа, ард иргэдийнхээ итгэлийг зургаан удаа хүлээж, парламентад сонгогдсон. Үр дүн нь Алтайг давуулан тавьсан хос хар зам. Монгол Алтайг давуулж зам тавих нүсэр ажлыг эрхлэн, мөнгө санхүүг нь олон аргаар шийдвэрлэж, ийм үр дүнд хүргэх чадамжанг олоход амаргүй дээ. Сонгогчид туйлбартай, сонгосон гишүүн тууштай байхын гайхамшиг ингэж бүтээгддэг байна. Оюутолгойн гэрээг түүний парламентын үеийн сайн өнгө төрхөн дээр баталсан нь эдүгээ Монголын ганц гэмээр саалийн үнээ байна. Сайн юмны гэгээ хол тусдаг гэдэг дээ. Сайн түшээгийн сайн үйл хэргийн гэгээ ард түмнийхээ ирээдүйн хөгжлийн харгуйг ингэж гэрэлтүүлдэг байна.

Дэлхийн сонгодог парламентад засаглалтай орнуудын парламентад олон жил сонгогдсон, хуучны хашрууд л сууж байдаг. Гүйцэтгэх засаглалын хэрэгжүүлэх бодлогын эхийг энд л, ийм л хашрууд өрж, шүүсгүй чамбай хяналтыг гүйцэтгэж суудаг байна. Д.Дэмбэрэл дарга бол энэ эталоныг бүтээж байгаа хүн юм.

Д.Дэмбэрэл дарга Монголын улс төрд хамгийн зөвийг хийж ирсэн, сонгосон түшээдээ ард иргэд үл гонсойхын жишээ болж ирсэн хүн юм. Их мөрөн дөлгөөн, эрдэмт хүн даруугийн төлөвийг өвч өөртөө бүрсэн түшээ. Түүнийг төрийн дархан түшээ хэмээн танилцуулан зарлаж, хэлэгдэн яригдаж хэвшжээ. Дархан аварга гэдэг шиг төр, түмнээсээ төрийн дархан түшээ хэмээн цоллогдон залагдана гэдэг бол ховор хувь юм. Яагаад ийн хэлэгдэх болов гэдгийн хариулт тодорхой. Итгэл сэтгэл, үүрэг хариуцлагын харилцан хамаарал, үр дүнгээр тайлбарлагдана.

Д.Дэмбэрэл дарга парламентын зөвшилцлийг онцгой хангаж ажилладаг. УИХ дээр ажил явахгүй, улс төрийн намууд, бүлгүүд зөрчилд орох нь нэг бус. Ийм тохиолдлуудад Д.Дэмбэрэл дарга бүлгийн дарга нарыг өрөөндөө дуудаж, зөөлөн дуугарч, улсын эрх ашгийг ухуулж, нэр төр болоод нийтийн эрх ашгийг цалгардуулахгүй байхыг ятган таниулж, хоёр тийш хараад суучихсан байсан бүлгийн дарга нарыг ойлголцуулж, мэдрэлцүүлж, зөв гарцыг нь олуулж, ингэж ажлаа явуулдаг. Наймаас арван хоёр оны парламентын дэг журам, бүтээмж, эв зохисыг эргэн санасан дөрвөн жил улирч байна. Яагаад нэхэгдэн санагдаж буйн учрыг бүгд ойлгоно. Ард иргэдэд амгалан сайхан, элбэг хангалуун амьдрал л чухал шүү дээ.

Хорин хэдэн жил парламентад суухдаа энэ хүн аливаа бэрхшээлтэй, амаргүй олон ажлын хэсгийг ахалж, оносон дүгнэлтийг гаргаж явсны цөөнгүй нь төрийг эдийн засгийн хямралаас гаргах, эдийн засгийн урт богино хугацааны олон төлөвлөгөөг туршиж, амжилттай хэрэгжүүлж ирсэн туршиц туршлагаууд юм. Спикерээр ажиллаж байгаа үедээ ч ийм тохиолдлыг амжилттай гэтэлж гарч байсан бэлээхэн туршлага бий. Д.Дэмбэрэл даргад төрийн хэргийг илүү өндөр түвшинд, бүр гарамгай төгс явуулах бүхий л боломж бололцоо, арал зангараг, бие оюун, тооцсон төлөвлөл бий. Тэр угаас үүний төлөө ажиллаж амьдарч ирсэн хүн. Тийн учир төрийн дархан түшээ. Даасан бодлоготон.

Улсын Их Хурлын гишүүн Самбуугийн ДЭМБЭРЭЛ ЭДИЙН ЗАСГИЙГ СОЛОНГОРУУЛАГЧ



С.Дэмбэрэл ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэнд “Хөрөнгөтөн орнуудын зах зээлийн эдийн засгийн үндэс”-ийг судалж байсан залуу эрдэмтэн, судлаачийн хувьд судалж мэдсэн зүйлдээ үндэслэн 1990 онд МоАН-ын анхдугаар их хурал дээр “Зах зээлийн эдийн засаг ба эдийн засгаар баталгаажсан эрх чөлөөний үзэл” суурь илтгэл тавьж оролцож байсан манай улсын шинэ үеийн анхны төлөөлөгч, шилдэг эдийн засагчдын нэг юм. Мөн МҮХАҮТ-ын даргаар 16 жил ажиллахдаа Монгол Улсад хувийн хэвшлийг бий болгож хөгжүүлэх, дэлхийн зах зээлд улсынхаа бараа бүтээгдхүүнийг сурталчилах, гаргах, чанар, өнгө үзэмжийн хувьд өндөр жишиг, стандартад хүргэх, үндэсний үйлдвэрлэл, бизнесийг хамгаалж хөгжүүлэхэд таатай татвар, мөнгөний болон хууль эрх зүйн зөв орчин бүрдүүлэхийн төлөө уйгагүй хөдөлмөрлөж, тэмцэж иржээ. Үүний нэг илрэл нь 2003 онд батлагдсан Арбитрийн тухай хууль юм.

С.Дэмбэрэл 2012 оны УИХ-ын сонгуулиар ИЗНН-аас нэр дэвшин намын жагсаалтаар УИХ-ын гишүүнээр сонгогдож, Эдийн засгийн байнгын хорооны харьяа Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны дарга, УИХ дахь албан бус Ногоон бүлгийн дарга, Авлигын эсрэг Монголын парламентын бүлгэмийн гишүүнээр ажиллаж байна. Тэрбээр ард иргэддээ эдийн засгийн эрх чөлөөг нь олгож, бизнесийн орчинд их цэвэрлэгээ хийх, төрийн хэт данхайсан бүтцийг ухаалаг хэлбэрт оруулах, “АМЬДРАЛ” мөрийн хөтөлбөрөө өөрийн болон нөхдгийнхөө оролцоо, дэмжлэгтэйгээр биелүүлэх хүсэл эрмэлзэл дүүрэн УИХ-д орж иржээ. Иргэд, сонгогчид болон намын гишүүд дэмжигчиддээ хэлсэн үг, хийсэн ажил бүхнээ нээлттэй харуулах зорилгоор demberels.parliament.mn цахим хуудсыг тогтмол ажиллуулж байв.

Сонгуулийн дараа Шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, өөрийнхөө боловсруулсан

ИЗНН-ын “АМЬДРАЛ” мөрийн хөтөлбөрөөс 31 зүйл санал оруулж батлуулжээ. Улс орны эдийн засгийг солонгоруулах, ногоон эдийн засаг болон экспортыг хөгжүүлэх, санхүүгийн хүртээмжийг хангах зэрэг санал санаачилгуудаа бүх салбар чиглэлүүдэд хэрэгжүүлүүлэхийг хичээжээ. Энэ хугацаанд хууль тогтоомжийн төслийн 72 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, 10 гаруй ажлын хэсгийг ахалж ажилласан байна. Мөн төрийн байгуулалт, түүний үйл ажиллагааг үр дүнтэй, хөнгөн, шуурхай, цогц уялдаатай болгох үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай зэрэг хуулийн төсөл санаачлан бусад гишүүдтэй хамтран өргөн мэдүүлж, батлуулжээ.

Эдийн засгийн шинэчлэлийг эрчимжүүлэх, иргэдийн болон бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хангах үүднээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Сууц өмчлөгчдийн холбооны тухай, Барцаалан зээлдүүлэх үйлчилгээний тухай зэрэг хуулийн төсөл санаачлан боловсруулж, өргөн мэдүүлсэн нь батлагдах шатандаа байгаа аж.

С.Дэмбэрэл гишүүн сонгогчдын өмнө хүлээсэн үүрэгтээ хамгийн хариуцлагатай ханддаг, чуулганы нэгдсэн хуралдааныг огт тасалдаггүй, хамгийн өндөр ирцтэй оролцдог гишүүдийн нэг агаад иргэд, бизнес эрхлэгчдэд садаа болдог бүх төрлийн хүнд суртлын бичиг баримтуудыг эрс цөөрүүлэх, шат дамжлагыг багасгах, шийдвэр гаргах замыг богиносгож хурдасгах, харилцааг хөнгөвчлөх, нэг цэгийн болон цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд ихээхэн анхаарч ажиллажээ.

Төрийн банкаар дамжуулан зээлийн хүүг буулгаж, хүртээмжтэй түвшинд хүргэх “Сайн малчин”, “Сайн оюутан” гэдэг нийтэд хүртээмжтэй хөтөлбөрүүдийг санаачилсан. Энэ санааг 2015 онд гаргаж УИХ-ын дарга, Ерөнхий сайд болон холбогдох бусад хүмүүст бичгээр хүргүүлсэн нь бодит ажил болоод байна. Эцэг, эхчүүд урьд нь 19 хувийн хүүтэй зээл аваад оюутан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлдөг байсан бол одоо 6 хувийн хүүтэй зээл авдаг болсноор өрхийн зээл багасч байгаа юм.

Түүний санаачилга, оролцоотойгоор 2012 онд Байгаль орчны яамыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам болгон өөрчилж, чиглэлийн яам болгосноор уул уурхай, зам тээвэр, дэд бүтэц, бүтээн байгуулалт, эрүүл мэнд, аялал жуулчлал зэрэг бүх салбар энэ яамнаас аливаа төсөл хөтөлбөртөө санал, чиглэл, удирдамж, зөвлөгөө авч баталгааждаг болсон. Мөн 2013 оныг “Ногоон хөгжлийн жил” болгон зарлаж, улмаар Монгол Улс “Хүрэн эдийн засгаас ногоон эдийн засагт шилжих тухай” үндэсний хөтөлбөр, Ногоон хөгжлийн дунд хугацааны хөгжлийн бодлогууд түүний улирдлага дор боловсрогдон батлагдаж, хэрэгжиж эхлээд байна. Түүнчлэн Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, Ойн болон Усны бодлогууд шинэчлэгдэн батлагдав. Нийгмийн салбарт хамгийн их тулгамдаж байгаа асуудал, ялангуяа ядуурлыг бууруулах чиглэлээр тал бүрийн судалгаа хийж, арга замуудыг хайж, бодлого боловсруулж, гарц, шийдлийг санал болгосоор ирсэн байна.

Эдийн засгийн өндөр мэдлэгтэй, амьдралын арвин туршлагатай, ард түмнийхээ ажил үйлс, амьдрал жаргал, зовлон бэрхшээлийг ойлгодог, тэр бүгдийг нь сайн сайхнаар өөрчлөн шинэчлэх хүсэл эрмэлзэл өрнүүн, санаж бодсоноо хийж хэрэгжүүлэх арга замаа ч мэддэг С.Дэмбэрэл гишүүн шиг ийм хүмүүс энэ цаг үедээ ч, ирэх он жилүүдэд ч Монгол Улс, төр түмнийхээ төлөө ихийг хийж бүтээх нь дамжиггүй.

Улсын Их Хурлын гишүүн Дашзэвэгийн ЗОРИГТ

ИТГЭЛ ДААХ ЧАДВАР



Бид нэгэн үеийнхэн, жараад оныхон. Жараад оныхонд онцлог бий. Социалист системийн үеийн үлдэгдэл энэ үеийнхэнд байдаг. Энэ бол өөрийгөө хөгжүүлэх, бусдадаа үлгэр дуурайл болох, тэгээд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээж, хийсэн ажилдаа эзэн болдог зан чанар юм. Ингэж хүмүүжсэн бидний үеийнхэн төдөлгүй 90-ээд оны эхээр тэс өөр нийгэм, зах зээлийн эдийн засагтай тулгарч, түүнийг гэтлэх арга ухаанаа сийлцгээсэн. Ийм л зам мөрийг 60-аад оныхон туулсан. Тэдний нэг бол одоогийн УИХ-ын гишүүн, Эрчим хүчний сайд Дашзэвэгийн Зоригт.

Түүнийг үеийнх нь нөхөд нь сайн мэднэ. Хуучин тогтолцооны үед онц сурна, сургуулиа онц төгсөнө гэдэг бол ахиж дэвшихийн суурь байлаа. Сургууль төгссөн хүн бүрт ажил хуваарилдаг, тэгэхдээ сурлага, хувь хүний хөгжил, тодорхойлолтыг харгалздаг байсан цаг. Ийм л цаг үед Д.Зоригтыг Гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хорооны “Комплекс импорт” нэгдэлд мэргэжилтэн, “Монгол барилга” нэгдлийн орлогч дарга, “Материал импэкс” нэгдүгээр орлогч дарга зэрэг хариуцлагатай албанд томилж байв. Тэрбээр ч чадварлаг мэргэжилтэн гэдгээ харуулж ирснийг хамт олон нь өнөө хүртэл үнэлдэг юм билээ.

Тэр чадварлаг удирдагч, бэрхшээлийг амжилттай даван туулагч, бусдыгаа хошуучлагч, манлайлагч гэдгээ олонтаа харуулсан. Тэрбээр 1991 оноос хойш 30 гаруй компани байгуулж, байгуулалцаж, унаж босож, өсч өндийсөн бизнес эрхлэгч гэдгийг үеийн нөхөд нь хүлээн зөвшөөрдөг. Тиймээс түүнд итгэх, түүнийг хүрээлэх тойрог жилээс жилд томорсоор. Бизнесээ ч өргөжүүлэх боломж их байсан.

Төрийн албанаас хөндийрч, бизнесийн амжилтын түүхээ тийнхүү бичиж эхэлсэн түүнд Ардчилсан нам 1996 оноос Төрийн өмчийн агентлаг, 1999 оноос

Төрийн өмчийн хороог итгэж удирдуулсан. Энэ он жилүүдэд л төрийн өмчийн тооллогыг удирдан явуулж, улсын үйлдвэрийн газрууд, аж ахуйн нэгжүүдийг хувьчлах ажлыг анх удаа эхлүүлэлцсэн түүхтэй. Тухайн үеийн Ерөнхий сайд Р.Амаржаргал “Д.Зоригт эдийн засгийн өргөн мэдлэг, зохион байгуулах өндөр чадвартай хүн. Буурьтай, ноён нуруутай, ямар ч үед нүүр улайлгахгүй хүн дээ” гэж түүнийг болон түүний ажлыг өндрөөр дүгнэсэн байдаг.

Д.Зоригт 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар өврийн хангай нутгаасаа УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар Ч.Сайханбилэгийн толгойлсон Шийдлийн Засгийн газарт Эрчим хүчний сайдын алба хашиж байна. Өрийн сүлжээнд хэрэгдсэн, жил тутам 60 тэрбумын алдагдалтай ажилладаг ийм л салбарыг тэр хүлээн авчээ. Энэ салбарыг өрнөөсөө салахгүй, сэхэхгүй салбар ч гэж зарим нь үздэг байв.

Хөрөнгө оруулалт ихээр шаарддаг, алдагдалтай салбарыг богинохон хугацаанд эдийн засгийн үр ашигтай ажилладаг болно гэж хэн ч итгээгүй, бүр хэн ч санаагүй гэхэд хилсдэхгүй. Гэтэл Зоригт сайд энэ салбарыг өрнөөс нь салгаад, эдийн засгийн үр ашигтай ажилладаг болгочихов. Маш богино хугацаанд тэр шүү. Зөв гаргалгаа, нарийн тооцоон дээр тулгуурласан хараатай бодлого, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх оновчтой механизм. Тэгээд үр дүнтэй, зөв зохион байгуулалт. Үүнийг л маш богино хугацаанд Д.Зоригт сайд болон түүний чадварлаг баг хийж чаджээ.

Инженерийн сэтгэхүйтэй, эдийн засгийн зөв тооцооллоор эрчим хүчний салбарыг ийнхүү босгож ирлээ. Мэдээж хууль эрх зүйн орчныг нь шинэчилснийг орхигдуулж болохгүй. Дашзэвэгийн Зоригтын удирдаж байгаа энэ үед эрчим хүчний салбарт 2012 онтой харьцуулахад 4 дахин их хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг. УИХ-ын тулхтай гишүүдийн нэг, Засгийн газрын гишүүнээр удаа дараа ажилласан Ц.Баярсайхан “Асуудлын эдийн засгийн мөн чанарыг олж хардаг, банк санхүүгийн тогтолцоо, үйлдвэрлэл, ажлын байр бий болгох чиглэлийн хуулиудад манай Зоригтын туршлага үнэтэй хувь нэмэр оруулсан” гэж үнэлсэн байдаг.

Өвөрхангай бол Д.Зоригт гишүүний удаа дараа сонгогдсон нутаг, зон олон. Өвөө, эмээ дээрээ өсөж өндийсөн нутаг.

Харин энэ удаа Ардчилсан нам хэнийг хаана сонгуульд өрсөлдүүлэхээ шийдвэрлэлээ. Энэ удаад Монгол Улсын эрчим хүчийг хөгжүүлэх төв болсон Баянзүрх дүүрэгт түүнийг “сойлоо”. Эрчим хүчний салбарын эрчимтэй сайд Дашзэвэгийн Зоригт гэж ийм л нэгэн дээ.

----oooOooo---

Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны ЗОРИГТ ЗОРИГТОЙ БӨГӨӨД ИЛ УЛС ТӨР



Сайн юмаа сурталчлах, сайнтай муутайгаа ил байх хоёр ондоо. Ухаад ухаад юм гарахгүй хүн, угаасаа л байгаагаараа байдаг хүн хоёр ялгаатай шиг зүйл.

Амьд махбод, нийгэм улс төрийн тогтоц хоёр үүгээрээ их төстэй. Ер нь ардчилал бол улс төрийн хамгийн төгс тогтоц бус, харин хамаг юм нь ил байдаг учраас л засах залруулах боломжтой тогтоц гэдэг. Засч залруулах боломжтой учраас л түүнээс дээр юм олдохгүй байгаа юм гэсэн.

Ил олдсон шарх сорвийг тэр дор нь эдгээгээд явдаг, харин далд эмгэг чимээгүй ужиграсаар нэг л өдөр аминд заналхийлдэг. Алдаагаа нуусан улс төрийн тогтоц өндөг шиг өөгүй гялалзаж харагдсаар нэг л өдөр сэхэшгүй ялзарсан нь харагддаг.

Ардчилсан нам үргэлж дотроо бужигнаантай харагддаг нь ил улс төр хийдэг нам болсны шинж. Хоорондоо байнга л сөргөлдөөнтэй яваа нь өөрөө өөрийнхээ өвчнийг харж, тэмцэлдэж яваагийнх. Ер нь улс төр нам гүм болоод дүнсийгээд ирвэл хуйвалдаан ноёлж, бие биедээ найр тавин, “хувааж хүртэж” эхэлсний шинж л гэх юм билээ, хэн мэдлээ.

Монголын бусад нам, нам болохыг хүссэн бүлгүүд сайн муу араншингаараа бүгд л адилхан. Монгол хүн л болсон хойно ямарч намд очиж нэгдсэн байг, төрөлх зангаа хаяна гэж ёстой байхгүй. Ийм учраас л доторхоо нуудаг нуудаггүйгээрээ хуваагдаж, битүү өвчтэй, ил эмгэгтэйгээрээ Монголын улс төрийн бүлэглэлүүд ялгардаг юм. Эцсийн дүндээ сайн муу нь ил явдаг нь эрүүл үлдэх тавилантай, ийм л юм.

Ардчилсан намд ав адилхан аавын хүүхдүүд цугларсан боловч хамаг юм нь ил байдгаараа л онцгой. Хамаг юм нь ил байдаг учраас л хамгийн сайн байх чадамжтай, тийм ч байгаа нам.

Ардчиллын Зоригоо (Уг нь М.Зоригт, гэвч 90-оны ардчиллын зүтгэлтний нэг учраас бид ингэж хэлдэг.) бол ил амьдардаг улстөрч. Хамгийн гол нь өөрийнх

тухай хүмүүсийн бодол санааг сайн муугаар нь ялгалгүй ил байлгадаг. Түүний фээсбүүк, твиттер цахим хуудыг харсан хүн болгон хэлнэ. Түүний ажилд талархсан, баяр хүргэсэн, дургүйцсэн, үзэн ядсан, дайрсан, доромжилсон бүх сэтгэгдэл, захиа ярайгаастай.

Авсан зургаа тэнд их тавьдаг. Хэр зурагчин болохыг бурхан мэдэх биз, харин явсан газар бүртээ зургийн сурвалжлага хийдэг нь олон түмэнтэйгээ амьд холбоотой байх аргын хувьд мундаг санагддаг.

Тэрбээр хамгийн сайн зохион байгуулагч биш байж магад, гэхдээ хамгийн ойлгомжтой зохион байгуулагч бол мөн. Улстөрч, удирдагчид яг юу хийх гээд байгаа нь ойлгогдоод ирэхээр олон түмэнд урам зориг төрөөд, хамтраад дэмжээд явчихмаар болоод эхэлдэг.

Сүхбаатар аймаг яаж хөгжих гээд байгаа нь ойлгомжтой байдаг байснаа одоо Зам тээврийн салбар хаашаа яваад байгаа нь бидэнд хичнээн ойлгомжтой болоод ирэв. Сүүлийн хэдэн жил ямар их засмал зам тавьсан, цаашдаа тавина гэдэг нь саяхнаас л маш сайн ойлгогдож эхэллээ. За тэр, саяны хэд хэдэн цасан шуурганаар Зам тээврийн салбарын зохион байгуулалт энэ тэр бол харагдаж байна аа, харагдаж байна...

Ардчилсан нам эрүүл байх чадамжтай, учир нь сайнтай муутайгаа ил байдаг нам.

Ардчиллын Зоригоо хийж байгаа нь ойлгомжтой, алхам бүр нь ил байх боломжтой улстөрч. Түүгээрээ л бидэнд олдошгүй бөгөөд хамгийн сайн нь байх чадамжтай улстөрч юм даа. Ийм л байна.

Б.Цэнддоо (Төрийн шагналт, сэтгүүлч)

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Данзангийн ЛҮНДЭЭЖАНЦАН

ТҮШЭЭ



Жинхэнэ төрийн түшээгийн шинжийг өнөөгийн улстөрчдөөс хайвал маш олон шинжийг Д.Лүндээжанцан гишүүнээс харах болно гэж нэгэн судлаач хэлсэн юм. Төрийн хүн юуны өмнө улс эх орон, хүн ардаа гэх шулуун сэтгэл, аливаад үл холбирах ноён нуруутай байх ёстой. Биелэгдэшгүй худал амлалтаар хуурч түмнийг төлөөлж төр түших албыг дөрвөн жилийн настай улс төрөөр төсөөлөх нь өрөөсгөл юм.

Монгол Улс ардчилсан сонгуулиар төрийн түшээдийг сонгодог болоод 7 удаагийн сонгууль хийжээ. Энэ бүх сонгуульд ард түмний итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр тасралтгүй сонгогдсон нь Данзангийн Лүндээжанцангийн ямар цараатай улстөрч, ямар итгэлтэй түшээ болохыг нь харуулах тоон үзүүлэлт. Харин асуудалд хандах төвч хандлага, аливаа бодлогыг хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхлоор биш төрийн хүний байр сууринаас шийдвэр гаргадаг чанар нь өнөөгийн парламентад хамгийн хэрэгтэй байгаа чанар юм. Данзангийн Лүндээжанцан 1957 онд Улаанбаатар хотод Нарангийн дэнжид төрж, 1975 онд нийслэлийн 28 дугаар дунд сургууль, 1980 онд МУИС-ийг Хуульч мэргэжлээр төгсчээ. Хүн эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь болж мэргэшин ажиллах чадвартай байх ёстой. Д.Лүндээжанцан хуульч мэргэжлийг эзэмшээд 1980-1985 онд МУИС-д багшилж, 1985-1989 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, хэлтсийн дарга, 1989-1990 онд ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэнд секторын эрхлэгч, 1990 оноос өнөөг хүртэл хууль тогтоох дээд байгууллагад тасралтгүй 26 жил ажиллаж байгаа юм. Бодлого боловсруулах түвшинд олон асуудлыг шийдвэрлэхдээ Д.Лүндээжанцантай зөвлөж, хууль эрх зүйн хувьд хамгийн зөв гарцыг олоход түүний үгийг сонсдог нь нууц биш.

Түүний ажил, амьдралын хуудсанд үл балрах мөрөө үлдээсэн томоохон үйл явдлуудын нэг нь Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн эхийг барихад гар

бие оролцож явсан 1990-1992 он юм. 1990 онд Ардын Их Хурлын сонгуулийн 15 дугаар тойрогт Сансарын 3 дугаар хорооноос депутатаар сонгогдсон байна. Монгол Улсын анхны Байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурлын 1 дугаарын үнэмлэхийг гардаж, шинэ ардчилсан Үндсэн хуулийг боловсруулж ард нийтээр хэлэлцүүлэн батлуулахад голлох үүрэг гүйцэтгэжээ.

Энэ цагаас хойш 1992-1996 онд УИХ-ын гишүүн, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 1996-2000 онд УИХ-ын гишүүн, 2000-2004 онд УИХ-ын гишүүн, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга, 2004-2008 онд УИХ-ын гишүүн, 2004-2007 онд УИХ-ын дэд дарга, 2007-2008 онд УИХ-ын дарга, 2008-2012 онд УИХ-ын гишүүн, 2008-2011 онд УИХ дахь МАН-ын бүлгийн ахлагч, 2012 оноос УИХ-ын гишүүнээр тус тус ажиллаж ирсэн. Мөн 1992 онд Батлан хамгаалах зөвлөлийн гишүүн, 2007-2008 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүнээр ажилласан байна.

Д.Лүндээжанцан 1989 онд Хууль зүйн ухааны доктор, 2000 онд Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан, профессор цолтой. Монгол Улсын гавьяат хуульч. Гадаад, дотоодын хэд хэдэн сургуулийн хүндэт доктор юм.

“Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” нэг сэдэвт бүтээлээрээ 2015 онд шинэ Үндсэн хуулийн эхийг баригч, өөрийн багш Бяраагийн Чимидийн нэрэмжит УИХ-ын шагналын анхны эзэн болсон. Энэхүү шагнал нь судалгаа шинжилгээнд суурилсан хууль тогтоох ажиллагааг хөгжүүлэх, парламент судлал, Үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр гарсан үнэ цэнэтэй томоохон бүтээлийг дэмжих, эрдэм судлалын ажилд оюун ухаанаа зориулах эрдэмтэн судлаачдын тоог нэмэгдүүлэх зорилготой юм.

Тэрбээр төр эрх зүйн онол, түүх, философи, улс төр судлалын сэдвээр 30 шахам ном, сурах бичиг дангаараа болон хамтран туурвижээ. Мөн уран зохиол, нийтлэлийн таван ном хэвлүүлсэн уран бүтээлч юм.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн НАРАНХҮҮ

АМГАЛАН ХИЙГЭЭД ОМГОЛОН



Сэтгүүлчид Б.Наранхүүг мөн ч олон жил гаднаас нь бичлээ. Тэрбээр хэвлэлийнхнээр олон жил араасаа элдүүлсэн, нийтийн өмнө хэзээ ч сэтгэл зүрхээ нээж байгаагүй, бусад шиг юм л бол тайлбар өгч гомдоллодоггүй, үргэлжид нууцлаг байхынхаа хэрээр сонирхол татдаг өвөрмөц эрхэм байсан. Одоо ч нэг их өөрчлөгдөөгүй санагддаг. Тийм ч болохоор гүжир гүтгэлгээр “нүдүүлсээр” явдаг байх. Дулаахан, нөмөрлөг, төв халхын түшигтэй эрсийн шинж ч мөн л дөө. Манай улс төрд иймэрхүү эрчүүд цөөн боловч бий. Өмнө нь бүр ч олон байсан юм. Одоо бол шалчгар, ховчин, хорчин эрс төрөөр элбэгшсэн харагддаг.

Улс төрийн зарим ажиглагчид Б.Наранхүүг үг цөөн хэлсэн, юм ярьж өгдөггүй гэж урж байгаа харагддаг. Угаасаа ярихыг хийх гэж ойлгодог бүтэн эгнээ манай улс төрд байдаг юм. Харин Б.Наранхүү бол хөлсөө урсгаж хөл дээрээ боссон хүн болохоор хийхийг чухалчилдаг. Хэлэмгий доломгой байдлаас өөрөө ч хувь хүнийхээ үүднээс дөлдөг зантай.

Тэр амгалан харагддаг ч дотроо бол омголон хүн. Дотоод омголон чанараа гадагшаа хийж, бүтээж харуулдаг. Дундговь аймагт өнгөрсөн дөрвөн жил төсвийн хөрөнгөөр 302,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ. Энэ бол хэдэн гишүүн нийлээд ч татахад хэцүү л мөнгө. Учир нь тэнд том зүтгэл, том ухаан бодлын уралдаан, зөв лобби, хувь гишүүний бусадтай харилцах стратеги гээд олон хүчин зүйлс үйлчилдэг. Улс төрийн хүрээнд хорин жил ажилласан сэтгүүлчийн хувьд тэнд юу болдгийг гадарлах юм. Зөвхөн автозамд гэхэд 141.2 тэрбум төгрөг зарцуулжээ. Инженерийн шугам сүлжээнд 71.8 тэрбум. Инженерийн шугам сүлжээ бол улсын хэмжээнд хөрөнгө оруулалтаар улдаж, харанга дэлдэж байгаа салбар. Ийм хэцүү нөхцөл байдлын дундуур ийм хэмжээний хөрөнгө чангааж чадсанд нь зүгээр л баяр хүргэмээр санагдсан.

Өөр нэг бахархам зүйл нь Дундговь аймагт өнгөрсөн дөрвөн жил хамгийн олон цэцэрлэг, сургууль, эмнэлэг барьсан он жилүүд болж өнгөрч байна. Мэдээж тэр хувийн хөрөнгө оруулалтаараа өчнөөн юм хийсэн байж таарна. Хийснээ нэг их ярьдаггүй болохоор тэр нь ил болдоггүй биз. Ер нь тэр удаан боддог зантай. Сайн бодож, сайн шийдвэр гаргадаг нь математикийнхны гэм биш чанар нь. Бодож гаргасан шийдвэрийнхээ ард бариад авсан ажлаа гүйцэд хийдэг, өөрийнхөө сэтгэл зүрхийг бүтэн өгч дуусгадаг нь Б.Наранхүүг тодорхойлох нэг том чанар юм.

Миний бие дөрвөн жилийн өмнө түүнд зориулж ийнхүү тэрлэж байжээ. “Амьдралд нь орж ирсэн анхны хамгийн хүчтэй дуудлага математик байсан нь гарцаагүй. Дараагийнх нь Их сургуулийн тооны гүнзгийрүүлсэн ангийн урилга. Дараагийнх нь мэдээж ардчиллын давалгаа. Дараагийнх нь зах зээлийн нийгмийн гэнэт онгойсон хаалга. Тэр хаалгаар зоримогхон шийдээд алхан орсон залуу өнөөдөр та бидний өмнө дараагийн цоо шинэ үеэ эхлүүлэхээр бас нэгэн дуудлага хүлээж аваад зогсч байна” гэж. Цаг хугацаа яралзан урссаар нэг мэдэхэд тэр миний хэлсэн шинэ үеийг туулаад, дараагийн өрсөлдөөнийхөө өмнө хүрч иржээ.

Тэр эхний үеэ нэр төртэй тууллаа гэж би хувьдаа үзэж байна. Авлига хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэг, элдэв оффшор, мүүн...гээд улайстал нь нийгмийг талцуулж байгаа аль ч хүнд сэдвээр энэ хүн нэрээ “чимсэнгүй”. Бага цагт их ажлыг амжуулах гэж хааяа чуулганы хуралдаан “тасалснаас” өөр “гэмт хэрэг” -т тэр холбогдсонгүй. Ер нь байнгын хороодын хуралдаанууд дээр Монгол Улсын халуун амьдрал хэлцэгддэг, тэнд гишүүд ханцуйгаа шамлан сууж сонгогдсон түмнийхээ төлөө шийдвэр гаргуулах гэж “байлддаг”. Хүнтэй нийцгүй, хоосон амласан, ааш авир нь төвөгтэй гишүүд энэ үед тойргоо хохироох нь ч цөөнгүй. Б.Наранхүү тэнд ярьдаг, бусаддаа ойлгуулдаг, эрүүл лобби хийж байж санасандаа тултал бодсон төсвөө авч гардаг. Энэ нь түүний олны дунд, эгэл бор хөрсөн дээр бойжсон, хүнээс салж давхиагүй, хүмүүстэй нийцтэй төлөвшлийг их тодорхой харуулдаг юм.

Хүн өөрийгөө амархан алдчих гээд байдаг хэврэг талтай. Өөрийгөө авч үлдэхэд нэр төр, хөрөнгө мөнгө гээд олон сорилт тулгардаг. Энэ сорилтуудад бүдрэх насаа туулчихаад зогсож буй нь ч түүнд итгэх нэг том шалтгаан юм. Б.Наранхүү хаашаа ч асгараад алга болж болохуйц өргөн амьдрал туулсан хүн. Бага залуугаасаа, бараг хүүхдээрээ амьтан бизнест хөл тавьж, унаж сөхрөлгүй явж амжилтаа босгосон.

Тэр халирамтгай хүн байсан бол уначих л байсан. Бас тэр нөхөрлөж чаддаггүй этгээд байсан бол өдийд туугдчихсан л байгаа. Тэр бас урвагч байсан бол бүр арчуулчихсан байгаа. Харин тэр энэ бүхний дунд хөл дээрээ бат зогсож чаджээ.

“Их л зөөлөн юм даа” гэж анх түүний тухай нэгэн улстөрч хэлж байсан удаатай. Гэхдээ түүнийг гаднаас нь илтгэх ноён нуруутай, чимээгүй оргисон амгалан зангийнх нь ард тийм амар няцлуулчихгүй омголон чанар нь ямагт босоо байдаг. Энэ нь ч гэсэн өнөөгийн улс төртэй хэлээ олоход нь нөлөөлдөг байх.

*Бадамдоржийн Ганчимэг
(Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч)*

Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын НОМТОЙБАЯР

НОМТЫН УДМЫН ҮРГЭЛЖЛЭЛ



Номт овогийн Нямтайширын Номтойбаяр 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 45 дугаар дунд сургууль, 1997-2001 онд АНУ-ын Индиана мужийн Валпарайсо Их сургуулийг төгссөн. Улс төрийн шинжлэх ухаан, практик бизнесийн хос мэргэжилтэй, Инженерчлэлийн магистр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй юм.

Тэрбээр 2001-2005, 2008-2009 онуудад Тагнуулын ерөнхий газарт ажиллажээ. Мөн 2005-2008 онд “Монголын Алт” /МАК/ компанид төслийн менежер, 2009 онд тус компанид Тамгын газрын захирал, 2010 онд “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн, 2010 оноос “Монголын Алт” компанид Бодлогын зөвлөлийн гишүүн, дэд ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж иржээ. Улмаар 2012 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар томилогдож, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар ажилласан байна.

Улмаар 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар МАН-аас нэр дэвшиж Дорнодчуудын итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Өнгөрсөн хугацаанд УИХ дахь Монгол ардын намын бүлгийн дэд даргаар ажиллаж иржээ.

Тэрбээр “Хэрэв чи төр түшилцэх гэж байгаа бол хувийн ашиг сонирхлоо хойш нь тавьж, хоёргүй сэтгэлээр зүтгэх ёстой. Харин чи хувийн хөрөнгөө арвижуулах хүсэлтэй бол бизнесийн салбарт өөрийн орон зайгаа олох алхмуудаа эртнээс хий. Төр, бизнес хоёр хутгалдах учиргүй. Бизнес амжилт олоогүй хүмүүсийн эцсийн хоргодох байр, шуналт сэтгэлээ гүйцэлдүүлэх талбар нь төр биш” гэж нэгэн ярилцлагадаа хэлсэн байна. Энэ бол хэр баргийн хүний амнаас унаад байх үг биш юм.

Бизнесийн салбарт амжилттай ажиллаж байсан туршлагатай, Монголын хамгийн том бүтээн байгуулагч, татвар төлөгч компанийн “өв залгамжлагч”-

ийн хэлсэн энэ үг зарим хүмүүст маш хатуу цохилт болдог бол зарим нэгэнд нь их хол сонсогддог. Гэхдээ Н.Номтойбаярын өвөг дээдэс болох Номтын удмын туулсан цаг хугацаа, амьдрал тэмцлийн үнэн түүхийг орхигдуулж, яаран дүгнэлт хийж боломгүй юм. Н.Номтойбаяр бол өнөө цагийн хүчтэй бизнесмэний “өв залгамжлагч” ях аргагүй мөн. Гэхдээ улирч үлдсэн түүхийн шаргал хуудсыг сөхвөл тэрбээр монгол төрийн түүхэнд тод мөрөөр бичигдэн үлдсэн Номтын удмын түүхийг үргэлжлүүлэх үүрэг хүлээсэн хүү билээ.

Баринтаглаж бичвээс зузаан хийгээд шимтэн уншихуйц ном бүтээхүйц түүхтэй Номтын удмын үргэлжлэл Н.Номтойбаяр өдгөө өөрийн цаг үедээ эзэн болж шинэ цагийн түүхийг үйл хэргээрээ бичиж явна. Тэрбээр УИХ-ын гишүүний хувьд 2012-2016 онд тойргийн иргэд сонгогчидтойгоо “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгуулжээ. Энэ нь түүний баримталдаг “УИХ гишүүн бол иргэдээ төрийн бодлоготой холбох нийгмийн ажилтан байх ёстой” гэсэн зарчмын бодит илэрхийлэл болсон шинэ хэлбэрийн ажил юм. Тэрбээр өнгөрсөн 4 жилийн ажлын тайлан номоо “НИЙГМИЙН АЖИЛТАН” гэж нэрлэсэн нь ч хоосон үг биш аж. Иргэдийнхээ үгийг төрд хүргэх үүрэгтэй нийгмийн ажилтны хувьд тэрбээр “Монголын төр дотроо хагаралдаж, төр-иргэдийн хоорондын зай холдож байгаад санаа зовниж, залуу хүн би юу хийх ёстойг эргэцүүлж, хууль тогтоох, шийдвэр гаргах түвшинд төрийн гажуудлыг засах өнцгөөс цаг үргэлж сануулж ярьж, ажиллаж байна” гэж өнгөрсөн дөрвөн жилд өөрийн хийсэн ажил, баримталж ирсэн зарчмаа цөөн үгээр тодорхойлсон байна.

Монгол Улсын хөгжлийн бодлого алдагдсан нь дотооддоо улстөржсөн хэрүүл маргаан, үүнээс үүдэлтэй тогтворгүй байдлыг бий болгоход нөлөөлсөн гэж үздэг тэрбээр улс, орон нутгийн хөгжлийн бодлогыг улстөржилтөөс салгаж, тогтвортой байлгах зорилго бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг журмын нөхдийн хамт санаачилж, УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Энэ хуулийн хүрээнд Дорнод аймгийн, баг, сумын бүх шатны удирдлагуудтай улс төрийн намын харьяалал үл харгалзан хамтран ажиллаж, тойргийн олон арван мянган иргэдийнхээ үг, захиас, хүслийг нэгтгэж “Дорнод сэргэн мандалт” хөгжлийн хөтөлбөрөө батлуулжээ. Ингэснээр нутаг орны хөгжилд чөдөр тушаа болсон асуудлуудад гарц шийдэл эрэлхийлж, эдийн засгийн хөгжлийн бүтэц, өрнөж байгаа ажил, төлөвлөлтийн эхний томоохон алхам болсон байна.

Өнгөрөгч дөрвөн жилийн хугацаанд ахмадуудынхаа ая тухай амьдралыг хангах “Ач санах хууль”, ирээдүйн хөрөнгө оруулалтыг бодитоор хийх “Залуусын хөгжлийг дэмжих хууль”, насан туршдаа хоногийн 24 цаг ажилладаг, нүүдлийн биет болон биет бус соёлыг тээгч малчдад зориулж “Малчдын нийгмийн баталгааны хууль”, талцал, улстөржилтийг халах Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг олон хуулийн төслийг бие дааж болон хамтран санаачилж боловсруулан заримыг нь хэлэлцүүлж батлуулжээ. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах боломжтой, “Алдарт эх”-ийн одонтой эхчүүдийн одонгийн мөнгийг хасах ёсгүй, хүүхдээ асраад гэртээ сууж байгаа ээжүүдэд цалин олгодог болох, жирэмсэн эмэгтэйчүүдийн ажлын байрыг гурван жил хадгалах, цалин тэтгэврийн тогтолцоог шинэчлэн бүтээмжид суурилсан үнэлгээг нэвтрүүлэх, авлигаас ангид төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зэрэг нийгмийг хамарсан, амьдралын хөрс, бодит байдлыг мэдэрсэн асуудал ярьж, шийдэл хайж, хууль эрх зүйн орчныг сайжруулахын төлөө ажилладаг Н.Номтойбаяр “Ахицаас ахиц, эцэст нь амжилт” гэх өөрийн зарчимтай улстөрч, нийгмийн ажилтан юм.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн НЯМДОРЖ ЗӨӨЛӨН СЭТГЭЛ ДЭЭР БОЛОВСОРСОН ХАТУУ ЖИМС



Үл таагдах далдын нэгэн ерөөлөөр 1992-1996 оныг хүртэл УИХ-ын танхимын баруун жигүүрийн өнцөгт Л.Энэбиш агсан, Ц.Нямдорж бид гурав нэгэн ширээнд дөрвөн жил суусан юм. Энэ хугацаанд бол үг бодлоо битгий хэл, үнэрээ хүртэл мартахааргүй дассан он жилүүд. Тэр үеийн Монголын анхны парламент “нялх” парламент байж дээ.

Энэбиш гоё тансаг дэвтэр, үзгэнд их дуртай. Гадаадад яваад ирэхээрээ ширээн дээрээ нэг л их олон үзэг дэлгэнэ. Гоё дэвтэр гурав, дөрвөөр нь тавина. Түүнийгээ өрж тавина. Тэгэхээр нь би гэдэг хэл нь загатнасан “амьтан” нэг үзгийг нь шүүрэн “Дэлгүүр онгойчихлоо, хэдээр өгөх юм вэ” гэж асууна. Гурвуулаа инээлдэнэ.

Ц.Нямдорж гадаадад яваад ирснийхээ дараа хурлын явцыг шунаг анхаарч, дуу цөөтэй болчихно. Эзгүй байсан хугацаагаа нөхөж, мэдэрч, ажилдаа хөл, толгойгоо нийлүүлэх гэж мэрийдгийнх байж. Би бас л “Хазгай хэлтэй гээд хэлийг чинь гааль дээр хураачихсан уу” гэнэ. Гурвуулаа инээлдэнэ. Урд ширээнээс Шийлэгийн Батбаяр эргэн харж инээд, хушуу хоёроо дүрнэ. Батбаярыгаа би “боловсрол” гэх, нэгэн зүйлд анхаараад суухаараа юуг ч тоодоггүй хүн. Жасрай гуай Батбаярын хажууд сууна. Ерөнхий сайд ажил ихтэй, хааяа хуралд ирнэ. Би бас л “Ойрдоо тог тасраад байсан. Өнөөдөр “гэрэл” ирчихэж” гэнэ. Бүгдээрээ инээлдэж, Багабанди даргын нүдээр ороолуулж байж намдана.

Би тэднийгээ ямар ном уншиж байдаг, юунд баярлаж, юуг үзэн яддагийг ч сайн мэднэ. Тэнэглэж байгаа хүн шударгад тооцогддог гэнэхэн сэтгэхүй дээр зарим нэг нь тоглосон, мөрөөрөө зүтгэсэн, учрыг олж ядан тэмцсэн, итгэл найдварт дарагдсан, завсарт нь өөр юм бодох завгүй, жагсаалын эхэнд яваа хүмүүс шиг биеэ барьсан, хамгийн цайлган парламентын жилүүд байсан юм. Эхлэл гэдэг хэцүү юм билээ. Туршлага гэдэг ойлголт энэ парламентын жилүүдэд хэрэггүй

байсан. Маргах, мэтгэх үе зөндөө гардаг ч бид бие биедээ гүн хүндэтгэлтэй ханддаг байсан санагдана. УИХ-ын гишүүдийг гүтгэх гоочлох гэж бараг үгүй. Алдаж болохгүй он жилүүд гэж хүн болгон ойлгодог байсан байх. Алдар хүндийн дайвар аргачлалд шилжээгүй, ашиглах завшихын сүүдэр дайраагүй үе байж...

Ц.Нямдорж тэр үед бодсоноо хэлж л байж амардаг, дутуу ойлгосон хүнд “гэнэн” ч гэмээр юм шиг залуу, ерөөсөн тал нь улаарсан “алим” байж билээ. Нэг хүнд сайн л бол алдааг нь харахааргүй “сохордог”, нэг хүнд тааруу бол гэгээг нь харахааргүй “зүтгэдэг”, хэтэрхий шулуухан “шөрмөс” мэдрэгддэгсэн. Түүнийг нь хүмүүс зөрүүд гэдэгт холбож үзнэ. Гэтэл энэ нь бурхны өгсөн зан нь юм билээ. Нямдорж зөөлхөн сэтгэл дээр боловсорсон “хатуу” жимс. Нямдоржоос би нэгэн их гэгээг олж үздэг байсан. Их цайлган, эргэж бодох нь их. Жаахан юмыг ч хэд хоног, сарын дараа дахиж ярина. Бурууд их шанална. Ахуйдаа хандах, арчтай амьдрахыг харин ч мэдэхгүй. Ахуйн “цагаан толгойд” тайлагдаагүй хүн байсан. Одоо л “том байшин барьж, хулгайд ухуулав” гээд сонинд бичигдэх юм. УИХ-ын гишүүд байшин бариулсан бол Нямдоржийнх далан хэд дэх нь байх. Тэднийхийг ухсан хүн бараг хоосон хариа биз.

Ц.Нямдорж улс төрд бүүр нэвт орсон, туршлага хуримтлуулсан, сайн мууг олонтаа дуулж, хэцүү хүнд алба хашиж яваад л хүндэтгэх сэтгэл төрдөг минь бусад хүмүүсийн Нямдоржийг хэрхэн үнэлдэгтэй хамаарал үгүй билээ. Төр гэдэг “хоосон чанар” атлаа төрийг түших хүний мөн чанараар төр “бодит” чанарыг олдог. Төрийн өнгө түшмэлээсээ гэдэг. Төр, түмэн хоёрыг бодож, болгоох тэнцэтгэл, ухаан, төрийн хүнд хэрэгтэй. Ц.Нямдорж энэ хүрээнд хэдийнэ багтсан, монголчуудын оюуны нэгэн өмч юм.

Хүний хувьд Ц.Нямдорж уяхан хүн. Яаж өсч өндийснөө мартдаггүй. Ямагт өчигдрөө өнөөдөртэйгээ жишиж амьдардагтаа зөв зүйтэй, хэтийдсэн боломж, өөрчлөгдсөн хүсэлд хөтлөгддөгүүдээ мөн чигээрээ явдаг гэж бодогддог. Монгол хүний дээд хүч хөх тэнгэр, төрийн сүлд, аав, ээж гэх гурван их сүндэл буй. Энэ гурвын таалалд нийцэж явна гэдэг хувь хүнээс ихээхэн ухаарал, ухаан, жудаг намба, хүн чанарыг шаардана. Ц.Нямдорж аав, ээж хоёроо үргэлж ярьж бодож явдаг нь “Үгүйлэхүйн үзүүлэлт” болгох гэсэн бус, үнэн голоосоо тэднийхээ үлдээсэн хайрын хүчинд яваа хүний “бяцхан үр” санагддаг. Аав, ээжээ ярьж, санаж, нулимсандаа дэвтэж яваа хүн муу мунхаг үйлийг хийж чаддаггүй юм. Энэ бол хүмүүн заяаны том хууль.

Ц.Нямдорж үүсэл амьтай, нутаг амьтай, монгол амьтай хүн. Тухай гээд элдвээр ярих нь тулж ойлгохоос хямд ойлголт. Хуулийг дэвэргэн сүржигнэж, хэтийдүүлэн хүнийг хохироогоогүй, хүнлэг хүн болох гэж хуулийг нялхамсуулж төрийг хохироохгүй явахаа мэддэг хүн Монгол Улсад хэрэгтэй. Магтаал, зэмлэл хоёр хүнтэйгээ адилхан, хүндээ зохисон байх ёстой гэж бодогддог. Өөртөө хэрэгтэй гэснээ цагийн өнгөөр магтаж, хэрэглээд хаядаг занд би дургүй. Билбүүр зальхай зангаар бус хүнийг нь мэддэг, тодорхой он цагт өөрийн хэрээр таньсан минь дээрх өгүүлбэрүүдийг хэнээс ч хараат бусаар бичих эрхийг надад эдлүүлж байна. Бид бие биеийнхээ төлөө дуугарч байхгүй бол нэг л өдөр дурсамж болдог нь уйтай. Тээр жилийн УИХ-д байхад л Л.Энэбиш, Ц.Нямдорж бид гурвыг өөхөн “Э”, үсэн “Лха”, ясан “Ня” гэдэгсэн. Нямдорж минь үнэхээр “ястай” эр хүн. Түүнийг минь түмний хайр, төрийн сүлд ивээх болтугай!

*Бавуугийн Лхагвасүрэн
(Төрийн шагналт, Ардын уран зохиолч)*

Улсын Их Хурлын гишүүн Салдангийн ОДОНТУЯА СЭТГЭЛ БАЙХАД ШИЙДЭЛ ОЛДДОГ



Улаанбаатарын унаган охин Одноо Сансарын 12 дугаар хороололд төрж өсчээ. Хүүхэд байхын л бусдад туслах гэж мэрийдэг, түүнийгээ биелүүлдэг сурагч байсан нь өдгөөгийн хариуцлагатай төрийн түшээгийн төлөвшлийн эхлэл байжээ. Хичээл номоосоо гадна төгөлдөр хуурын дугуйланд явж, пионер сурагчдын концертод гоцлол хөгжимчнөөр оролцож байв. Улсын тэргүүний 1 дүгээр сургуулийг 1982 онд онц төгсөгчдийн 1 дүгээрт жагссан тэрбээр ОХУ-ын Санкт-Петербургийн Их сургуульд суралцан олон улсын эдийн засагч мэргэжилтэй болжээ. Сургуулиа төгсөөд эх орондоо ирж Шинжлэх ухаан, техникийн улсын хорооны Мэдээллийн төвд ажилд орсон тэрбээр удалгүй бусдын адил хувиараа эрхлэх аж ахуйн нэгж байгуулан оёдлын цех ажиллуулж, ганзгын наймаанд ч явж байжээ.

Ийнхүү хувийн бизнесээ амжилттай явуулаад зогссонгүй өөрийн олсон, мэдсэн зүйлээ бусадтай хуваалцах үүднээс “Иргэн Та Баялаг” санг үүсгэн байгуулсан аж. Улс орны хөгжил бол хүний хөгжлөөр хэмжигддэг, улсын хамгийн үнэ цэнэтэй баялаг бол иргэн, тэр дундаа өсвөр насны хүүхдүүд гэдгийг олж харж, олон нийт рүү хандан амьдрах ухааны чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх, лекц унших ажлыг зохион явуулдаг болсон байна. Энэ нь хожим УИХ-ын гишүүн болсны дараа эрүүл мэнд, эмэгтэйчүүд, гэр бүл, хүүхдийн эрх хамгааллын талаарх түүний санаачилсан болон ажлын хэсгийг нь ахалсан хуулиудад тусгалаа олжээ.

Тэрбээр 2012-2016 оны хооронд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдэд шаардлагатай хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход голлон анхаарч ажиллажээ. Энэ хугацаанд 10 гаруй хуулийн төсөл санаачлан боловсруулж, 10 хуулийн ажлын хэсгийг ахалж, 60 гаруй хуулийн ажлын хэсгийн

гишүүнээр орж ажилласан байна. Мөн УИХ дахь АН-ын бүлгийн дэд даргаар ажиллахдаа чуулганы 226 нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, дэд хороодын 865 хуралдаан, УИХ дахь АН-ын бүлгийн 130 гаруй удаагийн хуралд оролцсон байна.

УИХ-ын гишүүний үндсэн үүрэг болох хуулийн төсөл боловсруулах ажил дээр түүнтэй хамтарч ажиллаж байсан хүмүүс хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөхдөө “...Одонтуяа гишүүн аливаа хуулийн төсөл дээр ажиллахдаа тухайн салбарын эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн холбоод, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэний нийгмийн төлөөллүүдтэй уйгагүй уулзаж, саналуудыг нь нэгтгээд хууль боловсруулах ажилдаа ордог”, “..эрүүл мэнд, эмзэгтэйчүүд, гэр бүл, хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр маш чухал хуулиуд санаачилж, боловсруулж, батлуулж чадсан”, “асуудлыг гацаанаас гаргагч, ангийнхаа нөхдийн эв зөийг олж эерэг цэнэг өгөгч”, “ажлын хэсгийг Одно гишүүнээр ахлуулахад найдвартай байдаг юм...” гэх зэргээр дурдсан байх юм.

Тэрбээр салбарын мэргэжилтнүүдтэй хамтран гурван жилийн хугацаанд шаргуу ажилласны үр дүнд Эрүүл мэндийн даатгалын хуулийг өнгөрсөн онд батлуулсан. Энэ хууль хэрэгжиж эхэлснээр иргэдийн халааснаас гарах мөнгө багасч, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ илүү бодитой болсон билээ. Түүнчлэн нийгэмд үгүйлэгдсэн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг санаачлан хэлэлцүүлж батлуулсан юм. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн шинэчлэлд ийм байдлаар оролцоод зогсохгүй, итгэл хүлээлгэсэн Баянгол дүүрэгтээ Эрүүл мэндийн төв, Хүүхдийн эмнэлэг барих асуудлыг шийдвэрлэхэд нь гар бие оролцсон. Мөн шинээр 150 ортой хүүхдийн, 80 ортой ахмадын эмнэлгийг 2016 оны 6 дугаар сард ашиглалтад оруулахаар болж, дүүргийнхээ иргэдийн эрүүл мэндийн асуудалд цаг зав зарж, анхаарлаа хандуулж ажилласныг иргэд сонгогчид нь үнэлдэг юм билээ.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа гишүүний амжуулсан бас нэг буянтай ажил нь JCI төрийн бус байгууллагын залуустай хамтран Эх нялхсын эрүүл мэндийн төвийн Нярай судлалын танхимыг засварлан шинэчилсэн явдал. Одоо энэ тасагт эмчилгээ нэн шаардлагатай нярай хүүхдүүдийг хүлээн авч үйлчилгээ үзүүлдэг юм билээ.

Тэрбээр ирээдүй хойч үеийнхэндээ ихээхэн санаа тавьдаг гишүүний нэг. Гишүүний бүрэн эрхийн хугацаандаа Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслүүдийг батлуулснаар 20 жил хүлээгдээд байсан хүүхэд хамгааллын асуудалд бодит эрх зүйн шинэчлэл хийсэн юм. Монгол Улс энэ хуулийг баталснаар анх удаа хүүхдийн эрхийн улсын байцаагчтай болж, хүүхэд хүчирхийлэлд өртвөл иргэн заавал мэдээлэх үүрэгтэй болж байгаа юм.

“Түмний хүлээлгэсэн итгэл бол хариуцлага, хариуцлага гэдэг эргээд шаардах эрх юм” гэж тэрбээр хэлдэг. Түүнтэй Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл боловсруулахад хамтран ажилласан НҮБ-ын Хүүхдийг ивээх сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Роберто Бэнес өндөр хариуцлагатай, төрийн түшээтэй хамтарч ажиллахад урамтай байснаа хэлсэн бол хууль батлах үеэр УИХ-ын дэд дарга Р.Гончигдорж “Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиуд нь парламентын түүхэнд иргэдээс хамгийн олон саналыг цуглуулж чадсан хууль болжээ” хэмээн хэлсэн юм. Энэ дүгнэлт нь түүний үзэл бодол, асуудлыг шийдэл болгох зоримог алхмууд, 2012-2016 онд хийж бүтээсэн ажлын нь нэгээхэн хэсэг, түүнийг илэрхийлэх “Дайчин” Одноогийн тухай цухас өгүүлэмж байлаа.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ЁНДОНГИЙН ОТГОНБАЯР

“ТӨР, ТҮМНИЙХЭЭ БУЯНЫ ХАРИУГ БИ БАРИНА”



УИХ-ын гишүүн Ё.Отгонбаяр энэ парламентын бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагаа, тойрогтоо хийж амжуулсан ажлынхаа талаар ийн өгүүлэв.

■ Эдийн засгийн өсөлт саарч, төгрөгийн ханш буурч, төсвийн орлого тасалдаж, төсөв байнга хасагдаж танагдсан, улс орон маань өрийн хүнд дарамтад орсон хүнд жилүүд өнгөрч байна. Улсын төсөв гэхэд л сүүлийн жилүүдэд жил бүр нэг их наяд төгрөгөөр тасарч, хасагдлаа. Энэ нь нийт улсын хэмжээнд ч, Булган аймгийн хэмжээнд ч хүндээр тусч байгаа нь ойлгомжтой. Хэдийгээр байдал ийм боловч аймгийн хөрөнгө оруулалтыг бууруулахгүй байх, эхэлсэн ажлуудаа дуусгахад шаардагдах хөрөнгө оруулалтыг тусгахад голлон анхаарч ирлээ. Зарим үр дүн байна. Жишээ нь, 2012 оны төсөвт аймгийн хөрөнгө оруулалтад 17.2 тэрбум төгрөг тусч байсан бол 2013 онд төсвөөр 14.6 тэрбум, Орон нутгийн хөгжлийн сангаар 7.3 тэрбум, нийт 21.9 тэрбум төгрөг төсөвт суулгасан. 2014 онд нийт 22.3 тэрбум, 2015 онд 10.8 тэрбум, 2016 онд 15.63 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт суулгалаа. Улсын хэмжээгээр шинэ объект огт суулгахгүй байгаа үед Сэлэнгэ мөрөн дээгүүр тавих гүүр, аймгийн төвийн 1 дүгээр сургуулийн өргөтгөл гээд мэр сэр шинэ объектын хөрөнгийг төсөвт суулгаж чадсан. Эд бүгд маань ажил хэрэг болоосой л гэж хүсэх юм.

■ Манай Засгийн газрын үед ажлууд хугацаандаа хийгдээд л явдаг байсан. Намайг сайд байх үед хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 90 хувиас доош гарчихвал бараг л огцруулах шахдаг байлаа шүү дээ. Одоо эдийн засгийн хүндрэлээр гул барьж, гүйцэтгэл 60 хувь байвал бараг шагнах шахуу л юм болцгоож байх шиг. Өнгөрсөн 2015 онд гэхэд л төсөвлөсөн мөнгөний 60 хувийг нь олгоод гүйцэтгэл нь бараг 50 хувьтай л байна. Тэгэхээр яаж ажил дуусах вэ дээ. Эхэлсэн ажлууд маань хэрэгжиж чадахгүй нөхцөл үүсч байгаа нь эрх баригчдын хөтөлбөргүй, бодлогогүй явж ирсний үр дагавар, мөн эдийн засгийн буруу төлөвлөлт, гүйцэтгэх

засаглалын урагшгүй байдалтай холбоотойг хэлэхээс аргагүй. Үүнийг гүйцэтгэх засаглалын урагшгүй байдал гэхээс өөр юу гэх вэ? Сайн байсан эдийн засгийг унагаад, өрөнд бариулчихлаа. Энэ байдлаас гарах гэж нэгээр тогтохгүй жил өдөр, шөнөгүй ажиллах үүрэг дараа дараагийн төр, Засгийн газрын нуруун дээр тохогдож байна.

■ Бараг бүх хууль дээр саналаа хэлж, оролцож байдаг идэвхитэй гишүүнд тооцогдоно шүү. Гэхдээ чухалчлан анхаарсан хуулиуд бий. Нийгмийн бодлогын чиглэлээр боловсролын бодлого, хуулийн өөрчлөлтүүд, эрүүл мэндийн цогц хуулиуд, эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хууль, эрүүл ахуйн хууль, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль, нийгмийн даатгалын хуулинд өөрчлөлт оруулах гээд анхаарч ажилласан хуулиуд байна. Соёлын өвийн тухай, Номын сангийн тухай зэрэг хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллав. Малчдын хувьд ажилласан жилийг нь 1.2 жилээр тооцох, малын хулгайн асуудлыг шинэ Эрүүгийн хуулинд тусгах гээд санаачилж, зүтгүүлж батлуулсан хуулиуд байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн нийгмийн бодлогын хэсэг дээр ажилласан. Үүнээс гадна буруу хуулийг батлуулахгүй байх гэдэг бас нэг чухал ажил байна. Өршөөлийн тухай болон Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд авлига, албан тушаалын хэргийг өршөөх гээд байсан заалтуудыг шүүмжилсээр байгаад хасуулсан.

■ Би шүүмжилдэг. Алдаатай бодлого орж ирж байгааг хараасай, засаасай гэсэндээ шүүмжилдэг. Алдаа гарчихвал улс маань хохироно шүү дээ. Саяхан Эрүүл ахуйн тухай хуулийг зад шүүмжилсний дараа ажлын хэсгийнхэн “Та ч будаа болтол шүүмжиллээ. Гэхдээ хуулийн “бөөсийг” сайн түүж өгсөнд баярлалаа” гэж байна лээ. Тэгж л хандаж байвал сайнсан. Даанч эрх баригчид маань ихэнхдээ зөв шүүмжлэлд хайхрамжгүй ханддаг нь харамсалтай. Бид алдаж болно, онож ч болно. Ямар ч байсан үнэнийг хэлж, шударгыг хамгаалж л байх хэрэгтэй. Тэгж байж л энэ улсад юм зөв замаар явж эхэлнэ гэж итгэдэг.

■ Булган аймаг маань 3 сая мал тоолууллаа. Харамсалтай нь бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр талхлалтаар улсын хэмжээнд хоёрт орж байна. Энэ бол МАА-гаар голлон амьдарч байгаа нутгийнхны маань хувьд аймшигтай аюул нүүрлэж байна гэсэн үг. Энэ нь чанар сайтай цөөн малтай байх, бэлчээр сайжруулах, аж төрөх шинэ төрлийн орлогын эх үүсвэртэй болох шаардлагатай гэсэн үг. Иймээс үзэмчин хонины төсөл хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд 55000 эрлийз хоньтой болсон. Сэлэнгэ үхрийг сэргээж байна. Өвөр Монголтой хамтраад бэлчээр сэргээх төсөл хэрэгжүүлэхээр тохироод байгаа, энэ сараас ажлаа эхэлнэ. Зудад хүндэрсэн малчдад тусалсан, эм, тоног төхөөрөмж олгосон гээд яриад байвал зөндөө юм бий.

■ Хамгийн гол бэрхшээл нь утга учиргүй энэ их талцал, намчирхал их саад болох юм. Нэг юм бүтээгээд ирэхэд шүүрээд авахын оронд янцагласан нэг түшмэл намын харьяаллаас нь ч айдаг юм уу, юм горьдоод байдаг ч юм уу, гацаагаад суучихлаар их бухимддаг. Гэхдээ би нутгийнхаа төлөө зорьсноо хийж яваа, цаашид ч хийнэ. Нутгийн маань иргэдийн сэтгэл, уул, ус намайг түшиж өдий зэрэгт хүргэсэн, тиймээс би хийхгүй яах юм гэж боддог. Би нутгийнхаа буяныг, төрийнхөө буяныг хүртсэн хүн, хариуг нь яаж ийгээд барих ёстой гэж итгэдэг.

Улсын Их Хурлын гишүүн Санжаасүрэнгийн ОЮУН

ПАРЛАМЕНТЫН “ЭКО ЭЛЧ”



С.Оюун бол парламентын содон гишүүдийн нэг. Ардчиллын алтан хараацай гэгддэг нэрт улстөрч С.Зориг агсны дүү гэдгээрээ олонд танигдаж гарч ирсэн ч тэрбээр улс төрийн гурав дахь хүчнийг толгойлж байгаа эгэл хэрнээ дайчин эмэгтэй. Даруухан, бас хэлэх гэснээ хэлчихдэг түүнийг ахынхаа эхлүүлсэн их үйл хэргийг үргэлжлүүлэгч болж их улс төрд хөл тавьсан гэдгийг мэдэхгүй хүн үгүй. Ахынхаа “Бидний хувь заяа зөвхөн бидний л гарт байна” гэдэг үгийг тэрбээр хэлэх дуртай.

С.Оюун 1998 онд анх УИХ-ын гишүүнээр сонгогдож, парламентын цөөхөн эмэгтэй гишүүдийн нэг болсоор хэдийнэ 18 жилийн үджээ. Манай парламентад каратэгийн 5 дугаар дан хүртсэн ганц гишүүн бий. Тэр нь С.Оюун. Каратэгийн философи нь довтолгоон биш аргагүй хамгаалалт, хүч бус арга юм. Яг түүн шиг гэсэн үг. Бас ч үгүй муугүй уулчин. Балба, Энэтхэг, Филиппин, Киргиз, Монголын зарим уулсад мөрөө үлдээгээд амжсан.

Тэрбээр 2000 оноос Иргэний Зориг Ногоон намын дарга, 2004-2005 онд УИХ-ын дэд дарга, УИХ дахь “Эх орон-Ардчилал” эвслийн бүлгийн дарга, УИХ-ын Мянганы хөгжлийн зорилт, ядуурлыг бууруулах бодлогын дэд хорооны дарга, 2007-2008 онд Гадаад хэргийн сайдаар ажиллаж байв. Харин энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд буюу 2012-2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, 2014 оноос НҮБ-ын Байгаль орчны Ассемблейн Ерөнхийлөгчөөр ажиллаж, “Эко Оюун” болсон. Монгол Улс ногоон эдийн засгийн хөгжилдөө НҮБ-аас тусгайлсан дэмжлэг авах анхны 7 орны нэг болсон нь түүний хичээл зүтгэлтэй салшгүй холбоотой.

Мөн энэ парламентын баталсан төрийн бодлогын чухал баримт бичгийн нэг болох “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” үзэл баримтлалд ногоон хөгжлийн үндсийг суулгаж, нийгмийн амьдралын маш олон

салбарт үр ашгаа өгөх суурь бодлого болох Ногоон хөгжлийн бодлогыг УИХ-аар батлуулах ажлыг гардан гүйцэтгэжээ.

С.Оюун сайд 2012-2014 онд байгаль хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутаг, ой, усны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлыг хэрэгжүүлж, байгаль орчны хамгааллын эрх зүйн орчныг шинэчилсэнд салбарын мэргэжилтнүүд нь талархалтай ханддаг юм билээ. Тухайлбал, 2013 онд Засгийн газраар батлуулсан шинэ журмаар усны үнэ тарифыг нэмэгдүүлэх, усыг дахин ашиглаж байгаа хэрэглэгчийн төлбөрийг хөнгөлж чөлөөлөх эдийн засгийн урамшуулалттай болсноор зөвхөн 2014 онд 73 сая тонн ус хэмнэсэн байна. Ойн бодлогыг шинэчлэснээр ойжуулах ажлыг зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр хийж ирсэн зарчмыг өөрчилж ойжуулах, ой хамгаалах ажилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлэн санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгосноор энэ чиглэлийн ажлын үнэлэмж, үр дүн дээшилжээ. Хоёр жилийн хугацаанд ойжуулалт, ойн аж ахуйтай холбоотой ногоон ажлын байраар 8317 хүнийг хангаснаас 2328 хүн байнгын ажилтай болсон гэсэн дүн мэдээ гарсан түүний санаж сэдсэн ажлын үр дүн юм. Мөн Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал, байгаль хамгааллын хосолсон үйл ажиллагааг явуулахдаа хүлэмжийн хийг хамгийн багаар ялгаруулах, усыг хэмнэлттэй ашиглах, хог хаягдлыг боловсруулах дэвшилтэт технологийг үйлчилгээндээ нэвтрүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан эко стандартыг шинэчлэн мөрдүүлж эхэлжээ.

Тэрбээр гишүүний бүрэн эрхийн хугацаандаа Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай, Органик хүнсний тухай, Хог хаягдлын менежментийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүд санаачлан боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн заримыг нь батлуулж чадсан аж. Мөн Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдрийг тохиолдуулан Бурхан Халдун уулыг “Монгол түмний Үндэсний бахархалт хайрхан”-аар зарлах тухай шийдвэрийг Засгийн газраар гаргуулсан нь түүний санаж сэдсэн ажлын нэг юм.

Ажлыг үр ашигтай, үр дүнтэй хийх ёстой гэсэн хатуу зарчмыг бармталдаг эрхэм гишүүн аливааг ач холбогдол, чухлаар нь эрэмбэлдэг. Тэрбээр “Үр дүнтэй, үр ашигтайгаар цагаа зөв зохицуулж чадвал гэр бүл, найз нөхдөдөө, өөрөөр хэлбэл “амьдрах” цаг гаргаж чадна. Цаг гэдэг зүйл хамгийн үнэтэй, ахиж олдохгүй амьдралын нэгээхэн хэсэг юм байна гэдгийг нас нэлээд явсан хойноо л ойлгосон. Залуу байхад цаг завтай ч байж, дуртай зүйлдээ цаг харамгүй зарцуулдаг байлаа. “3D-ийн зарчим буюу Do, Delegate, Dispose” гэж арга байдаг. Монголоор бол “Гурван Х-гийн зарчим буюу Хий, Хүнд даалга, Хая” гэж хэлж болно. Хийх ёстой, хийх хэрэгтэй зүйлээ л хий. Хэрэгтэй бол зарим зүйлийг чадах хүмүүст нь, итгэж буй хүмүүстээ даатга, хариуцуул. Шаардлагагүй, хэрэггүй зүйл бол шууд хая гэсэн утгатай. Үүнийг их бодож, хэрэгжүүлэх гэж хичээдэг” хэмээн хэлсэн нь бий.

С.Оюун гишүүн ийм л санаа бодол, хүсэл эрмэлзэл, тэмүүлэл, зарчимтай, аливаад хичээл зүтгэл шаргуу, шударга үнэн мөртэй нэгэн билээ.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн ОЮУНБААТАР БАГГҮЙГЭЭР “ТУЛАЛДАГЧ”



УИХ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарын улс төрийн замналыг нь мэдэх хүмүүс “баггүй улстөрч” гэгцгээх юм билээ. Үнэндээ тэрбээр том, жижиг олон тулаанд нэр төр, арьсаа хамгаалах гэж элдэв янзын баг өмсч, жүжиг тавиагүй. Өөрөө юу гэж бодно, түүгээрээ л дайраад гардаг зантай. Хэтэрхий шулуун үг нь зарим нэгний дургүйг хүргэдэг байж мэдэх ч, шударга үнэнийг эрхэмлэгчид түүнээс олон болохоор Ц.Оюунбаатарын талд үргэлж ялалтын туг хийсч байдаг. Нөгөөтэйгүүр УИХ дахь мэргэшсэн цөөн хуульчдын төлөөлөл. Үндсэн мэргэжил нь юм хойно арга ч үгүй биз. Тэртээ 1975 онд хууль, эрх зүйн салбарт хөл тавьсан гэхээр 41 жил засаглаж, засварлаж, заримд нь нэмэлт, өөрчлөлт оруулан бүр эрх зүйн орчин байхгүй тохиолдолд шинээр санаачилж ирсэн билээ, тэрбээр.

Энэ эрхмийн талаар тодотгож өгөх өөр нэг зүйл гэвэл хүн чанар, хэлсэндээ хүрэхийг хичээдэг монгол эр хүний жудаг юм. Эр хүн тугал ч хариулна, туг ч барина гэдгээр МАХН гэх улс төрийн гуравдагч хүчин эдүгээ улс төрийн тавцанд тугал хариулж яваа. Нэгэн цагт намдаа гомдогсод эднийхийг л зорьж байлаа. Харамсалтай нь тэд эдүгээ ирсэн замаараа мөрөө хөөн өөр нэгний нөмөрт толгой хоргодохоор одоцгоож. Харин Ц.Оюунбаатарын хувьд МАХН-ыг нэр төртэй байх үед ямар байсан тэр л араншингаараа бүдрэхэд нь хамт бүдэрсээр өнөөдөртэй золгожээ. Үзэл бодлоосоо, монгол төрд өөрийгөө зориулсан сэтгэл оюунаасаа урваагүй төрийн түшээ. Шинэ цагийн Монгол Улсын Шадар сайд. Хуулийн засаглалд түшиг тулгуур нь болох улстөрч. Хамгийн халуун цэгт үүрэг гүйцэтгэж буй амар амгаланг сахиулагч.

УИХ-д сонгогч олноо төлөөлөн суусан тохиолдол бүртээ суудал бөглөн кноп дарж суугаагүйг нь түмэн мэднэ. Зөвхөн улиран одож буй энэ парламентын жилүүдэд Ц.Оюунбаатар эрхзүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Зөрчлийн

тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай гээд 20 гаруй хуулийн төсөл боловсруулан УИХ-аар батлуулсан байх жишээний. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг өргөн мэдүүлж батлуулсан нь чухамдаа нийгмийн сэтгэл зүйг зарим талаар амраасан явдал болсон юм. Бас алдарт Өршөөлийн тухай хууль ч түүний оюуны өмч. Мөн Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ард нийтийн санал явуулах тухай гээд олон хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ахалж байсан болон ажлын хэсэгт багтаж ажилласан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Шадар сайдын шууд удирдлага дор үүрэг гүйцэтгэдэг Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагаатай холбоотой “Газар хөдлөлт, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолыг санаачилж батлуулсан.

Ц.Оюунбаатар зөвхөн УИХ-ын гишүүний төдийгүй Монгол Улсын Шадар сайдын нэр хүндтэй албыг хашихын зэрэгцээ Эрүүл мэнд, спортын сайдын үүргийг нэлээд хугацаанд хавсран гүйцэтгэж ирсэн юм. Шадар сайдад дээлийнхээ бүсийг тайлж, бүтэн нойртой хоносон өдрүүд цөөн байсан байх. Өвдөг давсан их цасан дундуур өвс, тэжээл ачсан цуваа удирдан зудтай аймгуудад ажиллаж газар дээр нь нөхцөл байдалтай танилцаж, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч чадсаны үр дүнд бичин жилийн эхний өвлийг монголчууд харьцангуй гарз хохирол багатай туулж гарсан. Тэгтэл асуудал ар араасаа хөвөрсөн. Улаанбурухан, салхин цэцэг, улаанууд гэх халдварт өвчин дэгдэв. Шулууухан хэлэхэд гамшгийн хэмжээнд хүрч очсон. Агаар дуслын замаар халдварладаг болохоор хөл хорио тогтоох аргагүй талаар эмч мэргэжилтнүүд ярьж байсан тэр хүнд үеийг эрүүл мэндийн салбарынхан туулж гарлаа. Уг өвчнийг дарах хамгийн оновчтой шийдэл бол иргэдийг вакцинжуулалтад хамруулах явдал гэдгийг Шадар сайд мэдэрч холбогдох төсөв хөрөнгийг Засгийн газраар гаргуулсны хүчинд өдгөө эмзэг бүлэг буюу 18-30 насныхныг вакцинд хамруулж, ямартай ч учирч болзошгүй аюулаас сэргийлж чадлаа. Иргэнээс нэг ч төгрөг гараагүй, бүгдийг нь төр даасан байна.

Ингэж тэрбээр төрийн нуруунаас нэг том ачааг мулталж чадсан юм. Хүнд, хэцүү байсан ч гэлээ өөрт ирсэн дарамт гэж харахгүйгээр хурдан шуурхай, тэгээд чанартай гүйцэтгэдэг тэр чадвараас нь залуу үе суралцах ёстой гэж бодогддог. Эрүүл мэндийн салбар гэхээр автор нь Ц.Оюунбаатар шүү гэж ам бардам хэлэх олон ажлыг тэр эхлүүлсэн, заримынх нь үр дүнг ч үзсэн. Болж бүтэхгүй байгаа зовлонгоо яриад очих сайдтай байлгаж чадсан юм. Зөвхөн эрүүл мэндийн салбараар зогсохгүй Монголын нэрийг дуурсгасан олон арван спортын амжилтын цаана сайдынх нь сэтгэл, зүтгэл хамт байсан гэдэгтэй олон хүн санал нийлэх байх.

Намынхаа залуу үед зөв үлгэр жишээ болж, албан тушаал, эд хөрөнгөд амархан хөтлөгддөггүйг тэрбээр үйл хөдлөлөөрөө ойлгуулж яваа улстөрч. Улс төрийн амаргүй талбарт шударгаар өрсөлдөж, албан тушаал, эрх мэдэлд биш өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд цуцалтгүй тэмцэж яваа чанараараа Ц.Оюунбаатар бусдаас ялгарч чаддаг нэгэн. Бас өнөө цагт хэн бүхний эрж хайгаад байгаа хээгүй, шударга зан нь түүнийг жинхэнэ эр хүн гэж харагдуулдаг юм.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэвдамбын ОЮУНГЭРЭЛ

ГЭРЭЛ ТҮГЭЭГЧ



Ц.Оюунгэрэл 1995 онд хүндхэн байдалд орсон аж. Бие нь өвдөж эмнэлгээр явсаар, эцэст нь түүнд эмч “Танд нэг жилийн нас байна” гэж хэлсэн гэдэг. Ийм үг сонссон хүн янз бүрээр л хүлээж авах байх. Харин Ц.Оюунгэрэл “Ганц жил үлдчихсэн юм бол аавдаа, хүүхдүүддээ, нутагтаа очиж дураараа байж байгаад үхье” гээд эмнэлгээс гарчээ. Яс арьс болж, халуурсан амьтан нутагтаа очсон ч хөл дээрээ босч ирэх тавилантай байжээ.

Хөвсгөл аймгийн Тариалан сумын охины замын хүзүү урт. Аав Цэдэвдамба нь тракторчин, анхны атар газар эзэмшигчдийн нэг. Ээж Должин нь охиноо төрүүлэхдээ оюутан байлаа. Жил дараалан мэндэлсэн хоёр охинтой тул шинэ хүнийг айлд өргүүлэх шахсан гэдэг. “Ээж сургуульдаа явна гээд хүүхдээ төрүүлээд айлд өргүүлэхээр ярьчихсан байсан чинь намайг төрөх үед 1966 оны аравдугаар сарын 26-ны шөнө Тариалан суманд анх удаа 24 цагийн гэрэл ассан гэдэг. Тэгээд миний нэрэнд “гэрэл” гэдэг үг орсон юм билээ” хэмээн Ц.Оюунгэрэл гишүүн хуучиллаа. Сумын эмнэлгийн эмч, асрагч, сувилагч, өвчтөнүүд бүгд л гэрэлтэй ирсэн охинд нэр өгөхийг хүссэн учраас хэнийг ч гомдоохгүйн тулд сугалах болжээ. Гэтэл ээжийнх нь өгсөн Оюунгэрэл гэдэг нэр сонгогджээ. Өмнөх эгч нар нь Оюунтай учраас ээж нь ийм нэр сонгосон аж. “Гэрэл гэгээ авчирсан” охиноо ээж нь мэдээж хүнд өгөөгүй. Ямар түүхтэй мэндэлснийг нь яриад “Тийм учраас аливаа юмыг өөдрөг, гэрэлтэй харж бай” гэж сургадаг байжээ. Багаасаа өөдрөг үзлээр төлөвшсөн охин хэцүүхэн өдрүүддээ “Ямар ч юманд сайн тал гэж байх ёстой” гэж боддог.

Хувь заяа түүнд нийгмээ гэрэлтүүлэх их ачаа үүрүүлсэн ч байж мэднэ. Хаана л хүний эрх зөрчигдөнө мань Ц.Оюунгэрэл “шүгэл үлээж” явна. Хүмүүс хэрэгт орчих вий гэж болгоомжилж, үгээ цэнэж байхад ч Ц.Оюунгэрэл л хүний эрх ярьж явдаг. Хамгийн сүүлд гэхэд л “хүргэн” Дэнзэн, С.Зориг агсны эхнэр Булганыг

хориход эргэж очиж, эрх нь зөрчигдөж байгааг зарласны хүчинд сайнаар эргэх жишээтэй.

Хүний эрхийн дуу хоолой тэрбээр мухардсан газарт шийдэл гаргадаг онцгой чадвартай. Хан-Уулчуудыг төлөөлж УИХ-д сууж байгаа энэ эмэгтэй цэвэрлэх байгууламжид хөрөнгө татаж чадсан юм. “Цэвэрлэх байгууламжийн лагийг яаж үнэргүй болгох вэ. Та нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Монголд туслаач” гэж хандив хүссэн захиа бичихэд нь гадаадын компани бүхэл бүтэн багаа явуулж, үнэрийн асуудлыг тусламжаар шийдчихсэн.

Ц.Оюунгэрэл том ажлыг ч үнэ төлбөргүй хийчихдэг нийгмийн хариуцлагатай хүмүүсийн холбоо, сүлжээтэй. Төрийн бус байгууллагад олон жил ажилласан учраас хүний сайхан сэтгэлийг ажил хэрэг болгож чаддаг юм билээ. Өөрөө ч сайхан сэтгэлээр бусдад үнэ хөлсгүй тусалдаг учраас хариу нь ирдэг байлгүй. Монголын аялал жуулчлалын сурталчилгааг CNN-ээр үнэгүй хийлгэсэн гээд бод доо. “Mongolia.Nomadic by nature” (Монгол. Нүүдэлчдийн эх орон) үндэсний аялал жуулчлалын уриа үгийг CNN-ийн маркетингийн баг үнэ төлбөргүй боловсруулж өгчээ. Дэлхийд алдаршсан Батаарыг эх оронд нь үнэ төлбөргүй авчруулсан гээд л нэг бус жишээ дурдаж болно.

Дэлхийн хууль бус зах зээл рүү Монголоос гарсан Батаар тэргүүтэй олдворууд нь нийтдээ 20 тэрбум орчим төгрөгөөр үнэлэгдсэн. Төрөөс хулгай хийгчид олон байдаг ч алга болсон үнэт олдворуудаа буцааж авч болдог гэдгийг Ц.Оюунгэрэл сайд харуулсан юм. Соёл, спорт аялал жуулчлалын яамны удирдлагын багт ажиллаж байсан нэгэн Ц.Оюунгэрэлийг “амар” сайд гэж тодорхойлсон. Сайд хэн нэгнийг ажилд авахыг үүрэгдэж байсангүй, бас танил талаа тендерт шалгаруулж, тал тохой татах хэрэг ч гараагүй ажээ.

Өнгөрсөн дөрвөн жилд хийсэн ямар ажлаараа хамгийн их бахархдаг вэ гэхэд “Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль” гэж тэр шуудхан хариулав. 2012 онд Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн байхдаа гэр хорооллуудаар явахад дандаа хоёроос гурван хүүхэдтэй. Ажил хийж орлогоо нэмэгдүүлэх хүсэлтэй ч хүүхдээ өгөх цэцэрлэг байхгүй эмэгтэйчүүд таардаг байж. Ийм алслагдсан газар ямар арга замаар хүүхдийг цэцэрлэгтэй болгох вэ гээд бодож явахад нь “Аавуудын цэцэрлэг” гэдэг кино санаа өгчээ. “Аавуудын цэцэрлэг” гэж орчуулсан ч жинхэнэ утгаараа аавуудын хүүхэд харах үйлчилгээний тухай өгүүлсэн энэ киноос санаа авч судлаад Канадын хуулийг орчуулж, уншиж байгаад анхны загвараа гаргаснаа Ц.Оюунгэрэл гишүүн ярилаа. Эмэгтэй гишүүд УИХ-д орж ирээгүй бол энэ хууль батлагдахгүй байсан байх. Хууль нь “унах” үед босгож ирэхийн тулд Ерөнхийлөгчийг хүртэл лоббидож “Та мөрийн хөтөлбөртөө оруулаад энэ хуулийг амилуулж өгөөч” гэж гуйж байсан удаатай аж.

Соёл спорт, аялал жуулчлалын сайдын албаа өгснийхээ дараа тэрбээр ганцхан сарын дотор “Монголоо таниулъя” гэсэн ном биччихжээ. Энэ бол аялал жуулчлалаас мөнгө хийхийг хичээж буй хэн бүхний ширээний ном байхаар бүтээл юм. Саяхан хэвлүүлсэн “Соёлоо таниулъя” ном нь ч өөрийгөө танихыг хичээж байгаа монгол хүн бүрт өгөөжтэй ном. Хэдийгээр төрийн сайд биш ч гэлээ Ц.Оюунгэрэл гишүүн Монголын аялал жуулчлал, соёлын салбарт ажилласаар, оюуны хөрөнгө оруулалт хийж, нийгэмд өнгө гэгээ өгч, гэрэл түгээж яваа нэгэн.

Улсын Их Хурлын гишүүн Дуламсүрэнгийн ОЮУНХОРОЛ НИЙГМИЙН САЛБАРЫН НЭРИЙН ХУУДАС



УИХ-ын гишүүн, БОНХАЖ-ын сайд асан Д.Оюунхоролыг сайн багш, бүтээн босгогч, улстөрч, нийгмийн зүтгэлтэн хэмээх олон ажил үйлсэд эзэн шиг эзэн болсон хүчирхэг эмэгтэй гэж бүрнээ хэлж болно. Математикийн багш мэргэжилтэй, МХЗЭ-ийн Төв Хорооны тэргүүлэгч гишүүнээр сонгогдож тухайн үеийнхээ залуусын манлайд явсан, хүн бүхэн гахай үүрч наймаанд явж байхад бусдаас зөрж хувийн сургуулийн шанг татаж, “Отгонтэнгэр” их суруулиа үүсгэн байгуулсан гэхчилэн түүний намтарт онцлох зүйл олон бий.

Энэ удаагийн парламентын бүрэн эрхийн хугацаанд Өрх толгойлсон ганц бие эцэг, эхэд үзүүлэх нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг санаачилсан гишүүдийн нэг нь УИХ-ын гишүүн Д.Оюунхорол. Түүнээс гадна дөрвөн эрэгтэй гишүүн уг хуулийн төслийг хамт санаачилсан ч ажил хэрэг болгохоор хамгийн их ярьж, Төрийн ордонд хэлэлцүүлэг хүртэл зохион байгуулсан нь ганц эмэгтэй нь тэр байв. Монголын гэр бүлийн 10 хувьд хүрсэн ганц бие эцэг, эхчүүдийн нийгмийн тулгамдсан асуудлуудыг амьдрал дундаас олж харж, төрийн бодлого болгож хэрэгжүүлэхээр хичээсэн нь энэ. Үнэхээр ч эхнэргүй эр, нөхөргүй эмэгтэйд ямар зовлон бэрхшээл тохиолддогийг эмэгтэй улстөрч, тэр тусмаа УИХ-ын гишүүн Д.Оюунхорол л олж харж, төрийн бодлогын төвд оруулахаар зүтгэж чадна. Учир нь тэрбээр УИХ-д гурван удаа сонгогдон ажиллахдаа нийгмийн халамж, анхаарлын салбараар мэргэшиж ажилласан байна.

Түүний санаачилж, батлуулсан хуулиудыг харахад дандаа нийгэмд хүлээлт үүсгэсэн, дунд, доод шатныхны эрх ашгийг хөндсөн байх жишээтэй. Тухайлбал, 2011 онд Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан ч УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад ороод шийдэгдэлгүй өдийг хүрчээ. Хүүхдийг өмчийн эзэн болгох заалт уг хуульд тусгагдсан нь тун олон хүн, тэр тусмаа эмэгтэйчүүдийн хүсэн хүлээсэн асуудал

юм. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж батлуулснаар 4-6 хүүхэд төрүүлсэн эхчүүд “Алдарт эх”-ийн нэг, хоёрдугаар одон, жил бүр 50, 100 мянган төгрөгийн тэтгэмж авахаар болсон юм. Мөн Боловсролын тухай, Малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлуулах, Хүүхэдтэй гэр бүл, өнчин хүүхэд, залуусыг дэмжих тухай, Тэтгэврийн зөрүүг арилгах хуулийн төсөл гэхчилэн дурдвал урт жагсаалт гарна. Энэ бүхнээр нь түүнийг “нийгмийн салбарын нэрийн хуудас болсон” түшээ гэж УИХ-ын нэг ангийнх нь нөхөд дүгнэн нэрлэх нь бий. Түүнчлэн эмэгтэйчүүдийн төлөөллийг шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхийн тулд Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг батлуулж, УИХ-ын сонгуулийн тухай хуульд нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байхаар хамгийн анх хууль батлуулсан нь эмэгтэй гишүүний хувиар хийсэн яах аргагүй том ажил байв.

Д.Оюунхорол эмэгтэй хүн л байгальд илүү ээлтэйг харуулж чадсан. БОНХАЖ-ын сайдаар хэсэгхэн хугацаанд ажиллахдаа “Энэ салбарын төлөө ажил хийсэн хүн бол буян хийсэн л гэсэн үг” гэж тэрбээр үргэлж хэлж, байгаль эх дэлхийнхээ төлөө чин сэтгэлээсээ зүтгэж ажилласан нь олон хүний талархлыг хүлээсэн. Тэр үед ажилласан сайдуудын ажлыг дүгнэх үед АН, МАН-ын гэлтгүй олон гишүүн Д.Оюунхорол сайдыг хамгийн сайн ажилласан гэгцгээж байв. Энэ хугацаанд УИХ-аар 11, Засгийн газраар 10 асуудал оруулж шийдвэрлүүлсэн ажил хэрэгч сайд. Сайд Оюунхорол зоригтой шийдвэр гаргаж, Зайсанд 1970-аад оноос хойш амьдарсан уугуул иргэдэд газрыг нь олгосон. Өмнөх ямар ч сайдын хийж чадаагүй энэ ажлыг хийснээрээ 302 өрх айл, тэдний цаана байгаа олон хүний амьдралд дэм болж, дээр нь Богд хан уулын эргэн тойрны газрын маргааныг нэгээр цөөрүүлсэн.

Тарьсан модоо ургуулахад чиглэсэн цогц ажил, байгалийн өгөөж хишгийг нутгийн ард иргэдэд зүй зохистой ашиглуулахын зэрэгцээ хамгаалуулах бодлого мөн л Д.Оюунхоролын үед амьдралд хэрэгжиж эхэлсэн. Хогийг баялаг болгож байгаа аж ахуйн нэгжүүдийг төрөөс урамшуулж эхэлсэн, модны хулгайтай санхүүгийн механизмтай, иргэдийн оролцоотой тэмцдэг болсон, Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хөрөнгийг улсын төсөвт суулгахаар болсон гэхчилэн бодитой хийсэн олон ажлыг нэрлэж болно.

Мөн Монголын аялал жуулчлалын салбарын хөгжилд өмнөх 20 жилд хийгдээгүй ажлыг хийсэн юм. Монгол Улс анх удаа Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөртэй болж, Торгоны зам дагуухь аялал жуулчлалын нэгдсэн зах зээлд улсынхаа байр суурийг бататгасан нь цэвэр салбарын сайдын хичээл зүтгэлээр хийгдсэн ажил. Эмэгтэй хүний нүдээр Монгол оронд аялал жуулчлал хөгжих таатай нөхцөлийг энгийн ч гэмээр зүйлээс эхлүүлсэн нь түүний өөрийнх нь ярьдгаар “00”-ын хувьсгалыг эхлүүлсэн явдал байв. Улаанбаатарын олон жилийн гэр хорооллын хөрсний бохирдол дээд цэгтээ хүрснийг анх удаа салбарын сайд ярьж, агаарын бохирдлын хэмжээнд асуудлыг тавьсан нь Д.Оюунхорол л байв. Тэрбээр энэ асуудлыг ард иргэдийн эрүүл мэнд талаас авч үзсэн билээ.

Хүүхэд, эмэгтэйчүүд, ядуусын зовлон бэрхшээлийг нимгэлэх, хүйн холбоотой байгаль дэлхийгээ хайрлахад сэтгэл л хэрэгтэйг Д.Оюунхорол харуулж чадсаан. Өнөө ч “эрчүүдийн ертөнц” гэгдсээр байгаа улс төрийн өрсөлдөөнд эмэгтэйчүүдийг оруулах, дэмжихэд нэг ёсны зүтгүүр болж ирсэн түүх ч бас түүнийх билээ.

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн САЙХАНБИЛЭГ ЭНЭ ЦАГИЙН УЛС ТӨРИЙН ТОД ДҮР



1990 оны цагаан морин жилийн хувьсгал ид эрчээ авч, Монгол орны төв талбай тэр чигээрээ ардчилсан шинэ үзэл санаагаар давалгаалж байхад Чимэдийн Сайханбилэг Москвагийн Хүмүүнлэгийн ухааны Их сургуульд сурч байжээ. Яг тэр үед Зөвлөлт гүрэн задралын босгон дээр ирчихсэн, хаа сайгүй Горбачевын өөрчлөн байгуулалтын тухай ярьцгааж энд тэндгүй жагсаж цуглаж, Оросын нийгэм бүхэлдээ сэргэж байв. Дараа жилийнх нь зун Сайханбилэг сургуулиа дүүргэж, нэг намын дайчин туслагч, бэлтгэл хүчин гэгдэж ирсэн Хувьсгалт залуучуудын эвлэлийн суурин дээр шинээр эмхлэн байгуулагдсан Монголын Залуучуудын холбооны ажилтан болов. Тухайн үедээ Залуучуудын холбооны удирдлагад Монголын залуусын шилдэг төлөөлөл цугларав. Залуучуудын байгууллагыг улс төрөөс ангид байлгах, залуучуудын нийтлэг эрх ашгийг хамгаалсан тэргүүлэх үүрэгтэй болгох, “Залуу удирдагч” сан байгуулж, шилдэг залуу улстөрч, шилдэг залуу эдийн засагч тодруулах, анхны Ерөнхийлөгчийг дуу алдуулсан Next stop шинэ жилийн цэнгүүн санаачлах зэргээр холбооны залуус хэвшмэл бус олон арга хэмжээг сэдэж, өөрсдөө ч нийгэмд танигдав.

Залуучуудын холбоонд Ч.Сайханбилэг бараг 6 жил ажиллаж, тус холбооны нарийн бичгийн дарга албан тушаалтайгаар 1996 оны УИХ-ын сонгуульд анх удаа нэр дэвшин өрсөлдлөө. “МҮАН-МСДН-ын Ардчилсан холбоо” эвслээс нэр дэвшигчид тэр жил парламентын дийлэнх буюу 50 суудал авахад нийслэлийн Сонгинохайрхан дүүргээс “Сувгаа битгий солиорой” нэвтрүүлгээрээ телевиз үзэгчдийн танил хэдийнэ болоод байсан Сайханбилэг нэг ялагчаар нь тодорлоо. Ингэж тэр Монголын төрийн өндөр босгоор алхан орж ирсэн юм.

Үндэсний хэмжээний улс төрийн олимпод эхний ялалтаа байгуулсан энэ цагаас 18 жилийн дараа 2014 оны 12 дугаар 21-нд тэрбээр Монгол Улсын Засгийн газрын тэргүүний тамгыг улс орны өмнө хүлээх бүхий л үүрэг хариуцлагатай нь цуг хүлээн

авлаа. Олон улсын зах зээлд эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ навс унаснаас голлон шалтгаалсан хөрөнгө мөнгөний хомсдол, түүнээс улбаатай эдийн засгийн хямралыг сааруулан зогсоох хүнд даалгавар Ч.Сайханбилэгийн танхимын нуруун дээр буусан. Тэр дөнгөж ажлаа авангуут УИХ-ын танхимд хэлсэн үгэндээ “Эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг” гэж чанга дуугарсан. Хямралтай үед улс орны эдийн засгийг сөхрөөчихгүйн тулд зориг зүрх гаргах хэрэгтэй байлаа. Хамгийн их хэл ам, хардлага сэрдлэг дагуулсан анхны томоохон шийдвэр нь Оюутолгойн далд уурхайн санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурахыг холбогдох албан тушаалтнуудад зөвшөөрсөн явдал байлаа. Хэн нэг нь хэзээ нэгэнтээ зориглож хийхээс өөр аргагүй энэ үйлдлийнхээ төлөө шийдлийн Засгийн газрын тэргүүн парламент дотроос ч, гаднаас ч зэмлүүлж шүүмжлүүлж, үүний улмаас Засгийн газраа огцруулалгүй хамгаалж үлдэхийн тулд улс төрийн эв дүй, мэдрэмж, ур ухаан гаргах шаардлагатай тулгарсан. Олон улсын банк санхүүгийн 20 хүчирхэг байгууллагаас 4,4 тэрбум ам.долларын хэмжээний санхүүжилт Монголын говийн Оюутолгой төслийн газрын гүний бүтээн байгуулалтад татаж чадсан нь дээрх алхмынх нь шууд үр дүн. Гацаад байсан Гацууртын алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах шийдвэр Ерөнхий сайдын хувьд гаргуулж чадсаныхаа төлөөсөнд янз бүрийн үг сонсож, ам муруйж ч байлаа.

Хамтрагч хүчин нь муйхарласны улмаас Эрүүл мэнд, спортын яамыг хэдэн сар үүрэг хариуцагч толгойлох, улс орны аминд тулсан томоохон асуудлуудыг хамтдаа шийдэхийн тулд МАН-ын зургаан сайдыг танхимдаа урьж ажиллуулаад удаагүй байтал улс төрийн шахалтаар төрхөмд нь буцаахаас аргагүйдэх зэргийг тэсэн гарч, улс төрийн тогтвортой байдлыг ханган ирлэгдэж хурцлагдаж, хатуужиж туршлагажсаар явна.

Түүний тэргүүлсэн Засгийн газар олон сорилт туулж иржээ. Олон жилд болоогүй ган тохиолдсон ч, нийт нутгаар зудтай, хатуу ширүүн өвөл таарсан ч даваад гарсан. Хүн, малын халдварт өвчин, гудамжны жагсаал цуглаан, улстөржилт, засгаа унагаах гэдэг улиг болсон ордны хуйвалдаан, төсвийн алдагдал, улс орнуудыг хамарсан эдийн засгийн хямрал, хүндрэл гээд сорилтууд шил шилээ даран цуварсан ч Монгол Улсын, бас Засгийн газрын, Ерөнхий сайдын ноён нуруу нь нугараагүй ээ.

Залуучуудын байгууллагаас улс төрд анх хөл тавьсан Сайханбилэг өнгөрсөн он жилүүдэд Гэгээрлийн сайд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга, Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албаны дарга, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга зэрэг нэр нөлөөтэй албан тушаалуудыг ээлж дараалан хашиж, УИХ-ын гишүүнээр гурван удаа сонгогдож, Засгийн газрын гишүүнээр мөн гурвантаа томилогдоод байна.

Монголынхоо өргөн уудам нутгийг шилэн кабелийн зөөлөн дэд бүтцээр хэрэх ажлыг нугалж, нийт сургууль, сум, баг, бүх багш нарыг компьютержүүлж, нийслэл, аймгийн төв, сум суурин газрын гэр хороолол, малчны хотонд хүртэл Улаанбаатарын үнэ, хурдаар интернетийн сүлжээ хүргэсэн гэгээлэг үйлсийн санаачлагч, хэрэгжүүлэгч нь Ч.Сайханбилэг. Хямралт эдийн засаг, улс төрийн зөрчилдөөний гал дундуур эсэргүүцлийг давж, амаргүй үед улс орноо урагшаа чирч яваа зүтгүүр нь тэр бас мөн. Тиймээс тэрбээр Монголын их улс төрд тохиолдлын дүр биш. Яг энэ цагийн төлөөлөл яах аргагүй мөн билээ.

Улсын Их Хурлын гишүүн Ядамсүрэнгийн САНЖМЯТАВ СЭТГЭЛИЙН БУЛАГ



Энэ гарчиг эзнээ хэн бэ гэдгийг илэрхийлсэн гэж хэлж болно. Гарчиг ч гэж дээ тодорхойлолт юм. Ийм тодорхойлолтын ард ямарваа нэг лавлах, эсвэл тодруулга болоод чимэг зүүсгэл байх хэрэггүй юм. Сэтгэл дутсан аливаа юмны гүйцэтгэл дандаа сул байдаг. Би түүнийг техникумд суралцаж, Хөдөө аж ахуйн их сургууль дүүргэж, Эрдэнэтэд ажиллаж байсныг нь мэдэхгүй. Харин ганц намын тогтолцоотой байх үед МАХН-ын бэлтгэл боловсон хүчнийг бэлтгэдэг МХЗЭ-ийн ажилтан байхаас нь мэдэх юм.

Тээр жил “Гороо” нэртэй хүн өөрчлөн байгуулалт хийж дэлхийг дэвэргэж байх үеэс Санжмятав МХЗЭ-ийн байгууллагад ажиллаж, эвлэлийн Онц их хурлыг зохион байгуулалцан нэг намын боловсон хүчинг бэлтгэдэг бааз суурийг ганц намын бус Монгол Улсын боловсон хүчнүүдийг бэлтгэдэг бааз суурь болж төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулсан хүмүүсийн нэг юм.

Сайн муугаар нэрээ дуудуулан, сайхан муухай хэлүүлэн өнөөдрийн цаг үеийн түүчээ, зүтгүүр нь болж яваа төр хийгээд хувийн хэвшлийн манлайлагчид бол түүний өөрчлөн зохион байгуулсан бааз суурийн бэлтгэсэн боловсон хүчин гэж хэлж болно. Тэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, сайд, УИХ-ын гишүүн, корпорац, группын ерөнхийлөгч болтлоо өсч өндийцгөөжээ. Тэднийг 26 жилийн амьдралаас харах дурангийн өнцөг олон ч “Хөгжил дэвшил, хичээл зүтгэл, орон зайн тэлэлт” гэсэн одонгийн урт улаан тууз тод чимэх бөлгөө. Тэрбээр энэ олон жилүүдэд магнайд нь дарцаглаагүй ч нууц ноёнтон нь байсан юм.

“Залуу удирдагч сан” байгуулагдаж шинэ цагийн төлөвшсөн манлайлагч нар тодорч, тэд нарыг тодруулж байхад ч тэрбээр тийм л байсан. Олон юмыг оргүй хувьчилж дуусаад орь ганцаараа Залуучуудын байр үлдэхэд ч, үлдээхэд ч тэр ийм л байсан. Засгийн газрууд ээлж дараалан солигдож, баг бүрэлдэхүүнээрээ байраа сольж байхад ч тэр нууц ноёнтон л байсан. Хэрэгтэй хүн хэзээ ч ад

болдоггүй байгалийн мөнхийн хууль зөвхөн түүнд л үйлчилж байсан мэт. Хаалган завсар Засгийн газрын тэргүүн солигдож байхад ч энэ үйлчилгээ явагдаж байв.

Тэрбээр намчирхаад сүйд болдоггүй. Номчирхоод дөвчигнөдөггүй. Харин нөхөрлөж, шадарлаж, хүнд хэцүү цагт дэргэд нь байж чаддаг. Уулаар бол нөмөр нөөлөг, усаар бол голдирол болж чаддаг. Нөгөө Сүрэнжав гуайн “Багш” найраглалд гардаг шиг чадахгүй юм түүнд байхгүй. Тийм болохоор тэр өөрийгөө Эрдэнэтэд шигдэлгүй суралцахаар дайчилж, эвлэлд шүтэлгүй өөрчлөхөөр зориглож, дулдуйдалгүй аж ахуй эрхэлж, хотод шигдэлгүй аймагтаа Засаг даргаар ажиллаж, сайдын сэнтийд сатааралгүй ангижирч, намдаа жийгдсэн ч бие даагаад товойж, хаана ч алзахгүйгээ харуулж чадсан, хариуцлага үүрүүлбэл дааж чадахаа нотолж чадсан, ирээдүйгээсээ өөр юманд хөрөнгө оруулалт хийдэггүй, он цагийн эрүүлгэнээс ангижирсан, одоо цагт ховор толгойнуудын нэг.

Түүний амин шүтээн нь оюуны сан хөмрөг. Монгол Улсын жаргалтай ирээдүй, монгол хүний амьдралын ерөөл болсон хүүхэд багачууд, тэдний уураг тархинд хөрөнгө оруулалт хийх нь түүний туйлын зорилго. Эргэнэгийн тэнд ээрүүл ээрч суугаа эмгэний ач, зээдээ аминчлан захисан үг, утаагүй улаанаа нэрэнгээ уужим хорвоогийн алаг өрөг дээр ухаанаа уралдуулах өвгөний цэн цэнгийн бодол өвөр дээр нь эрхэлж суугаа ач, зээ, жичид нь ямар агуу сансар огторгуйн аялал байдгийг таньж мэдсэн хүн бол Санжмятав.

Ерөнхийлөгч зарлиг гарган хоймортоо залах эрх нь сэргэсэн хэдий ч ис тортогт дарагдаж, тэвх нь хагсарсан хуурыг амилуулсан хүн бол Санжмятав. Ингэж тэр өнгөрсөн рүү өртөөлөх мөртлөө цахим ертөнцийн чанд руу түрүүлж довтолгон айсуу он цагийг анирдаж алсрах, ирэх хоёрыг томж өгч байх жишээтэй. Уламжлал, ургах мандах хоёрыг голдирол болгоно гэдэг ухаан. Торгоны зам, үхрийн улбаа шиг бүдгэрч байхад Тосон, Улиастайн зам Ар Бээжинг тордох мэт гэрэлтэж буй нь ч алсыг төдүүлэхээс илүү хот, хөдөөгийн ялгааг бүдгэрүүлэхэд чиглэсэн гэлтэй. Энэ бол сэтгэлийн их эрчим хүч юм.

Тэр бас сэтгэлийн их хаттай нэгэн. Амьдралын ноён нуруу, амраг сайхан ханиа алдаж байхдаа ч хазайгаагүй. Хүнээр л өртөөлдөг зовлон, жаргалын зоон дээр ч гундаагүй. Эрдэнэ мэт хэдэн хүүхэд төрүүлж өгсөн ханьдаа гэрэлт суварга бүтээгээд сэтгэлийнхээ хойморт дээдэлж явна. Явган үгэнд хааяа нэг шилбүүрдүүлсэн ч явдлыг нь андахгүй хорвоогийн аяыг аялж явна. Тэр сэтгэлдээ ижий гэдэг бурхантай. Он цагийн нугачаанд ижийтэйгээ хамт өтөлж том болсноо түр мартан эрхэлж яваа азтай эр.

999 идэр залуу хуурч бэлтгэн хан хурмастыг аргадан таалж, нийслэл хүрээнд ирэн нийтийн сонорыг мялаан Сүхбаатарын талбайд “Дуут нуур”-ыг хадааж, Дэлхийн шатрын холбооны ерөнхийлөгч Кирсан Илюмжиновоор монгол хүүхдийн оюуны мэлмийг нээлгэж, галын бурхны ган тулга мэт “Гурван тулгуурт бодлого” хэрэгжүүлж уулсын дундах Улиастайг Улаанбаатарын зиндаад авч яваа их гар аа.

Нутаг амьтай, нутаг сэтгэл. Нуруу нь авагддаггүй сэтгэлийн нэрмэл ийм нэгэн бодигал. Хөгжлийн түүчээ болж чаддаг сэтгэлийн хөгтэй, сэтгэлийн тэнхээтэй, 21 ундаргатай сэтгэлийн энэ дагшин булаг өвөл хөлдөлгүй харзалж, зун татралгүй мэлтэрч, зураг төөргөөрөө тодорч явах болтугай.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн САРАНГЭРЭЛ

ЗӨВ ЗҮГ, ЗӨВ ЖИШИГ



Сарангэрэлийг 1990 онд ОХУ-ын Ростовын Улсын Их сургуулийг төгсч ирэхэд Монголд ардчилсан хөдөлгөөн ид өрнөж байв. Тун сонирхолтой, бас адармаатай үед сургуулиа төгссөн тэрбээр Монгол телевизийн Мэдээллийн албаны сэтгүүлчээр ажлын гараагаа эхэлсэн парламентын анхны сэтгүүлчдийн нэг. Бүр Улсын Бага Хурлаас эхлэн чуулганы танхимаас сурвалжлага, нэвтрүүлэг бэлтгэн шинэ Үндсэн хууль батлах үйл ажиллагааг Төрийн ордноос хэд хоногоор гаралгүй дамжуулан олон нийтэд хүргэж байсан нь улс төрийн тогоонд чанагдах эхлэл байсан аж.

Улс төрд хэзээ хэзээнээсээ илүү эмэгтэйчүүдийн орон зай нэхэгдэх тийм цоо шинэ орчин бий болж байна. Ерөөсөө Монголд ч гэлтгүй дэлхий нийтээрээ эмэгтэй улстөрчдийг хүлээн зөвшөөрч, хүсэмжилдэг хандлага нэгэнт үүсчээ. Улс төрд эмэгтэйчүүдийн шинэ цаг ирлээ гэж хэлж болно. 2012 оны УИХ-ын сонгуульд олон эмэгтэй нэр дэвшигч өрсөлдөж, 11 эмэгтэй гишүүнтэй парламент бүрдсэн билээ. Тэдний нэг нь сайн улстөрч болох гараагаа аль хэдийнэ эхлээд ид жигдэрч яваа УИХ-ын эрхэм гишүүн Д.Сарангэрэл юм.

Тэрбээр 2012 оны 12 дугаар сард “ангийн нөхдөөсөө” ялимгүй хоцрон орж ирж тангаргаа өргөсөн ч нэг их түүртэлгүй төрийн түшээгийн эгнээнд жагсч, тойрогтой гишүүдтэй эн тэнцүүхнээр иргэдтэй харилцаж өдийг хүрсэн юм. Д.Сарангэрэл гишүүний өнгөрсөн 4 жилд 30 гаруй хууль, тогтоолын төсөл дээр ажиллажээ. Түүний хийсэн ажлаас цухас дурдахад, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төслийн хамтран санаачлагчаар ажиллав. Жолооны олон курс ажиллаж, туршлага, дадлага тааруу жолооч нарыг “бөөндөн” бэлтгэж, зам, тээврийн осол, эндэл ихээр гарах болсон энэ цагт олон нийтэд ээлтэй, хэрэгцээтэй тун чухал хууль болсон гэдгийг иргэд хэлдэг. Төрөөс эмийн талаар

баримтлах бодлого батлах тухай хуулийг батлуулахад Д.Сарангэрэл гишүүн ажлын хэсгийг нь ахалсан, мөн манай улс анх удаа Номын сангийн тухай бие даасан хуультай болоход ихээхэн хүчин чармайлт гаргасан гишүүн.

Зах зухаас нь дурдсан эдгээр хуулийг ажиглаад л эх хүн, эмэгтэй хүн хууль тогтоох байгууллагад ажиллах нь нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлуудыг шийдэхэд ямархан үр нөлөөтэй вэ гэдэг нь тодорхой харагддаг. Хүүхэд харах үйлчилгээний хуулийг хэлэлцүүлэх гэж чуулганы танхимд Д.Сарангэрэл нарын хэдхэн эмэгтэй гишүүд сууж байсныг сонгогчид сайн санаж байгаа байх аа.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууг улсын тусгай хамгаалалтад авах тогтоолыг Засгийн газраар гаргуулахад тэрбээр нөхдийн хамт хоёргүй сэтгэлээр зүтгэсэн гавьяатай нэгэн. Уг тогтоолыг УИХ-ын таван эмэгтэй гишүүнтэй хамтран санаачилж батлуулснаар байгаль орчноо хамгаалах, нэн ховордсон ан амьтан, тэр дундаа цоохор ирвэсийн өлгий нутгийг төрийн хамгаалалтад оруулсан нь Өмнөговьчуудын төдийгүй эх нутаг, байгальдаа элэгтэй монгол түмний талархал хүлээсэн буянтай үйл болсон билээ.

Иргэд, сонгогчдын ахуй, амьдрал ямархан байгааг анхаарч, санаа тавьж явдаг гишүүний нэг нь эрхэм түшээ Д.Сарангэрэл юм. Улаанбурухан өвчний гаралт нэмэгдэж, нялхас эндэж, эрүүл мэндийн салбар нь толгойлох сайдгүй зутарч байгаа үед тэрбээр Б.Бат-Эрдэнэ нарын гишүүдтэй хамтран эмнэлгүүдээр ажиллан нөхцөл байдлыг парламентад танилцуулж, асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байв. Эм ханган нийлүүлэх байгууллагууд, эх, нялхсын эрүүл мэндтэй холбоотой газрууд, шинжлэх ухааны байгууллагуудаар тэр л явж, нөхцөл байдалтай танилцаж, тэдгээр салбарынхны санаа бодлыг төрд хүргэж ажиллаж байв.

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны гишүүнээр сонгогдсоноосоо хойш Хан-Уул дүүргийн нэхмэлийн шарууд гэх “гологдмол” байрны оршин суугчид, гэр хорооллын дахин төлөвлөлтөд өртөн хохирсон иргэд, Багахангай дүүрэг дэх цацраг идэвхт бодисын хаягдал, тус дүүрэг дэх Боловсролын газрыг татан буулгасан талаарх иргэдийн гомдол, Багахангай дүүргийн газрын асуудал зэргийг цэгцлэх талаар хөөцөлдөж, олон хүнтэй уулзаж, нөхцөл байдлыг судлан төр, засагт хандах үгийг нь хүлээн авч гүүр болж зарим асуудлуудыг нь шийдүүлээд байна. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэх үеэр, мөн Сонгуулийн хуулийг батлах үеэр сэтгүүлчдийн зөрчигдсөн эрхийг хамгаалан тууштай тэмцсэн нь эрхэм гишүүн Д.Сарангэрэл байв.

Хамгийн сүүлд л гэхэд Д.Сарангэрэл гишүүн УИХ-ын гишүүн Ц.Нямдорж нартай хамтарч Эрүүгийн хуульд эмч нарыг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбон 20-80 сая төгрөгөөр торгох, эсвэл 2-8 жил хорих ял шийтгэх заалтыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх хуулийн төсөл санаачилж, санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн билээ. Тэрбээр Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг, эмч нарыг мэргэжилтэй нь холбон яллах хатуу заалтууд орж, нийгмийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарч байгааг соргогоор мэдрэн өөрчлүүлэх санал гаргасан мэдрэмжтэй эрхэм түшээ юм.

Д.Сарангэрэл гишүүн шиг эрүүл саруул сэтгэлгээтэй, улс орноо, ирээдүй үеэ бодсон олон түшээд байж гэмээнэ Монгол орон дэгжин дээшилж чадна.

Улсын Их Хурлын гишүүн Янгугийн СОДБААТАР

“ЭРХЭМ ТАНИЛ”



Хүн хүнтэйгээ танил байх сайхан. Харин эрхэм гэх тодотголыг зүүх тухайд бол ул суурьтайгаар бодох учиртай. Миний хувьд шинэхэн танил хэдий ч цаг хугацааг богино гэж хэмжилгүйгээр ухааных нь цар, бусдын төлөө сэтгэл оюунаа зориулж явааг нь олж хараад эрхэм хэмээн хүндэтгэн тодотгосон хэрэг. Ер нь бол Янгугийн Содбаатар монгол түмэнд хэдийнэ танил болсон эрхэм.

Эрхэм танилын маань өндөр өвөг нь Гэгнээн хутагтын нутгаас гаралтай аж. Бүр нарийн хэлбэл, хуучин Сайн ноён ханы язгуур өндөр ноёдын үр сад. Хамгийн ойрын жишээ гэвэл өвөг эцэг нь Төв халхынхны шүтээн болсон Автай сайн ханы байгуулсан Эрдэнэзуу хийдэд таван настайгаасаа шавилан сууж, насан өндөр болтлоо буддын гүн ухаанд сэтгэл оюунаа зориулсан нэгэн байж. Ийм буурлын энгэрээс Я.Содбаатар зүүгдэж өсчээ. Өссөн орчин нь ийм тул эдүгээ Я.Содбаатар тэрүүхэндээ шаггүй уншлагатай байж мэдэхээр. Харин тэрбээр “Хүний орчлонд нүгэл багатай, зөв явах юмсан гэж боддог. Хүн ер нь шүтэх шүтээнтэй, дотоод итгэл үнэмшилтэй, айж ичдэг байж гэмээнэ замбуулинд зөв амьдарна шүү дээ” хэмээсэн нь амьдралынх нь жанжин шугам гэлтэй.

Академич Б.Чадраа, С.Батмөнх, Д.Намсрай, доктор С.Доржханд нарын зэрэг Монголын нэртэй эрдэмтдийн лекцийг сонссон залуу эр ШУА хэмээх их айлын босгыг алхав. Энэ бол 1996 он. Монгол Улсын эрдэм судлалын хамгийн том өргөөний хаалга хүн бүхэнд нээлттэй байдаггүй. Чухам ийм ховор тавилангийн эзэн байж чадсан тухайд оюутан ахуйдаа цаг нартай уралдан эрдэм номд шамдсаны буян. Түүний эрдмийн оргил өөд мацах хүсэлд хязгаар байсангүй. Доктор Цэдэндамбын удирдлага дор “Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах онол-практикийн зарим асуудал” сэдвээр докторын зэрэг хамгаалсан нь Я.Содбаатарын хэн болохыг илэрхийлэх олон арван түлхүүрийн зөвхөн нэг нь юм.

Нөгөөтэйгүүр тэрбээр зөвхөн эрдэм номын мөр хөөн ширээний араас өндийдөггүй нэгэн байсангүй. Цагийн ороо бусгааг хэрхэн давах тухайд анд нөхөдтэйгөө үзэл бодлоо хуваалцан байр сууриа илэрхийлэх болсон нь цаад утгаараа улс төрд хүчээ сорих нөхцөл байж мэдэх юм. Энэ үүднээс оюутан, залуучуудын дуу хоолой болж, өөр хооронд нь уялдуулж хамтын ажиллагааг өргөтгөх, эрх ашгийг нь бодитойгоор хамгаалах зорилго бүхий хөдөлгөөнийг МАХН-ын дэргэд байгуулж, түүндээ өөрсдийн хүсэл мөрөөдлөө тунхаглан “Тэмүүлэл” хэмээн нэрийдсэн байдаг. Намын дэргэд байгуулагдсан энэхүү хөдөлгөөн нь эгнээндээ олон арван залуусыг нэгтгээд зогсохгүй МАСЗХ болж өргөжин Я.Содбаатарыг нарийн бичгийн дарга, Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсон нь залуучууд түүнд ямар их итгэл хүлээлгэж байсны гэрч биз ээ. Тэртээх он жилүүдэд зөвхөн оюутан залуучуудын сайн сайхны төлөө гээд гүйж явсан Я.Содбаатар эдүгээ Монголын төрийг түшилцэн, төр улс, цаашлаад нутаг ус, элгэн садан, бидний үр хүүхдийн сайн сайхны төлөө энэ бие, ухаан бодол, сэтгэл оюунаа зориулан зүтгэж явна.

Монголын төр түүний эзэмшсэн мэдлэг боловсрол, улс төрийн дадлага туршлагыг нь ашиглан 2008 онд Үйлдвэр, худалдааны дэд сайдын албанд томилжээ. Я.Содбаатар ч хэн бэ, ямархан улстөрч вэ гэдгээ ард түмэндээ, нутаг усныхандаа богино хугацаанд харуулж чадсан аж. Ялангуяа түүний уул уурхайн салбарт баримталж байсан бодлого тов тодорхой үлджээ. Өнөө хэр учир нь олдоогүй байгаагүй Оюутолгой, Асгат, Тавантолгой зэрэг томоохон орд газрыг ашиглуулахдаа Монгол Улсын үндэсний эрх ашигт нийцсэн, хүн зонд хүртээмжтэй, харилцан ашигтай байх тухайд тэрбээр хичээнгүйлэн зүтгэсэн билээ. Мөн өвөрхангайчуудын зүрх сэтгэлд сорви болон үлдсэн Уянга сум дахь гар аргаар алт олборлогчдын тарьсан балаг өөр бусад аймаг, сумдад нүүрлэх вий гэх үүднээс “Алтыг нь аваад авдрыг нь хаяж болохгүй” гэдгийг уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдэд хатуу анхааруулж, баялгийг нь хүртсэн бол байгалиа нөхөн сэргээдэг, тухайн бүс нутгийн иргэд байгалийнхаа хишгээс хүртдэг байх, аж ахуйн нэгжүүд орон нутгийг хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулдаг байх тухайд өөрийн байр суурийг зоригтойгоор илэрхийлж байжээ. Түүнчлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулан НҮБ-тай хамтран томоохон төслийг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь өвөрхангайчуудад төдийгүй бусад аймаг сумдад өгөөжөө өгсөн билээ.

Я.Содбаатар эдүгээ Монгол Улсын хууль, эрх зүйн орчныг сайжруулахын төлөө оюун бодлоо чилээн олон хуулийн төсөл санаачлан зарим төсөл дээр нөхдийн хамт ажиллаж УИХ-д өргөн мэдүүлсэн нь эхнээсээ батлагдан амьдралд хэрэгжиж эхэлсэн байна. Үүнээс гадна төрж өссөн нутгийн зон олон, өвөг дээдсийнхээ шүтээн болсон Өндөр гэгээн Занабазарын ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай тогтоолын төслийг гурвантаа санаачилж, хамгийн сүүлийнхийг нь цагаан сарын өмнөхөн Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьжээ. Мөн Сайн ноён хан Намнансүрэнгийн музейг шинэчлэн үзмэрийг нь баяжуулж нутгийн түмэндээ хүлээлгэн өгсөн.

Ийм эрхэм танилтай байх нь хэн хүнд тохиохгүй ховор завшаан. Та ч бас ялгаагүй. Төрийнхөө эрхэм түшээг зориод очоорой. Нэгийг хэлж өгөөд үдэх вий.

Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн СОДБИЛЭГ

ШИНЭ ЦАГИЙН ӨНГӨ



Монголын нийгэм, улс төрийн тавцанд шинэ үеийн залуусын төлөөлөл орж ирсээр байгааг бид хардаг. Шинэ бодлого, шинэ үзэл баримтлал, шинэ мэдлэг, шинэ эрч хүч тэднээс үнэртдэг. Ийм л эрин цагийн төлөөлөл болсон улстөрч бол О.Содбилэг юм. Шинэ үеийн шилдэг залуу гэж түүнийг бүрэн тодорхойлно. Залуусын манлайлал, өнөөгийн залуусын шинэ дүр төрх гэж бас үзэж болно. Түүнийг залуусын хот Эрдэнэтийнхэн 2012 онд өөрсдийн төлөөлөл болгож УИХ-д сонгосноор О.Содбилэг энэ удаагийн парламентад хамгийн залуу гишүүн болсон юм.

О.Содбилэг УИХ-д шинэ өнгө нэмж, шинэ үеийн улстөрчийн имижийг бүрдүүлсэн залуу гишүүн. Тэрбээр хүмүүстэй сайхан харилцана, эелдэг зөөлөн инээмсэглэнэ. Бас хүүхэд багачуудад санаа тавьж, ахмад настнаа хүндэлж, залуусыг дэмждэг гишүүн. Чуулганы танхимд бусдыг муулж, харааж, бүдүүлэг үг хэлж, үйлдэл гаргадаггүй, өөрийн бодолтой өнөөгийн залуусын сайн үлгэрлэл. Энэ бүхний цаана өндөр боловсрол нуугдаж байдаг юм. Түүн шиг өндөр боловсрол эзэмшсэн гишүүн одоогийн парламентад байхгүй. Швейцари улсын Кембриджийн Эйллон коллежид бүрэн дунд боловсрол эзэмшээд 2002-2006 онд АНУ-ын Жоржтауны Их сургуулийг олон улсын эдийн засагчаар бакалаврзэрэгтэй төгссөн. Францын INSEAD Их сургууль болон Хятадын Чинхуагийн Их сургуульд бизнесийн удирдлагын магистр хамгаалсан. Англи, орос, герман хэлтэй. Эндээс л О.Содбилэгийг хэр боловсролтой, хэр мэдлэгтэй гишүүн болохыг харж болно.

Эх орондоо ирээд Гадаад хэргийн яаманд нэг жил орчим атташегаар ажиллаж, төрийн яам хэрхэн ажилладагтай танилцжээ. Дараа нь хувийн хэвшилд шилжиж Капитрон банкны газрын дарга, НИК компанийн Тэргүүн дэд захирал, улмаар Петровис компанид дэд захирлаар ажиллаж байгаад УИХ-ын гишүүн болов. Эдийн засгийн онол, практик хоёрыг хосуулахын жишээ энэ. Тиймээс

л тэрбээр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх улс орны эдийн засаг, санхүү, бизнестэй холбоотой томоохон асуудлуудаар дуугарч, санал бодлоо жинтэйхэн шиг хэлчихнэ. Гэхдээ байнга биш, дуугарах ёстой асуудлуудад л өөрийн байр сууриа илэрхийлнэ.

О.Содбилэг гишүүн олон хуулийн төсөл санаачлан, ажлын хэсгүүдэд орж ажиллажээ. “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтал-2030 он” тогтоолын төслийн ажлын хэсэгт орж, гол үүрэгтэй ажилласан билээ. Энэ нь одоогийнх шиг савчсан, ийш тийш үсэрсэн төрийн бодлого биш, урт хугацаандаа Монгол Улс хэрхэн яаж хөгжихийг тодорхойлсон чухал ач холбогдолтой үзэл баримтлал юм. Түүнчлэн Нүүрснээс синтетик байгалийн хий боловсруулах, Хамтын тэтгэврийн тухай, Сонгуулийн тухай, Хяналтын тухай зэрэг хуулийн төсөл дээр хувь нэмрээ оруулсан байдаг.

УИХ дахь цөөнх, сөрөг хүчний бүлгийн гишүүний хувьд эрх баригчдын явуулж буй зарим бодлого, үйл ажиллагаанд нэлээд шүүмжлэлтэй хандаж иржээ. Тухайлбал, эдийн засгийг хямралаас гаргах оновчтой бодлогогүй, шуурхай ажиллаагүй, улсын төсөв улам тэлж, өр улам нэмэгдэж байгаад анхаарал хандуулаагүй, гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, бизнесийнхэнд хүндрэл учруулсаар байгаа зэрэг асуудлыг баримтаар баталгаажуулан ярьж, Засгийн газар огцрох ёстой хэмээн үзсэн гишүүний нэг. Мөн Оюутолгойн гэрээг эрс эсэргүүцсэн хүн. Оюутолгой төслийг явуулах нь зөв, гэхдээ гэрээний нөхцөл, заалтад өөрчлөлт оруулах хэрэгтэй гэсэн байр суурь илэрхийлж байсан юм.


Тэрбээр хамгийн сүүлд “Залуучуудын хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай” хуулийн төсөл боловсруулжээ. Энэ нь залуучуудын сурч хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулахад чиглэсэн төсөл юм. Залуусын хөгжил, сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөхөд ихээхэн анхаарна. Заримдаа УИХ-ын танхимд тэднийгээ өмөөрнө, хамгаална. Боловсролтой, ажилтай, чадвартай, хэлтэй, эрүүл монгол залуу иргэний төлөө гэх сэтгэлтэй хүн. МАН-ын НАМЗХ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, дэд ерөнхийлөгчөөр ажиллах үедээ “Залуусын хөгжлийн санаачлага-2030” цогц бодлого санаачилж хэрэгжүүлсэн байдаг.

О.Содбилэг сонгогдсон тойрогтоо ч залуусаа дэмжих олон ажил хийжээ. “Эрдэнэтийн брэнд-Боловсролтой залуус” гэсэн нийгэм дэх имижийг бий болгох зорилгоор “Эрүүл хөгжилтэй Эрдэнэтийн хүүхдүүд, хөдөлгөөнтэй, хөгжилтэй Эрдэнэтийн хүүхдүүд, хөгжимтэй, хөгжилтэй Эрдэнэтийн хүүхдүүд, хэлтэй хөгжилтэй Эрдэнэтийн хүүхдүүд” нэртэй дөрвөн хөтөлбөрийг хэрэгжүүлжээ. Энэ хүрээнд Орхон аймгийн төрийн өмчийн бүх цэцэрлэг, сургуулиудад таван хэлний лингафон танхим, олон төрлийн хөгжмийн зэмсгүүд, бүх багт дэлхийн стандартын хүүхдийн тоглоом өгч суурилуулсан бол аймгийн эмнэлгийн төрөх тасгийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангасан байна.

Энэ бүгдийг тэрбээр Эрдэнэтийн залуусын ирээдүйн төлөө хувийнхаа хөрөнгө оруулалтаар хийжээ. Эдийн засгийн хямралтай үед улсын санхүүжилт харж суулгүйгээр асуудлыг ийн шийдсэн байна. Нэг тэрбум гаруй төгрөгийг тойргийнхоо оюуны хөрөнгө оруулалтын ажилд зориулжээ. Одоогийн парламентад хувиасаа ийм хэмжээний хөрөнгө оруулалт тойрогтоо хийсэн гишүүн хэд байгаа бол гэсэн асуулт гарна. Түүний бусдаас ялгарах бас нэгэн шинэ өнгө энэ билээ. Төрөөс идэх сэтгэл биш өгч болдгийг харуулсан шинэ үеийн улстөрч бол Отгонбилэгийн Содбилэг юм.

Улсын Их Хурлын гишүүн Мишигийн СОНОМПИЛ

ЗӨВ ҮЙЛ ЗӨВ ЗАМ МӨРТЭЙ



Төрийн түшээ Сономпил

УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга М.Сономпил ардын армид байлдагчаас эхлээд Батлан хамгаалахын сайдаар дэвшин ажиллаж байсан, түүнчлэн УИХ-ын гишүүнээр хоёр удаа сонгогдож, Засгийн газрын гишүүнээр хоёр удаа томилогдон ажиллаж ирсэн төрийн түшээ. Тэрбээр бүрэн эрхийнхээ хугацаанд хугацаанд “Уул уурхайн хөгжил түр хороо байгуулах тухай”, “Ард нийтийн санал асуулга явуулах тухай”, “Юмжаагийн Цэдэнбалын нэр төрийг сэргээж, алдар гавьяаг нь мөнхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл, Өршөөлийн тухай хуулийн төсөл, Эрчим хүчний тухай тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, УИХ-ын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн оруулах тухай зэрэг хуулийн төсөлд гар бие оролцжээ. Мөн УИХ дахь Монгол-Австрийн парламентын бүлгийн даргаар ажиллаж, энэ хугацаанд Австрид айлчлан хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцон чухал шийдвэрүүд гаргажээ. Түүнчлэн Монгол-Австрийн Засгийн газар хоорондын комиссын 5 дугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Монгол Улсын эрчим хүч, уул уурхай, эрүүл мэнд боловсролын салбарт 40 сая еврогийн төсөл хэрэгжүүлэхээр болсон аж.

Улстөрчийн хувьд түүнийг хэрүүл хийж, хий ярьж байхыг нь хүмүүс хараагүй. Сүүлийн үед дэлхийн гадаад бодлогод “Soft power” буюу зөөлөн хүчний бодлого гэсэн шинэ нэр томъёо хэрэглэгдэх болж байгаатай адил “зөөлөн хүч” гэдэг энэ үгийг хувь хүн дээр авч үзвэл Мишигийн Сономпилийг ийм үгээр л тодорхойлмоор санагдаад тухай” нэгэн сэтгүүлч бичсэн байдаг нь их оносон зүйрлэл юм.

Эрчим хүчний Сономпил

Түүнийг эрчим хүчний мэргэжилтэн биш боловч бодлогоо зөв тодорхойлсноо хийсэн ажлаараа харуулж чадсан хэмээн салбарынхан нь үнэлдэг. Тэр ярихаасаа илүү бүтээгч хүн. “Залуу Монгол” пүүс хэмээх жижигхэн аж ахуйн нэгж Монголын том компани болсныг тооцохгүй юмаа гэхэд Батлан хамгаалахын, Эрчим хүчний сайдаар ажилласан он жилүүдийнх нь бүтээл үүнийг гэрчилнэ. Хамгийн сүүлийн жишээ татахад түүнийг Эрчим хүчний сайдаар ажилласан хоёрхон жилийн дотор эрчим хүчний салбарт сүүлийн 30 жилд хийгдээгүй том бүтээн байгуулалт хийгджээ. “Амгалан” дулааны станц, “ДЦС-3”-ын 50 мВт, “ДЦС-4”-ийн 120 мВт-ын өргөтгөлийг нэрлэхэд л хангалттай. Энэ ажлын үрээр нийслэлийн зүүн хэсгийн 60.000 айл өрх, 700-гаад орон сууц, байгууллага даарахын зовлонгүй болсон. “ДЦС-4”-ийн өргөтгөл хийгдсэнээр эрчим хүчээр 250 мянга, дулаанаар 15 мянган өрхийг нэмж хангах нөхцөл бүрдэв. “ДЦС-3”-ын шинэчлэлтээр Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн хүчин чадал 100Гкал/ц-аар нэмэгдэж, үйлдвэрлэлийн хэмжээ 250-300 сая кВт/цагаар өсч, борлуулалтын орлого нь жилдээ 30 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг “ Монгол Улс 1991-2011 онд буюу 20 жилийн хугацаанд эрчим хүчний салбарт хийсэн бүтээн байгуулалттай тэнцэх хэмжээний хүчин чадлыг 2012-2014 оны 2 жилийн хугацаанд бүтээн босголоо” хэмээсэн нь түүний хийсэн ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээг товчоор дүгнэсэн хэрэг гэж хэлж болно.

Батлан хамгаалахын Сономпил

Түүнийг Батлан сайдаар ажиллаж байхдаа батлан хамгаалах салбарын урсгал төсвийг 27 тэрбум, хөрөнгө оруулалтыг 360 сая төгрөгөөр батлуулж байсан нь тус салбарын хөрөнгө оруулалт өссөн үзүүлэлт хэмээн салбарынхан нь онцолж байдаг. Ийнхүү төсөв нэмэгдсэн нь алба хаагчдын цалин, хангамжийг нэмэгдүүлэх таатай нөхцөл болж, 800 гаруй алба хаагчийн цалингийн хэмжээг нэг шатлалаар ахиулжээ. Мөн тус салбарт хамаарах орон сууцнуудыг 1998 оноос үе шаттайгаар хувьчилсан нь нэг талаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан алхам байсан ч салбарын дараагийн үеийнхний нийгмийн хамгаалал, байр, орон сууцны хангамжийн асуудлыг орхигдуулж болохгүйг ойлгуулж, 011 дүгээр ангийн байрлалд энхийг сахиулагчдад зориулсан 50 айлын орон сууц ашиглалтад оруулжээ.

Түүнчлэн гадаад харилцаа, хамтын ажиллагаанд анхаарал хандуулсны ачаар түүнийг сайдаар ажиллах хугацаанд 150 гаруй хүн 21 улсад суралцсан бол хууль, эрх зүйн орчинд ч мөн ахиц дэвшил гарчээ. Тодруулбал, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан ахмадуудын тэтгэврийн зөрүүг арилгахад 6.2 тэрбум төгрөг зарцуулж, Төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, Нөхөн төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай Засгийн газрын тогтоолтой гаргуулсангэх зэргээр тоочьол олон ажил бий.

Салаан захирагчаас сайд болоод очихдоо хичнээн хүнийг орон байртай болгож, хэдэн хүний цалин хангамжийг нэмэгдүүлснийг, Зэвсэгт хүчний салбарт бүтээн байгуулалт хэрхэн өрнүүлснийг армийнхан нь мартаагүй байх аа.

М.Сономпил ажилласан салбар, итгэж хүлээлгэсэн алба болгондоо өөрийн зөв зам мөрийг үлдээж, ноён нуруутай явж ирсэн нэгэн.

Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн СУМЪЯАБАЗАР

ХОТООР “ЗАНИМАЛДСАН” ГИШҮҮН



Энэ парламентад бүрэн эрхээ хамгийн сүүлд баталгаажуулсан хоёр гишүүний нэг нь Д.Сумъяабазар. Чөлөөт бөхөөр тив, дэлхийд Монголынхоо нэрийг цуурайтуулсан олон улсын хэмжээний мастер, үндэсний бөхөөр бол ард түмэндээ хайрлагдсан аварга маань 2012 онд МАН-аас нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт нэр дэвшсэн билээ. Гурван мандаттай тус дүүрэгт дахин санал хураалт явуулж, тэрбээр сонгогдсон ч улс төрийн нөхцөл байдлын улмаас тангараг өргөх явц нь хойшилсоор 2013 оны тавдугаар сарын 10-нд сая нэг албан ёсоор УИХ-ын гишүүн болсон. Бусдаасаа бараг жилийн дараа УИХ-ын босгыг давсан энэ эрхэм өнгөрсөн хугацаанд хэрхэн ажилласан бол.

Тэрбээр 2008-2012 онд Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчөөр ажиллажээ. Энэ он жилүүд нь хууль тогтоох талаар бэлтгэлээ базааж, шат дамжлагаа давчихсан гэсэн үг. Нийслэлийн ИТХ-д Сонгинохайрхан дүүргийг төлөөлж байсан Сумъяабазар хотын хамгийн олон хүн амтай, гэр хороолол ихтэй дүүргийн иргэд сонгогчдыг эдүгээ УИХ-д төлөөлж байна. Мөн МАН-ын нийслэл хариуцсан нарийн бичгийн даргын сонгуульт үүргийг хавсран гүйцэтгэдэг. Нэг ёсондоо хотын асуудлаар “занималдсан” гишүүн аж. 2008 онд НИТХ-ын төлөөлөгч болсноосоо хойш Улаанбаатар хотын төлөвлөлт, хөгжилтэй холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилт тавьсан аж. Хууль тогтоогч болоод энэ чиглэлдээ нэлээд анхаарч ажиллаж буйг нь уншигчид санаж буй байх. Гэр хорооллыг дахин төлөвлөхийг эрхэм гишүүн дэмжиж буй ч энэ ажлыг хийхдээ иргэдийн эрхийг зөрчихгүй, газрыг баталгаатай болгох ёстой гэсэн байр суурь илэрхийлдэг. Улстөрч бүр шахам нэг нэг сэдэв сонгож, мэргэшин, түүгээрээ имижээ бүрдүүлдэг болчихсон цаг. Гол нь ингэж “мэргэшсэний” хэргийг гаргаж, бодит ажил хийх учиртай. Түүний хувьд ийм сэдэв нь дахин төлөвлөлтийг эрчимжүүлэх, зөв зүйтэй хийх асуудал юм. Нийслэлийн ИТХ-ын гишүүн байсан,

гэр хороолол ихтэй дүүргийг төлөөлдөг учраас агаарын бохирдлын эсрэг санаа тавьж, энэ сэдвээр асуулга тавихаас ажлаа эхэлсэн аж.

Мөн Сонгуулийн хуулийн төслийг санаачлагчдын нэг. МАН-ын гишүүдийн өргөн барьсан уг төсөлд сонгуулийн саналыг гараар давхар тоолох зэрэг найман санал тусгасан юм. Хэлэлцүүлгийн явцад уг төслийг АН-ынхны санаачилсантай нэгтгэж, баталсан билээ. Үүнээс гадна эрүүл мэндийн салбарын шинэчлэлд чиглэсэн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг санаачилжээ. Уг төслийг УИХ батлаад байна. Орон нутгийн эрх мэдэл, санхүүгийн хувьд бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Татварын, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахаар саналаа Засгийн газарт хүргүүлсэн байна. Орон нутгийн анхан шатны үйлчилгээг иргэдэд хүргэдэг гол хүмүүс нь хэсгийн ахлагч нар байдаг. Тиймээс тэдний статусыг төрийн албан хаагч болгон өөрчлөх, нийгмийн асуудал, цалин урамшууллыг шийдэх зорилгоор Засгийн газрын холбогдох тогтоолд өөрчлөлт оруулахаар ажиллаж буй гэнэ.

Дүүрэгтээ бол тэр байнга ажилладаг, сонгогчдооо “олдоцтой” гишүүн юм билээ. Сонгинохайрхан дүүрэгт улсын төсвийн хөрөнгөөр барих цэцэрлэг, сургуулийн санхүүжилтийг шийдвэрлэхэд сонгосон гишүүний хувиар багагүй санаачилга гаргаж ажилласан аж. Тухайлбал, 24 дүгээр хорооны 640 хүүхдийн суудалтай, 124 дүгээр сургуулийн 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдэх талаар ажиллаж, мөнгө тусгуулснаар долоон жилийн турш хүлээгдсэн барилга ашиглалтад орж 3-5 км холоос сургуульдаа явдаг хүүхдүүд гэрийнхээ ойр сурч эхэлжээ. Нэг жил алдаж гишүүний бүрэн эрхээ баталгаажуулсан ч энэ мэтээр нөхөж, шаргуу ажилласан байна. Ямар ч байсан сонгогчдоос нь элдэв гомдол гаргасан гэж сонсогдоогүй.

УИХ дахь тамирчин гишүүдийн тоог нэгээр нэмсэн энэ эрхэм ШУТИС-ийг бизнесийн удирдлагаар төгссөн аж. 2005 оноос хойш спортоос гадна банк санхүүгийн салбарт хүч үзэж яваа бизнесмэн. Түүнийг намын удирдлагууд нь “Холын хараатай, чамбай залуу” хэмээн үнэлдэг. Ямартай ч их спортоос олж авсан нэр хүндээ улс төрийн салбарт сэвтүүлэлгүй, элдэв идсэн уусан асуудалд ороолдоогүй яваа гишүүдийн нэг.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Алмаликийн ТЛЕЙХАН

“ЭНЕРГЕТИК”



УИХ-ын гишүүн Алмаликийн Тлейханыг ингэж хэлдэг нь санамсаргүй хэрэг огт биш ажээ. Энэ нь түүний намтар, туулсан амьдрал, ажилтай салшгүй холбоотой юм. Эзэмшсэн мэргэжил, эрхэлсэн ажил, хамгаалсан сэдэв төдийгүй ажлынх нь хэв маяг, хувийн зан, төлөв байдал, амьдралынх нь хамаг утга учрын хураангуйг чухамхүү “энергетик” гэх цомхон үгээр илэрхийлж болно.

“Энэ хүний гарал үүсэл нь энергетик юм” гэж Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан Пунсалмаагийн Очирбат хэлж байжээ. Ажлын гараа нь цахилгаан станцын мастер, цехийн дарга, ерөнхий инженер, станцын дарга гээд шат дамжлага алгасалгүй цахилгаан “энерги”-ийг эзэмдэж байсантай холбоотой юм. Дараа дараагийн эрхэлж байсан, одоо ч эрхэлж буй ажил нь ч бас л “энергетик”-тэй холбоотой. Баруун аймгуудыг цахилгаанаар тогтвортой хангах, сонгогдсон тойргийн сумд, алслагдсан багийг эрчим хүчний нэгдсэн системтэй холбох, нарны эрчим хүчээр хангах зэргээр тойргоо, сонгогчдоо “энерги”-жүүлж яваа эрхэм хүн бол УИХ-ын гишүүн А.Тлейхан мөнөөс мөн.

Тэрбээр ямар ч ажил хийж, албан тушаал эрхэлж байсан тэдгээрийг их, бага гэхгүй хариуцлагатай бөгөөд шударга гүйцэтгэж ирсэн нь түүний төрөлхийн эрхэм мөн чанар билээ. Өөрийгөө магтаж дөвийлгөдөггүй, аялдан дагалддаггүй, далд атгаг санаа гаргадаггүй, арцалдаж явдаггүй, аливаа хүндрэл бэрхшээлийг хатамжлан давдаг чанараараа бусдаас ялгардаг. Хэзээ ямагт нэр цэвэр байдаг, элдэв өр төлөөсөнд баригдаагүй, болчимгүй үг хэлж боогдоогүй, бохир улс төрөөр барьцаалагдаагүй улстөрчдийн нэг яах аргагүй мөн билээ.

2008 онд Өлгийчүүдийнхээ итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр сонгогдсоноос хойш найм дахь жилээ байгаль орчинд хор хөнөөлгүй, эдийн засгийн хувьд үр ашигтай, шинэ техник, технологи бүхий эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгоход төрийн хүний бодлого, үйл ажиллагаа,

чуулганы индэрээс хэлсэн жинтэй үг, цэнтэй санаа болгон нь чиглэгдэж байв. Түүний санаачлан боловсруулсан, батлуулсан олон хууль, тогтоол, хөтөлбөр, төсөл нь “энергетик”-ээс хальж, хамрах хүрээ, сэдэв нь үлэмж өргөжиж, үнэнхүү төрийн бодлоготны өндөр хэмжээнд хүрснийг, төсөөлөх болсныг гэрчилж байна.

Сонгогчиддоо итгэгдэж сонгогдох, тэднийхээ итгэлийг даах гэдэг бол туйлын өндөр хариуцлага, хэмжээлшгүй үүрэг, нэр төрийн хэрэг гэж эрхэм гишүүн үздэг. Онцгой эрх ямба огт биш гэдгийг ч тэр бас сайн мэднэ. Сонгогдсон тойрог, хариуцаж байсан салбартаа хөндөөгүй сэдэв, шийдвэрлээгүй асуудал, дэвшүүлээгүй санал санаачилга, давж гараагүй бэрхшээл гэж түүнд үгүй. Сонгогчдын санаа бодол нь гишүүн өөрөө болон бусад гишүүдтэй хамтран санаачилж боловсруулан батлуулсан олон хуульд тусгалаа олжээ. Тойрог болон салбарын өмнө тулгамдсан олон асуудлаар бүтээн байгуулалт хийгдэж, хөрөнгө оруулалтаар ч шийдвэрлэсэн асуудал цөөнгүй юм. Тиймээс ч эрхэм гишүүний хууль тогтоох, бодлого тодорхойлохдоо баримталдаг гол чанар нь “Ардчилал, эрх чөлөөний гол тулгуур нь шударга хууль” байх ёстой гэсэн түүний хэлсэн үгэнд оршдог гэхэд бүрэн боломжтой.

УИХ-ын гишүүн Алмаликийн Тлейхан 2012 онд Удирдлагын ухааны докторын зэрэг хамгаалжээ. Сэдэв нь мөн л “энергетик”-тэй холбоотой байв. “Монгол Улсын эрчим хүчний салбарын менежментийг шинэчлэх асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний ажил нь салбарын өмнө тулгарсан асуудлыг мэдэрсэн, тулгуур асуудлыг хөндсөн, тэдгээрийгшийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн, салбарын өнгө төрхийг тодорхойлсон зэргээрээ цаг үеэ тун олсон сэдэв байлаа гэж мэргэжилтнүүд үнэлж таалан хүлээн авсан байдаг.

УИХ-ын гишүүн төдийгүй Монгол Улсын зөвлөх инженер хүний мэргэжлийн үг, санаа, зөвлөгөө, шийдэл Монголын эрчим хүчний салбарынханд үлэмж үнэ цэнэтэй байх нь лавтай. Тэрбээр Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төсөл санаачилж батлуулсан нь нийгмийн хариуцлагатай, ногоон эдийн засаг хөгжүүлнэ гэж ярьж буй өнөө цагт зөвхөн эрчим хүчний салбарын төдийгүй нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чухал хууль болсныг эрдэмтэн судлаачид, салбарынхан нь үнэлдэг юм билээ. Учир нь ийм хуультай болсноор эрчим хүч хэмнэх асуудал нь зөвхөн эдийн засгийн ач холбогдолтой ойлголт байхаа больж, тусгай мэдлэг шаардсан, гэрчилгээгээр баталгаажсан, нийгмийн хариуцлагатай холбоотой асуудал болж байна гэсэн үг юм.

Монголын төр УИХ-ын гишүүн А.Тлейханы салбараа хөгжүүлэхэд оруулсан их хувь нэмэр, салбарынхаа эрх зүйн орчинг зөв төлөвшүүлэх, салбартаа олон жил нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэснийг нь үнэлж Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан хэмээх эрхэм цол хүртээсэн нь аргагүй л нүдээ олсон шагнал юм.

“Энергетик” гэсэн үгийг түүнд хамаатуулж хэлдэг нь бас нэг учиртай. Энэ нь Тлейханы гишүүний ажилд хандах хандлага, ажлын эрч хүч буюу энерги, хэв маягтай шууд холбоотой. Чухам л эерэг “энерги” цацруулсан, бусдыг эерэг энергиэр энэрэх сэтгэлтэй, удистай хүнийг бас “энергетик” гэж хэлдэг. Алмаликийн Тлейхан бол тийм ховор хос “энергетик”-тэй хүн яах аргагүй мөн.

Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн ТҮВДЭНДОРЖ

ТӨЛӨВ ТҮВШИН ТӨРИЙН ХУУЛЬЧ



Ш.Түвдэндорж 1984 онд Ардын армийн 124 дүгээр ангиас ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж, 1990 оныг хүртэл салаан захирагчаар ажиллаж байгаад Ардчилсан хувьсгалын үйл хэрэгт манлайлан оролцсоноор улс төрд хөл тавьжээ.

Тэсгим хүйтэн өвлийг “Хонхны дуу”-гаар сэрээж, төрийн эрх баригч нэг намын ноёрхлыг эцэслэх, жирийн иргэний эрх чөлөө, ардчиллыг түүчээлэх зорилготой залуусын жагсаал нийслэлийн төв талбайн жаврыг үргээснээс хойш 26 жил өнгөрчээ. Энэ хугацаанд уугуул, удаахь гэгддэг Ардчилсан нам, МАН-ынхан ээлж дараалан, эвсэж хамтарсаар төрийн эрхийг залуурдсан ч тэдний дундаас гарын арван хуруунд багтам цөөн тооны улстөрч тодорч гарсан. Жишээ нь, эрх баригч Ардчилсан намаас гэхэд УИХ-ын гишүүн Ш.Түвдэндоржийг дурдаж болно.

Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалд оролцож явсан анхны партизануудын нэг тэрбээр өдгөө УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дэд даргын албыг хашиж буй. Үүнээс өмнөх түүхийг нь сөхвөл 1990 оноос хойш Ардчилсан намын анхан шатнаас удирдах байгууллага хүртэл тасралтгүй ажиллажээ. Ингэхдээ Ардчилсан хувьсгалын гол зүтгүүр гэгддэг МоАХ-ны өрхийг таталцахаас эхлээд дарга, гүйцэтгэх захирал, Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргаар хоёр удаа, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, нийслэлийн Ардчилсан намын даргаар ажиллаж байв.

Ш.Түвдэндорж 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Ардчилсан намаас нэр дэвшин намын жагсаалтаар УИХ-ын гишүүнээр сонгогдож, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажилласан. Улмаар 2014 оны 12 дугаар сар хүртэл Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар ажилласан байв.

Тэрбээр Батлан хамгаалахын сайдаар ажиллаж байхдаа салбарын нийгмийн асуудлыг цогцоор нь шийдэж, энхийг дэмжих хүчний анхны албан хэлэлцээрүүдийг үзэглэж байлаа. Харин түүнийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар ажиллах

хугацаанд Монгол Улс 55 жилийнхээ түүхэнд байгаагүй их ургац хурааж, мал сүрэг нь 60 саяд дөхсөн сайхан мэдээтэйгээр 2015 оныг угаж байв. Салбарын сайд заавал мэргэжлийн хүн байхаас илүүтэй сайн менежер, стратегич байхад ямар үр дүнд хүрч болдгийг Ш.Түвдэндорж гишүүн өнгөрснөөс өнөөдрийг хүртэл хугацаанд хуримтлуулсан туршлагаараа харуулсан нь энэ.

Хүн бүр төдийлөн мэддэггүй, тэр өөрөө бусдад сайрхаж ярьдаггүй болохоос Ш.Түвдэндорж гишүүнд юмны эв зөийг олдог чанар бий. Тэрбээр УИХ-ын гишүүн болохоосоо өмнө нийслэлийн Ардчилсан намыг удирдаж байв. Энэ хугацаанд хоёр тамгатай болтлоо хуваагдаж, хэн нь дарга гэдэг нь мэдэгдэхгүй явсан Нийслэлийн есөн дүүргийн намын хороог нэг гарт зангидаж, 2012 оны нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиас өмнө нэг шугамаар алхах болсон нь түүний удирдах чадвар, зарчимч шаардлагын үр дүн гэж хэлж болох юм. Мөн 1996-2000 онд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ажилласан туршлагадаа тулгуурлан нийслэлийн Ардчилсан намын хорооноос “5А” хөтөлбөрийг тугаа болгон оролцох санал санаачилга боловсруулж дараагийн удирдлагадаа хүлээлгэж өгснөөр анх удаагаа Ардчилсан нам хотыг багаараа удирдах болж ялалтад хүрсэн нь Ш.Түвдэндорж гишүүнтэй салшгүй холбоотой. Тэрбээр “А” хэмээх анхдагч үсгийн дор “Агаар нь цэвэр, амины сууцтай, ажил орлоготой, аюулгүй амгалан, авлигагүй Улаанбаатар” гэсэн олон зүйлийг шинээр бодож, төлөвлөж эхлүүлэх, бас хийж бүтээх хөтөлбөрийн суурийг Ардчилсан намын хорооны даргаар ажиллаж байхдаа тавьсан гэдэг. Түүний боловсруулсан “5А” хөтөлбөрийг ч Э.Бат-Үүл баатрын баг чанартай, гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.

Ийм л нэгэн хуульч мэргэжилтэй стратегич түшээ Монголын улс төрийн өрөг дээр сууж, өөрийн нүүдлийг хийсээр дөрвөн жилийг ардаа үджээ. Олон улсын “Transparency” байгууллагаас гаргадаг авлигын индексээр Монгол Улс сүүл мушгиж, Мөнгө угаах гэмт хэргийн эсрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын холбоо “ФАФТ”-ын “саарал жагсаалт”-д орно гэдэг Монголын эдийн засгийн хувьд мэдээж муугийн дохио гэдгийг энэ салбарынхан андахгүй. Азаар Ш.Түвдэндорж гишүүн Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачлан УИХ-д өргөн барьж батлуулснаар “саарал жагсаалт”-д орох эрсдэл биднийг тойрон өнгөрч байсан билээ.

Улстөрчдөөс хамгийн их шүүмжлэл дайдаг, зарим нэгнийх нь шар үсийг босгодог Авлигын эсрэг хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Ш.Түвдэндорж гишүүн санаачлан боловсруулж ихээхэн үүрэгтэй оролцсон. Энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар “цагаан захтан”-уудад хэтэрхий хатуудсан хууль болсон хэмээгдэж одоогийн Авлигатай тэмцэх газрын хүч нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн гэх шүүмж байдаг ч Ш.Түвдэндорж гишүүн өөрийн байр сууриндаа хатуу зогсохоо, авлигын эсрэг хатуу тэмцэхээ илэрхийлсээр өнөөдрийг хүрч байна. Энэ бол түүний төрд хэрэгтэй хуульч, бас сайн стратегич гэдгийн илрэл юм.

---oooOooo---

Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН

ШИНЭЧЛЭГЧ



УИХ-ын 2012 оны ээлжит сонгуулийн дараа байгуулагдсан Н.Алтанхуягийн тэргүүлсэн Шинэчлэлийн Засгийн газарт түүний танхимын гишүүд дотроос “шинэчлэл” гэдэг үгийн мөн чанарыг хамгийн тодоор нийгэмд харуулсан хүн бол Хууль зүйн сайд, УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин. Хоёр жил хагас энэ салбарыг тэргүүлэхдээ хорин жил хөндөөгүй хуулийн салбарын суурийг хөдөлгөж, эрх зүйн шинэтгэлийг иж бүрнээр нь эхлүүлсэн юм.

Хуулийн байгууллагуудын үүд хаалгыг дэлгээд “Иргэндээ үйлчил, эрх мэдлээ хянуул. Хууль хүний төлөө байдгаас хүн хуулийн төлөө байдаггүй” гээд явахаар өөрийгөө “цаасгүй хууль” гэж эндүүрч явсан зарим нь тийм ч таатай хүлээж аваагүй. Олон жил өөрөө өөрийгөө хамгаалаад тогтчихсон, бусдын эрх чөлөөг болохоор санааны зоргоор хязгаарлаад сурчихсан, төрийн нэрээр албадлага хэрэглэх эрхтэй, хэнийг ч хэн болгож чадах эрх мэдэлтэй хууль, хүчний байгууллага руу ганц хүн явж ороод улаан гараараа бүгдийг өөрчилнө гэдэг хэр их эрсдэлтэй болохыг Хууль зүйн сайд нь өөр дээрээ харуулсан.

Үнэн хэрэгтээ Н.Алтанхуягийн Засгийн газрыг огцруулахад хүрсэн нэг шалтгаан нь Хууль зүйн сайд нь Х.Тэмүүжин байсан явдал. “Хуульгүй байсан газар хууль үйлчлээд эхлэхээр хуульгүй юм шиг амьдарч байсан хүмүүс хамгийн ихээр эсэргүүцэж босдог” гэж өөрийнх нь хэлсэн үг бий.

Гэсэн ч өөрчлөлт шинэчлэлийг заавал албан тушаалын арангаар хийдэг юм биш. Сэтгэл зүтгэл, итгэл үнэмшил байгаад зарчим дээрээ хатуу зогссон цагт зорилгодоо хүрч болдог гэдгийг тэр өөрийн биеэр үлгэрлэсэн. Хууль зүйн сайдын албан тушаалаас буусан ч өмнө нь санаачлан боловсруулсан хорь гаруй хуулийн төслөө үзэл баримтлал, зарчмыг нь алдагдуулалгүй дараагийн Засгийн газраар дэмжүүлэн УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан байдаг. Тэдгээрээс Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах

тухай гэсэн дөрвөн том хуулийг сүүлийн нэг жил зургаан сарын дотор УИХ-аар хэлэлцүүлж батлуулжээ. Эрүүгийн эрх зүйгээр мэргэшсэн эрдэмтэд, судлаачид, хуульчид, багш нар гээд шинжлэх ухааны том баг ард нь ажиллаж байв. Эдгээр хуулиудыг баталснаар Үндсэн хуулинд тунхаг төдий байсан иргэний эрх, эрх чөлөөний тухай заалтууд сая “амь орж”, хүний салшгүй эрх болж баталгаажсан юм.

Тиймээс эдгээр хуулийг баталсан энэ удаагийн парламентын түүхэн гавьяа, Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталсны дараа орохуйц эрх зүйн томоохон шинэтгэл болсныг хууль эрх зүйн салбарын эрдэмтэн судлаачид, хуулийн салбарынхан үнэлж, талархан хүлээн авсан байдаг.

Нэг үеэ бодвол Монголын парламентад хуульч мэргэжилтнүүд жин дарж эхэлж байна. Тэр дундаа мэргэшсэн хуульчид, судлаачид, өөрийн орны эрх зүйн тогтолцоог хөгжсөн бусад орны эрх зүйн тогтолцоотой харьцуулсан судалсан нь бас ховор. Харин Х.Тэмүүжин гишүүний хувьд хуулийн салбарт тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх, амьдарч байгаа нийгмийнхээ хэрэгцээ шаардлага, эрх зүйн хөгжлийн олон улсын стандарт, дэлхийн нийтийн хөгжлийн чиг хадлагад нийцүүлэн өөрчилж, шинэчлэхэд амьдралынхаа олон жилийг зориулж яваа мэргэшсэн цөөхөн хуульчдын нэг.

Дипломын боловсролтой хуульч, мэргэшсэн хуульч хоёрын ялгаа энэ. Үүгээрээ тэр парламентын бусад хуульчдаас ялгардаг. Тиймээс өнгөрсөн дөрвөн жилд иргэд, сонгогчдын зүгээс түүнд өгсөн үнэлэмж, өөртөө бий болгосон имиж нь ШИНЭЧЛЭГЧ Хишигдэмбэрэлийн ТЭМҮҮЖИН...

---000000---

Улсын Их Хурлын гишүүн Дэндэвийн ТЭРБИШДАГВА ЛИДЕР ҮҮ, ЛОЙДОР УУ?



Д.Тэрбишдагва 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ийн бүлгээс нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн тойрогт нэр дэвшиж өрсөлдөн ялалт байгуулж, нийслэлийн хамгийн олон хүн амтай, тэр хэрээрээ асуудал ихтэй, энэ тойргоос гурав дахь удаагаа сонгогдсон төрийн түшээ.

Юун түрүүнд эрхэм түшээ парламентын гишүүний суудлыг эрх мэдэл биш, элч зарц гэж өөрөөр харж чаддагаараа бусдаас ялгарна. Сэтгэлгээний зөв хандлага нь төр, түмний төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэхийн үндэс нь болсоор иржээ. Тиймдээ ч өнгөрсөн хугацаанд тэрбээр үндэснийхээ аюулгүй байдал, тусгаар тогтнол, байгалийн баялаг, орчны бохирдол, гадаад бодлогод онцгойлон анхаарч, хуулийн төсөл боловсруулах, ажлын хэсэгт ажиллах зэргээр ханцуй шамлаад зүтгэдэг “хэнхэг” нөхөр. Ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн салбарын хуулийг хэлэлцэн батлахад эрхэм түшээгийн хичээл зүтгэл, нөлөө их. Монголчуудын эрүүл мэнд, цаашлаад үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх учир хүнсний чанарын асуудалд ангидаа түүн шиг сэтгэлээ чилээдэг нь ховор. Хүнсний технологич мэргэжилтэйн зэрэгцээ Хүнс, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсны хувьд мал аж ахуй, газар тариалан, хүнстэй холбоотой салбарын асуудал хэлэлцэх үед ангийнхан нь түүний амыг л хардаг. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн биржийн тухай, Хүнсний аюулгүй байдлын тухай хууль, “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”, “Монгол мал” хөтөлбөр, “Бэлчээрийн тухай” хуулийн төслүүдийг санаачлахаас эхлээд энэ салбарын тухай хэлэх үг нь жинтэй, хийсэн ажил нь даацтай байдаг.

Зөвхөн хүнс ч биш монголчуудын эрх ашиг, олонхийн ашиг тустай асуудалд тэрбээр амаа жимийж, гараа хумьхин өнгөрөөж сураагүй “зөрүүд” эр. Тиймдээ ч

ангийнхандаа “эсэргүү” гэгдэхээс ч үл зүрхшээн олны, түмний эрх ашиг хөндөгдсөн асуудалд тууштай байр сууриа илэрхийлж, өөрийг нь чиглэсэн хатуу үгийн зэвийг ч үл тоодог. Үүний нэгэн жишээ гэхэд улстөрчдийн байр сууриа илэрхийлэхээс хамгийн ихээр жийрхдэг Оюутолгойн асуудалд тэрбээр анхнаасаа эсрэг кноп дарж ирсэн. Тухайлбал, 2008 оны Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан дээр гэхэд “Монголчууд Оюутолгойн гэрээний төсөл үнэхээр тааруу, эргээд амаа барихаар зүйл их байна. Эрдэмтэн, судлаачдынхаа үгийг сонсооч ээ” гэдгийг хэлж байр сууриа илэрхийлж байсан нь хэвлэлийн хуудаснаа түүх болж үлджээ. Өнөөг хүртэл энэ байр сууриа өөрчлөөгүй. Үүнийг нь Н.Алтанхуягийн Засгийн газарт Шадар сайд байхдаа өөрийг нь чиглэсэн их эсэргүүцлийн шуургыг сөрөн байж, танхимынхаа хоёр сайдтай хүчээ нэгтгэн Оюутолгойд санхүүгийн шалгалтыг оруулж, давхардсан тоогоор 3,2 тэрбум ам долларын зөрчил илрүүлж байснаас харж болно.

Тэрбээр энэ хугацаанд 40 гаруй хуулийн төсөл санаачлан боловсруулж батлуулснаас нь харахад УИХ-ын гишүүнээс жинхэнэ оюуны бяд, цаг зав, тэвчээр хөдөлмөр зарсан үндсэн ажилдаа хэр мэргэшнийг нь илтгэнэ. “Уул уурхайн хөгжил” түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоол, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Ард нийтийн санал асуулга явуулах тухай” УИХ-ын тогтоол, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Газрын тос, ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай гээд түүний нэрээр овоглогсон хууль тогтоомжийн төслүүдийг тоочвол олоон.

Д.Тэрбишдагва гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд Сонгинохайрхан дүүргийн иргэд, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагууд болон бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажилтан алба хаагчидтай 1300 орчим удаа уулзалт, хурал зохион байгуулж давхардсан тоогоор 100 мянга гаруй хүнтэй биечлэн уулзсан нь тойрогтойгоо хэрхэн тулж ажилладгийг нь харуулна. Өөрийн санаачлагаар болон улсын төсвийн хөрөнгө оруулалт, нийслэл, дүүргийн төсөв, орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн олон ажлууд түүний нэрээр овоглогдсоныг тоочоод барамгүй.

“Албан тушаалыг хариуцлага гэж хардаг” учраас тэрбээр Монгол Улсын Шадар сайдын албанд томилогдон ажиллахдаа нийгэмд нэгэн шинэ өнгө, шинэ хандлагыг түгээсэн. “Дэгтэй монгол, дэлхийд манлайлна” хэмээн зарлахдаа хөрөнгө мөнгө зарахгүйгээр Монголын нийгэмд ус, агаар мэт үгүйлэгдсэн хариуцлагын асуудлыг шийдэж болох гарцыг хэлсэн нь энэ. Танхимын тэргүүн нь “эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг” гэж онцолж байхад мань эр л “Хариуцлага, хариуцлага, хариуцлага” хэмээн анхааруулж сахилга, хариуцлагагүйгээс болж хичнээн их хөрөнгийг үргүй зарж, хичнээн их боломж алдаж, хөгжлийн суурийг чангаагч болсныг хэлж чадсан нэгэн.

Улстөрчийнхөө хувьд ч хийсэн алхам, хэлсэн үгэндээ хариуцлагатай нэгэн. 2016 оны парламентын их сунгааны эхэнд түүний хэлсэн “Лидер үү, лойдор уу гэдгээ тойрогт нэр дэвшиж харуулах хэрэгтэй” гэсэн үг улстөрчдийн дунд афоризм болоод байгаа. Үүгээрээ өөртэй итгэлтэй, хүчтэй улстөрч гэдгээ харуулсан юм.

Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн УЛААН

ШУДАРГА ЖУРАМТ ТҮШЭЭ



Ч.Улаан сайд хар залуугаасаа л Монгол Улсын санхүү, эдийн засгийн албыг Үндэсний хөгжлийн газар гэж байхаас нь удирдаж, энэ улс орны хөгжлийг өнөөдрийн өндөрлөгт хүртэл нь үүрэлцэж, хөгжлийн оргилд ялалтын туг хатгахын төлөө зүтгэсэн хүний нэг яах аргагүй мөн юм. Ерөөсөө аливаа орны эдийн засагчдын нэг алтан дүрэм нь улсын сан хөмрөгийг арвижуулах, мөнгөний үнэ цэнэ ханшийг чамбайруулж чангаруулах, бүр болдоггүй юмаа гэхэд нэгэн түвшинд барьж тогтоох арга механизмыг бий болгох явдал. Нөгөө нэг тал нь мөнгийг зориулалтын зүйлд нь зөв зохистой зарцуулах арвилан хэмнэлтийн зарчмыг алхам тутамдаа мөрдөх, гүйцэтгэлд нь тавих хяналт шалгалт, аливаа ажлын чанар, үр ашгаар эцсийн бүтээгдэхүүнийг хэмжиж дүгнэхээс л санхүүч хүний хэн болох нь тодордог. Энэ шалгуурыг хангаж, ард түмнийг гэдэс цатгалан, мөр бүтэн авч явах эсэх нь Сангийн сайд ямархан сэтгэхүй, тархи толгойтой хүн байхаас шууд хамаардаг учиртай.

Монгол Улсын эдийн засгийг гадаад хийгээд дотоодод тэлж өсгөсний ач буянаар ОХУ-д төлөх их өрийг барагдуулах угтвар ажил, эдийн засгийн орчинг бүрдүүлж монгол хүний мөс яс, итгэл найдвараар дүүргэсэн хүний нэг бол мөнөөх Ч.Улаан сайд. Үндэсний хөгжлийн газрыг оролцуулан тооцвол үндсэндээ Монгол Улсын сан нөмрөг болсон Сангийн сайдаар дөрөв дэх удаагаа томилогдсон энэ түшээ улс орны хөгжлийн зам мөр дээрх саад бэрхшээлийг нь засч алхам бүртээ орлогын шинэ эх үүсвэрүүдийг нээж, олж байсан уу гэхээс биш өнөөдрийн Засгийн газар шиг өр зээлэндээ баригдаж яваагүйг ард олон мэднэ.

Монгол Улс хол, ойрт алдартай олон сайн эдийн засагч, санхүүчтэй ч нэг хүн Сангийн сайдаар ийм олон удаа томилогдоно гэдэг бол яахын аргагүй шалгарал юм. Үүнд Сүхбаатарчууд Ч.Улааныг дандаа сонгож төрд илгээж байсан, Улаан ч ард иргэдийнхаа итгэлийг дааж зүтгэж ажилласны үр дүн биз ээ. Гэхдээ улс орны

эдийн засаг хүндэрч, энэ байдлаас гарах гарц хомс бүрхэг бүрэнхий болсон үед л эдийн засгийн жолоо цулбуурыг Ч.Улаан сайдын гарт шилжүүлж байсан нь яалт ч үгүй үнэн юм.

Монголд “Төрийн сан” гэдэг олон түмэнд өгөөж наалдацтай том газрыг анх байгуулсан хүн нь бас л Улаан сайд. Төрийн сан бол түүний оюуны том бүтээл, нэрийн хуудас юм. Эрдэмтэн мэргэдүүдийг цуглуулж, улс орны эдийн засгийн багц асуудлыг шинжлэх ухаанчаар удирдах, эрүүлжүүлэх, хөгжүүлэх Үндэсний хөгжлийн хүрээлэнг анх бас л Улаан сайд сэдэж санаачилж байгуулжээ. Түүнийг Сангийн сайдаар ажиллах арван хэдэн жилийн хугацаанд Монголын үндэсний мөнгөн тэмдэг өнөөдрийнх шиг ийнхүү амьсгал хураах цаг мөчөө хүлээн сэхээн амьдруулахын орон дээр хэвтэлээ ханш нь унаж, өргөн хэрэглээний ойр зуурын бараа таваарын өртөг үнийн галзуурал хэмээх халдвартай өвчинд нэрвэгдэж байгаагүйг хүн бүхэн мэднэ.

Тэрбээр ямарч үед ар хормойгоо авч урьд хормойгоо нөхөхийг тэвчдэг. Том эрх ашгийн төлөө толгойгоо тавьж тоглохоос буцдаггүй араншинтай шударга нэгэн. Тийм учраас улс орныхоо төлөө, бусдын төлөө өөрийгөө золиосолж чаддаг эх оронч эр зориг нь түүнийг олон олон гал, усны аюултай улаан нүүрээр нь учруулсан түүхтэй. Үүнээс цөөн хэдэн тохиолдлыг дор сийрүүлбээс Ч.Улаан гэдэг хүний хэн болох нь тодрох биз ээ.

1971 оны 12 дугаар сарын 31. Гэр хороололд гарсан гал түймрээс дөрвийн дөрвөн хүүхдийг гаргаж, айлын тавилга, эд хогшлыг нь зөөж аварсан байдаг.

1995 оны 6 дугаар сар. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон голын эрэгт 10 дугаар анги төгссөн хүүхдүүд зугаалж яваад үерт автжээ. Гадаадын зочин авч явсан Сайд Ч.Улаан газар дээр нь шуурхай арга хэмжээ авч, хотоос нисдэг тэрэг дуудаж, аймгийн төвөөс цэргийн хөвөгч БТР авчруулж аврах ажиллагааг шуурхай зохион байгуулсан байдаг.

2000 оны 6 дугаар сар. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын “Хундар” багийн нутагт гарсан хээрийн түймрийг унтраах ажиллагаанд нутгийн иргэдийн хамт өдөржин, шөнөжин ажиллаж, гар аргаар түймэр цохиж унтраалцаж явжээ.

2008 онд 6 дугаар сар. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум “Хонгор” багийн төвд усны үерт автсан айлыг аврах ажлыг зохион байгуулан оролцож байжээ.

2010 оны 06 дугаар сарын 1. Сэлэнгэ аймгийн нутаг Ерөө голын үерт урссан гурван хүүхдийг хөлгүй цүнхээлд орохынх өмнө амжиж аварсан учир Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Шударга журам” медалиар шагнагдсан байна.

Эдүгээ хүний мөс, яс муудсан цөвүүн цагт үерийн эргэлдсэн улаан ус руу “хүний амь” гэсэн бодлоос өөр сөхөөгүй үсрэн ордог “төрийн сайд” байтугай Онцгой байдлын ажилтан ч тийм ч олонгүй биз гэж бодогдоно.

Улаан сайд бол Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн гол гогцоо асуудлуудыг багцлан нэг гарт төвлөрүүлж, улс орныхоо хөгжлийн эрчлүүрийг хурдасгах эх үүсвэр болсон эдийн засгийг эрүүлжүүлж, түүний бааз суурь, хүч чадлыг нэмэгдүүлэхийн төлөө зүтгэж яваа ард түмэн, төр засагтаа хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч, улс төрийн зүтгэлтэн, төрийн дархан түшээ билээ.

Балжирын ДОГМИД

*(Ардын уран зохиолч, Төрийн шагналт,
Соёлын гавьяат зүтгэлтэн)*

Улсын Их Хурлын гишүүн Гантөмөрийн УЯНГА

ҮЗЭЛ САНААГ ЭРХЭМЛЭГЧ



Гантөмөрийн Уянга үндэсний үзлийг сэргээх, шинэ Үндсэн хуулийг батлуулахын төлөө тууштай тэмцэгч гишүүн. Улс төрийн алхам, үйлдэл, хөдөлгөөнийг нь ажиглавал намын эрх ашиг, улс төрийн сонирхлоос илүүтэй үзэл санааг дагадаг улстөрч болох нь тодордог. Үзэл санааны хувьд үндэсний суурьтай, ардчилсан чиг баримжаатай. Аливаа асуудалд улс үндэсний эрх ашгийг нэгдүгээрт тавьж, Монголын өөрийн онцлогт нийцсэн ардчилсан дэглэм тогтоох талаар хүчтэй ярьдаг нь зарим талаар хэт барууны чиг баримжаатай улстөрч гэж ойлгогдохоор байдаг ч нөгөө талаас өмнөх нийгмийн үеийн сайн ололттой талуудыг хадгалж үлдэх, төрийн уламжлалт шинж чанарыг таслахгүй байхыг чухалчилдаг нь цэвэр монгол төвтэй улс төрийн бодлогыг эрхэмлэгч болгож харагдуулдаг. Энэ чанараараа баруун, зүүний үзэл баримтлалын төвд үндэсний улс төрийн бодлогыг чухалчилж байршуулах сонирхолтой нь тодордог.

УИХ-ын гишүүн Г.Уянга бол улс төрийн хүчний хуваарилалтад шинээр түрж орж ирсэн Иргэний хөдөлгөөний удирдагчдын нэг, улс төрийн шинэ хүчний төлөөлөл. Монголд өрнөсөн иргэний шинэчлэлийн хөдөлгөөнд идэвхтэй манлайлан оролцохоосоо өмнө ч улс төрийн хүрээнд танигдсан. Одоо Тусгаар тогтнол эв нэгдлийн нам, Монголын Ногоон намын “Тусгаар тогтнол-эв нэгдэл” эвслийн тэргүүнээр ажиллаж байна.

Тэрбээр гадаадын хөрөнгө оруулагчидтай хийсэн гэрээнд үндэсний эрх ашгийг түлхүү хангах тал дээр хатуу, тууштай чиг шугам баримталдаг нь УИХ-ын гишүүдээс ялгаатай харагдуулдаг. Иргэний хөдөлгөөний тэмцлийн анхны чиг шугамаас өчүүхэн ч гажаагүй, тууштай тэмцэгч гэдгээрээ алдаршжээ. Мөн иргэний хөдөлгөөнүүд, иргэдийн зохион байгуулалттай санал санаачлагыг парламентын түвшинд татан оруулж, хэлэлцүүлэх замаар иргэдийн оролцоог төрийн бодлого шийдвэрт тусгаж хангах тал дээр бүхий л боломжоо дайчлан ажиллаж иржээ.

Иймээс парламентын гишүүн болсон цагаасаа судалгааны байгууллагуудаас зарладаг улстөрчдийн рейтингийн судалгаанд шилдэг 10 улстөрчийн эгнээнд байнга тогтвортой тэргүүлэгч байр суурьтай явж ирсэн байна.

Оюутолгойн гэрээнд засвар оруулж, Монголын талын хувь эзэмшлийг нэмэх, тус компанийн хөрөнгө оруулалтын зардалд хатуу хяналт тавьж, татварыг нарийвчлан тооцож авах, хөрөнгө оруулалтын өндөр хүүтэй зээлийн үйлчилгээнээс татгалзах замаар монголын талд ноогдох хөрөнгө оруулалтын нөхцөлийг хөнгөрүүлэх, өрийн дарамтыг бууруулах, монголын талын ашиг, эрх ашгийг нэмэх чиглэлээр ихээхэн чармайлт гаргаж ажилласан гишүүн. Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийг томилогдоход “Хэрэв Оюутолгойн гэрээний нөхцөлийг муутгасан алхам хийвэл огцруулах асуудлыг тавина” гэдгээ анхааруулж байсныхаа дагуу Дубайн гэрээг баталмагц Засгийн газрыг огцруулах асуудлыг тавьж, шаргуу ажилласны эцэст асуудлыг УИХ-аар хэлэлцүүлж байв. Бүлгийн дэмжлэггүй боловч өөрийн хувийн нэр хүндээр Засгийн газрыг огцруулах асуудлыг хэлэлцэх тооны гарын үсгээр баталгаажсан санал цуглуулсан явдал парламентын түүхэнд байгаагүй юм.

Дээр нь Оюутолгойн гэрээний асуудалтай холбоотой байж болзошгүй улстөрчдийн гадаад дахь үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн хөдөлгөөний талаарх мэдээллийг олон нийтэд ил болгож, хариуцлага тооцохыг Авлигатай тэмцэх газар болон холбогдох газруудаас шаргуу шаардаж шахаж ажиллажээ. Мөн Гацууртын ордыг ашиглахад түүхийн үнэт өв Ноён уулын хүннүгийн булш бунхан сүйдэх аюултайн дээр ой, голын сав, байгаль орчинд хөнөөлтэй гэж үзэн эсэргүүцэж байв. Хүүхдийн мөнгө, эхчүүдийн одонгийн мөнгө зэрэг нийгмийн халамжийг хасах тухай Засгийн газрын саналуудыг зогсоож, эмэгтэйчүүдийн бүлгийн хүрээнд нийгмийн хамгааллын болон хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр санаачлагатай ажилласан гишүүн. Энэ хугацаанд Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан агаад “Төрөөс аж үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай”, Монгол хэлний тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Хотыг дахин хөгжүүлэх тухай зэрэг олон хууль тогтоомжийн ажлын хэсэгт орж ажиллажээ. Мөн Ард нийтийн санал асуулга явуулах тухай, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 24 хуулийг хамтран өргөн мэдүүлсэн байна.

Парламент дахь олон нийтийн хяналтыг бодитой болгож, томоохон орд газруудыг ашиглах гэрээ хэлэлцээртэй холбоотой баримтууд, шалгалтын дүн, Төв банк болон төрийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой олон баримтуудыг нийтэд мэдээлж, холбогдох байгууллагуудад шалгуулахаар хандаж, хэрэгжилтийг шахаж иржээ. Олон нийтэд ийм хэмжээний мэдээлэл өмнө нь хүрч байгаагүй бөгөөд өнгөрсөн парламентын бүрэн эрхийн хугацаанд олон нийт улс орны хэмжээний бодлогын болоод хяналтын баримт бичгүүдтэй танилцах, түүнийг ил тод хүлээн авах боломж бүрдсэн юм.

Г.Уянга гишүүний байнга шаардаж ирсэн Монгол Улсын Үндсэн хуулийг өөрчлөх асуудал анх удаа энэ парламентын үед нээлттэй хэлэцүүлэгт орсон юм. Мөн хугацаанд IV Үндсэн хуулийн түүхэнд анх удаа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж парламентад нээлттэй тайлан тавьсан нь Г.Уянга гишүүний шаардлагатай холбоотой байв.

Тэрбээр Монгол Улсад “удирдагч, эмх цэгц, зохион байгуулалт” хэрэгтэй гэдгийг байнга сануулж, мэдэгдэж байв.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины ХАЯНХЯРВАА

ИХ-УУЛЫН УУГУУЛ, ИХ ДАРХАНЫ СУУГУУЛ



Газар газрын залуусын сэтгэлийн дуудлагаар Бурхантын хөндийд бууриа зассан Дархан хотын хөгжлийн түүхтэй Дамдины Хаянхярваагийн 30 гаруй жилийн амьдралын зам салшгүй холбоотой. Москва хотын Удирдлагын дээд сургуульд эдийн засагч мэргэжил эзэмшин 1986 онд Дархан хотын Угсармал барилга үйлдвэрийн нэгдлээс ажлын гараагаа эхэлж байсан тэрбээр төрийн албаны анхан шатнаас хууль тогтоох дээд байгууллага хүртэл төрийн албанд зүтгэсээр явна.

“Хууль тогтоох дээд байгууллага УИХ-д орон нутгийн амьдрал мэдэх, төрийн албаны туршлагатай гишүүд ус агаар мэт хэрэгтэй байдаг юм. Энэ шаардлагад бүрэн дүүрэн нийцэж байгаа гишүүдийн нэг нь яах аргагүй Д.Хаянхярваа. Тэрбээр УИХ-ын гишүүнээр сонгогдсоноор хүнийхээ хувьд асар их өслөө. Шүүмж сонсож, үг дуулж сурлаа, хат сууж хашир нэмлээ. Сэтгэлгээний цар хүрээ тэлж, мэдлэг боловсрол чамбайрав” хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгч асан Нацагийн Багабанди түүнийг үнэлсэн нь бий.

Д.Хаянхярваагийн унасан газар угаасан ус нь Завхан аймгийн Их-Уул сум. Төрж өссөн нутаг гэдэг хүний сэтгэлд он цагтай цуг татаж орхисон аргамжаа мэт байдаг хэдий ч цаг хугацаа өнгөрөх тусам хаана, ямар нутаг усанд амьдралын сайхан үе нь өнгөрсөн байна, тэр л газрынх нь хөнгөн дурдатгал сэв сэвхийн байнга орж ирнэ. Дарханаа хотын жишгээр хөгжүүлэхсэн, тэр зиндаанд нь ойртуулах юмсан, хотын гэх тэр жаягийг нь хөгжүүлж төлөвшүүлэхсэн гэсэн бодол түүнд байнга уяатай байж аймгийн Засаг дарга болсноосоо хойш мөрөөдөж байсан зүйлээ ажил болгож эхэлжээ. 2001 онд 10 жил хуримтлагдсан Дарханы хур хогийг 14 хоногийн хугацаанд цэвэрлэж, өнөөх л сэтгэлийн мухарт хадаатай байсан хотын соёл, жишиг хотыг бий болгохоор зорьж эхэлсэн байдаг. Орон сууцны дээвэр, зоорийн давхрын сантехникийн шугам сүлжээ,

хорооллын доторхи болон нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилт, сумдын дэд бүтцийг сайжруулах, сургууль цэцэрлэгийн өргөтгөл, гэр хорооллын гэрэлтүүлэг гээд аймгийн удирдлагуудад шийдэх асуудал бишгүй их. Аймгийн Засаг даргаар ажилласан 8 жилийн хугацаанд нь Дархан хотод “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн, “Морин хуур” цогцолбор, Бурхан багшийн сэрэг дүр бүхий Бурхант толгой, Монгол Улсын анхны дүүжин гүүр гээд бүтээн байгуулалтууд Дарханчуудын дэмжлэг, оролцоотойгоор хийгдэж, өнөө ч орон нутгийн нэрийн хуудас болсоор байна.

УИХ-ын гишүүнээр сонгогдож төр түшилцсэн өнгөрсөн 8 жилийн хугацаанд танхимын гишүүд нь “Манай Хаян бие бага ч бэлчээр томтой нөхөр шүү” хэмээн ярих нь олонтаа. Чуулганы танхимд орон нутгийнхаа дуу хоолой болохын зэрэгцээ улс эх орны төсөв санхүү, эдийн засгийн бодлого тодорхойлох, хууль санаачлах болон хэрэгжүүлэх ажилд идэвхитэй ажилладаг нь дээрх үгийг хэлэх гол шалтгаан болдог биз ээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг орон нутагтаа татах, нэг ч болов цэцэрлэг, сургууль шинээр барих, зам харгуйг засах мөнгийг шийдүүлэх нь орон нутгаас сонгогдсон гишүүн бүрийн хүсэл байдаг. Төсөв хэлэлцэх үеэр Увс, Дархан-Уул хоёрт л хамгийн их хөрөнгө оруулалт тавигдсан байна гэж чуулганы танхимд хэрүүл болж байсан үе ч бий.

Хууль тогтоох дээд байгууллагад ажил үйлс, үүрэг хариуцлагаараа хэдийнэ хүлээн зөвшөөрөгдөж, УИХ-ын Байнгын хорооны дарга, Сангийн сайд зэрэг төрийн өндөр албан тушаалуудыг хариуцлагатай хашиж байсан Д.Хаянхярвааг төрийн албаны мэргэшсэн боловсон хүчин, сайн эдийн засагч хэмээн парламентын гишүүд болон намын журмын нөхөд үнэлдэг юм билээ. Тиймээс ч журмын нөхөд нь түүнд итгэл хүлээлгэж УИХ дахь МАН-ын бүлгийн дэд даргаар сонгож ажиллуулжээ.

Д.Хаянхярваа өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд эрх баригчдын зүгээс улс орны эдийн засгийг доройтуулж, өрийн дарамтад оруулсан алдаатай бодлого болон бизнесийн салбарын хөгжлийн ололт амжилтыг бууруулсан үйлдэл бүртэй эдийн засагч, санхүүч хүний хувьд хатуу тэмцэж эрх баригчдын гаргасан алдааг зоригтойгоор шүүмжилж ирсэн улстөрчдийн нэг.

“УИХ-д сонгогдсоноосоо хойш Дарханд ирээгүй долоо хоног гэж надад ер байхгүй. Улаанбаатарт дасаж идээшиж хотын хүн болоход нэлээд хугацаа шаардагдах юм шиг байна шүү” хэмээн Дарханаар овоглосон УИХ-ын гишүүн Дамдины Хаянхярваа ярьж сууна. Чуулганы завсарлагаан болгоноор иргэд сонгогчидтойгоо уулзаж яриа хөөрөө дэлгэн санаа бодлыг нь сонсохоор Дарханыг зорино. Тиймээс түүнийг нутаг амьтай, нутаг усандаа ээлтэй ивээлтэй сэтгэлтэн гэж хэлж болно.

Арван гурван хүүхэдтэй эгэл жирийн малчин айлын том хүү нь болж төрсөн Д.Хаянхярваа ахын ёсоор дүү нараа харж хандан, амьдралд нь түшиг тулгуур болохыг хүсэвч төрийн ажлыг түрүүнд тавих нь элбэг. “Би ч дүү нартаа зөв сэтгэлтэй байж, буруу үйлээс л хол яваарай хэмээн захиж төдий л байх юм. Тэд маань ч миний чихийг халууцуулахгүй тус тусын ажлаа хийгээд, амьдралаа болгоод л явдаг даа” хэмээн ярихдаа дүү нартаа зовохын зэрэгцээ мөн тэднээрээ бахархах итгэлийн оч өвөрлөж явдаг нь илт харагдана.

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн ХҮРЭЛБААТАР
ӨӨРТӨӨ ИТГЭЛТЭЙ, ӨӨДРӨГ НЭГЭН



Чимэдийн Хүрэлбаатар дунд сургуульд байхаасаа тооны ухаанд сургуульдаа толгой цохидог, үеийнхэн дотроо мэдлэг оюуны чадамж өндөртэй “толгой” хүүхэд байсны зэрэгцээ аймагтаа төдийгүй математикийн улсын олимпиадад удаа дараа амжилттай оролцож, улмаар улсаа төлөөлөн Польш улсад зохиогдсон олон улсын олимпиадад шагналт байрт шалгарч байсныг ангийнхан нь одоо ч бахархан ярьдаг. Улаангомын 10 жилийн сургуулийг алтан медальтай төгсөөд төвөггүйхэн Ленинградын Санхүү, эдийн засгийн дээд сургуульд элсэн орж, бас л “улаан дипломтой” дүүргэсэн нь ирээдүйд Монголын нийгэм, улс төр, эдийн засгийн бодлогыг тодорхойлж, эх орондоо ихийг бүтээхийн эхлэл байсныг түүний туулсан зам мөр тод харуулдаг.

Ч.Хүрэлбаатар Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнаар ажлын гараагаа эхэлж, улмаар МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш, Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа” төсөлд ахлах эдийн засагч, улмаар 2000-2003 онд Монгол Улсын Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх, 2003-2007 онд Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2007-2008 онд Засгийн газрын гишүүн, Түлш эрчим хүчний сайдын албыг хашжээ.

Тэрбээр УИХ-ын 2008, 2012 оны сонгуульд увсчуудынхаа итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр хоёронтоо сонгогдоод байгаа билээ. УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллахдаа 2008-2009 онд УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга, 2009-2012 онд Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, эрх зүйн шинэтгэлийн чанартай томоохон хууль тогтоомжуудыг хэлэлцэн батлалцаж, Монгол Улсад хэрэгжсэн олон төсөл хөтөлбөр, эдийн засгийн шийдлүүд дээр идэвх чармайлттай ажиллаж хувь нэмэрлэсэн эрхэм. Тэрбээр МИД, Мянганы

сорилын сан, Тогтвортой амьжиргаа зэрэг төслүүд, Их өрийг тэглэх, Оюутолгойн гэрээний анхны алхмыг хийхэд гардан оролцож, Тавантолгойн гэрээний анхны ажлын хэсгийн ахалж ажилласны зэрэгцээ Монгол Улсын банк, санхүүгийн системийн реформууд гээд дорвитой томоохон ажлуудыг сэдэж санаачилж, гардан хариуцаж эхлүүлсэн байдаг.

Харин энэ урт хугацаанд тэр унаган нутгаасаа холдоогүй юм. Түлш эрчим хүчний сайд байхдаа байгалийн гамшгийн улмаас унасан өндөр хүчдэлийн 21 тулгуурыг 14 хоногт сэргээн засварлаж, баруун 3 аймгийн цахилгаан хангамжийг хэвийн байдалд оруулсан нь эрчим хүчний түүхэнд урьд өмнө байгаагүй том дэвшил болсон санагддаг. Бас Улаангомын 2 дугаар дулааны станц, төвийн цэвэр усны сүлжээний шугамуудаас эхлээд сумдад очсон эрчим хүчний шугамууд нь Увс нутгийнхаа олон түмний төлөө хийсэн, төрж өссөн уул усаа баярлуулсан, өвөг дээдсийнхээ нэрийг гаргасан түүний сайн үйлс болсныг нутгийнхан нь үнэлж талархдаг юм билээ.

Монголд загвар болсон томоохон бүтээн байгуулалт нь Хяргас нуурын хөвөөг эмжин тавьсан засмал. Энэ замыг тэрбээр анх санаачилж Засгийн газраар дэмжүүлэн эхлүүлж чадсан нь нийслэлийг аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар холбох их ажлын эхлэл, шинэ сэдэл санаа болсон түүхтэй. Эл зам тавигдах нь тухайн үедээ увсчуудын хувьд үлгэр мэт санагдаж байсан ч өнөөдөр биелэл болсон нь Ч.Хүрэлбаатарын төрөлх нутгийнхаа төлөө хийсэн гэгээн сайхан үйлсийн нэг гэдэгтэй маргах хүн байхгүй биз ээ. Нутаг усныхаа төлөө хийж буй түүний сайн үйлс өнөө ч үргэлжилсээр байгаа. Нутагтаа аль эх үүсвэрээс, ямар хөрөнгө оруулалт татах, аль газарт ямар бүтээн байгуулалт өрнүүлэх, Увсын ирээдүй хойч болсон хүүхэд залуусын төлөө юу хийх вэ, хэрхэн хөгжүүлэх вэ хэмээн байнга бодож, нэгийг сэтгэж, хоёрыг эргэцүүлж явдаг чанар нь бусдаас ялгарна.

Тэрбээр улс орноо эдийн засгийн хямралаас урьдчилан сэргийлэх, хямралыг хэрхэн даван туулах талаар байнга санаа тавьж ярьж зөвлөдөг, бүр нэгдүгээрт, хоёрдугаарт...хэмээн хуруу даран хэлж, тайлбарладгийг хүмүүс сайн мэднэ. Эдийн засгийн өндөр мэдлэг боловсрол, төрийн ажлын арвин туршлага нь монгол төрд ямагт үр өгөөжөө өгч ирсэн байдаг.

Түүнийг УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, салбарын сайдаар ажиллах хугацаанд Монгол Улсын эдийн засаг 17 хувийн өсөлттэй, хөрөнгө оруулагчдын итгэл өндөр, ихээхэн идэвхжсэн, Оюутолгойн бүтээн байгуулалт эрчимжсэн, гадны эрдэмтэн судлаачид Монголын эдийн засгийн өсөлтийг ойрын жилүүдэд 25-30 хувьд хүрнэ гэж тооцсон, хаа сайгүй хүмүүс бизнес ярьж, гадаадад ажиллаж сурч байгаа монголчууд Монгол руугаа яарсан ийм л улс орон болсон. Энэ бүхнийг тэр залалцаж явсан. Түүнийг үнэлэх хамгийн том үнэлэмж энэ юм.

Тэр өөдрөг нэгэн. Өөдрөг хүний хамгийн сайн чанар нь өөртөө итгэлтэй байдагт оршдог. Ч.Хүрэлбаатар өөрийн мэдлэг боловсрол, төрийн ажлын их туршлагадаа итгэдэг. Увсын улаан хацартай жаалаас УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн болтлоо Монголын төрд хоёргүй сэтгэлээр зүтгэж яваа түүнд улс орноо хөгжүүлэх, зөв гольдрилоор авч явахад ачааны хүндийг үүрэлцэх эрч хүч, мэдлэг чадвар бий.

Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн ХҮРЭЛСҮХ

ТӨГС ЧАНАР



Ухнаагийн Хүрэлсүх Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент УИХ-ын гуравдахь удаагийн сонгуулиар Хэнтий аймгаас 2000 онд сонгогдон их улс төрд хөл тавьж, тухайн үеийн хамгийн залуу парламентч болсон юм. Тийнхүү улс төрийн тэргүүн эгнээнд орохоосоо өмнө тэрбээр намын ажилд суралцсан, улс төр хэмээх хатуу ширүүн тэмцэл дунд өөрийн тод хурц өнгөө нэгэнт илэрхийлсэн байв.

Хэнтий нутгаасаа 2000-2008 онд хоёр удаа, 2012 онд сонгуулийн пропорциональ системийн хүрээнд намын нэрсийн жагсаалтаар УИХ-д гуравдахь удаагаа сонгогдож, улмаар Засгийн газрын гишүүн-Онцгой байдлын сайд, Засгийн газрын гишүүн-Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, Монгол Улсын Шадар сайдаар ажиллаж нам, төрийн ажлын арвин баялаг туршлага хуримтлуулж, тэр хэрээрээ Монголын улс төр, нийгмийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж яваа залуу лидер. Намынхаа залуучуудын байгууллагын удирдагчаар ажиллаж, Монголын Зүүний хүчний холбооны ерөнхийлөгчийн алба хашиж ирсэн олон нийтийн байгууллагын томоохон зүтгэлтэн юм.

У.Хүрэлсүх бол өнөө цагийн Монголын улс төрийг тодорхойлолцож яваа лидерийн хувьд түүний үзэл, зарчим, ёс зүй, үнэт зүйлийн талаар өгүүлэх нь илүү тохирох болов уу.

Хууль тогтоогчоор болон гүйцэтгэх засаглалд ажиллахдаа төрийн албыг хурдтай, чадварлаг, дэг журамтай байх чанга хатуу шаардлага тавьж, мөрдөж хэвшүүлсэн. Төрийн алба бол ард олондоо туслах гэж оршдог болохоос тэднийг дарамтлах төрийн машин биш гэсэн зарчим барьж ажилладаг нэгэн. Тэрбээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдаар ажиллахдаа шинэ тутам байгуулагдсан Онцгой байдлын албаны өнөөгийн дүр төрхийг олох, эрх зүйн

орчныг бүрдүүлэх, орчин үеийн олон улсын стандартад хүргэх бүх талын шинэчлэлийг удирдаж ажилласан бол Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдаар ажиллахдаа “Мэргэжлийн хяналтын байцаагч бол хадны мангаа биш. Та бүхэн ард олны зөвлөгч, туслагч байх ёстой” гэсэн зарчим барьж хэвшүүлсэн байдаг.

Монгол Улсын Шадар сайдын албан тушаалд ажиллахдаа ч салбараа мэддэг хүний хувьд шинэчлэгдэн, бэхжихэд нь ихээхэн хувь нэмэр оруулсан. УИХ, Засгийн газар дээр асуудлаа хамгаалж, шийдүүлж чаддаг нь түүний зангараг, зарчим барьж шахаж шаардах, заримдаа найз нөхдийн холбоогоо ашиглаж чаддаг цараатай улстөрчийн чадварт буй хэмээн улс төрийн хүрээнийхэн, мэргэжлийнхэн нь үнэлдэг юм.

Намынхаа хувьд тэр анхнаасаа л шинэчлэгч байж, 1990-ээд онд өөрөө шинэ үеийн төлөөлөл болж орж ирсэн. Парламентын засаглалтай орны хувьд гарцаа байхгүй улс төрийн намын төлөвшил хөгжлийн тухай яригдана. Зах зээлийн нийгэмд шилжсэн хүнд хэцүү цагт тухайн үеийн МАХН-д залуучуудыг түүчээлэн орж ирж шинэчлэл хийв. Хорин жилийн дараа Ерөнхий нарийн бичгийн дарга болохдоо намынх нь өмнө тулгарч байсан, аль ч үеийн удирдлага зориглон хийж чадаагүй нэр солих асуудлыг барьж авсан. Хийсэн.

Улстөрч хүнд эр зориг, эрсдэл, мэдрэмж гэж гурван чухал зүйл байх ёстой. Дээр нь багийн сайн тоглогч байх хэрэгтэй. Энэ бүх чанарыг шингээсэн улстөрч бол У.Хүрэлсүх мөн гэдэгтэй маргах хүн гарахгүй байх. Улстөрчийн энэ чанаруудаа гаргасан түүний үг, үйлдлийг олон нийт нэгэнт мэднэ. Бусдын сүүдэрт хоргодсон, бултаж, бүлбийсэн нэгэн байснаас өөрийн өнгөөр тоглогч байж, лидершдэг нь тоглоомын дүрэм. Дэлхийн том улстөрчдийн тодорсон түүх ч тийм байдаг. Энэ үүднээс авч үзвэл У.Хүрэлсүх гарцаа байхгүй өөрөө өөрийгөө Монголын улс төрийн түүхэнд тод өнгөөр бичиж явна.

Тэрбээр албан тушаалыг авч ч болдог, өгч ч чаддаг гэдгээ Монголын улс төрийн тавцанд харуулж жишиг үзүүлсэн гэнэ. УИХ-ын гишүүний эрхэм сэнтийгээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж байв. Цаг нь болоход намынхаа итгэлийг хүлээн сайдын сэнтийд сууж л байлаа. Заавал гишүүнд нэр дэвшинэ, сайд болно гэж нэр төр, албан тушаалын төлөө улайран тэмүүлж байсангүй.

Түүнд байх нэг чанарыг заавал дурдах хэрэгтэй. Аав, ээж нь хоёул тээврийн жолооч байж. Өөрөө өвөө, эмээгийн хүүхэд. Хүний насан туршийн боловсрол гэрийн хүмүүжил гэдэгчлэн түүний цаанаа нэг хамтач, энгийн чанар нь өдий хүртэл тавигдсангүй. Хэнтэй ч найзалж нөхөрлөнө, байгаагаа хувааж идээд, тас тас хөхрөн онигоо ярьж зогсоно. Хар залуугаасаа удирдах ажил хийж, төрийн өндөр дээд алба хашсан ч түшмэл зан суугаагүй нь олны хүндэтгэл хүлээдэг. Найз нөхөдтэйгөө хамтран хамтлаг байгуулж, насан багынхаа мөрөөдлийг биелүүлж ч үзсэн. Ханийнхаа төлөө төрийн өндөр албаа өгч чадсан гээд хүнээрээ үлдсэн олон сайхан чанарыг түүнээс харж болно.

Улсын Их Хурлын гишүүн Логийн ЦОГ ШУДАРГА ЁСНЫ ТӨЛӨӨХ ЗҮТГЭЛ



Логийн Цог 1990 онд анхны бүх нийтийн ардчилсан сонгуулиар Ардын Их Хурлын депутатаар сонгогдож, улмаар Монгол Улсын анхны байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны анхны даргын албыг хашсан намтар түүхтэй нэгэн.

Тэрбээр УИХ-ын 2012 оны зургаа дахь удаагийн сонгуулиар Орхончуудын итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар УИХ дахь “МАХН-МҮАН-ын Шударга ёс эвсэл”-ээс УИХ-ын дэд даргаар ажилласан юм.

Л.Цог 1992 оны шинэ Үндсэн хуулийг боловсруулах Улсын комиссын гишүүнээр ажиллаж, Үндсэн хуулийг хэлэлцэн батлахад идэвхтэй оролцож чухал үүрэг гүйцэтгэсэн түүхэн гавьяатай. Тиймээс хэрэв Үндсэн хуулиа ягштал мөрдөж, түүний чадавхийг бүрэн дүүрэн ашиглавал улс орон хөгжил дэвшлийн замд эргэлт буцалтгүй орох эрх зүйн суурь тавигдсан гэсэн хатуу үзэл бодолтой явдаг нэгэн. Тэрбээр 1999 онд УИХ-аар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсанд шүүмжлэлтэй ханддаг хүмүүсийн нэг төдийгүй 2012 онд УИХ-ын гишүүнээр сонгогдсоныхоо дараа ч нийтийн дунд “дордохын долоон нэмэлт өөрчлөлт” хэмээн нэршсэн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгуулахын төлөө өөрөөсөө шалтгаалах бүхий л хүчин чармайлт гаргаж ажилласныг хүмүүс сайн мэднэ.

Л.Цог энэ удаагийн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд олон хуулийн төсөл санаачилснаас гадна улс орон, ард түмний язгуур эрх ашигт нийцээгүй, шударга бус хуулиудыг батлуулахгүйн төлөө нэн зүтгэлтэй ажилласан юм. Шударга бус, бодит амьдралаас тасархай хууль ямар их аюултай, хор уршиг учруулдгийг тэрбээр мэргэжлээрээ ажилласан он жилүүдийн явцад сайтар мэдэрсэн гэдэг.

Монгол Улсад өндөр боловсролтой хуульчдыг бэлтгэсэн хуучин ЗХУ-ын

Эрхүү хотын Их сургуулийг амжилттай дүүргэсэн тэрбээр өмнөх тогтолцооны үед хууль сахиулах байгууллагуудыг тэргүүлдэг байсан Улсын прокурорын газарт хэлтсийн прокуророор томилогдсоноор ажлын гараагаа эхэлсэн нь түүний оюутан байхдаа хэр зэрэг бэлтгэгдсэн болохыг нь харуулдаг. Тухайн үед Улсын ерөнхий прокуророор Монголын хууль зүйн ухааны анхны эрдэмтэд, нэрт хуульчид болох Р.Гүнсэн, Ж.Авхиа зэрэг хууль сахиулах байгууллагын “акулууд” ажиллаж байсан бөгөөд тэднээс маш их зүйлийг сурч мэдсэн гэдэг юм билээ. Ийнхүү дадлагажиж, туршлагажсан Л.Цог Улсын ерөнхий прокурорын газраас яам, улсын хороо, тусгай газар, нийслэл, аймаг, орон нутгийн засаг, төрийн байгууллага, түүний албан тушаалтнаас хуулиудыг нэг мөр биелүүлж байгаад хяналт тавих чиг үүрэг бүхий Дээд хяналтын салбарыг удирдаж байжээ.

Хууль бол нийгэмд шударга ёсыг бэхжүүлэгч, гэмтнийг гэсгээж, гэмгүйг хамгаалдаг он жилүүд, цаг хугацааны шалгарлаар буй болсон сонгомол хэрэглүүр юм. Хуулиудыг сонгогчдын өөрсдийгөө төлөөлүүлэн сонгож парламентад илгээсэн ёс суртахуунлаг төлөөлөгчид /гишүүд/ батлах, батлахгүйгээ хариуцан мэдэх учиртай байдаг. Харин хуульчид бол хуулийг жинхэнэ ёсоор амьдруулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Л.Цог гишүүн мэргэжлийнхээ учир утгыг ингэж л үздэг эрхэм. Ийм учраас мэргэжлийнхээ дагуу ямар ч ажил, албан тушаал хашсан тэрбээр асуудалд энэ л байр сууринаас хандаж иржээ. УИХ-ын нэгдсэн чуулган, байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн хууль, тогтоолын төсөлд ч тэр энэ зарчмыг л барьж, өөрийн гэсэн дүгнэлтээ гаргаж, үгээ хэлж байдаг.

Түүний эзэмшсэн мэргэжил нь ч үнэн, шударга жудагтай байхыг цаг ямагт шаарддаг, энэ хэрээр Л.Цог мэргэжилдээ үнэнч байсан, байсаар ч явна.

Хуульч Л.Цог улс орныхоо байгалийн нөөц баялгийг ард түмнийхээ язгуур эрх ашгийн үүднээс үр ашигтай ашиглахын төлөө иргэний хөдөлгөөнийг тэргүүлж гадаа гудамжинд ч, УИХ-ын танхимд ч хэнээс ч эмээлгүй тэмцэж ирснийг ард түмэн бэлхнээ мэднэ. Тэрбээр 2012-2016 онд УИХ-ын дэд даргаар сонгогдон ажиллах явцдаа мөнгө хөрөнгөний төлөө албан тушаалын эрх мэдлээ хортойгоор урвуулан ашиглах, өргөсөн андгай тангаргаа уландаа гишгэж, иргэд, сонгогчдынхоо итгэлийг эвдэх ёс зүйгүй үйлдлийн эсрэг шударга, үнэний дуу хоолой болж, өөрийн байр сууриа илэрхийлж ирснийг олон нийт үнэлж хүндэлдэг, талархан дэмждэг юм билээ.

Л.Цог гишүүн УИХ-ын дэд даргаар парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллахдаа Монгол-Оросын парламентын бүлгийн дарга, мөн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын үүрэгт ажлыг хавсран идэвх зүтгэлтэй, нэр төртэй гүйцэтгэж, олон асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулсан түшээ.

---oooOooo---

Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн ЦОЛМОН

НОЁН НУРУУ, ЧИГ ШУГАМ



Цэрэндашийн Цолмон 1953 онд Архангай аймгийн Цэнхэр суманд төрж, 1970 онд Архангай аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль, 1976 онд ЗХУ-ын Эрхүү хотын Политехникийн дээд сургуулийг Цахилгааны инженер мэргэжлээр төгссөн. Мөн 1982 онд Улаанбаатар Намын дээд сургуулийг улстөрч мэргэжлээр, 1987 онд ЗХУ-ын Москва хотын Дипломатын академийг дипломатч мэргэжлээр дүүргэж, эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Монгол Улсын Удирдлагын академийн профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолтой.

Тэрбээр 1976 онд Махконсервын комбинатад цахилгааны инженерээр ажлын гараагаа эхэлж, улмаар 1977-1980 онд Хөнгөн, хүнсний үйлдвэрийн яаманд цахилгааны инженер, 1982-1984 онд МХЗЭ-ийн Төв хороонд хэлтсийн эрхлэгч, 1987-1990 онд Гадаад явдлын яаманд хэлтсийн орлогч дарга, зөвлөх, 1990-1992 онд Хөдөлмөрийн сайд, 1992-1994 онд Удирдлагын хөгжлийн институтийн захирал, дэд захирал, 1994-1995 онд ЮНЕСКО-ийн Үндэсний хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, 1995-2000 онд ОХУ, Болгар Улсад Монгол Улсаас суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар ажиллажээ. 1987-1990 онд Гадаад явдлын яаманд ажиллах хугацаандаа Монгол Улсаас анхлан Европын эдийн засгийн хамтын нийгэмлэгтэй харилцаа тогтоох саналыг дэвшүүлж боловсруулжээ. Мөн НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн 5 орны зүгээс Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолыг баталгаажуулсан амлалт авахын тулд цөмийн зэвсэггүй орон байх, цэрэг зэвэглэлээр хөөцөлдөхгүй байх саналыг боловсруулж яамны удирдлагад танилцуулж байжээ.

Туршлагатай дипломатч, улстөрчийн хувьд түүнд итгэл хүлээлгэж 2006-2007 онд Гадаад хэргийн дэд сайд, 2007-2008 онд Барилга, хот байгуулалтын сайдаар томилон ажиллуулсан байна. Барилга, хот байгуулалтын сайдаар ажиллах хугацаандаа салбарын олон чухал бодлого боловсруулсны дотор “Дөчин мянган айлын орон сууц” хөтөлбөрийг санаачилж, орон даяар бүтээн байгуулалтыг

өрнүүлэхэд идэвхтэй оролцож, төв орон нутгийн барилгын салбарыг бэхжүүлж хөгжүүлэхэд анхаарч ажилласныг салбарынхан нь үнэлдэг.

Ц.Цолмон 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиар МАХН-МАУАН-ын “Шударга ёс” эвслээс УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2014 оны сүүлчээс Батлан хамгаалахын сайдаар томилогдон ажиллаж байна. Мөн УИХ дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн дэд дарга, Монгол-Африкийн бүлгийн дарга, Монгол-БНСУ, Монгол-Франц, Монгол-Бразил, Монгол-Киргиз зэрэг парламентын бүлгэмүүдийн гишүүнээр ажиллаж иржээ.

Парламентын бүрэн эрхийн хугацаанд тэрбээр УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан болон байнгын хороод, “Шударга ёс” эвслийн 41 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, зарим ажлын хэсгийг ахалж ажилласны зэрэгцээ хэд хэдэн хуулийн төслийг нэр бүхий гишүүдийн хамт өргөн мэдүүлж хэлэлцүүлж батлуулсан байна. Тэр дундаа УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар ажиллахдаа ач холбогдол бүхий хэд хэдэн хуулийн төслийг батлан гаргахад үүрэг оролцоо ихтэй байв. Түүний ажлын хэсэгт багтан ажиллаж УИХ-аар батлуулсан хуулиудаас Иргэний хуульд нэмэлт оруулах тухай болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Уул уурхайн хөгжил түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөл зэргийг нэрлэж болно. Мөн Хяналтын тухай хуулийн болон бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, Ард нийтийн санал асуулга явуулах тухай УИХ-ын тогтоолын төслүүд нь УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд байгаа аж. Түүнчлэн Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай болон дагалдан бусад хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төслүүд дээр бусад гишүүдтэйгээ хамтран ажиллажээ.

Ц.Цолмон гишүүний хууль, эрх зүйн шинэчлэлд гар бие оролцож ажилласан өөр нэг салбар нь Батлан хамгаалах салбар юм. Тэрбээр Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн тэргүүлсэн Шийдлийн Засгийн газарт 2014 оны 12 дугаар сарын 10-наас эхлэн өнөөг хүртэл ажиллахдаа батлан хамгаалах салбарын эрх зүйн шинэчлэлд эерэг үр дүн авчирсан. Тухайлбал, 2015 онд УИХ-ын 85 дугаар тогтоолоор Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг шинэчлэгдэн батлагдав. Үүнтэй уялдуулан батлан хамгаалах салбарын багц хуулийн төсөлд өөрчлөлт оруулах эрх зүйн үндэс нээгдэж, цэргийн эрдэмтэн судлаачид, ажлын хэсгийнхэн хамтран боловсруулсан багц хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьсан юм. Ерөнхийлөгчөөс УИХ-д өргөн мэдүүлсэн батлан хамгаалах салбарын багц хуулийн төсөл өдгөө эцсийн хэлэлцүүлгийн шатанд байна. Мөн Батлан хамгаалахын сайдын хувьд УИХ-ын үйл ажиллагаа, баталсан хуулийн тухай танилцуулгыг Зэвсэгт хүчний анги байгууллагад таниулж ажиллажээ.

Тэрбээр хувь хүнийхээ хувьд аливаа асуудалд ноён нуруугаа барьж, жанжин шугамаасаа хэзээ ч гаждаггүй. Энэ тулхтай эрхэм чанараараа улс төр төдийгүй ард иргэд, батлан хамгаалах салбартаа танигдсан нэгэн бөгөөд энэ нь түүний дипломатч зан чанартай холбоотой гэдгийг ойрын хүмүүс нь онцлон өгүүлдэг юм билээ.

Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын ЧОЙЖИЛСҮРЭН ЯРИХААС ХИЙХИЙГ ЧУХАЛЧИЛДАГ



Б.Чойжилсүрэн Увс аймгийн унаган хүүхэд. Тэрбээр Тэс суманд төрж, Улаангомд өссөн гэдгээрээ бахархдаг. Багаасаа байгалийн ухааны хичээлүүд, тэр дундаа тоонд гойд сонирхолтой байсан тэрбээр Увс аймгийн 10 жилийн хоёрдугаар дунд сургуулийг 1988 онд төгсөөд ОХУ-ын Екатеринбург хотноо автоматик телемеханикийн мэргэжлээр суралцсан байна. 1993 онд сургуулиа дүүргэсний дараа Екатеринбург хотноо хэсэг нөхдийн хамт хамтарсан компани байгуулан захирлаар нь ажиллаж, бизнесийн салбар дахь анхны гараагаа эхэлжээ. Арван жил хүнс, барилга, бөөний худалдаа зэрэг бизнесийн салбарт амжилттай ажиллахдаа Б.Чойжилсүрэн “Хурд Ч” хувиараа эрхлэх аж ахуй, “Хурд Хүнс” ХХК-ийг удирдаж байв. Тэрбээр аймгийнхаа хөгжлийн төлөө багагүй ажлыг хийж, өөрийн үүсгэн байгуулсан “Хурд” групптээ нутгийнхаа залуусыг олноор авч ажиллуулдаг байна. Тиймээс олон мянган хүнийг ажлын байраар хангаж, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзаганд хүргэсэн учраас увсчууд түүнд ам сайтай байдаг юм билээ.

Тэрбээр бизнесийн салбараас 2005 онд улс төрд хөл тавьж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргаар ажиллан, улмаар 2008 оны УИХ-ын сонгуулиар Увсчуудынхаа итгэлийг хүлээж УИХ-ын гишүүнээр сонгогдсон юм. Түүнийг УИХ-д нэр дэвших бодолтой нутагтаа ирэхэд аймгийн төв нь нэлээд гундуу байсан гэдэг. Иймээс эхний ээлжинд гишүүдийн тойрогтоо зарцуулдаг тэрбум төгрөгнөөс Увсаас сонгогдсон гишүүдтэйгээ хамтран 1.5 тэрбумаар нь хагарч бутарсан Улаангомын 34 км хатуу хучилттай замыг шинэчилсэн байна. Үүгээр зогсохгүй Дулааны хоёрдугаар цахилгаан станц, наадмын талбайн ажлыг эхлүүлсний зэрэгцээ 19 сумын тохижилтыг хийж, сургууль, эмнэлэг, цэцэрлэг, дотуур байр, аймгийн Засаг даргын Тамгын газрын байр гээд навсайж хуучирсан барилгуудын 80 гаруй хувийг шинээр бариулжээ. Түүнчлэн Наранбулаг-Хяргас нуур-Үзүүрийн

булаг чиглэлийн 195 км зам, Увс аймагт олон улсын зэрэглэлийн “Дэглий цагаан” нисэх онгоцны буудал бариулж ашиглалтад оруулсан гээд түүний нутагтаа хийж бүтээсэн ажлыг тоочвол барагдахгүй.

Б.Чойжилсүрэн найман жил УИХ-ын гишүүнээр ажиллах хугацаанд Увс аймагт улсын төсөв, Хөгжлийн банк, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 274 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Энэ нь баруун бүсийн бусад аймгуудтай жишиж үзэхэд 2-3 дахин их хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн гэсэн үг. Түүнчлэн 2012-2016 онд УИХ-ын гишүүнээр ажиллахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийг чуулган, байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг ахлан ажиллаж амжилттай батлуулж чадсан гавьяатай нэгэн.

Монголчуудын мартаж эрхгүй, мартаж болохгүй хүн бол төр, нийгмийн зүтгэлтэн Юмжаагийн Цэдэнбал билээ. Тиймээс Б.Чойжилсүрэн Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Юмжаагийн Цэдэнбалын нэр төрийг сэргээж, алдар гавьяаг нь мөнхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг санаачилж, өргөн мэдүүлсэн гишүүдийн нэг.

Тэрбээр моголчууд өрөөл бусад нутаг дээр бий болсон баялгийг өөрийн нутаг татаж авчирах нь тийм ч сайн зүйл биш. Харин бид өөрсдөө нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгож, улсын төсөвт орлого бүрдүүлдэггүй юмаа гэхэд өөрөө өөрсдийгөө тэжээгээд явчих хэмжээний эдийн засгийн бүтэцтэй болохсон гэсэн хүсэл мөрөөдөл байдаг. Хүссэн ч, эс хүссэн ч уул уурхайг хөгжүүлэхээс өөр арга байхгүй. Гэхдээ хамгийн гол нь байгаль орчиндоо сөрөг нөлөөгүй байх ёстой гэсэн бодолтой явдаг нэгэн.

Б.Чойжилсүрэн ярихаас илүүтэй хийхийг чухалчилдаг гэдгээ нэг бус удаа хэлсэн байдаг. Мөн тэрбээр бодит үнэнийг хэлэхгүйгээр ард түмнийг хуурч болохгүй. Эрх барьж байгаа сөрөг нам олон алдаа, дутагдал гаргасан ч шүүмжлэх нь гол биш гэсэн байр суурьтай байдгаа нэг биш удаа илэрхийлж байв.

Түүнийг 2008 онд УИХ-ын гишүүн болсных нь дараа жил Увс аймгийн Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн даргаар сонгосон нь нутгийн зон олон ямар их итгэл хүлээлгэж байдгийн нэг илрэл юм. Энэ ажлыг авснаас хойш Увсчууд урлаг, спортын олон сайхан амжилт үзүүлж, Ардын төрийн наадмын 4 түрүү, 1 үзүүр хүртэж, улсын цолтон 10, Дэлхийн жудо бөхийн анхны аварга төрсөнд тэрбээр бахархаж явдаг аж. Өөрийн хийж бүтээж, хумьж хуримтлуулсан орлогоос нэлээд хэсгийг нь төрж өссөн нутаг орноо хөгжүүлэх, залуу хойч үеэ сургаж төлөвшүүлэх үйлсэд зарцуулж буйгаа ч тэрбээр өөрийгөө их азтай, хувь заяатайд тооцож, миний үүрэг, миний хийх ёстой ажил хэмээн үздэг юм билээ.

---0000000---

Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН

АСУУДАЛ БҮРИЙГ ТООЦОО СУДАЛГААТАЙ ГАРГАЖ ТАВЬДАГ ГИШҮҮН



Л.Энх-Амгалан 1992 онд ОХУ-ын Санктпетербургын Их сургуулийг олон улсын сэтгүүлч мэргэжлээр төгсөж ирээд өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн хөгжлийн чиглэлээр ном орчуулахын зэрэгцээ “Ил товчоо”, “МОНЦАМЭ” сонины хариуцлагатай нарийн бичгийн даргын албыг хашиж, тухайн үедээ асуудал хөндсөн нийтлэл, эрэн сурвалжлах чиглэлээр мэргэшсэн толгой сэтгүүлчдийн нэг байв. АНУ-д эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр 1996 онд мэргэжил дээшлүүлэх хугацаандаа зах зээлийн нийгэмд иргэд хэрхэн амьдарч болдог, хууль бүхнийг зохицуулдаг жишээг нүдээр харж, улмаар хувийн бизнес рүү хөл тавьсан гэдэг.

Л.Энх-Амгалан Монголын анхны хэвлэлийн компаниудын нэг “Интерпресс” компанийг үүсгэн байгуулж, удалгүй М-Си-Эс компанитай нэгдэж мэдээллийн технологи, дэд бүтцийн чиглэлийн компаниудыг нь удирдах болов. Энэ үед шилэн кабель татаж, интернэтийн үнийг бууруулах, “Өрх бүрт компьютер” зэрэг томоохон төслүүдийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байсан нь өнөөдөр бидний өдөр тутам хэрэглэж, хоол ундны хэрэглээтэй адил болсон интернэт хэрэглээ юм. Түүнийг мэдээллийн хурд, мэдээллийн технологийг Монголд нэвтрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүн гэж тодорхойлдог.

М-Си-Эс группийн тэргүүн дэд ерөнхийлагчөөр ажиллаж байхдаа хамт олныхоо боловсролд анхаарч, шилдэг татвар төлөгч болгож, ажлын байрыг хамгийн их нэмэгдүүлсэн үзүүлэлтээр Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын шилдгээр олон удаа тодорч байв.

Хөвсгөл нутгаас төрсөн олны танил улстөрчид болох хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч Б.Чимэд агсан, философийн ухааны доктор Б.Даш-Ёндон, улстөрч С.Баяр, Ө.Энхтүвшин, Л.Гүндалай, Ц.Сэдванчиг, Ц.Даваасүрэн нарын

залгамж халаа болж улстөрд орж ирсэн Л.Энх-Амгаланг хүмүүс шинэ гишүүн, бизнесмэн төдийгээр дүгнэж байсан цаг саяхан. Гэвч тэрбээр Хөвсгөлчүүдийн итгэлийг хүлээж УИХ-ын гишүүн болсноор амьдралд ойр, хөрсөнд буусан хууль батлуулж, эдийн засгийг эрүүлжүүлэх, Монгол Улсын хөгжлийн талаар бодитой санал дэвшүүлдэг манлайлагч болохоо харуулж чадсан гэж үнэлэгддэг.

Шинэ гишүүн гэж тэрбээр бүлхи залгисан мэт дуугүй суусангүй, аливаа асуудлыг надаас хол сэдэв гэж өөрөөсөө холдуулсангүй. УИХ-ын гишүүний үндсэн үүргээ биелүүлж, мэдэрч ажилласанд иргэд, сонгогчид нь талархаж явдаг юм билээ. Монгол ардын нам 2012-2016 оны УИХ-д цөөнх болсон ч иргэдийнхээ эрх ашигт нийцсэн томоохон хуулиудын төслийг өргөн барьж, улс орны эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг сайжруулах, эдийн засгийн оновчтой бодлого явуулах, эрүүл мэнд, боловсролын салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар идэвхтэй ажилласан. Энэ бүхэнд эдийн засгийн тооцоо судалгаатай, гарах үр дүнг тооцож анхааруулга өгч ирсэн гол гишүүдийн нэг нь Л.Энх-Амгалан.

Тэрбээр Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого батлах тогтоолын төсөл, Малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Хамтын тэтгэврийн тухай, Ойн тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай гээд иргэд, олон түмэн рүүгээ чиглэсэн олон хуулийг санаачилж, ажлын хэсэгт орж идэвхтэй ажилласан юм. Түүнчлэн Хөвсгөл аймагт үйл ажиллагаа нь зогссон барилгуудыг гүйцээх хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулсны зэрэгцээ Хөвсгөлийн зам, гүүрийн ажлыг урагшлуулахад анхаарал тавьж, үе үеийн Засгийн газрын түвшинд идэвхтэй хамтран ажиллаж тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлж чадсан байна. Мөн Хөвсгөл нуурыг хамгаалах чиглэлээр улсын хэмжээний томоохон төсөл хэрэгжүүлж, бодитой ажил эхлүүлж байгаа гээд түүний хийсэн, амжуулсан ажил олон бий.

Хөвсгөл аймгийг нийслэлтэй холбосон босоо тэнхлэгийн замын хоёр ч том төслийн зураг төсвийг гаргуулж яваа түүнийг томоохон төслийг удирдаж сурсан, бүтээн байгуулагч гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. Үүгээр ч зогсохгүй Л.Энх-Амгалан УИХ-ын гишүүн болсноосоо хойш хувиасаа нэг тэрбум орчим төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймгийнхаа эрүүл мэнд, боловсрол, сум, багийн түвшинд шийдвэрлэжээ. Жилд 2-3 удаа аймгийнхаа бүх сум, багт хүч ажиллахдаа иргэдийн санал хүсэлтийг сонсч, 14 мянга орчим өргөдөл хүсэлтийг холбогдох, яам газарт уламжлан хариу өгч, боломжтой асуудлыг бие даан шийдвэрлэсэн нь иргэд сонгогчидтойгоо хэр ойр, нягт хамтран ажилладаг нь харагдана.

УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “ангийнхан” дотроо чуулган, байнгын хорооны хуралдаанд хамгийн олон удаа буюу таслалгүй суусан “онц сурлагатан” төдийгүй Монгол Улсын Ерөнхий сайд, салбарын сайд, хууль санаачлагчдад хамгийн олон удаа асуулт, асуулга тавьж, үг хэлсэн гишүүнээр шалгарсан юм. Тэрбээр “Хүн бүхэнд сул болон давуу тал бий. Бие биеэ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ямар ард түмэн байна, тийм төр байдаг гэж үг бий. Гишүүд заримыгаа эх оронч, популист гэх мэт янз бүрээр дууддаг. Гэхдээ өнөөдрийн парламентын өнгө, дуу хоолой бол ард түмний л тусгал” гэсэн зарчим барьдаг нэгэн.

Түүнийг ирээдүйтэй, боловсролтой шилдэг улс төрч, Монгол Улсын эдийн засгийг сайжруулах, төрийн зөв бодлого тодорхойлоход заавал байх ёстой төрийн түшээдийн нэг хэмээн нутгийн зон олон төдийгүй монгол түмэн зүй ёсоор үнэлдэг юм билээ.

Улсын Их Хурлын гишүүн Жадамбын ЭНХБАЯР

ЭХ ОРНЫ ХҮҮ



Олзуурхам...

“УИХ-ын гишүүн болоод ганц зорьсон зүйл маань авлигатай тэмцэх байлаа” хэмээн ярих Ж.Энхбаяр гишүүн Монголын төрд ус, агаар мэт үгүйлэгдэж буй шударга ёсыг тогтоохын төлөө тууштай ажиллаж байгаа нэгэн. Тэрбээр 2008 онд анх УИХ-ын гишүүнээр сонгогдоод авлигыг бууруулах чиглэлд зүгээр нэг анхаараад зогсохгүй залуу гишүүдтэйгээ бодит санаачилга гаргасан юм. Тухайн үеийн УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар, Х.Тэмүүжин нарын хамт авлигыг үл тэвчих хүсэл зоригоо илэрхийлэн Авлигын эсрэг парламентчдын дэлхийн байгууллагын салбарыг УИХ-д албан бус бүлэг хэлбэрээр байгуулсан түүхтэй. Улмаар 2010 онд албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт тавьж, дүн шинжилгээ хийж, хэрхэн хариуцлага тооцож буй талаарх мэдээллийг ажил хариуцсан хүмүүс, зөрчил гаргагчдын аль алиныг нь байлцуулан орон даяар нээлттэй сонссон юм. Уг сонсголоос АТГ-ыг үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын хувьд бэхжүүлж, аливаа ашиг сонирхлыг зааглах, хөрөнгө, орлогын мэдүүлэг авах, өгөх үйл явцыг боловсронгуй, тодорхой болгох олон чухал санал гарсан нь Авлигын эсрэг хуульд туссан юм.

Монголд өндөр түвшний авлига аюулын харанга дэлдэж байгааг судлаачид сануулдаг. Тэгвэл найман жилийн өмнө УИХ-ын залуу гишүүд өндөр түвшинд авлигатай тэмцэх хүсэл зоригоо өөрсдөөсөө эхлэн илэрхийлж, ажил хэрэг болгосон нь нийгэмд том дохио болж чадсан юм. Залуу гишүүд хууль санаачилж, батлуулахаас эхлээд өөрсдөө ч цэвэр гэдгээ баталж АТГ-т хүсэлтээрээ хүртэл шалгуулж байлаа. Өнгөрсөн дөрвөн жилд шударга ёсны үнэлэмж үлэмж алдагдаж, уршигт нь нийгэм, эдийн засаг, ард түмний аж байдал үлэмж доройтсонд тэр харамсаж явдаг. УИХ-ын чуулган дээр ч байр сууриа хамгаалсаар ирсэн. Монголын төрд шударга бустай тэмцдэг хүн бас байдгийг УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр баталж яваа нь олзуурхам ажээ.

Батлан хамгаалах бодлогын залгамж халаа

36 насандаа генерал цолны эзэн болж байсан Жадамбаагийн хүү Энхбаяр 36 насандаа аавынхаа нутгийн ард түмний итгэлийг хүлээн УИХ-ын гишүүн болсон юм. 36 нас эцэг, хүү хоёрт ээлтэй нас бололтой. Удалгүй Ж.Энхбаяр аавынхаа хашиж байсан өндөр дээд алба-Батлан хамгаалахын сайдаар томилогдож ажилласан. “Монгол төрийн эрхэмсэг алба Батлан хамгаалахын сайдын, аавынхаа сууж байсан суудалд хүү нь сууна гэдэг ховор хувь заяа” хэмээн тэрбээр ярьдаг. Хүмүүс түүнийг аавгайгаа улам л адилхан болж байгаа гэдэг аж. Харин Ж.Энхбаяр “Аавтайгаа адилхан болно оо гэдэг чинь “аав шигээ байгаарай” л гэсэн үг шүү дээ” гэсэн юм.

Жадамбаа генерал зарчимч, уйгагүй хөдөлмөрч, шаргуу, дайчин хүн байсныг салбарынхан нь дурсдаг. Ж.Энхбаяр ч аав шигээ л байхыг хүсдэг. Батлан хамгаалах салбарыг удирдахдаа ч аав шигээ л зарчимтай удирдахыг хичээжээ. Тийм ч учраас тус салбарынхан түүнд итгэж, Ж.Энхбаяр гишүүн ч салбарын хууль эрх зүйн өөрчлөлтийг хийхэд өөриймсгөөр зүтгэж явна. Өнгөрсөн дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаандаа уг салбарын асуудалд онцгой анхаарч ажиллав. Батлан хамгаалах салбарын хууль эрх зүйг шинэчилж, хөгжлийн шинэ шатанд гаргах шаардлагатайг мэдэрч, УИХ-д лообий хийж ажилласны үр дүн ч гарсан.

Тэрбээр Монгол Улсын батлан хамгаалахын бодлого, төрийн цэргийн номлолыг УИХ баталж чадсанд сэтгэл нэн хангалуун байдаг. Үүн дээр үндэслэн шинээр батлан гаргах Батлан хамгаалах салбарын багц хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан билээ. Батлан хамгаалахын сайдаас улбаалсан зэвсэгт хүчний анги салбаруудыг шинээр эмхлэн байгуулах, Монгол Улс энхийг дэмжих хамтын ажиллагаанд улам бүр идэвхтэй оролцох, офицер, ахлагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх гээд түүний санаа чилээн оролцох ажил олон. Үүнийгээ тэрбээр өөрийнхөө хүлээсэн хамгийн чухал үүргүүдийн нэг гэдэг юм билээ.

Ж.Энхбаярын толгой дахь бүрэн зураглал

Улс төрийн намуудын шинэчлэлт, Үндсэн хуулийн өөрчлөлтийг заавал хийх ёстой хэмээн ярьдаг гишүүдийн нэг бол Ж.Энхбаяр. Улс төрд байгаа, улстөрчдийн “өдүүлж” буй шударга бус явдлын уут хүүдий нь нэг талаас Үндсэн хууль болоод байгаа нөхцөлд засах юмаа засаж залруулаад урагшлах нь зүйтэй гэж тэр үздэг. Мөн “эцэг” хуулийн өөрчлөлтийг барьж авбал өнгөрсөн 25 жилээ дүгнэх, ирээдүйгээ тодорхойлж, цаашдын зорилгоо зөв дэвшүүлэх боломж гэж хардаг ажээ. Товчоор томьёолбол Үндсэн хуулийн өөрчлөлт, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын бодлого, намын шинэчлэл гэсэн гурван зүйл бол УИХ-ын гишүүн Ж.Энхбаярын улс төрийн байр суурь. Түүний хийх ажил нь тодорхой, тэр хэрээрээ тархи толгойд нь бүрэн зураглагдчихсан яваа гэсэн үг. Мэндийн Зэнээ агсны МАН-ын залуу гишүүдэд хэлж үлдээсэн нэг үг байдаг. “Нэг удаад ямар ч аавын хүү, ээжийн охин УИХ-ын гишүүн болж болно. Хоёр дахь удаагаа болбол чи өөрийгөө намдаа, эх орондоо хэрэгтэй хүн гэж бод, харин гурав дахиа сонгогдож чадвал эх орны хүү болсон гэж өөрийгөө бод” гэж хэлж байжээ.

Монголын төрийн шударга ёсны индикатор, улсыг батлан хамгаалах бодлогын залгамж халаа, улс төрийн орчны цэвэршил, тунгалагшлын том бодлогыг олоод харчихсан Ж.Энхбаяр гишүүнийг аль хэдийнэ эх орны хүн болжээ гэж анзаарсан юм. УИХ-ын гишүүн бүр түүн шиг байдаггүй юм.

Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн ЭНХБОЛД

ХАЛАМЖ АВЧ СУУСАН МОНГОЛ УЛСЫГ ҮЙЛДВЭРЛЭГЧ МОНГОЛ УЛС БОЛГОХ АЖЛЫГ БИД ЭХЛҮҮЛСЭН



Монгол Улсын Их Хурлын дарга, Ардчилсан намын дарга Зандаахүүгийн Энхболдтой ярилцлаа.

- Ардчилсан намын засаглалын ерөнхий дүр зургийг ажихад “хийгээд байя” гэсэн өнгө аяс давамгай юм уу даа?

- Гадныхан биднийг “хадаас ч үйлдвэрлэж чаддаггүй улс” гэж элэглэдэг байсан нь саяхан. Тэр элэглэл нэгэнт түүх болж үлдсэн. Өнөөдөр манай аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ хурдтай өсч, дотоодын хэрэгцээнээс давсан олон бүтээгдэхүүнээ бид экспортолж байна.

Өнгөрсөн жил УИХ Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг баталж, дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой барааны тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг шалгаруулахыг хориглож, 370 нэр төрлийн барааны импортын гаалийн албан татварыг 5 хувиас 20 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг Засгийн газарт олгосон. Мөн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортолдог үндэсний үйлдвэрт зээлийн хөнгөлөлт үзүүлэхээр болсон. Энэ хуульд зааснаар экспортын үйлдвэрлэлд факторингийн дэмжлэг үзүүлж, экспортод чиглэсэн дэвшилтэт технологийн судалгаа, хөгжлийн зардлын 75 хүртэлх хувьтай тэнцэх дэмжлэгийг тухайн үйлдвэрт буцааж олгохоор хуульчилсан.

2012 онд Чингис, Самурай бондыг гаргаж, үйлдвэрлэлийн салбарыг дэмжих зорилгоор 6 хувийн хүүтэй зээлийг 1055 үйлдвэржилтийн төсөлд олгосон. Ардчилсан намын Засгийн газар бонд авснаар хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг өрнүүлж чадсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Учир нь манай улсын хувьд өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт үйлдвэрлэл 80.4 хувиар өсч, гадаад худалдааны тэнцэл эерэг болсон төдийгүй аж үйлдвэрийн салбарт л гэхэд 70

гаруй мянган хүн ажиллаж байна. Замын бүтээн байгуулалтын талаар товчхон ярья. Сүүлийн гуравхан жилд 2720 км зам тавьж 7 аймгийн төвийг нийслэлтэй холбосон. 2016 онд 1284 км зам барихаар төлөвлөн ажиллаж байгаа. Харин 1921-2012 оны хооронд буюу 91 жилийн хугацаанд 2964 км зам тавьж, 6 аймгийн төвийг нийслэлтэй холбосон байдаг. Зам дагаж хөгжил гэдэг, Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдсон замын үр шимийг Монгол Улсын иргэн бүр хүртэж байгаа. Аж үйлдвэрийн бусад дэд салбар дахь амжилтуудыг яривал хэдэн өдөр болно.

- *Та улс орныхоо эдийн засгийн бүтцийг ямархуу байдалтайгаар хардаг вэ?*

- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт үйлдвэржүүлэх чиглэлээр тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн алхмын нэг нь 2014 онд Аж үйлдвэрийн яамыг шинээр байгуулж, Аж үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүнд, хөнгөн, жижиг дунд үйлдвэрийн бодлого, үйлдвэрлэл технологийн парк, чөлөөт бүсийн хөгжил, гадаад дотоод худалдаа, үйлчилгээ, экспорт, импортын асуудлууд хамрах болсон явдал юм. Бүс нутагт үйлдвэрлэл эрхлэх тэргүүлэх чиглэлийг тогтоон түүхий эдийг экспортлохыг үе шаттайгаар бууруулж, дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар байгуулах, газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрүүдийн хамт цогцоор нь хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

- *Ипотекийн зээл бол Ардчилсан намын хийсэн гол ажлуудын нэг. Ардчилсан нам ирэх сонгуулиар ялахгүй бол ипотекийн зээл зогсоно гэдэг айдас нийгэмд байх шиг...*

- Хүн ардаа тохилог орон сууцаар хангах нь төрийн анхдагч үүрэг. Ипотекийн зээлийн нөлөөгөөр барилгын салбарын бүтээн байгуулалт эрс өсч, олон тооны ажлын байр бий болсон. 1921-1996 он хүртэлх 75 жилийн хугацаанд Монгол Улсад нийтдээ 100 мянган орон сууц баригдсан байдаг. Харин одоо жилд 27 мянган айлыг шинэ орон сууцанд оруулж байгаа нь бодитой ажил, амжилт. 2008 онд барилгын салбарт 50 мянган хүн ажиллаж байсан бол өнөөдөр энэ тоо хоёр дахин өссөн. Мэдээж энэ бол 2013 оноос хэрэгжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийн үр дүн. Энэ жил нийт 18450 айл ипотекийн 8 хувийн зээлээс 5 хувьд шилжиж байна. Мөн энэ онд шинээр 9772 айл 5 хувийн зээлд хамрагдана. Ипотекийн зээл нь мөн ажил эрхлэлтийг хүчтэй дэмжиж, уул уурхайн салбарын үлдээсэн орон зайг тодорхой хэмжээгээр нөхөж байна. Иргэдийг орон сууцжуулах бодлогын цаана олон жил яриад шийдэгддэггүй агаарын бохирдол гэх мэт нийгмийн эмзэг асуудлууд шийдэгдэх учиртай.

- *Та “Тавантолгойд биш, таван хошуу малдаа найдаж амьдарцгаая” гэх уриалгыг хүчтэй дэвшүүлсэн. Үнэхээр ч манай улсын нийт өрхийн тэн хагас нь ХАА-н салбараас хамаарч байна?*

- Манай улсын нийт хөрөнгө оруулалтын хоёрхон хувь нь хөдөө аж ахуйн салбарт ордог. Гэтэл хөдөө аж ахуйн салбараас манай улсын нийт өрхийн тал хувь нь хамаарч байна. Өнгөрсөн 60, 70 жилд бидний хийж чадаагүй зүйл бол малаа эрүүлжүүлэх ажил байсан. Энэ алдааг засахын тулд малаа эрүүлжүүлсэн малчдаа дэмжихээр Засгийн газраас “Сайн малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчдын үйлдвэрлэлийн зээлийн хүүг 10 хувь болгож бууруулсан.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн шинэ боломжуудыг хөгжүүлэхийн тулд “Тавантолгойд биш, таван хошуу малдаа найдаж амьдарцгаая” хэмээн уриалж

байгаа. Бид зөвхөн хөрш орнууд төдийгүй Европын холбоо, Өмнөд Солонгос зэрэг өндөр хөгжилтэй орнууд руу экологийн цэвэр бүтээгдэхүүн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Ялангуяа Япон Улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг үр бүтээлтэй ашиглаж нэмүү өртөг үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чиглэлд түлхүү анхаарч, Японы үйлдвэрлэл, худалдааны сүлжээнд нэгдэн байр сууриа эзлэх нь чухал байна.

- Та АН, МАН, МАХН, ИЗНН, бие даагчид гэсэн бүтэцтэй парламентын дарга. Өөр өөр үзэл бодол, өдөр бүр тулгарах сорилтыг давах хэцүү юү?

- Одоогийн парламентын онцлог нь олонхигүй. Бодлогоо тодорхойлоод тэргүүлж явах намыг 2012 оны сонгуулиар ард түмэн сонгоогүй. Гэхдээ олуулаа болж чадсаны хувьд, миний дээр ярьсан бүтээн байгуулалт болоод дэлхийн эдийн засгийн хүндрэлийг бид зөв бодлогоор удирдаж ирсэн. Харин улстөрч хүний хувьд, хувийн амьдралаа хойш тавиад өөрийгөө төрд зориулдаг жишгээр өдөр бүр ирэх сорилтыг давж, дараагийн давааг харахын тулд л ажиллаж байна.

- Ер нь энэ парламентын онцлог юу вэ?

- Энэ парламент өөрөө дэлхий эдийн засаг хүндэрсэн цаг үед улс орныг удирдаж, угтан ирэх сорилтыг даван ажиллаж байгаагаараа онцлогтой, ачааны хүндийг үүрч буй парламент мөн.

- Та ирэх 4 жилийг хэрхэн харж байна?

- Ирэх 4 жилд Ардчилсан нам өнгөрсөн 4 жилд эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлэх боломжийг сонгуулиар авч чадвал эдийн засагт бидний эхлүүлсэн бүтцийн өөрчлөлт бодит дүр төрхөө олж, экспорт голлосон үйлдвэрлэл хөгжиж, уул уурхайн бус салбаруудын дарах жин нэмэгдэнэ. Бид яг тийм эхлэлийг нь тавьчихсан.

Дан ганц уул уурхайгаас хамааралтай эдийн засгаа дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ огцом унасан энэ он жилүүдэд элгээр нь хэвтүүлэлгүй өнөөгийн түвшинд барьж, үйлдвэржилтийг хөгжүүлэх чиглэлд бодитой томоохон алхмуудыг зоригтой хийсэн. Аливаа их ажлын үр дүн өргөс авсан мэт түргэн нүдэнд харагдаж, гарт баригдахгүй л дээ. Цаашид бидний авч хэрэгжүүлж, эхлүүлсэн бодлого маш зөв гэдэг нь амьдрал дээр батлагдах болно. Дэд бүтцийн хөгжил, боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эдийн засгийн урамшууллын механизм хөнгөлөлттэй зээлээр дэмжиж, дотоод зах зээлээ хамгаалах, экспортыг урамшуулах эрх зүйн орчинг бүрдүүлж чадсан. Цаашид энэ суурин дээр тулгуурлаад хийх ажил маш их байна.

Эцэст нь дахин хэлэхэд бид халамж авч суусан Монгол Улсыг үйлдвэрлэгч Монгол Улс болгох ажлыг эхлүүлчихлээ. Ардчилсан нам ухрагч биш санаачлагч, үргэлж анхдагч байж ирсэн. Цаашид ч бид эхлүүлсэн ажлаа тууштай үргэлжлүүлнэ. Ардчилалд хүрэх хязгаар гэж байхгүйтэй адил Ардчилсан намын хийж бүтээх ажилд төгсгөл гэж үгүй.

Улсын Их Хурлын гишүүн Миеэгомбын ЭНХБОЛД

ЛИДЕР



Монгол төрийн тулх нуруу, түших багана

XVIII зууны Францын их зохиолч Вольтерын хэлснээр дийлэнх хүмүүс хэн нэгэнд захирагдаж байх мөн чанартай гэнэ. Улмаар захирагдаж буй хүнээ даган дууриах хандлагатай байдаг аж. Харин философийн ухааны доктор Б.Галиндэв “Улс төрийн намыг төлөвшүүлнэ гэдэг лидер төлөвшүүлэх үйл явц” хэмээн хэлсэн. Тэгвэл “Засгийн эрхэнд гарсан намууд гишүүдээ зангидаж чадахгүй байгаагаас ийм замбараагүй юмнууд гараад байна” хэмээн философийн ухааны доктор, профессор Б.Даш-Ёндон гуайтай уулзах үед хэлж байв.

Гурван зууны алсад амьдарсан хийгээд амьдарч буй гурван хүний хэлсэн үгийн утгыг хураангуйлан томъёолбол, лидерийг төлөвшүүлэх нь намыг, төрийг, цаашлаад нийгмээ өөрчлөх чухал суурь болдог ажээ. Онол, номд зааснаар бол удирдлагадаа байгаа багийн гишүүдийг нэгэн зүгт чиглүүлж, тэдэнд зөв үлгэр дууриал үзүүлж, зөвөөр нөлөөлж чаддаг, зохион байгуулах чадвартай хүнийг ЛИДЕР гэж нэрлэдэг. Үүнийг яг өнөөдрийн Монголын улс төрийн амьдрал дээр буулгаж харвал МАН-ын дарга, УИХ-ын дэд дарга М.Энхболд лидер болж тодорч харагдаж байна.

Сөрөг хүчин МАН-ын дарга М.Энхболд өнгөрсөн дөрвөн жилд үнэхээр улс төрийн гал тогоонд чанагдсан лидер гэдгээ харуулж чадсан. Үүнийг батлахын тулд мэдээж нотолгоо хэрэгтэй. Нэгд, Монголын улс төрийг намууд авч явна. Хоёр нам байлаа гэхэд нэг нь зарчмаа барьж, монголчуудын хэлдгээр ноён нуруугаа авч явж байж наанадаж улсын хөгжил, цаанадаж тусгаар тогтнолын асуудал яригдана. Харин нам далайцаараа ноён нуруутай байхад дарга ихээхэн үүрэгтэйг МАН, АН-ын Энхболд нараас хангалттай харж болохоор.

МАН-ын дарга М.Энхболд өнгөрсөн жилүүдэд эвийг сахиж ажиллав. Намдаа ч, УИХ-ын дэд даргын хувиар ч эвийн тугийг барьж явснаараа тэр өнөөдөр

илүү тод лидер болжээ. Арван жилийн өмнө тэрбээр Эв нэгдлийн Засгийн газрын тэргүүнээр ажиллахдаа ч эвийг сахисан учир эдийн засаг өсч, цалин тэтгэвэр нэмэгдэж, ард иргэдийн 53.6 хувь нь түүний Засгийн газрыг дэмжиж буй нь судалгаагаар гарч байв. Улс төрийн намууд бие биеэ шүүмжилж суухаар үзэл бодлоо нэгтгэж, улс орныхоо хөгжлийн төлөө нэгдэж зүтгэх зөвшилцлийн санаачлагыг М.Энхболд өнгөрсөн жилүүдэд байнга санаачилж ирсэн. Улс төрийн намын дарга нарын Үндэсний зөвшилцөл уулзалтыг гэхэд л өнгөрсөн хугацаанд нийтдээ 13 удаа санаачлан зохион байгуулжээ.

Хоёрт, ёстой л нөгөө ханхар уул дүнхийнэ гэдэг шиг эрх баригчид бужигнаж, элдвээр дээрэлхэхийг оролдож, эх орноор тоглож байхад М.Энхболд зөвхөн зарчим л ярьсан. “Эрх баригчид нь ингэж болоод байхад бид яагаад болохгүй” гэж гэсэн өнгөц сэтгэхүйгээр асуудалд хандаж, адилхан л үймүүлээд явсан бол ард иргэдийн төрд итгэх итгэлийг арчиж хаях байлаа. Энэ бол МАН-ын дарга М.Энхболдын тулх нуруу байсан юм. Өнөөдөр Монголын төрд ам, ажил нь зөрдөггүй, хагалан бутаргадаггүй, ноён нуруутай, ёс зүйтэй, бусдыг хүндэлдэг хүн ус, агаар шиг л үгүйлэгдэж байна. Удирдаж буй нам /УИХ, Засгийн газар, яам ялгаагүй/-ын хамт олноо нэгэн зүгт чиглүүлж чаддаг алсын хараа ч хэрэгтэй байна. Ийм үед олон нийт МАН, түүний дарга руу харж байгаа нь ч үнэн. М.Энхболд лидер учраас харах нь ч аргагүй.

Бүтээн байгуулагч

Миеэгомбын Энхболд хэзээний л бүтээн байгуулагч улстөрч байсан. Бүтээн байгуулагч хүн хэзээ ч нураан сүйтгэгч байдаггүйн үлгэр жишээг ч бас үзүүлсээр яваа нэгэн. Улаанбаатар хотын Засаг даргаар ажиллахдаа хот гэдэг их айлыг айлын дайтай авч явсныг өнөө ч дурсан ярих хүн олон байдаг. Өнөөдөр МАН хэмээх их айлыг мөн л айл шиг айл байлгаж, УИХ-ын дэд даргын албыг хашсан шиг хашиж байгаа учир өмнөх зам мөрийн улбаа ч тодрон харагдах нь зүй юм. Ганцхан жишээ. 2004 онд М.Энхболд хотын даргаар ажиллаж байхдаа ард иргэдээсээ хандив цуглуулж, Сүхбаатарын талбайг гантигдсаныг сая л сонсов. Хөшигтийн хөндийн олон улсын онгоцны буудлыг 10 жилийн өмнө Ерөнхий сайд байхдаа Японд айлчилж, тус улсын Ерөнхий сайд Койзүмитай уулзахдаа анх санал тавьснаар Ази, Европыг холбосон агаарын хамгийн дөт зам Улаанбаатарын ойролцоо олон улсын нисэх буудал баригдах асуудал шийдэгдсэн юм. Энэ мэтээр хотын дарга, Ерөнхий сайдаар үр бүтээлтэй ажилласан хүнд хийсэн ажил маш их, хэлэх үг ч олон. Гэвч даруухан дарга М.Энхболд бусад шиг “шоудаж чаддаггүй учир” даруухан сууж, мэддэг бусад хүмүүс нь үргэлж үнэлж ярьдаг.

Өнгөрсөн дөрвөн жилд сөрөг хүчний байр суурин дээр байхдаа ч МАН-ын дарга хөгжлийн бодлого, бүтээн байгуулалтын асуудлаар л байр сууриа хамгийн их илэрхийлжээ. УИХ дээр ч, намынхаа хурлууд дээр ч улс төр тойрсон элдэв хэрүүл гэхээсээ хөгжлийн асуудлыг байнга хөндөж байсан нь олон түмний сонсохыг хүсдэг сэдвийн нэг болсон. УИХ-ын дэд дарга, МАН-ын дарга М.Энхболд нийслэл хотоос нэг удаа, төрөлх Төв аймгаасаа хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа. Тойргийн ард иргэдийнхээ санал бодлыг маш сайн сонсч ажилладаг учраас хөгжлийг хөтлөөд хүргэчихсэн. Сүүлийн үед тус тойргийн сонгогчид бэрхшээл зовлон тоочихоосоо илүү хөгжлийн элдэв асуудлыг уулзалт дээр түлхүү хөнддөг болсон гэнэ.

Бүтээдэг хүн хөгжил ярьдаг. Бүтээдэг хүн нураадаггүй юм.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн ЭНХБОЛД

ЗӨВ ЯВАХЫН ЖИШЭЭ



Нямаагийн Энхболд гэдэг дөч гаруй насны эр анх 2000 онд УИХ-ын гишүүнээр сонгогдож байв. Тэр үед одоогийнх шиг олны танил хүмүүс улстөрч болдог “мода” дэлгэрээгүй байлаа. Тэр тусмаа тухайн үеийн МАХН гэдэг их айл бол нэр дэвшигчээ олон жил дагуулж, “давтаж” байж “Төрийн хүний цээнд хүрсэн”-д тооцдог, тэд нь ч одоогийнхоор бол онцын “пиар”-гүйгээр сонгогддог байв.

Парламентын сэтгүүлчийн хувьд шинээр сонгогдсон гишүүдтэй ярилцана гэдэг “нээлт хийхтэй” адил. Тэднийг нээнэ, болж өгвөл барьц алдуулна гэдэг кайфтай байлгүй яах вэ. Ингээд Н.Энхболд гишүүнийг урилаа. Тэр бүр ярилцлага өгөөд байдаггүй ч “Тэнгэрлэг эрчүүд” гэсэн танил булан таашаал билэгшээлтэй санагдсан юм болов уу, арайхийн зөвшөөрөв. Яагаад ч барьц алдах шинжгүй. Харин ярих тусам төвийг сахисан төвшин нуруутай тэр эрийг олон жил “Төрд байх ёстой” хүмүүсийн нэг юм даа гэх сэтгэгдэлтэй салж билээ.

Миний “шинжсэн морь” санаснаас минь хавьгүй хол давхиж, өнөөдөр нүүр улайлгалгүй төрийн нуруу төвшин байхын тод жишээ болоод байгаад нь би жигтэйхэн баярлаж явдаг юм. Эрхэм гишүүнтэй нүүр тулан уулзахын тухайд тусгайлан ярилцлага авах биш л бол бараг л таван жилд нэг удаа таарна. Гэхдээ хаана, юу хийж явааг нь алган дээрээ тавиад харж байх мэт. Ингэж л хар, цагаан хосолсон мэдээлэл дунд зөвхөн сайн мэдээг чихэнд дуулгаж 16 жилийг үднэ гэдэг тийм ч элбэг тохиолдол биш билээ.

Өнгөрсөн хугацаанд Н.Энхболд гишүүн УИХ-ын дэд дарга, Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гээд аль л ноён нуруу шаардсан, төрийн нүүр царайг харуулсан албан тушаалуудыг чих халууцуулалгүй хашсан юм. Түүнийг өдий хугацаанд алба хашихдаа ажлын алдаа, авлигын сураг ч дуулгаж байгаагүй, тэр ч байтугай хувийн бизнестэй болж чадаагүйд нь хүртэл баярлаж явдгаа нуугаад яах вэ. Учир нь энэ бүхэн

“Төрд цэвэр ажиллаж болдог”, “Төрөөс тэрбумтан төрөх албагүй” гэхчлэн зарим теоремыг батлахад минь айхавтар том амьд жишээ болж явдаг юм. Тэрбээр “зөөлөн зөөлөн замбуулин”-д зөв яваа түшээ мөн. Гэхдээ энэ нь зөөлөн хүн гэсэн үг огт биш. Зарчимч, ялангуяа буруу гэж бодсон зүйлдээ дөргүй бух шиг зөрүүдлээд суучихдаг гэж нэг танхим дахь нөхрийнх нь хэлсэн нь үнэний хувьтай.

Түүнийг хамгийн тод харуулсан сонгууль нь 2008 оны сонгууль болов уу гэж боддог юм. Хөтлөлцөөд гардаг Төв аймгийн дөрвөн гишүүн мөн л ялсан. “Онц ноцтой” хүчтэй сурталчилгаа хийж харагдаагүй. Харин сонгогдсон хойноо Н.Энхболд гишүүн УИХ-ын дэд даргаар 4 жил ажилласан. 2012 оны сонгуулийн дараа ч мөн УИХ дахь МАН-ын бүлгийн даргаар ажилласан юм. Нуулгүй хэлэхэд түүнд намын дарга болох боломж ч байсан. Гэвч тэрбээр өнөөх л бүлэг, фракц гэх задралд дургүй, “бүхнийг дундынх” байлгах гэдэг эв нэгдлийг эрхэмлэдэг, дээр нь хүн чанараа харуулж намын даргын суудлаас мултраад гарчихаж билээ. Тэр дэмжих баггүйдээ нэрэлхээгүй, хөтлөлцөөд гарсан нутгийн гишүүнээ дарга болоход нь дэм болбол надад биш намд хэрэгтэй гэж үзсэн болов уу гэсэн хардлага төрдөг юм. Ээ дээ, бараг зөрөөгүй л болов уу.

Төв аймгийнхан нь түүнийг зөв, жудагтай хүн болохоор нь итгэл хүлээлгэдэг байж таарна. Харин улс төрийн хүрээнд түүнийг нам, намд нөхөдтэй хэр нь яг өөрийнх нь “харьяалдаг” багийнхан гэхээр төөрчихөөд байдаг юм. Н.Багабанди, С.Баяр, Л.Энэбиш агсных, М.Энхболдынх гээд овоглох гэж оролдож үзсэн ч сонгогчид түүнийг “Ж.Самбуугийнх” гэж тодорхойлчих гээд байдаг. Монгол төрийг дээдэлдэг, монгол үнэртэй, малчид, тариаланчдад талтай гээд тоочвол нэг их холдохгүй ч байж мэдэх юм. Товчхондоо зөв зарчим хаа байна, Н.Энхболд тэнд санал нийлдэг. Задрал, хагарал, хувийн эрх ашгийн нэгдэлд маш дургүй тэрбээр их улс төрөөс хөрөнгөө зузаалж гарахыг хүсээгүй.

Хатуухан хэлэхэд орлого багатай гишүүдийн тоонд ордог юм билээ. Нэгэнтээ УИХ-ын гишүүн, дархан аварга Б.Бат-Эрдэнийн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихдээ “брэнд, тренд” болгосон “Гар цэвэр, нэр цэвэр, сэтгэл цэвэр” л байх нь Н.Энхболд гишүүний хувьд капитал болж үлдэх нь дамжиггүй.

Парламентын соёл, төрийн хүний төлөвшлийн талаар Н.Энхболдын яриаг залуу улстөрчдөөс эхлээд сэтгүүлчид хүртэл сонсох, олонд түгээх дуртай байдаг. Хүний хуучин, дээлийн шинэ нь дээр гэдэг. УИХ-ын гишүүд туршлагатай, тулхтай, нүдний болоод сэтгэлийн хор гарсан хүмүүс байх ёстой. Ялангуяа төр, засаг хөл толгойгоо алдсан өнөө цагт. Тэрбээр монгол төрийн сүүлийн 16 жилийн амьд гэрчийн хувьд алтан дундаж, тэрүүхэндээ лавлах товчоо, туйлшраагүй архив нь яах аргагүй мөн.

Яг энэ цаг үетэй мөр зэрэгцэн яваа улстөрчдийг авч үзвэл иртэй, хурц, холбиромтгой, мөлүүхэн, гэнэн цагаахан гээд олон өнгө бий. Харин зарчмаа л дагаж, нүдэнд үл үзэгдэж, зөвхөн сэтгэлийнх нь хоймрыг эзлэх тэр дотор хүнтэйгээ л зөвлөлдөж шийддэг алсын хараатай, ашиг унацаас холуур, ёстой л Ж.Батмөнх агсан шиг ундны усаа Дамбадаржаагийн худгаас өөрөө зөөж, Ц.Намхайнambuу агсан шиг оюутны байранд жижүүр хийж, насаараа шахам төрийн сан хөмрөгийг атгаж байсан хэрнээ Ерөнхий сайд асных нь хувьд ярилцлага авахаар очиход цоорч элэгдсэнийгээ цойлдож өмсөөд гоёчихсон суудаг П.Жасрай агсан шиг тийм л шуналгүй төрийн зүтгэлтний үнэр энэ хүнээс ханхалдаг юм.

Энэ ховор “үнэр”-ийнх нь төлөө, үнэнч зарчимчийнх нь төлөө Нямаагийн Энхболд гэдэг хүнд Төв аймгийнхан төдийгүй монгол түмэн итгэдэг билээ.

Улсын Их Хурлын гишүүн Өлзийсайханы ЭНХТҮВШИН СЭТГҮҮЛЧДИЙН АРМИЙН ТҮҮЧЭЭ



Монголын парламентын түүхийг туурвин бүтээсэн анхны сэтгүүлчдийн нэг бол Өлзийсайханы Энхтүвшин. Тэрбээр 1990-1995 онд “Ардын эрх” сонины парламентын тоймчоос хариуцлагатай нарийн бичгийн дарга, 1995-1996 онд Монголын радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга, улмаар МАХН-ын нарийн бичгийн даргаар 1996-1997 онд ажиллаж байхдаа “Үнэн” сонины ерөнхий эрхлэгчийн албыг тус тус хашиж байжээ. Энэ бүхэн нь түүнийг Монголын хэвлэл мэдээллийн хөгжил, сэтгүүлчийн зам мөрийг тэгшитгэж явсныг гэрчилнэ.

Парламентын сэтгүүлчээс төрийн түшээ болоод 30 гаруй жил улс төрийн халуун тогоонд чанагдаж яваа түүний амьдралын намтар түүх арвин бөгөөд хэлэх үгтэй, хийсэн ажилтай нэгэн билээ.

Ө.Энхтүвшин эхээс арвуулаа. Багаасаа л олон дүү нараа гэсээр хэрсүүжиж өссөн гэх. Айлын эмээд ус дөхүүлж өгөөд шанд нь авсан чихрээ хэд таллан есөн дүүдээ л хувааж өгнө. Ангаахай шиг тэд нь ч “Ах гоё юм авчирна” гэдэг итгэлтэйгээр хүлээж байгааг ойлгож өссөндөө ч тэр үү, тэр одоо ч хүүхдүүддээ дэмий юманд зарцуулах мөнгө барагтай л бол өгдөггүй аж. Ямартаа л хүүхдүүд нь сургуулийнхаа хажуугаар цагийн ажил хийдэг байхав.

Сумын сургуулиас оюутны амьдрал руу, сэхээтнээс төрийн түшээ, сайдын сэнтийд суухдаа ч эрсдэлтэй, амаргүй шийдвэрүүдээс тэр ухарч, няцалгүй хариуцлагатай, зарчимч байр суурийг баримталж ирсэнтэй хэн ч маргахгүй. Барагтай л бол үг дуугардаггүй, сэтгэл хөдлөлөө тэр бүр ил гаргаад байдаггүй. Түүний энэ байдлыг нь ажихаар итгэж болох хүн санагддаг. Тэрбээр 1976 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн дунд сургууль, 1980 онд МУИС-ийг түүхч, түүхийн багш мэргэжлээр, 1989 онд ЗХУ-ын Коммунист намын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академи төгссөн. 2000-2004, 2006-2008 онд УИХ-ын гишүүнээр сонгогдож, Засгийн газрын гишүүн, Хэрэг эрхлэх газрын

дарга, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, 2008-2010 онд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын албыг тус тус хашиж байв. Түүнийг 2012 онд УИХ-ын зургаа дахь удаагийн сонгуулиар УИХ-ын гишүүнээр дахин итгэл хүлээлгэн сонгосон юм.

УИХ-ын гишүүнээр сонгогдож, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар томилогдон ажиллах хугацаандаа тэрбээр дөрвөн жил нойр хоолгүй зүтгэж, үр дүнтэй ажилласан. Яг энэ он жилүүдэд Мянганы замын бүтээн байгуулалт өрнөж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал хэрэгжиж эхэлжээ. Өмнөх дөрвөн жилд эрх баригчдын өвдгөөр нь газар хэвтүүлсэн эдийн засгийг хөл дээр нь босгоход хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэг. Тийм учраас монголчууд түүнийг андахгүй.

Тэрбээр төр түмэндээ нэгэнт танигдсан, цаасан дээр намтар түүхтэй, цасан дээр тод зурагтай мөртэй нэгэн. Төрийн алба хашиж буй олон хүнд тэр бүр байдаггүй эгэл даруу зан, түвшин нуруу, хачин намбалаг төрх түүнд бий. Хөвсгөл нуур шигээ гүн бодолтой. Олныг эргэцүүлдэг болов уу гэмээр ухаалаг харцтай. Хотгойдын Шадар ван Чингүнжав баатраар бахархаж, үлгэрлэж өссөн нь гүдэс шулуун зангаас нь илэрнэ.

Тэрбээр энэ удаагийн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг, Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл, Монгол Улсын хилийн боомтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эдийн засгийг хүндрэлээс гаргах арга хэмжээний хөтөлбөр батлуулах тухай УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, Монголын Иргэний агаарын тээврийн салбарын үйл ажиллагаатай танилцаж, дүгнэлт хийх, цаашид тус салбарын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх шийдвэрийн төсөл боловсруулах, Санхүүгийн чөлөөт бүс байгуулах тухай хуулийн төсөл боловсруулах, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай, Улаанбаатар хотод зүүн хойд Ази, Төв Азийн бүс нутгийн банк, санхүүгийн төв байгуулахтай холбогдсон хууль боловсруулах зэрэг ажлын хэсгүүдэд орж ажиллажээ. Мөн Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах, үндсэн чиглэл батлах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, уг хуулийг батлуулсан юм.

Энхтүвшингийн аав Өлзийсайхан гуай намын ажилтан байж. Гайхалтай ажилсаг, гайхамшигтай хүнлэг энэрэнгүй хүн байсан юм гэнэ лээ. Тэр хүн насаараа нутгийнхаа зон олны төлөө, Монголынхоо төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэжээ. Ө.Энхтүвшин эцгээ дуурайсныг нутгийн хүмүүс дурсан ярьдагийг мэднэ. Мэдэх мэдэхдээ хүн ардаа хайрлах сэтгэл, Монголын төлөө цохилох зүрхтэй нэгэн гэдгээр нь мэднэ. Энэ хүн хөрөнгө хурааж бизнес хийсэнгүй, хурдан морь, үнэт эдлэл цуглуулаагүй, хилийн чанадад хөрөнгө нууж “оффшор данстан” ч гэж цоллуулсангүй. Ингээд бодохоор гагцхүү монгол төрөө цэвэр ариун байлгахын төлөө сэтгэл, оюунаа зориулан шударга ёсны төлөө зүтгэж, тэмцэж, асч яваа хүн юмдаг. Түүний амьдарч ирсэн зам мөр даанч хайрламаар дэндүү үнэн.

Улсын Их Хурлын гишүүн Содномзундуйн ЭРДЭНЭ

ХУУЛИЙН АВТОР



С.Эрдэнийн хувьд энэ удаагийн парламентын дөрвөн жил онцгой үр бүтээлтэй он жилүүд байсан гэж хэлж болно. Учир нь тэрбээр Баянгол дүүргийнхээ сонгогч түмний итгэлийг хүлээж УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар томилогдон ажиллахдаа иргэд сонгогчид, олон түмэндээ амласан хэлснээ бүтээж хэрэгжүүлэхийн төлөө олныг санаж сэдэж, уйгагүй ажилласныхаа үр өгөөжийг харж, бахархаж яваа нэгэн.

Төрийн түшээ С.Эрдэнэ энэ парламентын бүрэн эрхийн хугацаанд Хамтын тэтгэврийн тухай, Ажилласан жил нөхөн тооцох тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай, Хүүхдийн эрхийн тухай зэрэг 52 хууль санаачилж, 31-ийг нь УИХ-аар батлуулжээ. Санаачилсан хууль бүр нь хүний амь, амьдралтай холбоотой нарийн эмзэг асуудлыг хөндсөн байдаг нь хал үзэж хашир суусан парламентч гэдгийг илтгэнэ.

Тэрчлэн иргэдийнхээ амьдралд бодитой дэмжлэг үзүүлэхүйц зүйл, заалтыг нягт нямбай тооцож боловсруулсан байдаг учраас түүний санаачилсан хууль УИХ-ын өндөр босгыг харьцангуй төвөг багатай давдаг нь үнэн. Тэр чинээгээрээ ард түмэнд үр өгөөжөө өгч, олон нийтийн талархал хүлээсээр иржээ. Ахмадууд түүнийг “Бидэнд ээлтэй хүү” гэж ойшоодог бол залуус “Учир мэдэх хүн” гэж итгэнэ. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамыг толгойлсон эхний жилээ л тэр анх удаа Залуучуудын асуудал хариуцсан нэгжийг бий болгож, Залуучууд хөгжлийн үндэсний хөтөлбөрийг санаачлан батлуулж байлаа. Мөн Баянгол дүүрэг анх удаа дүүргийнхээ иргэдэд үнэ төлбөргүй үйлчилдэг нийтийн номын сантай болж, залуус дүүргийнхээ “Хуримын ордон”-д гэрлэх ёслолоо үйлддэг болж байгаа нь түүний хийсэн ажлын нэгээхэн хэсэг.

Хууль цаасан дээр бий болдоггүй, амьдралаас урган гардаг гэдэг. Үнэхээр түүний санаачилсан хууль бүхэн амьдралаас үндэслэсэн байдаг учраас нийгмийн

хөрсөнд гүнзгий сууж, иргэдийнхээ амь амьжиргаанд дэм болж явдаг юм. 1990-2000 онд монголчуудын олонхи тогтсон ажилгүй, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөлгүй явж ирснийг тэр л анзаарч харсан. Өөрөө ч тэр цаг үеийн бүтээгдэхүүн учраас бусадтайгаа зовлонтой нэгтэй байсан биз. Ажилласан жил нөхөн тооцох тухай хуулийг санаачлан батлуулснаар олон хүний бүрэн тэтгэвэр авах эрх нээгдэж, түүнээс ч олон хүн тэтгэврийнхээ хувь хэмжээг нэмүүлжээ. 1995 оноос хойш Монголын Засгийн газар иргэддээ өртэй явж ирсэн. Нийгмийн даатгалын нэрийн дансны тухай хуулийн дагуу 1960 оноос хойш төрсөн хүн бүр нэрийн данстай болж, нийгмийн даатгалын шимтгэлээ хуримтлуулдаг болсон. Гэтэл 2015 он хүртэл энэ мөнгө зөвхөн цаасан дээр л байлаа. Харин С.Эрдэнэ гишүүн хөөцөлдсөөр ипотекийн зээлийн эргэн төлөлтийн гурван их наяд гаруй төгрөгийг Нийгмийн даатгалын санд байршуулж, иргэдийг бодит мөнгөн хуримтлалтай болгох эхлэлийг тавьсан. Энэ мөнгөөр иргэдийг орон сууцжуулах Ипотекийн зээлийг санхүүжүүлэхийн зэрэгцээ Засгийн газрын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх юм. Энэ бол тэр хойч үеийнхээ өмнө хийсэн ажилтай, хэлэх үгтэй хүн гэсэн үг. Үүгээр ч дуусахгүй.

ХАХНХЯ-ыг толгойлсон дөрвөн жилд нь Нийгмийн даатгалын сангийн хүүгийн орлогоор 200 гаруй тэрбум төгрөг олсон бол өмнөх дөрвөн жилд 30 хүрэхгүй тэрбум төгрөгийн орлого олж байжээ. “Баянхог” хочтой нийслэлийн дүүргийг Баянгол болгож, улсын хэмжээнд сүүлийн 32 жилд бариагүй эмнэлэг, 25 жил сураг нь дуулдаагүй Хүүхдийн эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулжээ. Энэ бол түүний хүний төлөө гэсэн сэтгэлээс урган гарсан ажлын үр дүн.

Тэр бол хуулийн ч, бүтээн байгуулалтын ч автор байж чаддаг хүн юм.

---oooOooo---

Улсын Их Хурлын гишүүн Дондогдоржийн ЭРДЭНЭБАТ

ТӨРИЙН ХҮН



Бөх болгон аварга болдоггүйтэй адил улс төрийн намд орсон, УИХ-д сонгогдсон болгон улстөрч болдоггүй. Тэднээс зарчимтай нь, олны итгэлийг дааж чадсан нь цаашаа явдаг. Тийм хүмүүсийн нэг нь УИХ-ын гишүүн, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат юм. Тэрбээр уурхайн засварчнаас эхлээд хэсгийн дарга, дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, дүүргийн Засаг дарга, Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн дарга, УИХ-ын гишүүн, тэгээд өнөөдөр төрийн сайд болтлоо Монголын улс төрд явж иржээ. Явах нэг хэрэг. Хамгийн гол нь улс төрийн карьер нь тасралтгүй, замдаа уналтгүйгээр дандаа өгсөж ирсэн нь түүнийг улстөрч хүнд байх хамгийн гол шалгуур болох итгэл алдаагүйг илтгэнэ.

Сайн улстөрч улс төрийн намд хэрэгтэй. Харин монгол төрд, монголчууд бидэнд, жирийн сонгогч та бидэнд төрийн хүн, төрийн зүтгэлтэн илүү хэрэгтэй. Төрийн хүн, улстөрч хоёрыг ялгахад хэцүү ч гэлээ тухайн хүний асуудалд хандах хандлагаар хэн нь төрийн хүн, хэн нь улстөрч вэ гэдгийг ялгах их амархан. Ерөөсөө тэднийг ялгадаг ганц гол арга нь энэ. Улстөрч хүн ямарч асуудалд тодорхой бүлгийн, бүлэг сонирхлын, тодорхой эрх ашгийн өмнөөс ханддаг. Харин төрийн хүн түүнээс дээгүүр, нийтлэг эрх ашиг, том зургаа эрхэм болгодог. Үүгээрээ төрийн хүн улстөрч хүнээс зааг ялгаатай.

УИХ-ын гишүүн, Аж, үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатын хувьд аль нэгэн фракц, компани, бүлэглэлийн эрх ашгийг хамгаалж, тэдний өмнөөс асуудалд хандаад байдаггүй. Олон хүн Д.Эрдэнэбат сайдыг төр талдаа илүү ханатай гэж хэлнэ. Яагаад гэвэл өнөөдрийг хүртэл улс төрд яваа “замын зураг”-аас нь харвал Д.Эрдэнэбат гишүүн асуудал бүрт хашиж байгаа албан тушаалынхаа үүрэг, зиндаанд дүйх байр суурь баримталж ирсэн харагддаг. Ам, ажил нь нийлдэг гэдэг шиг Д.Эрдэнэбат гишүүний хувьд албан тушаал, зарчим хоёр нь зөрчилддөггүйг журмын нөхөд нь хэлдэг. Үүнийг түүний улс төрийн амьдралын мөчлөгт тохиосон

хамгийн “том”, хамгийн өндөр хоёр албан тушаалын дараах хоёр жишээнээс харьцуулан харах боломжтой.

Д.Эрдэнэбатыг намын “гал тогоо”-г барьсан дөрвөн жилд Ардчилсан нам УИХ-ын сонгуульд хамгийн олон суудал авсан, түүхэндээ анх удаа орон нутгийн сонгуульд ялсан, ардчиллын төлөөх намуудын нэр дэвшигч 1990 оноос хойш анх удаа Ерөнхийлөгчийн сонгуульд ялсан юм. Хувь хүнийх нь хувьд авч үзвэл Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн даргаар дөрвөн жил буюу хамгийн олон жил ажилласан, бас энэ албан тушаалаас огцроогүй, дэвшиж явсан цорын ганц генсек.

Тэрбээр 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа УИХ дахь намын бүлгийн дарга болов. Намаа ялуулсан намын генсек яагаад сайд биш, бүлгийн дарга болсныг сэтгүүлч асуухад “Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг биелүүлэх нь миний сайд болохоос чухал. Нам УИХ-ын гишүүдээ хамгийн сайн чадах ажил дээр нь томилсон” гэж хариулсан байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө биелүүлэхийн тулд Засгийн газраа тогтвортой ажиллуулах, Засгийн газраа тогтвортой ажиллуулахын тулд бүлгээ зангидаж, фракцуудын тэнцвэрийг хадгалах үүрэг дахиад Д.Эрдэнэбатад ногдсон нь энэ.

Н.Алтанхуягийн дараа Ерөнхий сайдаар томилогдсон Ч.Сайханбилэг аж үйлдвэрийн салбарыг яамтай болгохоор зориг шулуудав. Зориг шулуудав гэсний учир нь Монгол Улс 1968 оноос хойш энэ салбарт “загасчны морь” усгүй мэт явж иржээ. Аж үйлдвэрийн түүхий эд болох бүх төрлийн баялагтай атлаа боловсруулах үйлдвэр бараг үгүй, салбар нь яамгүй, төрийн нэгдсэн бодлогогүй, бас хуульгүй. Ийм л эзгүй талд хана дугуйлж, гэр барьж чадах баталгаатай хүний эрэлд Ардчилсан намынхан гарав. Тэгж явах үед нам дотроо Ерөнхий сайдад Ч.Сайханбилэгтэй өрсөлдөөд ялагдсан Р.Амаржаргал гишүүн “Ерөнхий сайдад өгч чадах миний хамгийн сайн зөвлөгөө байж магадгүй юм” гэж байгаад Аж үйлдвэрийн сайдад Д.Эрдэнэбатыг санал болгосон гэдэг юм билээ.

Ингээд шинэ яам байгуулж, шинэ сайд ажлаа авав. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогоо батлуулж, нефтийн үйлдвэр барих шийдвэрийг анх удаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хэмжээнд зөвлөмж болгон шийдвэр гаргуулав. Одоо говийн бүст барих нефтийн үйлдвэрийн ТЭҮЗ-гээ хийлгэнэ, үйлдвэр барих ажлыг эхлүүлнэ гэж зүтгэж явна. Яагаад гэвэл нефтьтэй мөртлөө нефтийн үйлдвэргүй, шатахуунаа гаднаас авдаг дэлхийн дээрх цорын ганц улс нь Монгол. Тэгэхээр дотооддоо шатахуун үйлдвэрлэх нь Монгол Улсын стратеги юм.

Сайдын тооцоогоор эхний ээлжид говийн бүст хоёр сая тонн нефть боловсруулах үйлдвэр барьснаар манай улс шатахууныхаа жилийн хэрэгцээний 40 хувийг дотоодоосоо хангана. Ингэж чадвал жилд зөвхөн бензиний импортод өгдөг “Чингис бонд”-той тэнцэх 1.5 тэрбум долларын урсгалыг дотооддоо авч үлдэнэ. Ингэснээр өнөөдөр 2000-ыг даваад байгаа долларын ханш 1000 төгрөгтэй тэнцэх боломжтой гэж салбарын мэргэжилтнүүд нь тооцоолжээ. Үүнийг төрийн бодлого болгох нь улстөрчдийн шийдэл. Харин хэрэгжүүлэх нь төрийн хүний ажил.

Тэгэхээр төрийн хүн бол бодлого тээгчээс гадна Монгол Улсын төлөө бодлого боддог, тэрийгээ хэрэгжүүлж чаддаг, хэрэгжүүлэхийн төлөө зүтгэдэг хүн байх ёстой. Ийм эрхэм чанар түүнд бий.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын ЭРДЭНЭБАТ ТӨСӨВ ЗАНГИДАГЧ



Ж.Эрдэнэбат 1981-1991 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын 10 жилийн дунд сургууль, 1992-1995 онд Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль, 1997-1998 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, 2002-2004 онд Удирдлагын академи, 2003-2005 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч мэргэжилтэй. Эдийн засгийн ухааны магистр.

Тэрбээр 1996-1997 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Сүүтэй” ХХКомпанид нягтлан бодогч, 1997-2000 онд аймгийн Хянан шалгах хороонд байцаагч, 2000-2004 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, 2004-2005 онд аймгийн Засаг даргын орлогч, 2005-2008 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын алыг хашиж байгаад 2008-2012 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргаар ажиллажээ. Улмаар 2012 оны УИХ-ын зургаа дахь удаагийн сонгуулиар Сэлэнгэчүүдийнхээ итгэлийг хүлээн УИХ-ын гишүүнээр сонгогдож, хэсэг хугацаанд Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилогдож улсынхаа төсвийг атгаж ажилласан түшээ.

УИХ-д суудал бүхий намуудын хамтарч байгуулсан Шийдлийн Засгийн газар байгуулагдахад тэрбээр Сангийн сайдаар томилогдож, зарлага нь орлогоосоо хэд дахин давж, нэгдсэн төсвийн алдагдал нь хэдэн зуун тэрбумаар хэмжигдэж байсан Монгол Улсын төсвийг нэгтгэн зангидаж чадсан гавьяатай нэгэн. Үүнд түүний үндсэн мэргэжил, энэ салбарт нягтлан бодогчоос эхлээд аймгийн Засаг дарга хүртэл шат дараалан дэвшиж ажилласан мэдлэг чадвар, дадлага туршлага нөлөөлсөн нь лавтай.

Ж.Эрдэнэбат Сэлэнгэ аймгийн Мандал сум, олны нэрлэж заншсанаар Зүүнхараа хотын хүүхэд. Ноён уулын ар бэлийг ороон урсах Хараа гол, түүнээс салбарлан мяралзах Тултын тохой бол түүний өндөр дээд эцэг өвгөдийнх нь

өлгий нутаг юм билээ. Өвөө нь Хэрх тосгоны арван жилийн сургуулийн захирлаар олон жил ажиллаж боловсролын салбар, тэр дундаа газар тариалан хөгжсөн сумын сургууль эдийн засгийн хувьд хөл дээрээ бат зогсох учиртай хэмээн үзэж, сургуулийнхаа дэргэд нарийн ногооны туршилтын талбай бүхий хөдөлмөр амралтын зуслан, жижиг аж ахуй байгуулсан нь БНМАУ-ын хэмжээнд анхдагч болж, туршлага судлах гэсэн хот, хөдөөгийн багш нар Хэрх тосгоныг зорьдог байсан түүхтэй аж. Тиймээс Ж.Эрдэнэбат аавынхаа зөвлөснөөр эдийн засагч мэргэжлийг сонгосон нь түүнийг ирээдүйтэй санхүүч болох эхлэлийг тавьжээ.

Тэрбээр аймгийн санхүүгийн албаны даргаар найман жил ажиллах хугацаандаа мэддэг, чаддаг бүхнээ нутгийн зон олондоо харуулж, тэр хэрээр итгэлийг нь олж чадсан учраас түүнийг Залуучуудын холбооны тэргүүн, улмаар 2008-2012 онд Сэлэнгэчүүд санал нэгтгэйгээр Засаг даргаараа сонгож, хувь заяагаа даатгажээ. Ж.Эрдэнэбатыг Засаг даргаар ажилласан жилүүдэд Сэлэнгэ аймаг улсад ажил үйлсээрээ жил дараалан шалгараад зогсохгүй “Атрын III аян”-ыг амжилттай хэрэгжүүлсэн тул Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан тус аймгийг Сүхбаатарын одонгоор шагнасан байдаг. Түүнийг Засаг даргын албыг хүлээж авахад Сэлэнгэчүүд эргэлтийн талбайнхаа дөнгөж 30 хувьд нь үр тариалдаг байсан бол дөрвөн жилийн дараа буюу УИХ-д сэлэнгэчүүдээ төлөөлөн суухаар мордоход дээрх үзүүлэлт 100 хувьд хүрсэн нь түүний хөдөлмөр зүтгэлийн нэг илрэл гэж хэлж болно. Түүнчлэн аймгийн төвийн бүх гудамж, талбайг гэрэлтүүлэгтэй болгож, хотын доторхи дэд бүтцийнхээ асуудлыг бүрэн шийдэж чадсан төдийгүй ажлын байрыг 25 хувиар нэмэгдүүлсэн, эрүүл мэнд, боловсролын салбарын ажил байдалд онцгой анхаарсан, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж чадсан, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хүүгүй зээл олгосон гээд түүний хийж бүтээсэн ажил их ээ.

Ж.Эрдэнэбат төр түшилцсэн өнгөрсөн дөрвөн жилд ч хэн болохоо сонгогч олондоо бататган таниулсан төдийгүй хэр улстөрч вэ гэдгээ санаачилсан хуулийн төсөл, ажлын хэсэгт орж ажилласан байдал зэргээрээ харуулж чадсан. Сангийн сайдаар ажиллахдаа төрийн албан хаагчдыг цомхотголд оруулахгүй гэсэн байр суурийг тэрбээр хатуу баримталж, зөвхөн төр, захиргааны албан хаагчдын хэмжээнд цомхотгол явуулсны дээр хэмнэж болох бүхий л зардлыг төсөвлөхгүй байхыг үүрэг болгосон байдаг.

Тэрбээр улс орон маань хөгжилтэй бол иргэдийн амьдрал ч гэрэл гэгээтэй байх болно гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй явдаг нэгэн. Ийм хүнд итгэл сэтгэлээ өгдөг сэлэнгэчүүд, түүний дотор Зүүн, Баруунхараа, Ерөөгийн ард түмэн ухаантай, бас азтай. Түүнд цаашид ч ихийг хийж бүтээх хүсэл эрмэлзэл, мөрөөдөл, боломж чадавхи бүрэн дүүрэн бий.

---oooOooo---

Улсын Их Хурлын гишүүн Лувсангийн ЭРДЭНЭЧИМЭГ

“МОНОС” ЦЭЦЭГЛЭСЭЭР



1990 оны Цагаан морин жилийн ардчилсан хувьсгал өрнөхөд Л.Эрдэнэчимэг Болгарт төгсөх курсийн оюутан байжээ. Энэ бол Зүүн Европ даяар ардчилал өрнөж, зүүн баруун Германыг заагласан Берлины хана нурж байсан түүхэн үе. Түүнийг 1990 оны өвлийн амралтаараа Монголд ирэхэд ах нь өлсгөлөнд сууж байсан тул амралтын хэд хоногоо ахынхаа хажууд талбай дээр өнгөрүүлсэн байдаг. Өлсгөлөн ардчиллын залуусын ялалтаар дуусахад тэрбээр Болгарт буцаж ирээд оюутнуудаа цуглуулж МоАХ-ын салбар зөвлөл байгуулан ЭСЯ дээр цуглаан зохион байгуулж, тухайн үеийн Элчин сайдад МОАХ-ны салбар байгуулагдсаныг албан ёсоор өргөх бичгээр мэдэгдэж байсан ардчилсан хувьсгалын анхдагчдад зүй ёсоор тооцогдох нэгэн юм.

Энэ удаагийн парламентад компаниараа овоглож орж ирээд санаачлан батлуулсан хуулиараа нэрлэгдсэн цөөхөн гишүүн байдгийн нэг нь “Монос”-оос “Тамхины хяналтын” болж хувирсан Л.Эрдэнэчимэг гишүүн юм. Л.Эрдэнэчимэг өнгөрсөн 2012 оны УИХ-ын сонгуульд Ардчилсан намаас Сонгинохайрхан дүүрэгт өрсөлдөн УИХ-ын гишүүнээр сонгогдож, улмаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, УИХ дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлгийн ахлагчаар ажиллаж байна.

Түүний энэ удаагийн парламентад амжуулсан олон ажлаас хүмүүсийн анхааралд хамгийн их өртөж, батлагдсанаасаа хойш хамгийн хэрэгжилт сайтай байгаа хууль нь Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль юм. Засгийн газраас 2010 онд өргөн мэдүүлсэн ч хоёр жилийн турш маргалдаад баталж чадахгүй байсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Л.Эрдэнэчимэг гишүүн гардан боловсруулж 2012 оны 10 дугаар сарын 25-нд батлуулсан нь 2013 оны гуравдугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн билээ.

Өнгөрсөн 2012 оны сонгуулийн үр дүнд 11 эмэгтэй УИХ-ын гишүүн болсон нь шийдвэр гаргах түвшинд аль болох олон эмэгтэйчүүдийг гаргахаар зорьж тэмцсэн Л.Эрдэнэчимэг гишүүнд улам их урам зориг өгчээ. Өмнөх УИХ гуравхан эмэгтэй гишүүнтэй байсан энэ парламентад эмэгтэй гишүүдийн тоо бараг дөрөв дахин нэмэгдэж, бүлэг байгуулах хэмжээнд хүрсэн билээ. Тиймээс парламент дахь улс төрийн таван намыг төлөөлсөн эмэгтэй гишүүд УИХ дахь эмэгтэй гишүүдийн албан бус бүлэг байгуулан Л.Эрдэнэчимэгийг даргаараа сонгосон нь тохиолдлын хэрэг биш юм.

Төрийн түшээ Л.Эрдэнэчимэг журмын нөхдийн хамт Хамтын тэтгэврийн тухай хуулийн төсөл өргөн барьж батлуулсан нь тэтгэвэр авагчдын тухайд жинхэнэ цагаа олсон, чухал шийдвэр болоод байгаа билээ. 2017 оны нэгдүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхлэх энэ хуулиар ахмадууд маань хорвоогийн мөнх бусыг үзсэн ханийнхаа авч байсан тэтгэврийн тодорхой хувийг өвлөн авахаар болж байгаа нь нийгмийн тодорхой хэсгийн амьдралын баталгаа эрс сайжрах боломж бүрдэх юм.

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг 2016 оноос Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар сонгогдон ажиллах хугацаандаа Тос, Тосон бумбын нурууг Улсын тусгай хамгаалалтад авах тогтоолын төслийг өргөн барьж батлуулсан нь Өмнөговь аймгийн Гурвантэс болон ойр орчмын Ноён зэрэг сумдын иргэдийн зүй ёсны талархлыг хүлээсэн юм. Ирвэс хамгаалагч, биологич залуугийн амь насаар үнэлэгдсэн Монголын үзэсгэлэнт газар, дэлхийд ховордсон ирвэсийн нутаг Тосон бумбын нуруу Өмнөговь аймгийн малчдын эзэмшилд үлдэж, уул уурхайгаас ангид болсон нь эх оронч төрийн түшээ Л.Эрдэнэчимэгийг хийсэн ажлын бас нэгэн томоохон үзүүлэлт.

Түүний сонгогдсон Сонгинохайрхан дүүргийн нийт өрхийн 80 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг. Тиймээс гэр хорооллын иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд иргэдийн эзэмшлийн газар үнэтэй байх нь чухал гэдгийг Л.Эрдэнэчимэг гишүүн иргэд сонгогчидтой уулзах болгондоо ярьж, тайлбарлаж ойлгуулсаар явна. Энэ ажлын хүрээнд “Сайн хашаа” хөтөлбөр санаачилсан нь үр дүнтэй хэрэгжиж эхлээд байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд иргэд хашааныхаа газрыг нийлүүлж, хамтран байшингаа барьж, илүү гарсан газар дээрээ үр хүүхэддээ байшин барих, эсвэл зарж борлуулан орлогоо нэмэх, аж ахуй эрхлэх боломжийг нь бүрдүүлэх юм.

Газраараа барьцаалан ипотекийн таван хувийн зээл авах эрхтэй болж байгаа нь иргэдийн өмчлөлийн газар жинхэнэ утгаараа эдийн засгийн эргэлтэд орж байгаагийн нотолгоо. Иргэд эвлэлдэн нэгдээд дундаасаа газраа гаргаад өгвөл улсаас газрыг нь худалдаж аваад сургууль, цэцэрлэгийг нь бариад өгнө. Хамтарч чадаж буй иргэддээ улсаас ус, бохир, дулааны дэд бүтцийг хийгээд өгье гэж байгаа нь эрхэм төрийн түшээ Л.Эрдэнэчимэг нарын ухаалаг, алсыг харсан санаачилга, шийдвэрийн үр дүн билээ. Товчхондоо өнөөдөр хоёр ерөө байраар л үнэлэгдэж байгаа хашааны газрыг илүү үнэ цэнэтэй, илүү найдвартай, үр өгөөжтэй эдийн засгийн эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчныг төрийн түшээ Л.Эрдэнэчимэг бодож, боловсруулсаар явна.

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Улсын Бага Хурлаас эхлэн тасралтгүй сонгогдсон



Д.Дэмбэрэл



Л.Лүндээжанцан

Улсын Бага Хурлын гишүүд (1990-1992)



С.Баярцогт



Л.Болд



Р.Гончигдорж



Д.Дэмбэрэл



Л.Лүндээжанцан



Л.Цог

Үндсэн хууль баталцсан (1992 оны)



Н.Батбаяр



С.Баярцогт



Л.Болд



Р.Гончигдорж



Д.Дэмбэрэл



Л.Лүндээжанцан



Л.Цог

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Улсын Их Хуралд 6 удаа сонгогдсон



Д.Дэмбэрэл



Л.Лүндээжанцан



Ц.Нямдорж

Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон



Р.Гончигдорж



С.Оюун



Ч.Улаан

Улсын Их Хуралд 4 удаа сонгогдсон



Р.Амаржаргал



Д.Арвин



Су.Батболд



Ц.Баярсайхан



С.Баярцогт



Н.Энхболд



Ө.Энхтүвшин

3

3

7

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Улсын Их Хуралд 3 удаа сонгогдсон



Н.Алтанхуяг



Н.Батбаяр



Сү.Батболд



Х.Баттулга



Г.Батхүү



Б.Бат-Эрдэнэ



Л.Болд



Л.Гантөмөр



Д.Ганхуяг



Ц.Дашдорж



Д.Оюунхорол



Ч.Сайханбилэг



Д.Тэрбишлагва



З.Энхболд



М.Энхболд

Шинжлэх ухааны доктор



А.Бакей



Р.Гончигдорж



Д.Лүндээжанцан

15

3

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Улсын Их Хуралд 2 удаа сонгогдсон



А.Бакей



Ж.Батсуурь



Н.Батцэрэг



Д.Бат-Эрдэнэ



Г.Баярсайхан



С.Бямбаабогт



Ц.Даваасүрэн



Д.Зоригт



М.Зоригт



Ц.Оюунбаатар



Я.Санжмятав



М.Сономпил



А.Тлейхан



Х.Тэмүүжин



Д.Хаянхярваа



Ч.Хүрэлбаатар



Б.Чойжилсүрэн



Ж.Энхбаяр



С.Эрдэнэ

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Улсын Их Хурлын даргаар ажиллаж байсан



Р.Гончигдорж



Ц.Нямдорж



Л.Лүндээжанцан



Д.Дэмбэрэл

Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан



Р.Амаржаргал



Н.Алтанхуяг



Сү.Батболд



М.Энхболд

Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар



Б.Бат-Эрдэнэ

Шинжлэх Ухааны
Академийн Академич



Р.Гончигдорж

Монгол Улсын Гавьяат цолтон

Гавьяат хуульч:



Д.Лүндээжанцан



Ц.Нямдорж

ЭНХБОЛДЫН АНГИЙНХАН

Гавьяат эдийн засагч:



А.Бакей



Н.Батбаяр



Ц.Баярсайхан



Д.Дэмбэрэл



С.Дэмбэрэл



Ч.Улаан

Шинжлэх ухааны гавьяат ажилтан:



Р.Гончигдорж

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан:



А.Тлейхан

Гавьяат багш:



Д.Оюунхорол

Соёлын гавьяат зүтгэлтэн:



Д.Сарангэрэл

Гавьяат тамирчин:



Б.Бат-Эрдэнэ



Х.Баттулга

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭМЭГТЭЙ ГИШҮҮД

Энэ удаагийн УИХ-д өмнөх парламентуудаас хамгийн олон буюу 11 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдож ажиллав.



Зураг дээр: (зүүнээс) Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Сарангэрэл, Д.Арвин, С.Оюун, Г.Уянга, Ц.Оюунгэрэл, Л.Эрдэнэчимэг, Д.Оюунхорол, М.Батчимэг, З.Баянсэлэнгэ, Р.Бурмаа

БОЛОВСРОЛЫН ДОКТОРУУД

Энэ удаагийн УИХ-д (эдийн засгийн, хууль зүйн, удирдахуйн, түүхийн, философийн, техникийн, байгалийн болон биологийн ухаан) боловсролын докторын зэрэгтэй 18 гишүүн бий.



Сү.Батболд



Сү.Батболд



Ж.Батзандан



Д.Бат-Эрдэнэ



Б.Бат-Эрдэнэ



Ж.Батсуурь



Г.Баярсайхан



Д.Дэмбэрэл



Ё.Отгонбаяр



С.Оюун



Д.Оюунхорол



А.Тлейхан



Ш.Түвэндорж



Ч.Улаан



Ц.Цолмон



Ө.Энхтүвшин



С.Эрдэнэ



Л.Эрдэнэчимэг

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮД ГЭРЭЛ ЗУРГИЙН ДУРАНД











ГАРЧИГ

Ачааны хүндийг үүрсэн парламент байлаа	3
Тамгын газар хуулиар хүлээсэн чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж ирлээ	6
I БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ	
Монгол Улсын Их Хурлын бүрэлдэхүүн	10
Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	12
Улсын Их Хурлын дарга, дэд дарга нар	17
Улсын Их Хурлын Байнгын, дэд хороодын дарга нар	19
Монгол Улсын Их Хурлын гишүүд	23
Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдийн үйл ажиллагаа	27
II БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ОНЦЛОГ ҮЙЛ ЯВДЛУУД	
Улсын Их Хурлын Анхдугаар чуулган	34
Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөв	37
Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаанууд	38
Олон улсын хурал, чуулганууд	43
III БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
Монгол Улсын Их Хурал дөрвөн жилд	48
Улсын Их Хурлын Байнгын хороодын үйл ажиллагаа	56
Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаатай холбоотой тоон үзүүлэлтүүд	72
Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн жагсаалт	76
Улсын Их Хурлын Тамгын газар	84
IV БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА	
Монголын парламентын бүлгэмийн хамтын ажиллагаа	90
Гадаадын парламентын төлөөлөгчдийн айлчлал	93
Парламентууд хоорондын хамтын ажиллагаа	95
V БҮЛЭГ: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮД	
Улсын Их Хурлын гишүүд	100
З.Энхболдын ангийнхан	255
Парламентын гишүүд гэрэл зургийн дуранд	263